

СИДНИ ШЕЛДОН



**ШӨНӨ ДУНДЫН ХАР
ДАРСАН ЗҮҮД**

Сидни Шелдон

Шөнө дундын хар дарсан зүүд

www.kiebooks.com

Эхлэл

Коулун, 1949 оны 5 сар

-Золгүй явдал шиг харагдахаар хийгээрэй дээ. Чадна биз дээ, чи!

Мөн их доромжлох нь ээ. Золгүй явдал байшин дотор явагдаж болно. Тэгвэл яг Марселийн бүжигчин хүүхэн шиг шатнаас хийсч хүзүүгээ хугалж эсвэл нөгөө Гстаадын үв залгамжлагч шиг усанд ордог онгоцондоо согтуугаар живж бас болно. Бас энэ эмэгтэй геройн хэрэглэхдээ хэтрүүлж орхисон ч байж болно. Энэ аргыг тэр гурван ч удаа хэрэглэсэн билээ. Мөн цогтой янжуураа тэврээд унтаж орхисон байхыг үгүйсгэх аргагүй. Энэ аргаар Парисын нэгэн зочид буудалд Шведээс ирсэн мөрдөгчтэй тооцоо бодож байж билээ. Золгүй явдал бас цэвэр агаарт явагдаж болно. Автын юм уу, онгоцны осол эсвэл далайд живж алга болохын аль нь таны санаанд илүү нийцэх бол? гэж эгдүүцсэндээ хэллчих дөхлөө.

Гэвч тэрээр юу ч хэлсэнгүй. Өөдөөс нь хараад сууж байгаа энэ хүний талаар аймшигтай, балмад адал явдал олон дуулддаг бөгөөд үүнд итгэх үндэслэл байсан болохоор тэр айж байжээ.

-Тийм ээ, эрхэм ээ. Би золгүй явдал шигээр зохион байгуулж чадна. Хэн ч хэзээ ч учрыг мэдэж чадахгүй гэдгээр үгээ хязгаарлалаа.

Тэд нар Коулун хотын нэгэн байшингийн гуравдугаар давхарын өрөөнд ярилцаж суух бөгөөд энэ нь бүр 1840 онд Британы халдан довтлогчдоос хамгаалж хятадуудын хотыг тойруулан барьж босгосон хан хэрэм дунд оршиж байв.

Дэлхийн хоёрдугаар дайны үед хана хэрэм нурж эдэрсэн хэдий ч гадаадынханаас хотыг ангид бариад байх хэрэм хангалттай үлджээ.

Тэнд таг харанхуй шат бүхий муруй тахир гудамжнууд, дээрмчин тонуулчид, мансууруулах донтон, хүчирхийлэгчид дүүрэн байдаг ажээ.

Жуулчдад энд ирэхийг хэн ч зөлөдөггүй, тэгээд бас цагдаагийнхан Тун Тау Цены гудамжнуудад үзэгдэхийг ч үхүсдэггүйд хэргийн учир байгаа билээ.

Цонхны цаанаас уг хороонд амьдран суугчдын зүсэн зүйлийн хэлээр хэлэлцэх сөөнгө хахирган хоолойгоор хашгиралдах дуу холилдон сонсогдоно.

Хөөрөлдөн суугаа эрхэм хүн түүнийг бодлогоширсон нүдээр харж сонжин хэсэг сууснаа эцэст нь,

-За яах вэ, яаж хийхээ өрөө мэдэгтүн гэв.

-Тэгье, эрхэм ээ. Тэр эмэгтэй Коулунд байгаа юу?

-Лондонд байгаа. Нэр нь Кэтрин Александр.

Хээнцэр ганган машин хамгаалагчдыг араасаа дагуулсаар бодлогоширсон нүдтэй эрийг Цин Ша Цуй дүүргийн Ласкер Поудад орших Цэнхэр ордны өмнө авчирлаа. Цэнхэр ордон бол зөвхөн сонгомол шилдгүүдэд зориулагдсан төдийгүй төрийн тэргүүнүүд, кино, одод, том корпорацийн ерөнхийлөгчид л багтана. Ордны эзэд амаа сайтар хамхиж чаддагтаа ахархдаг байв. Хэдэн жилийн өмнө энд ажилладаг байсан нэг хүүхэн сэтгүүлдчдэд өөрийн түншийн талаар чалчих гэж оролдож байгаад маргааш өглөө нь Абердбины далайн боомт орчмоос хүүр нь олдсон юмсанжээ. Түүний хэлийг эхлээд огтолсон байсан гэдэг. Цэнхэр ордонд онгон охид, балчир хөвгүүдийн аль алиныг олж болох ба лесби, эр хүнгүйгээр аьтайхан амжуулж орших хэрэгсэл эсвэл бүр боломжийн амьтан ч худалдан авч болно.

Эрхэм энэ удаад ихрүүдийг захиалсан байв. Тэд бие биетэйгээ усны дусал мэт адилхан бөгөөд, онцгой үзэсгэлэнтэйн дээр ер бусын гайхалтай уян налархай биетэй байлаа. Мөн тэд огтхон ч биеэ барьж ичингүйрдэггүй болохоор залууд их таалагддаг байж болох л юм. Тэрээр сүүлийн удаа энд ирсэнээ нэхэн санав... төмөр сандал, ихрүүдийн зөөлөн бөгөөд энхрий ялдам хуруунууд түүний биен дээр бүжиглэх мэт... анхилуун үнэрт халуун ус, дүүргэсэн торхноосоо хэдийн халин асгарч байв. Тэдний халуун уруул хамаг биеийг нь озно.... Одоо тэр өөрий нь сэрэл хэрхэн хөдөлж байгааг мэдэрч эхлэв.

-Бид ирлээ, эрхэмээ

Гурван цагийн дараа ажлаа дуусган, сэтгэл ханасан байртай лимүзиндээ суун Мөүдү Рөүдийг зорин давхина. Хааяа нэг машиныхаа цонхоор, хэзээ ч нойрсдоггүй байхдаа гэмээр байнгийн хөл хөдөлгөөнтэй энэхүү хотыг ажиглан явна. Хятадууд үүнийгээ Гау-Лүн буюу 9н луу хэмээн нэрийдсэн ба тэрхүү луунуудыг хотын ойр орших өндөр уулын оройд отон, тун удахгүй доош бууж хүчгүй дорой бүхнийг устгана хэмээн итгэцгээдэг ажээ.

Тэд Мөүди Рөүдэд ирлээ.

Түүнийг хүлээн зогсох шар нөмрөгийг давхарлан хаясан, урт цагаан сахалтай ламтан яг л шаазан хүүхэлдэй мэт харагдана.

-Жоу сан

-Жоу гамин

-Гэй до чин?

Ламтан нүдээ анин мөргөлөө хийж эхэллээ. Дээр нь тоо сийлэн бичсэн модон савхнуудаар дүүргэсэн аягыг сэгсэрч эхлэв. Тун удалгүй нэг савх газар унав. Ламтан нухацтай ажиглаж дууссаныхаа дараа зочин руугаа харуулан тавив. Тэр англиар бага зэрэг түгдрэн ярьж эхэллээ.

-Бурхад таныг тун удахгүй маш аюултай дайснаасаа бүрмөсөн ангижрана хэмээж байна.

Бодлогоширсон нүдэт эрхэмд таатай бөгөөд гайхмаар мэдрэмж төрлөө. Гэвч тэр ламын хэлсэнийг зүгээр л нэг мухар сүсэг гэдгийг хангалттай ойлгохоор ухаантай нэгэн аж. Тийм ч учраас үл тоомсорлон суусан биз.

Үүнээс гадна түүнд өөр нэгэн сайхан зүйл болно гэж совин татаад байв. Өнөөдөр бол Агиос Константины өдөр буюу эрхэм ноёнтоны төрсөн өдөр билээ.

-Бурхад таныг ивээх болтугай, эрхэмээ.

5 минутын дараа тэр өөрийн лимүзиндээ суун Кай Такийг чиглэн давхив. Учир нь тэнд түүний хувийн онгоц нь Афин явахаар хүлээж байв.

Нэгдүгээр хэсэг

Ионин, Грег 1948 оны 7-р сар

Залуу бүсгүй шөнө болгон зүүдлэх нэгэн хэвийн хар дарсан зүүднээсээ үргэлж хашгирсаар сэрнэ. Ширүүн салхитай шөнөөр нуурын голд зогсох түүнийг үл таних эмэгтэй, эрэгтэй хоёр цэв хүйтэн ус руу живүүлэх гэж оролдоно... Яг тэр үед бүсгүйн амьсгаа нь давхцан, хүйтэн хөлсөндөө нэвчсээр сэрнэ.

Тэрээр өөрийгөө хэн гэдгээ мэдэхгүйгээр үл барам өнгөрсөн амьдарлыхаа тухай юуг ч үл санана. Англиар ярьж байсан боловч хаанаас ирсэнээ, яагаад заавал Грегд, тэр тусмаа өөрийг нь ямар нэгэн далдын хүчнээс хамгаалах мэт энэ жижигхэн гэлэнмаа нарын сүмд ирсэнээ даанч мэдэхгүй байлаа.

Цаг хугацаа өнгөрөх тусам бага багаар түүний ой ухаан сэргэх мэт хэд хэдэн дүр зураг зэрэг толгойнд нь буух авч түүнийг юу гэдгийг нь санаж амжихаас өмнө алга болно. Тэр дүр зургууд үргэлж санаандгүй агшинд буун хөөрхий бүсгүйг байнга балмагдуулна.

Эхэндээ бүсгүй үргэлж сүмд тааралдсан гэлэнмаа нараас асуулт асуун шалгаадаг байв. Хэдийгээр тэд бүсгүйд байнга халамж тавин асрах боловч анир чимээгүй байх үүрэгтэй учир төдийлэн сэтгэлийг нь хуваалцах нь ховор. Гэвч бүсгүйтэй ярилцдаг хүн байсан бөгөөд түүнийг Тереза эх гэх бөгөөд, тэрээр энэ сүмийн ахлах нь юм.

-Та намайг хэн гэдгийг мэдэхгүй биз?

-Мэдэхгүй дээ, үр минь

-Би яаж энд ирсэн юм бол?

-.....

-Энэ уулын бэлд Ионин гэдэг хот байгаа. Өнгөрсөн жилийн ширүүн шуурганы үеэр чамайг жижиг завин дээр ухаангүй хэвтэж байхад бурханы авралаар манай 2 гэлэнмаа олсон юм.

-Гэхдээ... би өмнө нь хаана байсан юм бол?

-Уучлаарай охин минь, би мэдэхгүй юм байна

Түүнд энэ хариулт хангалтгүй байлаа.

-Хэн ч намайг дурсан, нэхэл дагал болоогүй гэж үү? Хэн ч намайг хайгаагүй гэж үү?

Тереза эх толгойгоо сэгсрэн,

-Хэн ч ирээгүй,

гэдгээс өөр зүйл хэлсэнгүй.

Бүсгүйн сэтгэл гонсойн, чангаар хашгирмаар байвч тэвчээр заана. Дахин оролдож үзхээр шийдэв.

-Сонингууд...намайг алга болсон гэж шуугисан л байж таарна.

-Чи мэдэж байгаа шүүдээ, бид зөвхөн бурханы хүсэлтээр түүнд л үнэнчээр хандан, гадны нөлөөнд автдаггүй шүү дээ. Бид бурханд талархах хэрэгтэй, чи амьд байна.

Бүсгүй үүнээс өөр юу ч тодруулж чадсангүй.

Эхний хэдэн сар тэр өөртөө анхаарал тавихад хэтэрхий сул дорой биетэй байсан боловч цаг хугацаа өнгөрөх тусам бие нь дээрдэж байлаа.

Сүүлийн үед бүсгүй өдрийг аль болох, өнгө өнгө алагласан сүмийн үзэсгэлэнт цэцэрлэгт, усан үзмийн модны анхилуун үнэрт алхан өнгөрөөх болов. Тэндхийн уур амьсгал хэдийгээр тайван амгалан байсан боловч бүсгүйн дотор давчдан, хэзээ мөдгүй дэлбэрэх галт уул адил тогтворгүй байлаа.

-Би хаягдчихсан, хэмээн тэр бодно, би хэн ч биш....

Яагаад? Би тийм муу юм хийсэн юм гэж үү? Би ингэхэд хэн юм? Хэн юм?...

Өнөөх л дүр зургууд сэтгэлд нь өөрийн эрхгүй буусаар л...Нэгэн өглөө бүсгүй өөрийх нь хувцасыг тайчих нүцгэн залуун дүрсийг зүүдэндээ олж харав. Энэ бол цоо шинэ дүр зураг байсан юм. Санамсаргүйгээр харсан бүхэн нь ердөө л нэг зүүд байсан юм болов уу? Эсвэл түүний амьдарлаас тасарч ирсэн дурсамж? Энэ залуу хэн байв? Түүний сүйт залуу? Тэр ер нь нөхөртэй байсан болов уу?....Гэвч түүнд ямар ч бөгж алга.

Үнэндээ түүнд Тереза эхийн өгсөн хар гэлэнмаа нөмрөг, сүлбээр зүү мөн далавчаа дэлгэсэн улаан нүдэт алтадмал өнгөтэй шувуу бүхий үсний даруулга л байв.

Тэр өөрийгөө нэр нь үл мэдэгдэх, танихгүй хүмүүс дундах танихгүй хүн болохоо одоо л ойлгов. Энэ сүмд түүнд тус болж чадах нэг ч хүн байсангүй, энэ бөглүү тосгоны сүмд, түүний ой ухаан нь аймшигт өнгөрсөнөөс нь болоод бага зэрэг гэмтсэн ба тун удахгүй бүх зүйлээ эргэн санана гэдгийг тайлбарлаад өгөх сэтгэл зүйч яаж байх билээ дээ...

Тиймээ, тэр одоо нөгөөх учир нь үл ойлгогдох хар дарсан зүүднүүдээ урьд нь болж байсан бодит зүйлс гэдэгт итгэдэг болсон! Одоо түүний оюун ухаанд томоос том эвлүүлдэг тоглоом үүссэн гэхэд бараг болно. Хэсэг бүр нь нэг нэгээрээ санаанд нь орно, гэвч хоорондоо ямар ч авцалдаа алга. Энэ байдал түүнийг галзууруулах шахна.

Нэг удаа түүнд маш олон офицер хувцастай залуусаар дүүрэн студи харагдав. Ямар нэгэн зураг авалт болж байгаа бололтой.

-Би жүжигчин байсан юм болов уу?

Үгүй ээ, тэр ямар нэгэн зүйл зохицуулж байгаа харагдана. Гэвч юуг? Нэг цэрэг түүнд тэвэр

дүүрэн цэцэг өгөв. "Чи хариуг нь биеэрээ төлсөн ч болно шүү, хэхэ"

Тэр эрийн инээд..

Хоёр хоногийн дараа мөнөөх л эр зүүдэнд нь орно.Бүсгүй залуу эртэй онгоцны буудал дээр салах ёс хийж байгаа харагдана.Энэ шөнөөс хойш ахин хар дарж зүүдэлсэнгүй.

-Би заавал өөрийхөө хэн болохыг олж мэдэх хэрэгтэй! Гэвч яаж....

Хоёрдугаар хэсэг.

Афин, Грек.

Константин Демирисийн ноёрхлыг хэн ч газрын зураг дээр зураад тодорхойлж чадахгүй билээ. Феодалын бант улсын хаадаас дутахгүй их хүч чадал, эрх мэдэлтэй түүний нэр нөлөө хязгааргүй ажээ. тэр бол хорвоогийн хамгийн баян хүмүүсийн нэг. Түүний ямар нэг албан ёсны бичиг данс, цол хэргэмээс үл хамааран тэр амбан сайд, хамба лам, тэр байтугай хааныг ч худалдаад авчихаж элбэг дөнгөнө, худалдаж ч чадна. Түүний захиргаанд арваад орон багтдаг бөгөөд хүн нь өөрөө бусдын сэтгэлийг татах увидастай, хурц ухаантай, өндөр нуруутай, ханхар өргөн цээжтэй сайхан эр билээ. Тэр бараандуу царайтай, ердийн грек хамартай яг л хар тас мэт нүд нь махчин шувууг санагдуулам аж. Демирис өөрөө хүсвэл гайхамшигтай сайн эр ч болж чадна. Тэрээр найман ч улсын хэлээр чөлөөтэй ярихаас гадна гайхамшигтай сайн илтгэгч байлаа. Түүнийг дэлхийд алдартай уран зургийн цуглуулгатай хүн гэдгийг дэлхий даяар андахгүй, бас хэд хэдэн онгоцны бааз, сүрлэг орд харш, сэрүүн лаврин гэхчилэн хорвоо дээр хүний хүсэж болох бүхнийг эзэмшсэн нэгэн. Константин Демирис гоо сайхныг тэр дундаа эмэгтэй хүний гоо сайхныг үнэлж чаддаг бөгөөд гялалзсан амраг гэдэг нэрийг олж, түүний дурлалын адал явдлууд янагийн паянгууд нь тэнгэрлэг, сайхнаасаа илүү үрлэгэ зарлага ихтэй байдгаараа ихээхэн ладратай байдаг юм.

Константин Демирис өөрийгөө эх оронч хэмээн бахархаж ихэд тоон үздэг. Түүний сэрүүн лаврингийн болон Парис дахь хувийн ордоны дээр грекийн цэнхэр далбаа байнга намирч байдаг. Тэр ямар ч татвар төлдөггүй бас бараг хүн болгоны шахуу захирагддаг аливаа хууль дүрэм журмыг заавал биелүүлэх шаардлагагүй гэж үздэг. Түүний судас шөрмөсөөр бурханы цус гүйж байна уу гэлтэй.

Демирис тэй уулзсан бүхэн ажил төрөлдөө эдийн засгийн тусламж хүсэх, сайн санааны хандив гуйх эсвэл зүгээ рл нөхөрлөлийнхөө хариуд нэр нөлөөг нь ашиглахыг хүсэцгээнэ. Хүмүүс зорьж ирсэн хэргээ тойруу замаар хэлж, бүрхэгдүүлэхэд түүнийг нь жинхэнэ зорилгыг тааж олохдоо хашир ухаантай Демирис ихэд зугаацан хөгждөг байснаа яваандаа энэ бүхнийг хэрэгсэхээ больж, хэнд ч итгэхгүй гэсэн зарчим баримтлах болжээ. Түүний аж амьдарлын талаар юухан хээхэн бичиж талхныхаа мөнгийг олдог сэтгүүлчид зөвхөн энэрэнгүй өгөөмөр буянтай, уран сайхан арга мэхтэй хүнийг л дүрсэлдэг, энэ сайхан багны цаана хүний үнэргүй, юунд ч торж саатахгүй өршөөлгүй алуурчин, аймшигтай хүн нуугдаж байгааг мэддэггүй байв. Юуг ч мартдаггүй, өршөөдөггүй энэ хүн dikaiosini буюу шударга энэн гэдэг үгийг endikasis буюу өшөө авалт гэсэн эсрэг утгаар ямагт ойлгон хэрэглэх агаад ямар ч тохиолдолд ялагч нь болон гардагтаа дэндүү дассан нэгэн. Тэрээр өөрийг нь гомдоосон өчүүхэн төдий зүйл, өөрийнх нь дутуу дулимаг талыг хөндсөн тохиолдолыг хэзээ ч мартдаггүй ямагт санаж хариугаа заавал авч байж салдаг байна. Демирис дайснаа огтхон ч хар авахааргүйгээр сүйрэлд оруулж, аалзны тор мэт урхи зангаар туйлын нямбай заль мэх хэрэглэн зэхэж хурц ухаантайгаар холын бодлоготойгоор шүүж тунгаадаг байлаа. Түүний амьдарлын бараг цаг мөч болгон дайснаа дарах нүх малтаж, зовлонд унасан байхыг нь харан тавлан баясаж байхад зориулагддаг гэж хэлэхэд болно. тэрээр өстнөө уйгагүй судалж зан араншингийн сайн муу талуудыг сайтар шинжиж цэгнэдэг байжээ. Нэг удаа үдийн хоолны үеэр түүнийг кино найруулагч хүн "тослог нүдтэй грек" хэмээн нэрлэсэнд түүнийг сонссон

Демирис хариугаа авах тохиромжтой мөчийг тэвчээртэйгээр хүлээсэн байна. Хоёр жил өнгөрч нөгөө кино найруулагч бараг бүх хөрөнгөө зарцуулан гол дүрд нь дэлхийд алдартай жүжигчин эмэгтэйг тоглуулахаар урьсан торгон мчийг Демирис зүгээр л тэр хүүхэнтэй учирч кино зураг авхуулахын оронд далбаат завиар надтай аялна уу гэсэн санал тавьж тохиролцоодож. тэрээр хүүхэнд:

-Энэ бол бидний бал сар байх болно. гэж хэлсэн юмсанжээ. Харин бал сар болсон боловч ямар ч хурим бололгүй өнгөрч нөгөөх муу кино найруулагч нэг мөр дампууралд орсон гэнэ. Кино ч сүржин ярианаас цаашгүй тэгсгээд өнгөрчээ.

Демирисийн занганд дахиад тооцоо бодох ёстой хэдэн хүн үлдсэн бөгөөд иймэрхүү үед сурсан зангаараа тэр хаашаа ч үл яармуй. тэрээр төлөвлөгөө зохион хэрхэн биелэгдэхийг харж хязгааргүй таашаал авдаг байв. Одоохондоо түүний санаанд шинэ дайсан алга байлаа ч хэн нэгэн хүн огтын санамсаргүй байж байгаад л түүний дайсан болж орхидог байна.

Константин Демирис *dikaiosini* гэж нэрлэж болох бас нэгэн чанар байдаг нь гомдлоо мартдаггүйн адил хэний ч тусыг мартдаггүй зан байсан юм. Түүнийг хүүхэд ахуй цагт нь асарч тойлдог байсан ядуу загасчин нэг л өдөр загас агнуурын бүхэл бытэн флотын эзэн болон хувирсан нь түүний өгөөмөр зангийн хишиг байв. Мөн ядуу даржин цагт нь мөнгөөр тэтгэж хувцаслаж байсан янхан хүүхнийг уран аргаар буудлын эзэн болгохдоо өөрийгөө мэдэгдүүлэлгүй далдалж чаджээ,

Демирис бол арван таван хүүхэдтэй боомтын ачигч хүний хүү болон төрсөн бөгөөд тэдэнд хоол унд хэзээ ч хүрэлцдүггүй байжээ. Багаасаа их авхаалжтай хүүхэд болохоо харуулан 16 настайдаа хичээлээ тараад ажил хийн, дараа нь өөрөөсөө нилээд ах залуутай хамтран мухлаг ажиллуулж ашиг овоо олж иржээ. Гэвч хамтран зүтгэгч нь түүнийг ганц сохор зоосгүй үлдээгээд одсон байна. Демирис түүнтэй тооцоо бодох гэж амьдарлынхаа арван жилийг зориулсан аж. Тэрээр аугаа их нэр хүндийг хүсэн мөрөөдөж шөнө ч унтаж чадахгүй адар ширтэн хэвтдэг байв. "Би баяжина. Би алдаршина. Миний нэрийг дэлхий даяар мэддэг болно" гэж л бодно. Энэ бүүвэйн дуу л түүнийг тайвшруулан унтуулдаг байв.

Арван долоон настайдаа Демирис Саудын Арабын нефтийн ажилбарын тухай өгүүлэл олж уншжээ. Тэгээд эцэг дээрээ очин,

-Би Саудын Араб явлаа. Нефтийн үйлдвэрт ажиллана.

гэж хэлсэн байна.

-Чи энэ тухай юу ч мэдэхгүй шүү дээ.

-Зүгээр, аав аа. Би суралцана.

Энэ ярианаас сарын дараа Демирис замдаа гарчээ.

Гадаадаас ирсэн ажилчидтай "Константинополийн тээвэр" ийн компани голдуу хоёр жилийн гэрээ байгуулдаг. гэхдээ Демирис үүнд санаа зовсонгүй. Түүнд Саудын Арабад байх нөхцөл

боллолцоо л хэрэгтэй. түүнд энэ хачин сонин хүмүүсийн нууцлаг орон, газар дороос оргилон гарах хар алт, гайхамшигт адал явдал л сэтгэл хөдөлгөм сайхан санагдана.

Зуны нэгэн өглөө болоход Демирис цөлийн дунд орших нурж навсайсан чулуун байшин, түүнийг хүрээлсэн жижигхэн хулсан овоохойнуудаас бүтсэн уйтгартай бяцхан лагерь болох Фадилид очсон байлаа. Энд ойролцоогоор мянга гаруй мэргэжлийн бус ажилчид, ихэнх нь нутгийн оршин суугчид амьдарна. Тоос шороо ихтэй гудамжинд дайралдах эмэгтэйчүүд цөм нүүрэндээ халхавчтай явдаг байлаа.

Демирис шууд явсаар боловсон хүчний хэлтсийн эрхлэгч Мак-Интайрын өрөөнд орж очвол түүнийг хараад,

-Тэгэхээр чи хөлсний ажил эрж явна уу? гэж асуув.

-Тийм ээ, эрхмээ.

-Урьд нь нефтийн үйлдвэрт ажиллаж байсан уу?

Яагаад ч юм бэ түүнд худал яримаар санагдаж,

-Тийм, эрхмээ гээд хэлчихжээ.

Мак-Интайр жуумалзан,

-Энд чамд таалагдана гэдэгт итгэж байна. Хамгийн ойрхоны тосгон хүртэл мянган миль зайтай...тэгээд ч чамайг төмсөгөө огтлуулахад туслах нэг ч эм хүйстэн энд байхгүй. Иймээс шөнө оройн цагаар ямар нэг асуудал гарахгүй. Гэхдээ мөнгө гэдэг аятайхан зүйлтэй эвлэрнэ биздээ? гэж хэлжээ.

-Би суралцахыг хүсэж байна гэж Демирис болгоомжтойхон хэлэв.

-Тийм үү? Тэгвэл хурдхан шиг суралцаж үз. Энэ чинь лалын шашинтай орон. Тэгэхээр архидан согтуурах явдал байдаггүй, хулгай хийсэн хүний эхлээд нэг дараа нь нөгөө гарыг нь, эцэст нь хөлийг нь огтолдог, хэн ч байсан тэр шүү дээ. Харин аллага хийвэл шууд толгойг чинь цавчина даа.

-Би хүн алах гэж ирээгүй.

-Жаахан хүлээ гэж Мак-Интайр үгийг нь таслаад, -Чи дөнгөж ирээд байгаа гэдгээ битгий март хэмээн сануулав.

Гацаа яг л Вавилон хот гэсэн үг. Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүс өөр өөрсдийн хэлээр шулганалдана. Демирис ой сайтай учир хэл сурахдаа чадамгай байв. Энд цугларсан хүмүүсийн үүрэг даалгавар нь энэхүү зочломтгой бус цөлийн дунд орон сууц барих, зам тавих, цахилгаан болон утсан холбооны шон босгох засварын газар байгуулах, хэрэглээний болон ундны усаар хангах, цэвэрлэгээний байгууламж, эмнэлгийн байгууллагатай болох зэрэг амьдарлын чухал асуудлыг шийдэх явдал байсан бөгөөд залуу Демирисийн хувьд өөр бас

амин чухал асуудал зөндөө байх шиг санагдана.

Тэд Фарагейтын 100 хэмд ажиллах бөгөөд ялаа шумуул хумхийн тоос шороо дунд халуун чичрэг, гэдэсний халдварт өвчин ихэссэнээс зовж шаналсан хүмүүс хаа сайгүй.

Мөн энэ цөлд гэхэд л нийгмийн ангилал гарчихсан байдаг. Юу гэвэл, нефть хайж олдог хайгуулчид хамгийн дээд давхаргынханд тооцогддог, харин хамгийн доод шатныхан бол шумуул гэж нэрлэгддэг барилгачид, ажилчид, мод цэвэрлэгч хэмээгдэх конторын албан хаагчид байв. Хайгуулчид, инженер, химичид, мөн шууд өрөмдлөг хийдэг ажилчид нь голдуу америкчууд бай ба Америкт эргэлддэг өрөм зохиогдсоныг тэд бусдаас илүү сайн эзэмшиж чаддаг байснаар Демирис тэдэнтэй ойртон нөхөрлөхийг илүүд үздэг болов.

Тэрээр өрөмчдийг байнга тойрон эргэлдэх бөгөөд тэд нараас элдвийг асууж шалгаадаггүй харин элс усыг шингээхийн адилаар элдэв мэдээ мэдээллийг хомхойрон чагнаж суудаг байлаа. Тэгээд нэг гаргалтанд хоёр төрлийн өрөмдлөг байгааг анзаараад,

-Сонин юм. Яагаад хоёр төрлийн өрөмдөх арга хэрэглэдэг юм бэ? гэвэл,

-Хүү минь, зарим үед бид багаж хэрэгслийг цамхаг дээр гаргаж, доош цооног руу буулгах хэрэгтэй болдог гээд тэр хүн энэ бүхнийг ингэтлээ сонирхоод байгаа залуу руу харж:

-Үүнийг derrish гэдгийг чи лав мэдэхгүй гэдэгт би тангараг тавихад бэлэн байна гэвэл,

-Мэдэхгүй, эрхэмээ.

-ХҮШ зуунд амьдарч байсан нэг их нэртэй алуурчны нэр гэдэг юм.

-Ойлгомжтой.

-Аргамж татлагат өрөмдлөг бол эртний хуучин арга л даа. Зуугаад жилийн өмнө хятадууд худаг ухахдаа энэ аргыг хэрэглэж байсан, Тэд татлагаар дээш доош гүйдэг хэрэгслийн тусламжтайгаар энэ аргыг хэрэглэдэг байжээ....

Түүнд юм бүхэн сонин гэж жигтэйхэн.

Тэд эндээс хаа сайгүй нефть оллоо. Эхлээд Абы Хелригоос, дараа нь Катиф, тэгээд Хорадоос. Ажилчид улам шаргуу ажиллах болов.

Тэнд шинээр англи геологич эхнэртэйгээ ирлээ. Жар гарсан Генри Паттерсоны гэргий дөнгөж гуч шүргэж яваа Сибил бол бүдүүн орилоо дуутай, өөр газарт бол онцгой сэтгэгдэл төрүүлэхээр боловч Фадилд эр хүн болгонд үзэсгэлэнт авхай мэт харагдана. Нөхрийгөө нефть эрж явах болгонд эхнэр нь ганцаараа үлддэг байв.

Залуу Демирис хатагтай Сибилд тусалж шинэ байраа тохижуулахад дэм болж байх үүрэг авав.

-Энэ муухай газар надад үзэж сонирхох юм даанч алга гэж эхнэр халаглан,

-Генри намайг ямагт аймшигтай газраар чирч явах юм даа. энэ бүгдийг би яагаад тэсвэрлэж байх ёстой юм бэ? гэж тэр үглэв.

-Таны нөхөр их чухал ажилтай хүн шүүдээ хэмээн түүнд Демирис итгүүлэхийг оролдов.

Хүүхэн залуу эрийг сонирхсон харцаар зэрвэс хараад,

-Миний нхөр үүргээ бүрэн биелүүлж чаддаггүй. Та миний юу ярьж байгааг ойлгож байна уу? гэсэнд мэдээж бүгдийг ойлгож байсан Демирис,

-Үгүй, хатагтай гэлээ.

-Таныг хэн гэдэг вэ?

-Демирис, хатагтай Константин Демирис гэдэг.

-Найз нөхөд ойр дотныхон чинь хэн гэж дууддаг вэ?

-Коста гэдэг.

-За тэгвэл Коста хоюулаа ойр дотно танилцья. Чи бид хоёрт энэ хүмүүстэй адил юм юу ч байхгүй, тийм үү?

-Би явж ажлаа хийх ёстой гэж Демирис хариулав.

Хэдэн долоо хоногийн турш Сибил Паттерсон авгай залуу хүүг зарах шалтаг хайж олоод,

-Генри өглөө дахиад л яваад өгсөн. Ямар нэг юм өрөмдөх гэнэ гэж залууд хэлэв.

Демирис юу хэлэхээ мэдкүү байв. Түүний нөхөр хайгуулч компаны захиргаанд нилээд дээгүүр албан тушаалд суудаг тул Демирис түүний эхнэртэй учир ургуулж ажлаа алдмааргүй байсан ч Сибилйн тусламжтайгаар мөрөөдлөө биелүүлж болно гэдэгт итгэлтэй байсан юм. Нефть бол их ирээдүй, тэгэхээр энэ боломжийг алдаж яасан ч болохгүй гэж тэр шийджээ.

Сибил Демирисийг шөнө дундын алдад дуудав.

демирис байшинд тулж очоод хаалгыг тогшсонд,

-Ор, ор гэх нь дуулав. Сибил юугаа ч нууж хааж чадахааргүй сиймгэр эдээр оёсон унтлагын хувцастай байсанд Демирис сандран,

-Би... Та намайг дуудсан уу?

-Тийм ээ, Коста. Энэ шөнийн дэн ажиллахаа байчих шиг боллоо.

Коста анхаарлаа өөр тийш залахыг хиээн дэнг өргөөд,

-Чийдэн алга гэснээ... гэнэт нуруунд нь наалдаж араас нь тэврэхийг мэдрэн дуугүй болов.

-Хатагтай Паттерсон...

Хүүхэн түүнийг зузаан уруулаараа озон орон дээр дарж унасанд демирис өөрийгөө захирч чадахаа болиоо. Хувцасаа мулт татан хаяад хүүхнийг эзэмдэж авах үед тэрээр,

-Дахиад, дахиад, гуйя дахиад! Тэнгэр минь, үүнийг хийхгүй яасан ч их удав даа гэж бахардан орилох дууг л сонсож байв. Эцэст нь хүүхэн өндийгөөд,

-Хонгор минь, би чамд хайртай! гэлээ.

Демирис түүнтэй зэрэгцэн хэвтэнгээ " Би чинь юу хийчихэв ээ? Хэрэв Паттерсон мэдвэл би ч дуусах нь тэр дээ" гэж түгшүүрлэн бодов.

Сибил түүний бодлыг таасан бололтой инээгээд,

-энэ бидни бяцхан нууц болог, тийм үү? Миний баяр баясгалан минь гэв.

Энэхүү бяц хан нууц ийнхүү хэдэн сар үргэлжиллээ. Нөхрийгөө хэдэн хоногоор эзгүй байх хооронд Сибил түүнийг байнга дуудах ба сДемирис ч авгайтай зугаацахаас дургүйцэх юм алга байв. Гагц хүү сибил түүнд дурласан нь тоогүй санагдана.

-Чи эн үнэхээрийн муухай газарт дэндүү сайхан санагдаж бн шүү! Хоюулаа англи уу буцъя гэв.

-Манайх Грект байдаг л даа.

-Байсан болог гэж хүүхэн түүнийг таалангаа засаж хэлээд:

-Чи надтай буцах уу? Би Генригээс салаад хоюулаа гэрлэчихье гэх нь тэр.

Демирис баахан сандарч,

-Сибил, би... надад мөнгө байхгүй...гэхэд нь Сибил түүнийг үнсээд,

-Энэ бол санаа зовох зүйл биш. би мөнгө яаж олохыг мэднээ, хайрт минь гэлээ.

-Яаж?

-Өнгөрсөн шөнө Генри нефтийн нөөц олсоноо надад ярьсан. Хаана их нөөц байгааг тэр мэдэж чаддаг юм. Тэгээд тун их сандарч байна билээ. Бид энэ тухай мэдэгдэлийг өглөөний шуудангаар илгээх ёстой гэсэн. Тэр нь одоо надад бий. Чи үзэх үү?

-Тэгье, үзье гэхдээ Демирисийн зүрх дэлдэн цохилж байв.

Сибил босож ширээний жижигхэн татуурганаас зузаан дугтуй гарган авч түүн дээр ирэв. Бүгд таван хуудас байлаа. Түүний царай хувхай цайн цааснуудыг харж байснаа дараа нь

анхааралтай уншиж эхэллээ.

-Энэ юу гээч вэ?

Энэ бол нефтны шинэ орд газрын тухай, магадгүй нефть олборлолтын түүхэнд байхгүй тийм баялаг газрын тухай мэдэгдэл байлаа.

Демирис хахаж цацан байж,

-Тийм ээ, байж болох л юм гэвэл,

-За тэр, би юу гэж ярилаа хэмээн сибил хөгжилтэйгээр хэлэв.

-Одоо бид мөнгөтэй болно гэсэнд Демирис хүндээр амьсгаа аван,

-Бүгд бас ч тийм хялбар биш ээ гэв.

-Яагаад?

-Энэ цаас бол тухайн газрыг эзэмших эрхийг худалдан авсан тэр хүнд л ашигтай үнэтэй зүйл юм гэж тайлбарлаад банкин дахь дансандаа ердөө 300 доллартайгаа санав.

-Энэ тухай санаа хэрэг алга. Генрид мөнгө байгаа. Би чек бичээд өгье. 5000 доллар хүрэх болов уу?

Демирис чихэндээ итгэсэнгүй. Дэмий л,

-Би юу хэлэхээ мэдэхгүй байна гэлээ.

-Хонгор минь дээ, энэ чинь ибдний л төлөө шүү дээ. Бидний ирээдүйн төлөө.

Тэр ород дээрээ суугаад жаахан тайвшрахыг хичээв.

-Сибил чи энэ мэдэгдэлийг илгээхгүйгээр ганц хоёр хонуулж чадах болов уу?

-Мэдээж чадна. Би үүнийг баасан гариг хүртэл хадгалж чадна. Энэ хугацаа чамад хүрэлцэх үү, хонгор минь?

-Хангалттай гэж тэр толгой дохин хэлээ.

Сибилээс олж авсан энэ 5000 доллараар демирис нефтийн орд бүхий газрыг эзэмших эрхийг олж авчээ. Хэдэн сарын дараа гол өрөмдлөгийн үеэр нефть оргилон гарч Константин Демирис саятан болох замдаа шуударчээ.

Тэрээ Сибил Паттерсонос авсан 5000 доллараа эргүүлэн өгч дээр нь унтлагын шинэ цамц бэлгэлж орхиод Грек рүүгээ буцжээ. Сибил хүүхэн түүний барааг амьдралдаа дахин олж хараагүй гэнэ билээ.

Гуравдугаар хэсэг.

Байгал дээр алив зүйл ул мөрөө үлдээлгүй алга болдоггүй гэсэн хууль байдаг...

Кэтринд Александрт өнгөрсөн амьдарлынх нь тухай үе үе санагдавч тэр нь огт тодорхой бус, хоорондоо ямар ч холбоо сүлбээгүй салангид дуу хоолой төдий байх бөгөөд энэ нь зөвхөн айдас төрүүлэхээс цаашгүй.

"Кэт, чи гайхамшигтай хүн ээ. Би чамайг анх хармагцаа л үүнийг ойлгосон."

"Гүйцээ, бид салах хэрэгтэй. Би өөр хүүхэнд дурласан."

"хүлээ л дээ, би биеэ муу авч яваагаа мэдэж байнаа. Одоо бүгдийг шинээр эхэлье, тэгэх үү? надад бололцоо олгооч дээ..."

-Тэр намайг алах гээд байна...

-Хэн тэр вэ?

-Миний нөхөр...

Энэ л дуу хоолой үргэлж сонсогдох нь түүнийг шаналган зовоосоор. Өнгөрсөн амьдрал түүний тархи толгойнд давхардан давхцаад ч болов бага багаар эргэн ирж байлаа.

Хорвоогийн хамийн амар амгалан газар болох энэ сүм яваандаа түүнд шорон шиг санагдах болжээ. !Би энд гадны хүн. Тэгэхээр би урьд нь хаана байсан болж таарах вэ?" гэсэн бодолдоо Кэтрин хариу олж үл чадна. Сүмд толь огт байдаггүй, харин цэцэрлэгт орчин тойрныхоо үзэсгэлэнг тэгш гадаргуудаа тусган гэрэлтэх цөөрөм байдаг. Кэт байнга түүнийг тойрон явахдаа тонгойн өөрийгөө тольдоё гэж бодовч нүдэнд нь юу үзэгдэх бол гэхээс түгшин зүрхэлдэггүй байлаа. Нэгэн өглөө Кэт огт санамсаргүйгээр түүнрүү тонгойж өвдөг дээрээ сөгдөн харсанд наранд борлосон зөв хэлбэрийн хөөрхөн царай, өвчнөөсөө бол гунигласан том саарал нүдтэй бараан үстэй хүүхний дүрс үзэгдэв. Үнэндээ энэ нь зөвхөн зүүд байж болох боловч инээмсэглэсэн том амтай шантгардуу гуч дөхсөн болов уу гэмээр эмэгтэй царай түүнд хөөрхөн ч юм шиг санагджээ. Өнгөрснөө төдийгүй, ирээдүйгээ бас ч гээчихсэн эмэгтэй...

Надад туслах хүн хэрэгтэй.Хэнтэй яривал болох вэ? гэж бодоод тереза эхийн өрөөг чиглэн алхав.

-Тереза эх минь ээ...

-Юу гэв, үр минь?

-Би эмчид үзүүлэх шаардлагатай юм шиг санагдаад байна. Магадгүй тэр надад бүгдийг тайлбарлаж өгч чадах ч юм билүү?

Тереза эх нь түүнийг анхааралтай ширтээд,

-Суу даа , үр минь гэлээ.

Кэт хуучин хийцийн бичгийн ширээний дэргэдэх сандалд суув.

-Хонгор минь, чамайг Бурхан л эмчилж чадна. Тэр чамд юу мэдүүлэхийг хүснэ, чи түүнийг л мэдэх болно шүү дээ. Түүнээс гадна манай сүмийн энэ хана гадны хүнийг нэвтрүүлдэггүй юм.

Гэнэт Кэтриний ой ухаанд нэг эрэгтэй хэн цэцэрлэг дотор ярилцаж түүнд ямар нэг юм өгч байгаа дүр зураг үзэгдээд алга болов.

-Би энд гадны хүн. Тэгээд яаж байх ёстой юм бэ?

-Үүнд чинь л хамаг учир байгаа юм.

-Би итгэхгүй байна. Би ямар нэг юм эрж хайгаад л. Гэхдээ өршөөгөөрэй эх минь, ямар ч гэсэн энд миний байх ёстой газар биш гэдгийг би маш сайн мэдэж байна.

Тереза эх түүнийг бодлогоширон хараад,

-Ойлгомжтой, тэгээд чи хаачих юм бэ? гэж асуув.

-Мэдэхгүй байнаа.

-Надад бодох хугацаа өгөөч, үр минь. Удахгүй бид дахиад энэ тухай ярилцах болноо.

-баярлалаа, танд.

Кэтийг гарсаны дараа тереза эх тулгарсан хүнд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар удаан бодож суув. тэгсэнээ цаас үзэг авч бичиж эхлэв.

"Хүндэт эрхэм ээ. Танд мэдэгдэхээс өөр аргагүй явдал гарлаа. Бидний нөхөр сүмийг орхин явах хүслтэй байгаагаа надад хэллэ. Яавал зохихыг хэлж өгнө үү" гэж бичлээ.

Демирис зөөлөн хүнхэр сандалд суун зурвасыг уншаад гарч болох төвөгтэй байдлыг эргэцүүлэн бодож эхлэв. "За Кэтрин Александр ухаан орж эхэлжээ. Тэр тусмаа л өөрт нь муу даа. Түүнээс аль болох цэвэрхэн шиг л салах хэрэгтэй. Юуны өмнө сүмээс гаргаж авчрах хэрэгтэй" гэж Тереза эхтэй уулзах өдрөө шийдэн тогтлоо.

Дараачийн өдрийн өглөө Демирис жолоочоо Янина орохыг тушаагаад Кэтрин Александрыг анх олж харахад хичнээн сайхан харагдсаныг бодлоо. Берк руу яж байхдаа хичнээн хөгжилтэй байсан, ухаалаг, алиа хошин үргэлжийн сайхан зантай тэр хүүхэнд юм болгон байсан. Даанч Бурхан түүнийг залхаасан даа. Миний нэг нисгэгчийн гэргий байсан түүний амьдрал ад болон хувирч хэдхэн хоногийн дотор хүүхэн арван жилээр хөгширч балиар бүдүүн хөгшин авгай болсон. Демирис "Яасан харамсалтай вэ" гэж бодов.

Тереза эхийн яриаг сонсон суухад,

-Бид танд төвөг удсандаа маш харамсаж байна. Гэхдээ түүнийг хаашаа явуулж болохыг би огт мэдэхгүй байсан болохоор захидал бичсэн юм л даа.

-Та бүгдийг зөв хийжээ. Өөрийнхөө тухай ямар нэг юм санасан уу? гэж асуухад Тереза эх толгой сэгсрэн,

-Санаагүй, золгүй амьтан...гээд цонх руу очиж цэцэрлэгт ажиллаж байгаа хэдэн гэлэнмааг харж байснаа,

-Тэр байна гэлээ.

Демирис Тереза эх рүү дөхөж очоод цааш харан ажил хийж буй гурван гэлэнмааг цонхоор харав. Хэсэг хугацааны дараагаар тэдний нэг нь эргэн харахад Демирисын амьсгаа давхцаад ирэв. Өнөөдөр сайхан харагдаж байх чинь. Нөгөө балиар бөдөөн архичин авгай мөн гэж үү?

-Тэр дунд зогсож байгаа нь гэж Тереза эхийг хэлэхэд,

-Би харж байна. Юу хийхээ би бодъё, тэгээд танд мэдэгдэнээ гэж түүнд Демирис хэллээ.

Константин Демирис ямар нэгэн шийд хурдхан гаргах хэрэгтэй байлаа. Кэтийг харсан тэр мөчид тэрээр үнэхээр цочирдон балмагдаж, асар их өөрчлөгдсөнийг нь мэдэв. "Одоо түүнийг хэн ч танихгүй ээ" гэж бодно. Тэгээд толгойд нь ороод ирсэн маш хялбархан санаанд баясан тэр арай л чангаар инээд алдсангүй.

Тэр оройдоо л Демирис Тереза эхэд зурвас бичиж явуулсан нь Кэтэд их итгэл төрүүлсэн явдал болжээ. "Ашгүй миний санаа биелэх нь" гэж хөөрхий Кэт бодлоо.

Оройн хоолны дараа Тереза эх өрөөнд нь орж ирээд,

-Үр минь, чамд хэлэх шинэ сонин мэдээ байна гэж хэлжээ.

-Тийм үү?

Тереза эх үг болгоноо тодосгон,

-Сайхан мэдээ. Би нэг найздаа чиний тухай бичсэн юм. Тэр хүн тусална гэсэн гэв.

Кэтийн зүр цохилж эхлэн,

-Надад туслах аа?...Яаж тэр вэ?

-Тэр хүн өөрөө энэ тухай чамд хэлнэ. Тэр маш эелдэг буянтай хүн. Тэр хүн чамайг эндээс гаргаж авна.

Үүнийг сонсмогц Кэтийн дотор хүйт оргиод ирлээ. Тэр одоо юу ч санаагүй хэвээр шинэ хүмүүс дунд орох нь.

"Тэр ачтан нь хэн юм бол доо?"

Сүүлчийн хоёр шөнө Кэт унтаж чадсангүй. Сүмээс холдож огт танихгүй хүмүүс дунд орно гэхээс айдас төрөөд байлаа. Тэр өөрийгөө ымаар ч өмөг түшиггүй хаягдаж орхигдсон амьтан гэж бодно. " За яах вэ, би өөрийн хэн болохыг мэдэхгүй байсан нь ч дээр юм уу?! Бурхан минь, намайг авраач гэж гуйя" хэмээн мөргөн залбирлаа.

Өглөөний долоон цагт сүмийн гадаа гоёмсог лимузин ирж зогсов. Шөнөжингөө Кэт түүнийг чухам ямар хувь тавилан хүлээж байгаа бол гэж бодсоор нойргүй хоножээ.

Тереза эх түүнийг явган хаалга хүртэл хүргэж өгөөд,

-Бид чиний төлөө Бурханд залбирнаа. Хэрэв хүсвэл эргээд ирээрэй. Чамайг энд хүлээсэн хэвээр байна гэдгийг санаж яв гэжээ.

-Баярлалаа, эх минь. Би санаж явъя.

Гэхдээ тэр энд дахиж хэзээ ч ирэхгүй гэдгээ сэтгэлийнхээ гүнд мэдэж байлаа.

Янинаас Афин хүртэл урт зам туулахад Кэтийн сэтгэлд янз бүрийн муу муухай бодол төрсөөр байлаа. Хэдийгээр сүмийн амьдрал ард нь хоцорсон нь сайхан санагдавч аймаар нь, тулж ирсэн шинэ ертөнц яагаад ч юм бэ нэг л аймаар санагдана. Тэр өмнөх амьдралаа мэдэхгүй, байнга зүүдэнд нь үзэгддэг тэр өөрийг нь живүүлэх гэсэн хүний ч хэн болохыг мэдэхгүй шүү дээ.

Хагас өдөр явгал замд нь тосгон дайралдаж, тэр оройдоо Афинд ирлээ. Удалгүй шуугиант хотын төв рүү ороход Кэтэд сонин сүртэй харагдавч бас хүү нэг л танил дотно санагдахад урьд энд ирж байсан байх даа хэмээн бодов. Машин цааш баруун зүг чиглэн 15 минут орчим яваад нэгэн гүвээ дээрээс уруудан том баримал хөшөөний дэргэдүүр өнгөрч асар том төмөр хаалгатай майлсны модон гудамжаар орон хаалгачын жижиг чулуун шовгорын урдуур гараад тэнгисийн эрэгт байрласан гоёмсог чамин хийцтэй цагаан лаврингийн өмнө очиж зогсов.

Жолоочыг хаалга дэлгэж өгөхөд Кэт машинаас гарвал харшийн үүдэнд нэг үл таних эрэгтэй хүн түүнийг хүлээх янзтай зогсох үзэгдлээ.

-Калимера.

Кэтийн уруул өөрийн мэдэлгүй хөдөлж энэхүү грек мэндчилгээний үгийг дадмаг гэгч давтан хэллээ.

-Та...та намайг авчирсан хүн мөн үү?

-Үгүй, ноён Демирис таныг номын санд хүлээж байгаа..

Демирис гэнээ?! Тэр хэзээ нэгэн цагт энэ нэрийг сонсож байсан гэж үү? Үгүй. Тэр хүн танихгүй эмэгтэйд яах гэж тусладаг билээ? Кэт ийн бодох зуур тэр хүний араас даган өргөн дугуйрсан гудмаар явбал ханаар нь дүүрэн вааран эдлэл тавьж чимсэн байх ба шал нь гантиг

бололтой, цааш яваад хүнхэр таазтай уужим саруул зочдын өрөөнд ороход тохилог зөөлөн буйдан, сандлууд энд тэндгүй тавилсан байх агаад нэг хана нь бүхэлдээ алдарт зураач Гойны гялалзсан сайхан зургуудаар дүүрсэн байлаа.

Номын сангийн үүдэнд ирээд нөгөө эрэгтэй хүн тэндээ үлдэж,

-Таныг ноён Демирис хүлээж байгаа гэлээ.

Зассан модоор хийсэн дардас хээ угалз бүхий арьсан хавтастай ном битүү өржээ.

Том бичгийн ширээний ард суух эрэгтэй Кэтийг хараад өндийв. Түүнийг анхааралтай харан өөрийг нь таньж байгаа эсэхиг шинжвэл мэдэгдэх юм алга.

-Тавтай морилно уу. Намайг Константин Демирис гэдэг, таныг хэн гэдэг вэ? гэж их л энгийнээр асуулаа.

-Та өөрийнхөө нэрийг санаж байна уу?

-Кэтрин Алесандр гэдэг.

Тэр огт сандарч тэвдсэнгүй.

-Тавтай морилно уу, Кэтрин александр. Та суугаач.

Тэгээд өөдөөс нь харуулан тавьсан байсан хар арьсан буйдан дээр суухад бүсгүй ойрхоноос бүр ч үзэсгэлэнтэй харагдаж байлаа. "Гайхамшигтай хүүхэн юм гээч. Ийм сайхан хүүхнийг ална гэдэг ердөө л бузар жигшүүртэй явдал. Ядаж аз жаргалаас болж үхлээ гэвэл ч..." гэж Демирис бодлоо.

-Та...та надтай уулзахыг зөвшөөрдөг үнэхээр сайхан сэтгэлтэйи хүн юмаа. Би гайхаж байна...та ямар учраас надад...би ойлгохгүй байна...гэж Кэт ээрэв.

Демирис найрсагаар инээмсэглэн байж,

-Үүнээс хялбар юм гэж байхгүй. Би Тереза эхэд дандаа тус болохы хичээдэг юм. Сүм нь их ядуу, иймээс би чадах ядахаараа л тусладаг юм л даа. Түүнийг захиа бичихэд нь би баярлуулья гэсэндээ тус болохоор амласан юм.

-Таны зүгээс маш...гээд тэр цааш юу хэлэхээ мэдэхээ болив. Тэгсэнээ үргэлжлүүлэн:

-Тереза эх лав танд хэлсэн байлгүй, би...намайг бараг юу ч санахгүй байгаа гэж?

-Тиймэрхүү юм ярих нь ярьсан гээд чимээгүй болсоноо:

-Гэхдээ одоо бол та бүгдийг санаж байгаа биздээ? гэж асуув.

-Би нэрээ л санаж байна. Хаана байсан хэн болохоо мэдэхгүй. Магадгүй Афинд намайг таних

хүн олдох л байх.

Энэ үг Демирист огт таалагдсангүй. Яг л үүнээс тэр ихэд болгоомжилж байжээ.

-Нээрээ тийм шүү гэж тэр болгоомжтойхон хэлээд:

-Энэ талаар өдөржин ярилцсан ч болох санж. Гэвч би өнөөдөр чухал уулзалттай. Танд өрөө бэлтгүүлсэн байгаа болохоор таныг тавтай сайхан байна гэдэгт найдаж байна гэв.

-Танд яаж талархахаа ч мэдэхгүй байна.

-Энэ яах вэ. Энд таныг халамжлах болно. Гэртээ байгаа юм шиг байгаарай.

-Баярлалаа, ноён...

-Найз нөхөд маань намайг Коста гэж дууддаг юм.

Кэтэд гайхамшигтай сайхан унтлагын өрөө бэлдсэн байлаа. Тэр өрөөнд торгон хөшиг бүхий өргөн ор, цагаан өнгийн зөөлөн сандал буйдан, эртний грек хийц загварын ширээ, бүрхүүлтэй чийдэн тавилсан байх агаад хананд нь зураг өлгөжээ. Цайвар ногоон өнгийн хүнд зузаан хөшиг нарны хурц гэрлээс өрөөг халхлах бөгөөд цонхны цаахна тэнгисийн долгио мяралзах нь гайхалтай.

-Ноён Демирис танд хувцас авчрахыг тушаасан. Та хувцасаа сонгоно уу.

Кэт одоо болтол гэлэнмаагийн хувцастай байгаагаа сая л анзаарлаа.

-Гялайлаа танд ,гээд зөөлөн орон дээр суухдаа зүүдэлж байна уу даа гэж бодно. Энэ танихгүй эрэгтэй хэн юм болоо? Яагаад түүнийг ийнхүү халамжилна вэ?

Цагийн дараа янз болгоны хувцас ачсан бүрхүүлтэй тэрэг ирлээ. Оёдолчин ч ирэв.

-Намайг хатагтай Димос гэдэг. За одоо юу хийвэл зохихыг харцгаая. Танд хувцасаа тайлахад эвгүй биш байгаа?

-Би...уучлаарай. Та юу гэв ээ?

-Та хувцасаа тайлж чадах уу? Танд ямар хувцас зохихыг наад нөмрөг дороос чинь тааварлахад бэрх байна.

Кэт гэнэт хэн нэгэн хүний дэргэд хувцасаа тайлалгүй хичнээн их удсанаа таах гэж оролдлоо.

Тэгээд дадмаг бус хөдөлгөөнөөр тайчиж дуусахад түүнийг тэчээртэй хүлээж зогссон Димос түүнийг толгойноос хөл хүртэл нүд гүйлгэн ажаад сэтгэл хангалуун болж,

-Та сайхан бие галбиртай хүн юм. Бид танд зохимжтой бүхий л хувцасыг сонгож чадна гэлээ.

Хоёр туслагч өрөөнд хайрцаг дүүрэн дотуур хувцас, цамц, банзал гутал оруулж ирэв.

-Таалагдсанаа сонго гэж хатагтай Димос түүнд хэлэв.

-Би...надад ахадсан хэрэг байна, надад нэг ч зоос байхгүй шүүдээ гэж Кэт сандран татгалзав.

Оёдолчин инээмсэглэн,

-Мөнгөний талаар санаа бүү зов. Ноён Демирис үүнд санаа тавьж байгаа гэв.

Гэвч яагаад гэсэн бодол төрнө.

Биед шүргэх зөөлөн даавуу түүнд хэзээ нэгэн цагт хэрэглэж дадсан хувцасыг санагдуулна. Энд байгаа торго, хөвөн даавуун твид панс цөм л гоё сайхан өнгөтэй ажээ.

Үйлчлэгч нар тун шиг шалмаг хөдөлсөний үрээр хоёр цагийн дараа гэхэд Кэт нилээн ганган хүүхэн болсон байлаа. Дараа нь тэр юу хийхээ бодож, мэдэхгүй хэсэг суув. "Би ч өмсөөд гарах хувцастай боллоо. Гэвч одоо хаашаа явах вэ?" гэж бодлоо. Хот руу явдаг ч юм билүү? Юу болж өнгөрсөнийг тайлж нээж түлхүүр Афин хотын хаа нэгтэйгээс олоно гэдэгт тэр эргэлзсэнгүй. "За үл таних бүсгүй минь, та өөрийнхөө хэн гэдгийг мэдэх гээд оролдоод нэг үз дээ" гэж өөртөө хэлээд босов. Түүнийг үүдний өрөөнд бууж очиход бойдаа дөхөж очоод,

-Би танд юугаар туслаж болох бол, хатагтай? хэмээн асуув.

-Би хот руу явмаар байна. Та надад такси захиалаад өгж чадахгүй биз?

-Ингэх шаардлагагүй хатагтай. Тани мэдэлд өгсөн машин бий. Би жолоочид нь хэлчихье.

-Баярлалаа гэж Кэт эргэлзэнгүй хэллээ.

-Гэвч машинаар нь хот орсон гэж ноён Демирис хилэгнэхгүй байгаа? Тэр яах бол?

-Та санаа зовох хэрэггүй.

Хэдэн минутын дараагаар тэр ганган "Даймлер"-ын арын суудалд тухалж аваад Афин руу довголгож явлаа.

Хотын нүргэлсэн их чимээ, үргэлжилсэн нуранги балгас хөшөөнүүдийг хараад Кэтийн толгой эргэлээ.

-Хатагтай энэ бол Акрополын оргил дээрх Нантес гэж жолооч гараа урагш сунгахад нь барилгыг олж харлаа.

-Афины хүндэтгэлд зориулсан цэцэн дарь эх биз гэх өөрийн дууг сонслоо. Жолооч тааламжтай инээмсэглэн,

-Та Грекийн домог сонирхдог юмуу даа, хатагтай? гэж асуусанд Кэтийн нүдэнд нулимс

гүйлгэнэн,

-Мэдэхгүй, би мэдэхгүй гэж шивгэнэв.

Дараа нь тэд эвдэрхий балгасны дэргэдүүр өнгөрсөнд жолооч,

-Энэ Геродатын театраас одоо зөвхөн хана төдий л үлдэж дээ. Цагтаа энд 5000 үзэгч багтдаг бсайн гэнэ лээ гэхэд нь Кэт:

-6257 хэмээн аяархан хэлэв.

Эвдэрхий нуранги балгастай зэрэгцэн орчин үеийн хийц загвартай барилга, зочид буудал баригдсан байх нь өнгөрсөн болоод одоо үеийн хачирхалтай холимог шиг санагдана. Машин хотын төв дэх маш гоё цэцэрлэгийн дэргэдүүр өнгөрөв. тэнд олон тооны усан оргилуурууд байхаас гадна эргэн тойрон ногоон шар шургаанууд хүрээлүүлэн бэхэлсэний доогуур цэнхэр өнгийн бүтээлгэтэй ширээнүүд тавьсан үзэгдэнэ. "Энэ бүхнийг би урьд үзсэн юм байна. Тэр үед би аз жаргалтай байсан" гэж Кэт бодлоо.

Бараг байшин болгонд цайны газар, булан тохой бүрт далайн хөвөн авахыг санал болгосон байхаас гадна хаа сайгүй дайралдах цэцгийн мухлагууд өнгө өнгөөр алаглан нүд эрээлжлүүлнэ.

Машин Синтагмын талбайд хүрэлцэн ирэв.

Байшингийн буланд байрладаг зочид буудлын хажуугаар өнгөрөх үед Кэт,

-Зогсоорой, таныг гуйя! гэж орилов.

Жолооч эргэлтийн наахна зогслоо. Кэт арайхийн амьсгалж байв. "Би энэ буудлыг таньж байна. Би энд амьдарч байсан" гэж бодоход амьсгал давхцана.

Кэт чичирсэн хоолойгоор,

-Би энд үлдмээр байна. Та хоёр цагийн дараа ирнэ үү? гэхэд жолооч,

-Тэгье, хатагтай гээд яаран хаалга онгойлгож өгөв.

Зуны халуун агаар нүүр халаах хэдий ч өвдөг нь чичирсээр байгааг тэр мэдэрлээ.

-Таны бие зүгээр үү? хатагтай?

Тэр юу хариулахаа ч мэдсэнгүй. Түүнд үл ойлгогдом зүйлийн ирмэгт тулаад байгаа нь юу юугүй доошоо унах гэж байгаа мэт аймаар сэтгэгдэл төрнө. Хүмүүс орилолдон шуугисан гудамжаар гайхшралд автан алхахад чимээ аниргүй амгалан сүмийн дотор байгаад ирсэн түүний хвүд нэг л итгэх аргагүй санагдаад бажээ. Кэт гэнэтхэн эртний Афины төв болох уйтан гудамж, хэлтэрч эвдэрсэн шат бүхий байшин гудамжтай хуучирсан барилгатай Плак руу чиглэн явж байгаагаа мэдэрлээ. Тэрээр зөн совиндоо хөтлөгдөн одоо хотод ихэд дэлгэрээд

байгаа архины мухлагийн дэргэд хүрч гэнэтхэн зогтусав.

"Би энэ сандал дээр сууж байсан, надад грек хоолны цэс өгч байсан. Бид тэгэхэд гурвуулаа байсан..."

-Чи юу идэх вэ?

-Татгалзахгүй бол миний өмнөөс захиалга өг л дөө. Тэгэхгүй бол би эзнийг нь захиалчихаж магад гээд тэд инээлдэцгээв.

Түүнтэй цуг байсан хүмүүс хэн юм бол?

Мухлагийн эзэн Кэтринд дөхөн ирж,

-Bovo na sas Ucithiso? (Танд би юугаар тус болж болох бол?)

-Ochi efhaviisto (Зүгээр баярлалаа...)

"Би энэ үгийг хаанаас сурч авсан юм бол? Би грек хүүхэн юм гэж үү?"

Кэт эндээс ааш яаран хөдлөв. Түүнийг хэн нэгэн хүн л удирдаад байх шиг тэрээр хааш явахаа сайн мэдэж байв. Эргэн тойрон цөм түүнд хуучны танил болсон зүйлс байлаа. "Бурхан минь, би солиорч байгаа юм биш байгаа? Би хий юм үздэг болоо юу даа?" хэмээн тэр бодно. Хөшгөн дээр "Тре флинкас" гэсэн бичигтэй цайны газрын хажуугаар өнгөрлөө. Аль нэг мухар гудам болгонд түүний ой ухааны гүнд хадгалагдсан ямар нэгэн дурсамж хөврөн гарч ирэх нь магадгүй, энд урьд нэг цуххал явдал болж байсан байлгүй гэмээр. Харин чухам юу болсоныг л яагаад ч юм санаж өгсөнгүй.

Тэгээд шуугиант нарийн гудамжаар уруудан цаашилсаар Боукоурестиоу тийш эргэв. Энд олон дэлгүүрүүд дайралдсанд "Би эндээс юм худалдан авдаг байжээ" гэж бодон цааш алхаж явтал булангийн цаанаас гарч ирсэн цэнхэр өнгийн "седан" золтой л мөргөчихсөнгүй. Тэрхэн зуур ой ухаанд нь "Грекүүд машин хэрэглэж сурах бас л болоогүй байна. Тэдний сэтгэл санаа нөгөөл илжигнээсээ салж чадаагүй байгаа. Грекүүдийг ойлгоё гэвэл аялагчидад зориулсан зааврыг биш харин тэдний эртний домог түүхийг унших хэрэгтэй. Бидний хооронд гүн гүнзгий тачаалаа дарах асар том ялгаа байна. Бид бол гүнзгий баярлаж, айхтар гуниглаж ч чаддаг улс. Бид энэ соёлжиж боловсорсон аргыг нууж хаахааргүй гэгээрсэн хүмүүс шүү..."

Энэ юун тухай яриа юм бол? Хэн эдгээр үгийг хэлсэн байж таарах вэ?

Хүүхний өмнөөс хурдан алхаагаар ирж явсан бараан үстэй өндөр эрэгтэй гэнэт түүнийг хармагцаа алхаагаа удаашруулан таньж байгаа нь илт харагдана. Гэвч Кэтрин түүнийг хэзээ ч хараагүй гэдэгтээ итгэлтэй байлаа. Тэгэх тусам нөгөө хүн,

-Сайн уу гэж асуух нь уулзсандаа баяртай байх шиг.

-Сайн гээд Кэт:

-Та намайг таньдаг юм уу? гэхэд залуу инээгээд,

-Тиймээ, би таныг танилгүй яах вэ гэлээ.

Кэтийн зүрх цохилоод ирэв. Одоо л тэр өөрийн өнгөрсөн амьдралаа үнэн зөвөөр нь олж мэдэх нь. Гэвч харин яаж энэ олон хүмүүс дунд бас танихгүй байгаа хүнээсээ өөрийнхөө тухай асуух вэ дээ?

-Тантай ярилцаж болох уу?

-Бололгүй яахав.

Кэтрин улам айн сандарч эхэллээ. Одоо түүний хэн болохыг тайлбарлана гэхээс л аймаар байв.

Эрэгтэй түүнийг дагуулан цайны газарт орж,

-Тантай уулзсандаа баяртай байна гэхэд Кэт хоолой чичрүүлэн,

-Би ч мөн адил гэж шивэгнэв.

Үйлчлэгч хүрч ирээд,

-Юу уух вэ? гэж асуухад Кэт толгой сэгсрэв.

Тэгээд шуудхан л асууж шалгаагаад эхэлмээр айвч юунаас эхлэхээ мэдэхгүй байлаа.

-та сайхан харагдаж байна шүү. Энэ бол хувь заяа тийм үү? гэхэд,

-Тийм ээ гэж хүүхэн чичрэхээ арайхийн барьж өгүүлэв. Тэгсэнээ гэнэт шийдэн,

-Та бид хаана уулзаж байлаа? гэхэд залуу инээснээ,

-Энэ ямар хамаатай юм бэ Парист байна уу, Ромд байна уу, морин уралдаан дээр, эсвэл үдэшлэг дээр уулзсан байлаа гээд ямар ялгаа байна? гэж хэлэн гарыг нь атгаад,

-Тан шиг гуа үзэсгэлэнг энд ирээд лав үзсэнгүй. Чи хэдийг авдаг вэ? гэх нь тэр.

Кэт юу ч ойлгосонгүй түүний өмнөөс гөлийн хэсэгхэн зуур сууснаа дараа нь гэнэт үсрэн босож хаалга руу ухасхийлээ.

-Хүүе чи яав аа? Би чамд хэд ч байсан төлнө.

Гэвч Кэтрин аль хэдийнэ гудамжинд гарсан байлаа. Булан тойрсон хойноо л алхаагаа удаашруулж доромжлуулсандаа уйлж эхэллээ. Түүний урд талд "Мадам Пирис-төлөгч" гэсэн хаягтай дунд гарын ресторан байхыг хажуугаар нь өнгөрч явсанаа "Би хатагтай Пирисыг танина. Түүнтэй урьд нь уулзаж байсан" хэмээн бодов. Энэ харанхуй хаалганы цаана түүний

амьдралын нууцыг тайлах түлхүүр би гэж бодохоос дахиад л зүрх нь хүчтэй булиглаад ирэв. Тэр хаалга татан явж ороод харанхуйд нүдээ дасгах гэж хэдэн минут хөдөлгөөнгүй зогсов. Буланд арваад ширээ сандалтай баар байхыг тэр дараа нь олж харжээ.

Үйлчлэгч түүнд дөхөн ирээд,

-Kalimehra.

-Kalimehra. Pou inen madam Piris? (Би мадам Пиристэй уулзаж болох уу?)

-Мадам Пирис ээ?

Үйлчлэгч буланд байх сул ширээ зааж өгөв. Кэтрин бүгдийг тодхон санаж байв. Ширээнд хар хувцас өмссөн барзгар нүүртэй хөгшин авгай дөхөж ирэн,

-Юугаар тусалж болохсон бол? гэснээ авгай түүний царайг харан таг болов. Тэгсэнээ:

-Би чамайг мэдэх юм байна. Гэхдээ чиний царай...гээд гайхсандаа түүний эрүү унжаад ирлээ.

-Чи эргээд ирээ юу?

-Та намайг хэн болохыг мэдэх үү? гэж Кэт найдвар төрөн асуухад авгай түүнийг дүрлийтэл ширтэж байснаа айсандаа:

-Үгүй! Чи үхсэн! Зайл! гэж орилов.

Кэт аяархан дуу алдан айсандаа үс нь босохыг мэдэрч,

-Уучлаарай, би зөвхөн...гэтэл,

-Яв, ахатагтай Дуглас гэлээ.

-Би зөвхөн...мэдэх гэсэн юм...

Авгай гялсхийн эргэж хурдхан арилаад өгөв. Кэтрин хором хэртэй дагжин сууснаа гэнэт босож гудамжинд гарав. Толгой дотор нь : "Хатагтай Дуглас" гэсэн үг сонсогдсоор байлаа.

Гэнэт манан будан арилах лугаа адил түүний сэтгэлд тод сайхан дурсамж тодорч "Би хатагтай Ларри Дуглас" гэж бодон нөхрийнхөө сайхан царайг олж харав. Тэр түүндээ ухаангүй хайртай боловч ямар нэгэн муухай зүйл болжээ дээ? Юу болсон байж болох вэ?

Дараа нь тэрээр амиа хорлох гэж оролдоод эмнэлэгт хэвтэж байснаа санах. Тэгээд гудамжинд сөхөрч ойчихоос айн алхах чадалгүй болон зогсоход ой ухаанд нь нэгэн дүр зураг нөгөөгөөр солигдсоор байх ажээ.

Тэр Ларрид хаягдсанаасаа болоод архи зөндөөүүсэн. Гэвч дараа нь ЛАрри эргээд ирсэн. Түүний өрөөнд орж ирээд Ларри: "Би муухай зан гаргансаа мэдэж байна. Кэtti, би засрана

гэдэгтээ итгэлтэй байна. Чи надад итгээрэй. Би чамд хайртай" гэж хэлсэн.Бас: "Би хэнд ч ингэж дурлаж байгаагүй, Надад боломж олго л доо. Хоюулаа дахиад бал сараа тэмдэглэе. Би гайхалтай сайхан газар мэднэ. Янина гэдэг газар даа" гэж ч хэлсэн юм. Ингээд л аймшигт явдал эхэлсэн. Түүнд үзэгдсэн юмнууд үнэхээр айдас төрүүлэм. Тэд Ларритай хамтдаа уулын орой дээр нэг нэгээ бараг олж харахгүй шахам манан будан дунд явж байтал Ларри ойртон ирж түлхэн унагахыг оролдоно. Жуулчид дайралдсан нь түүний аминд орж байх шиг...

Дараа нь битүү хадан дунд...

"Үйлчлэгч надад нэг хад зааж өгсөн. Хуримласан хосууд бүгд л тийшээ явж сонирхоцгоодог гэж тэр хэлсэн", тэгээд тэд хамтдаа хад руу очиход Ларри түүнийг бүр гүн аваачаад орхин одно.

Кэт алгаараа чихээ таглан энэ аймшигтай явдлыг санахгүйг хичээв.

Түүнийг аварч зочид буудалд авчрах ба тайвшруулах эм өгсөн. Гэтэл шөнө дундын үед сэртэл Ларри нууц амрагтайгаа гал тогооны өрөөнд түүнийг хэрхэн устгааа ярилцан төлөвлөгөө зойхож байж санамсаргүй чих дэлсэж билээ. Тэдний яриа салхины исгэрээнд аажуухан замхарсаар...

-Хэн ч хэзээ ч...

-Би бүгдийг хийнэ гэж хэлж байна шүү...

-Бүтэхгүй ээ. Тэд яаж ч чадахгүй.

-...одоо л, түүнийг унтаж байхад нь...

Дараа нь далайн шуурга араас элдэж хүчтэй салхи завийг давалгаат нууран дунд тууж ирсэнийг саналаа.Завь холбилзон дайвалзаж эхлэх үед л тэр ухаанаа алдсан юм.

Хөдлөх тэнхэлгүй болсон Кэтрин дайралдсан бандан сандал дээр л унаад өглөө. Түүний зүүд үнэн байжээ. Түүний нөхөр нууц амрагтай байсан, тэд хамтарч түүнийг алах төлөвлөгөө зохион оролдлого хийсэн нь үнэн ажээ. Тэр бас түүнийг аварч сүмд аваачиж өгсөн үл таних хүнийг санав. Тэр хүн түүнд далавчаа дэлгэсэн шувууг гайхалтай урласан алтадмал урлал бэлэглэхдээ: "Одоо хэн ч таныг түйвээхгүй байх болно. Таны дайснууд цөм үхсэн" гэж хэлж байсныг санав. Тэр хүний царай ч бүүр түүрхэн санагдана.

Кэтрины толгой хүчтэй өвдөж эхэлжээ.

Тэрээр босож жолоочоо хүлээх ёстой гудамжийг чиглэн алхав. Жолооч машинаараа түүнийг Константин Демирис дээр аваачих болно. Тэнд л зөвхөн аюулгүй.

Дөрөвдүгээр хэсэг

-Чи юунд түүнийг гэрээсээ гарахад нь туслав? гэж Демирисийг асуухад,

-Өршөө эрхэм ээ, түүнийг гаргаж явуулж болохгүй гэж та тушаагаагүй болохоор мэдсэнгүй... гэж бойдаа сандчин хариуллаа.

Демирис биеэ барин тайвширч,

-За энэ ч яахав, тэр удахгүй буцаж ирэх байгаа гэлээ.

-Өөр юм хэрэгтэй юу, эрхэм ээ?

-Үгүй гэхэд бойдаа гарч явав.

Демирис цонх руу ойртон очиж гоёмсог цэцэрлэг рүүгээ ширтэнгээ: Кэтрин Александрыг Афины гудамжаар явуулах осолтой. Таньж мэдэх хүн тааралдахыг үгүй гэх газаргүй. Түүнийг амьд үлдээж болохгүй нь юутай харамсалтай вэ! Гэхдээ эхлээд өшөөгөө авах хэрэгтэй. Өшөөгөө автал тэр амьд байх ёстой. Тиймээс түүнийг таньж мэдэхгүй газар руу явуулах хэрэгтэй. Лондонд л хамгийн аюулгүй. Тэнд түүнийг дагаж мөрдөж байхад ч хялбар. Тэгэхээр өөрийнхөө аль нэг конторт ажилд оруулчихая гэж бодов.

-Цагийн дараа Кэтрин эргэж ирлээ. Демирис түүнийг хараад хамаг юмаа эргэн санасан болохыг мэдэв. Хүүхэн цагаан өнгийн цамцан дээр мөн адил өнгийн торгон хүрэм өмссөн нь гайхалтай зохисон байхыг хараад: "Дур татам юм" гэж бодов. Харанхуй хөшиг сөхөгдөж хүүхэн нэг л амьдын шинж орсон мэт санагдана.

-Ноён Демирис...

-Таны хувьд бол зүгээр л Коста.

-Би одоо өөрийгөө хэн болохыг мэдэх боллоо. Юу болсоныг ч мэдсэн.

Гадаад байдалдаа огтхон ч сандарч байгаагаа мэдэгдсэнгүй, царайгаа ч хувиргасангүй зүгээр үнэнгээсээ мэт,

-За ашгүй дээ. Нээрээ гэж үү? Суу л даа хонгор минь. Надад тэгээд бүгдийг ярьж өгнө үү гэлээ.

Кэтрин нэг газраа тогтож суух аргагүй догдолсон байжээ. Тэрээр хивсэн дээгүүр нааш цааш холхин будлин сандран ярьж эхэллээ.

-Миний нөхөр нууц амрагтайгаа нийлж намайг алахаар оролдсон гээд тэр мэгдэн чимээгүй болчихов. Тэгснээ:

-Магадгүй энэ танд нилээд зэрлэг сонсогдож байж болох юм. Би сайн мэдэхгүй байна л даа. Андуурч байж ч мэдэх юм.

-Үргэлжлүүл дээ хонгор минь гэж Демирис хариуд нь зөөлнөөр хэлэв.

-Намайг гэлэнмаа нар аварсан. Нөхөр маань танайд ажилдаг байсан уу? гэхэд Демирис түр эргэлзсэнээ,

-Тиймээ, тэр манай нисгэгч нарын нэг байсан. Иймээс би таны өмнө хариуцлага хүлээх ёстой гэж бодож байна. Ийм л байна даа.

Кэтрин түүнд тулж очоод нүүр өөд нь харж,

-Тэгвэл та намайг таньж байсан юм шивдээ? Өглөө та түүнийгээ яагаад хэлээгүй юм бэ? гэсэнд,

-Би таныг эвгүй байдалд оруулахыг хүсээгүй юм. Та өөрөө л бүгдийг олж мэдэх нь дээр юм шиг санагдаад...

-Тэгвэл та миний нөхөр болон нөгөө эмэгтэйд юу тохиолдсоныг надад одоо хэлнэ биздээ? Тэд одоо хаана байна?

Демирис түүний нүдийг ширтэн,

-Тэднийг цаазалсан гэлээ. Хүүхний нүүр улайгаад ирсэнээ сандалд лагхийн унан тусаж сулхан дуу алдан,

-Би...үгүй гэхэд,

-Тэднийг шүүхийн шийдвэрээр цаазалсан гэлээ.

-Гэхдээ яагаад?

"Болгоомжтой бай. Аюултай болж ирлээ шүү" хэмээн Демирис бодсоноо,

-Тэд таныг алахыг завдсан шүү дээ гэвэл Кэт хөмсөгөө зангидан,

-Ойлгохгүй байна. Тэднийг цаазлах ямар хэрэг байна? Би амьд л байна шүү дээ,

-Грекийн хууль их хатуу шүү, Кэтрин. Тэднийг олон нийтийн шүүхээр шийтгэсэн. Гэрчүүд цөм таны нөхөр болон Ноэлль Пэйж таныг алахыг оролдсон гэж гэрчилсэн юм. Тэгээд л шүүх тэдэнд алах ял заасан даа.

-Итгэхэд бэрх байна.

-Гэвч шүүх...

Константин Демирис түүн рүү ойртон очиж мөрөн дээр нь гараа тавиад,

-Та өнгөрсөн бүхнийг мартаж хэрэгтэй. Тэд танд муу юм хийхийг хүсэж байсныхаа хариуг

амссан гэснээ ярианы сэдвийг өөрчлөн:

-Одоо хоюулаа таны ирээдүйн талаар ярилцая. Танд ямар нэг төлөвлөгөө байна уу? гэж асуув.

Гэвч Кэт юу ч сонссонгүй. "Ларри" хэмээн бодож,

"Түүний инээмсэглэсэн сайхан царай, түүний гар, дуу хоолой..." гэж бодно.

-Кэтрин...

Хүүхэн түүн рүү харж,

-Өршөөгөөрэй, та юу гэв ээ?

-Та ирээдүйнхээ тухай бодож байсан уу?

-Үгүй, би... Яахыгаа мэдэхгүй байна. Афинд үлдэж болох юм.

-Үгүй, та энд үлдэж болохгүй. Афинд танд олон таагүй дурдатгал санагдуулж магад. Та - Грекээс явсан нь дээр гэж бодож байна гэж Демирис хэлэв.

-Гэхдээ би чаачих юм бэ?

-Би энэ талаар бодсон. Лондонд миний хэдэн контор бий. Та Вашингтонд байхдаа Уильям Фрезерийнд ажиллаж байснаа санаж байна уу?

-Зульяам...гээд хэсэг бодсоноо бараг тэр дороо түүнийг саналаа.

-Та түүний туслагч нь болж ажиллаж байсан биз дээ?

-Тиймээ

-Та Лондонд энэ ажлаа миний төлөө хийж чадах уу?

-Мэдэхгүй ээ, би хэлж мэдэхгүй байна.

-Би ойлгож байна. Тэнд бүх зүйл өөрчлөгдөнө гэж бодож байна. Танд бодох хугацаа хэрэгтэй. Энэ тухай бид маргааш ярилцаж болох юм.

Кэтрин өрөөндөө оройн хоолоо идэх нь Демирисийн хувьд их чухал байлаа. Яагаад гэвэл эхнэрийг нь хараасай гэж тэр хүсэхгүй байв.

-Та үнэхээр эелдэг хүн юм. Тэгээд бас энэ хувцас...тун өгөөмөр зан гаргасан гэхэд Демирис түүний гар руу зөөлөн алгадаад,

-Таларах хэрэггүй дээ гэлээ.

Кэт унтлагынхаа өрөөнд ороод эргэн тойрноо тод улаан гэрэлтүүлэх наран Эгейэн тэнгисийн

усанд шингэн орохыг ажиглан харав. Өнгөрсөн амьдралаа бодож шаналах нь утгагүй хэрэг. Ирээдүйгээ бодох хэрэгтэй. Константин Демирисийн төлөө бурханд залбирая. Тэр бол түүний аврагч мөн. Бас Лондонд ажил олж өгж байна гэж бодож суутал хаалга цохиж бодлыг нь тасалдуулан,

-Таны оройн зоогийг авчирлаа, хатагтай.

Кэтринийг гарсаны дараагаар Демирис номын сандаа удаан сууж саяын яриагаа сайтар эргэцүүлэн бодов. Амьдралдаа Демирис цорын ганц удаа л өөрийгөө хянах чадвараа алдаж билээ. Ноэль урлаг хөгжим, тэр ч атугай бизнесийн талаар ч гүн гүнзгий мэдлэгтэй бөгөөд юм болгоныг нь гайхан шагшиж хүлээж авдагсан. Демирисийн хувьд Ноэль бол урьд хожид үзэгдээгүй гуа үзэсгэлэнтэйн дээр дүрэлзсэн гал мэт тачаангуй хүүхэн байв. Түүний төлөө тэр хүүхэн аугаа жүжигчиний нэр алдраасаа татгалзаж байж билээ. Нууц амраг төдий биш хамгийн сайн найз, бүх юмаа итгэн хэлдэг үнэнч итгэлт хүн нь байжээ. Тэр хүүхэн л түүний урьд огт мэдээгүй сэрлийг нь сэдээж өгсөн дөө. Ингэж бүрэн итгэж байхад тэр хүүхэн өөдгүй муу эр Ларри Дугласаар түүнийг сольсон. Үүнийхээ хариуг тэр амь амьдралаараа төлсөн, Константин Демирис түүнийг Эгейэн дэх өөрийн арлуудын нэг болох Псаре дээр оршуулахыг засаг захиргааныхантай ярьж тохирсон билээ. Бүгд л тэгэхэд түүний гайхамшигтай хүнлэг сэтгэлийг шагшин гайхацгаасан. Үнэн хэрэгтээ бол Демирис түүний шарилыг хүртэл доромжилохыг л санаархсан юм. Унтлагын өрөөндөө өлгөсөн Ноэлийн зургийг харж тэр жоготой инээмсэглэдэг байлаа.

Тэр явдалаас хойш жил гаран хугацаа өнгөрсөн ч гэсэн Демирис түүнийг мартаж чадсангүй. Түүний энэ шарх хэзээ ч эдгэхгүй нь лавтай биз ээ.

"Яагаад тэр вэ? Ноэль, яагаад? Би чамд байгаа бүхнээ өгсөн. Би чамд дурлаж байсан, муу өлөгчин эм. Би чамд хайртай байсан шүү дээ"

Ларри Дуглас ч амь амьдралаараа төлсөн. Гэхдээ л Демирис энэ юу ч биш байв. Одоо тэр огт өөр гайхалтай зүйл бодож олсон. Тэр муу Дуглас түүний Ноэльтөй яасан шиг эхнэртэй нь ийнхүү зугаацна даа. Харин дараа нь Кэтрин нөхрийнхөө араас очих болно.

-Коста...

Эхнэрийнх нь дуу гарч Мелина номын санд орж ирлээ.

Константин Демирис эртний сурвалжит язгууртаны охин үзэсгэлэнт Мелина Ламброутай гэрлэжээ. Мелина бол хатан хаан шиг төрхтэй өндөрдүү хүүхэн билээ.

-Коста, саяны надтай танхимд дайралдсан юун хүүхэн бэ?

Демирис цочиж,

-Хэн? Аа, энэ чинь миний ажил хэргий холбоотон. Лондон дахь миний конторт ажиллах юм гэж хариулав.

-Би түүнийг зэрвэсхэн төдий харсан ч гэсэн надад нэг хүнийг санагдуулах шиг болсон шүү.

-Тийм гэж үү?

-Тиймээ гээд Мелина гайхширан чимээгүй болсоноо,

-Тэр манайд ажилладаг байсан нисгэгчийн эхнэрийг санагдуулчихлаа. Гэхдээ байж боломгүй юм. Тэд түүнийг алчхсан биз дээ гэхэд,

-Тиймээ, алсан гэж демирис дэмий л амыг нь дагав.

тэгээд Мелинаг гарч явтал хараа салгасангүй. Болгоомжтой байх хэрэгтэй. Мелина тэнэг хүүхэн биш. Тэр түүнтэй гэрлэх хэрэггүй л байж. Том алдаа хийснээ тэр одоо л ойлгов.

Арван жилийн өмнө болсон Мелина Ламброу, Константин Демирис хоёрын хурим Афинаас авахуулаад Ривьера, Ньюпорт хүртэл дээдсийн хүрээлэнгийнхнийг сүрхий доргиожээ. Гэхдээ хамгийн хачирхалтай нь хуримын бэр маань сарын өмнө л огт өөр хүнтэй сүй тавьсан байсанд оршино.

Мелина жаахан хүүхэд байхдаа л эрх дураараа зангаараа гэр бүлийнхнээ ихэд зовоодог байжээ. Арван настайдаа л тэр далайчин болохоор шийдэж тэднийд ажилладаг жолооч хөлөг онгоц дээр нууцаар нэвтрэх гэж байхад нь олж ичгүүртэйгээр гэрт нь хүргэж ирдэг байжээ. Арван хоёр настайдаа явуулын циркийхэн дагаж оргох оролдлого хийсэн байна. Харин арай гэж арван долоон насанд хүрмэгцээ л Мелина өөрийгөө үлгэрт гардаг шиг баян Михалис Ламброугийн үзэсгэлэнт охин гэдэгтэйгээ эвлэрчээ. Сонинд түүний талаар үргэлж сайн сайхан зүйл бичдэг байв. Тэр өөрөө тэр чигээрээ үлгэр домгийн биелэл, түүний найз нөхөд нь жинхэнэ жонон, гүнж нар. Тэгээд ёс суртахууны хувьд ч ариун гэгээн охин байжээ.

Түүнд ганцхан ах байдаг байлаа. Спирос ах нь түүнээс арван насаар ах ч тэд бие биенээ ихэд хайрладаг байв.

Мелинаг арван гуравхан настай байхад нь эцэг эх нь хөлөг онгоцны сүйрлээр амь эрсдэж, Спирос ах нь л түүнийг хүмүүсжүүлэх болжээ. Спирос түүнийг туйлын их халамжлан үзэж өчүүхэн төдийи зүйлийг ч анхаарлаасаа гадуур өнгөрөөдөггүй эрхэмлэн авч үзнэ. Өсч том болсон хойно нь охины гар хүрсэн юм болгоныг нарийвчлан шалгаж анхаарах болов. Тэдгээр юмс ахын санаанд огтхон ч үл нийцнэ.

-Чи болгоомжтой байх хэрэгтэй. Чи баян сүйт хүүхэн ангуучилдаг дурлалын ангуучны олз болов. Чи баян, гоо үзэсгэлэнтэй, нэр алдартай, залуу бүсгүй гэдгээ хэзээ ч битгий март гэж байнга сургана.

-Баяр хүргэе, ах минь. энэ бүхэн намайг сая хүрсэн чавганц болоод үхэх цагт минь тайтгаруулах байлгүй.

-Бүү санаа зов, Мелина минь.

-Сэтгэлд чинь нийцэх грек сурвалжит гэр бүлээс гаралтай эрхэм хүн тааралдаж л таарна.

Дөч гарсан ч Вассилис Манос гүн одтой яваа бизнесмен хүн. Тэрээр огтын гэнэтхэн Мелина хатагтайд дурлаж орхижээ. Ингээд хэдэн долоо хоногийн дараагаар хүүхний зөвшөөрлөөр анхны удаа болзжээ.

-Ёстой гайхалтай хосууд хэмээн бахдалд автан гийсэн царайтай ах Спирос нь хэлээд:

-Тэр хөл дээрээ бат зогссон хүн, тэгээд ч чамд ухаангүй дурлаж орхиж гэж аз жаргалтай үглэнэ.

Мелина түүнийг эсэргүүцэн,

-Үгүй, тэр маш уйтгартай хүн юмаа, Спирос минь. Надтай зөвхөн наймаа арилжаа л ярих юм. Надад тэр хөнгөн хийсвэр байвал таармаар санагдах юм.

-Гэрлэнэ гэдэг чиний яриад байгаагаас хамаагүй өөр зүйл. Чамд итгэлтэй, түшигтэй нөхөр хэрэгтэй гэж ах нь ятгана.

Эцэст нь Мелина гүнгийн саналыг хүлээн авчээ. Тэр үүнд нь баярласандаа учраа олохоо болив.

-Та намайг хорвоогийн хамгийн аз жаргалтай хүн болголоо. "Би Мелина интернейшнл" гэдэг нэртэй шинэ компани байгуулна гэжээ.

Тэр энэ балайрлынхаа оронд сарнай цэцгийн баглаа өгсөн бол Мелина арай илүү сонирхож байжээ. Ингээд хуримын өдрийг товлож мянга мянган урилга илгээж бэлтгэл ажил эхэлжээ.

Яг энэ үед л Мелинагийн амьдралд Константин Демирис орж ирсэн юм. Тэд залуусыг нэр алдар олоход тусладаг жирийн л нэг үдэшлэг дээр танилцжээ. Гэрийн эзэн тэднийг хороонд нь танилцуулахад Демирис хүүхнийг ихэд бишрэн харж,

-Та бидэнтэй хэр удаан цуг байх вэ? гэж асуужээ.

-Өршөөгөөрэй, та юу гэв ээ?

-Таныг жирийн үхэх тавилантай бидэнд тэнгэрээс илгээсэн гоо үзсэглэн гэж юу байдгийг таниулах зорилготой элч байх ёстой гэдгийг л хэлсэн юм.

-Та надад бүү бялдуучил, ноён Демирис.

-Танд зусар үг хэлэхгүй байх арга алга, хатагтай. Би хэлэх үгээ үнэхээр олохгүй нь.

Энэ үед Манос гүн ирж тэдний яриаг тасалдуулав.

Шөнө болж унтахын өмнө Мелина Демирисийн тухай бодлоо. Магадгүй тэр урьд нь түүний талаар сонсож байсан шиг. Баян бэлэвсэн эр, бизнесийн хүрээндээ алдар нэртэй, дурлалын адал явдалаар уйгүй хөөцөлддөг гэсэн. "Бидний хооронд ямар ч холбоо сүлбээ байхгүй нь юутай аз вэ!" гэж Мелина олзуурхан бодов.

-Бурхад ивээг!

Үдэшлэгийн маргааш өглөө Мелинаг өглөөний цайгаа уугаад сууж байхад бойдаа ирээд,

-Танд илгээмж ирлээ, хатагтай Ламброу. Түүнийг ноён Демирисийн жолооч хүргэж ирсэн гэж мэдэгджээ.

-Аваад ирээч.

"За ингээд Константин Демирис намайг өөрийнхөө баялаг хөрөнгөөр гайхуулахаар шийджээ. Түүний урмыг хугалахаас яах вэ дээ. Энэ нь учир утгагүй хөөрхөн зүйл, эсвэл замбараагүй үнэтэй хуучин эдлэл байх юм бол дор нь буцаая"

Илгээмж том биш, гонзгой хэлбэртэй, маш гоё баглаатай зүйл байв. Үзэх гэсэн сонирхолоо барь чадалгүй баглааг задалбал "Танд таалагдана гэж найдаж байна. Константин" гэсэн энгийн хэдхэн үгтэй зурвас гарлаа.

Дотор нь Никос Казацакисын "Toda Raba" гэдэг романы нэг хувь байсанд "Дуртай зохиолч маань энэ гэдгийг тэр хаанаас мэдэв ээ?" гэж хүүхэн гайхан бодов.

Мелина талархал илэрхийлсэн хэдэх үг бүхий бичээд "Ингээд гүйцээ" хэмээн бодов.

Маргааш өглөө нь дахиад нэг илгээмж ирсэний дотор энэ удаад түүний дуртай хөгжмийн зохиолч Делиусын хөгжим бүхий пянзыг илгээсэн байлаа. Бас "Та энэ хөгжмийн аянд "Toda Raba"-г уншвал таатай болов уу" гэсэн зурвас дагалдсан байлаа. Үүнээс хойш хүүхэн өдөр болгон дуртай сүрчиг, цэцэг, хөгжмийн нот, ном зэргийг хүлээн авах болжээ. Демирис түүний дуртай бүхнийг олж мэдэхийг хичээн талтайгаа харуулахыг зорино. Мелина түүнд талархалаа илэрхийлэхээр гэр рүү нь утасдсанд Демирис,

-Танд үнэнхүү тохирох сайхан зүйлийг би одоо хэр нь олж явуулж чадаагүй л байна гэж хэлжээ. Мөн хамт зоог барихыг санал болгов.

"Хичнээн хүүхэнд ингэж хэлсэн бол доо? Чи,"

Хүүхэн татгалзах гэж шийдээд байснаа гэнэт больж,

"Үүнд муу нь юу байгаа юм бэ? Тэр дэндүү халамжтайхүн юм" гэж бодоодохжээ.

-Дуртайяа зөвшөөрье.

Тэгээд энэ тухайгаа гүн Маност хэлэхэд цаадах нь дургүйцэн,

-Ямар хэрэгтэй юм бэ, хонгор минь? энэ аймшигтай хүн та хоёрт адил юм юу ч байхгүй. Танд тэрэнтэй уулзах хэрэг үгүй гэжээ.

-Вассилис, тэр өдөр болгон надад жижиг бэлэг явуулдаг. Би очиж уулзаад түүнийг үүнийгээ болихыг тушаамаар байна.

Константин Демирис хамгийн дээд зэргийн зоогийн гарзруудын нэг болох Панепист гудамжинд орших "Флока"-д хүүхнийг дайллаа.

-Таныг ирэхгүй юм болов уу гэж айж байлаа гэхэд хүүхэн,

-Би амласандаа ямагт хүрдэг хүн гэж хариулжээ.

демирис түүнийг ширтэж баяр хөөртэйгөөр,

-Би ч бас хэлсэндээ хүрдэг хүн. Би таныг эхнэрээ болгоноо гэж хэлэв.

Мелина энэ үгийг дуулаад цочиж сандарсан төдийгүй уурлаж толгой сэгсрэн,

-Ноён Демирис, би өөр хүнтэй сүй тавьсан хүн гэлээ.

-Маностой юу? гээд хайхрамжгүй гар занган,

-Тэр таньд тохирохгүй гэж хэнэггүй хэлэв.

-Яагаад? Учрыг нь хэлж өгөхгүй юу?

-Би түүний талаар сонирхосон юм. Түүний удам угсаанд галзуу хүн байжээ. Бас тэр чинь цусны өвчтэй түүнийг хүчингийн хэргээр Брюсэллийн цагдаагийн газар эрэн сурвалжилж байгаа, тэгээд ч теннис тоглохдоо дур гутмаар муу юм билээ.

Мелина инээдээ барьж ядан,

-Харин та? гэвэл,

-Би теннис огт тоглодоггүй гэлээ.

.Ойлгомжтой. Энэ л шалтгаанаар би тантай гэрлэх ёстой болж байх шив?

-Үгүй л дээ. Та миний эхнэр болбол би таныг хорвоогийн хамгийн жаргалтай эмэгтэй болгоно.

-Ноён демирис...

Тэр хүүхний гараас барьж,

-Коста гэвэл хүүхэн гараа татан авж,

-Ноён Демирис, би танаас цаашид бэлэг сэлт явуулахаа болиоч гэж гуйхаар ирсэн юм. Би тантай дахиж уулзахыг бодохгүй байна.

-Би таныг ийм хатуу хүн гэж бодохгүй л байна шүү.

-Үгүй гэж бодож байна.

демирис инээмсэглэн,

-Сайн байна. Тийм бол та миний зүрх сэтгэлийг шархлахаас аварна даа.

-Тийм амархан гэж бодохгүй л байна. Таны тухай гадуур өөрөөр л ярихцах юм байна шүү дээ.

-Тантай уулзсанаас хойш бүх юм төгсгөл болсон. Таныг мөн ч удаан мөрөөдлөө дөө.

Мелина инээгээд л байлаа.

-Би үнэнээсээ ярьж байна. Залуу зандан байхаасаа л би Ламброугийнхний тухай их уншдаг байсан. Танайх тийм баян би туйлын ядуу байлаа. надад тэгэхэд юу ч байгаагүй. эцэг маань боомтод ачигч хийдэг байсан. Бидэнд зөвхөн тэмцэж амьдрах л үлдээд байлаа.

Мелина түүний үгэнд өөрийн мэдэлгүй уяран,

-Гэхдээ та одоо баян хүн шүү дээ гэхэд,

-Тиймээ, улам ч баян болно.

-Таныг баяжихад чухам юу тус болсон юм бэ?

Өлсгөлөн. Би дандаа өлсдөг байсан. Одоо ч би өлсөж байна гэсэнд түүний нүднээс Мелина үнэн ярьж байгааг нь ойлгов.

-Яаж...яаж энэ бүхэн эхэлсэн бэ?

-Та үүнийг мэдэхийг хүсч байна уу?

-Тиймээ гэж Мелина хэлэв.

-Арван долоон настайдаа би нефтийн нэгэн компанид ажиллаж эхэлсэн юм. Надад санамсаргүй аз тохиосон юм. Нэг залуу геологичтой хамт оройн хоол идэхээр суудаг юм байна. Намайг бифштекс захиалтал тэр шөл л идээд байв. Учрыг асуувал араа огт байхгүй хиймэл шүд захиалая гэдэх надад мөнгө байхгүй гэж надад хариулсан. Би түүнийг хиймэл шүд хийлгээрэй хэмээн 50 доллар өгсөн юм. Сарын дараа тэр над руу утасдаад нефтийн шинэ орд газар нээсэн бөгөөд энэ тухай эзэндээ юу ч хэлээгүй гэж хэлсэн. өглөө нь би боломжийнхоо хэрээр мөгө цуглуулаад орой нь тэр газрыг худалдаж авсан даа. Тэр бол дэлхийн хамгийн том орд газруудын нэг болсон юм.

Мелина түүний үг болгоныг хичээнгүйлэн сонсов.

-Ингэж л эхэлсэн юм даа. эхлээд олборлосон нефтээ зөөх шатахууны онгоц хэрэгтэй болсон, би түүнийг худалдан авлаа. Дараа нь нефть боловсруулах үйлдвэр, дараа нь агаарын тээвэр гэснээ мөрөө хавчин,

-Ингээд л үргэлжилсэн гэлээ.

Зөвхөн хэдэн жил өнгөрсөн хойно л Мелина түүний ярьсан энэ түүх худлаа байсныг олж мэджээ.

Мелина Ламброу Демирис хоёр дахин уулзсангүй боловч хүлээн авалт, театр, жүжиг гэд хаа л бол хаа дайралдах бололцоог тэр алдахгүй эрэлхийлж байв. Тэр болгондоо Мелина түүний шантаршгүй зоригийг мэдэрч байжээ. Дотроо үүнийг хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй байлаа ч Василис Манос гүнтэнг түүнтэй зэрэгцүүлбэл дэндүү уйтгартай нэгэн санагдана.

Мелина Фламандын уран зураачдыг шүтдэг байтал нэг удаа Брейгелийн "Цасан дундах анчин" зургийг худалдан авах гээд чадсангүй, харин демирисээс бэлгэнд хүлээн авч өөрийнх нь сонирхдог зүйлийг ийм гойд мэдэж чаддагт нь гайхаад барахгүй байлаа.

-Би танаас ийм үнэтэй бэлэг хүлээн авч чадахгүй хэмээн түүнийг татгалзахад Демирис,

-энэ жирийн бэлэг бишээ. Та өнөөдөр надтай цуг оройн хоол идэхийг зөвшөөрвөл үүний үнийг төлсөн болно гэж хариулжээ.

Мелина энэ мятрашгүй эрийн өмнө буун өгчээ. Хэдэн хоногийн дараа Мелина хүүхэн Манос гүнтэнтэй харилцаагаа бүрмөсөн тасласан байна.

Энэ тухайгаа ахдаа хэлбэл тэр нь дуугарч чадахаа байж,

-Яагаад? ээ тэнгэр минь, яагад? гэж л асуухаас өөр мэхгүй болов.

-Яагаад гэвэл би Константин Демиристэй сууна.

Спирос ах нь сая л ухаан орж,

-Чи чинь галзуурчихаа юу? Чи түүнтэй сууж болохгүй. Тэр чинь гажиг амьтан. Тэр чамайг минь зүгээр л үгүй хийж орхино. Хэрэв...

-Чи түүний талаар буруу ойлголттой байна. Спирос, тэр агуу хүн. Тэгээд ч бид бие биедээ хайртай. Бид...

-Чи л өөрөө түүнд дурласан байна шүү дээ. Түүний ухаан санаандаа бодож тунгааж байгаа юмыг зөвхөн чөтгөр л мэдэх байх даа. Дурлал түүнд ямар ч утгагүй. Хүүхнүүдтэй түүний ямар холбоо сүлбээтэй байдгийг чи мэдэх үү?

Хүүхнүүдийг юу гэж боддог гээч?...Тэр бол...

-Энэ бүгд өнгөрсөн явдал, Спирос ах минь, Би түүний эхнэр болно.

Спирос юу ч хэлээд хүүхэн бодлоо өөрчилсөнгүй.

Сарын дараа Мелина Ламброу, Константин Демирис хоёр хуримаа хийлээ. Демирис гайхалтай ухаалаг, анхааралтай хүн байсан болохоор гэрлэх ёслол эхэндээ ер бусын санагдаж болох байв. тэр авгайдаа гоё бэлэг барихаас гадна тэд сайхан газруудаар их аяладаг байв.

Хуримын ахны шөнө Демирис гайхалтай амраг болохоо харууулан Мелинад,

-Миний ахны эхнэр үргүй хүн байсан. Чи бид олон хүүтэй болно гэж хэлжээ.

-Охид хэрэггүй гэж үү? гэж Мелинаг тоглон асуухад,

-Хэрэв чи хүсэж байгаа бол...гэхдээ эхнийх нь заавал хүү байх ёстой гэсэн байна.

Тэрээр Мелинаг жирэмсэн болсон гэдгийг дуулаад учиргүй баярлан,

-Чи миний эзэнт гүрнийг залгамжлах хүү төрүүлнэ гэж хэлэв. Үүнээс хойш гурван сарын дараа түүнийг ажлаар явах хооронд үр зулбалт болж хүүхэд бүтсэнгүй. Демирис буцаж ирмэгцээ үүнийг дуулаад аймшигтай уурлаж,

-Чи юу хийсэн бэ? Яагаад ийм явдал болов? хэмээн хашгиран загнав.

-Коста, би...

-Чи болгоомжтой байсангүй.

-Үгүй, яалаа гэж, би тангаргалая...

Тэр хүндээр санаа алдаад,

-За яах вэ, өнгөрсөн явдал, дахиад л хүүтэй болно гэтэл авгай.

-Намайг дахиад хүүхэдтэй болохгүй гэсэн гээд нүд рүү нь эгцэлж харж зүрхэлсэнгүй нүүрээ таглачихав.

-Чи чинь юугаа яриад байнаа?

-Хагалгаа хийхээс өөр арга байгаагүй. Надад дахиад хүүхэд заяахгүй болсон гэсэнд Демирис гэнэтхэн царцсан мэт хөдөлгөөнгүй болсноо дуугүй эргэн гарч оджээ.

Үүнээс л хойш Мелинагийн амьдрал там болон хувирав. Эхнэр нь хүүхдээ алсан юм шиг л Демирис түүнтэй муухай харьцах болсон байна. Тэгээд ч Мелинаг огт тоохоо больж ар өвөргүй завхайрах болов. Мелина орхигдон хаягдаж, хоцроод доромжлуулахын зэрэгцээ түүний хормойн явдлуудыг зарлахыг байнга сонсож байх хэрэгтэй болжээ. Энэ бүхнийг тэвчихээс өөр аргагүй. Тэрээр кино жүжигчин, дуурийн дуучин, хамт ажиллагчдын эхнэрүүд гээд янз бүрийн хүмүүстэй агаад тэднийгээ Псарт авчирч завиар зугаалж бүр сонин хэвлэл дээр хүртэл зураг хөрөгтэйгөө гардаг болов. Хэвлэл мэдээллийнхэн ч Демирисын шинэ дурлалын адал явдал болгоныг дор бүрт нь шүүрэн авч тохуутайгаар мэдээллэдэг байлаа.

тэр нэг удаа томоохон банкны эзнийд уригдсанд тэр нь, хятад тогоочтой болсон. Тэр танд гайхалтай сайхан хятад хоол хийж өгнө гэж хэлжээ. Тэнд цөм л алдартангууд кино жүжигчид, үйлдвэрийн эзэд цугларч хөлтэй оройн зоог барихад Мелина гэрийн эзний дэргэд ширээний буланд харин нөхөр нь эзэгтэйтэй зэрэгцэн эсрэг талд суусан байлаа. Демирисын

баруун талд үзэсгэлэнт жүжигчин эмэгтэй суусан агаад тэд элдвийг ярилцаж бусад хүмүүсийг огт анхаарахгүй сууцгаана. Тэдний яриа Мелинад хүртэл сонсогдоно.

-Та кино зургаа дуусгаад миний усан онгоцоор зочилно биз дээ. та тэнд амарч болно. Хоюулаа Далмацийн эрэг хүртэл аялсан ч болно шүү дээ.

Тэдний яриаг сонсохгүйг хичээвч сонсогдоод байх нь гачлантай. Тэгэх тусмаа Демирис аяр ярья гэж бодох ч үгүй байх бололтой.

-Та Псарт очиж үзээгүй биз дээ? Псар бол үнэхээр сайхан арал шүү. Танд лав таалагдана даа.

Мелинад ширээн доогуур ормоор санагдаад байлаа. гэвч улам л муугаа үзэх дугуу байжээ.

Зочид хиврга мөлжөөд дөнгөж дуустал гар угаах аягатай усыг авчирлаа. жүжигчин хүүхний өмнө аягатай ус тавусанд Демирис "энэ танд огт хэрэггүй" гэж хэлээд хүүхний соусанд будагдсан хуруунуудыг нэг нэгээр нь долоож гарав. Зочид цөмөөрөө харц буруулцгаана.

Мелина босож эзний зүг хандан: "Намайг өршөөж үз. Би явмаар байна. Миний...миний толгой их өвдөж байна" гэж хэлэв. Зочид түүнийг өрөөнөөс гаран гартал дагуулан харцгаалаа. тэр шөнө ч, дараачийн шөнө ч Демирис гэртээ хоносонгүй.

Энэ тухай дуулаад золтой муужирч унаагүй Спирос,

-Энэ муу новшийн зулбасгыг алаад аль гэж хэлээд өгөөч гээд хилэгнэн хашгирав.

-Тэр өөрөөр байж чадахгүй. Түүний зан л тэр гэж Мелина нөхрөө өмөөрнө.

-Зан нь уу? Тиймээ, тэр чинь зүгээр л араатан байна. Түүнийг сараалжин торонд хоривол таарна. Чи яагаад түүнээс салдаггүй юм бэ?

Мелина Демирис өөрөө ч энэ асуултыг өөрөөсөө байнга асуудаг боловч хариулт нь нэгэн хэвээр:

Би түүнд хайртай гэдэг үг байсан юм.

Өглөөний 6:30-д Кэтийг зарц бүсгүй сэрээж,

-Өглөөний мэнд, хатагтай гэж мэндлэв.

Кэт нүдээ нээгээд хаана байгаагаа эхлээд мэдсэнгүй. Өргөн сайхан ор, тансаг өрөө...Тэгээд гэнэт бүгдийг саналаа. Афинд аялсан...Кэтрин Дуглас. Тэд цаазлагдсан.

-Хатагтай

-За?

-Ноёнтон таныг өөртэйгөө цуг тагтан дээр өглөөний зоог барихгүй юу гэж асуулгаж байна?

Өглөөний дөрвөн цаг хүртэл унтаж чадаагүй хөрвөөсөн болохоор Кэтрин нүдээ нээж чадсангүй нилээд сандрав.

-баярлалаа, ноён Демирист намайг одоо очлоо гэж хэлнэ үү.

Хорин минутын дараа бойдаа түүнийг далайн зүг харсан асар том тагтан дээр дагуулан аваачив. Намхан чулуун хана түүнийг тойрон хүрээлж хорин фунтын цаахнаас цэцэрлэгт үргэлжилжээ. Демирис түүнийг хүлээж, ширээний ард суух бөгөөд дөхөж очтол нь ажиглан хараад байлаа. Хүүхнээс ариун сайхан, гэнэн хонгор зан илэрхий байх бөгөөд энэ бүхэн түүнийх, тэр эзэн нь болно гэж бодон нүцгэн байгаагаар төсөөлөх гээд үзэв. тэр түүнд Ноэлль Ларри хоёроос дахин дахин өшөөгөө авахад нь туслах болно.

Демирис босоод,

-Өглөөний мэнд. Ийм эрт сэрээсэнд минь уучлаарай. Гэвч хэдэн минутын дараа би алба руугаа явах учраас тантай ярилцах гэсэн юм гэж хэлэв.

-тэгэлгүй яах вэ гээд Кэт түүний өөдөөс далай тийш хандсан том гантиг ширээний ард суув. Нар дөнгөж мандаж түүний эхний туяа далайн мандлыг гийгүүлэн байна.

-Танд юу авчруулах вэ?

-Зүгээр, би өлсөхгүй байна.

-Тэгвэл кофе бэлд гэх үү?

-Баярлалаа.

Бойдаа түүнд цайвар шаргал өнгийн аяганд кофе аяглаж өглөө.

-За Кэт минь, та миний хэлсэн зүйлийн талаар бодож үзэв үү?

Шөнөжингөө л энэ тухай бодсон. Афинд түүнд хийх юм байхгүй. Өөр хаа нэгтээ ч мөн адил. Би сүмд эргэж очихгүй. Лондонд Демирисын конторт ажиллах л хамгийн зөв. Миний санаанд энэ нийцэж байна. Магадгүй амьдралаа шинээр эхлэх болох ч юм билүү гэж Кэт өөртөө хэлсэн байжээ.

-Тиймээ, би бодсон. Би оролдоод үзье гэж бодож байна.

Константин Демирис баярласандаа золтой л дуу алдчихсангүй.

-Би баярлаж байна. Та ер нь Лондонд байсан уу?

-Үгүй гэж бодож байна гээд Кэт,

-Би яг таг мэдэхгүй байна. Миний ой ухаанд ямар нэг бүдэг бадаг л зүйл байгаа болохоор хэлж мэдэхгүй нь гээд Кэт "Намайг хичнээн тоогүй явдлууд хүлээж байгаа бол?" гэж дотроо

бодов.

-Лондон дэлхийн хамгийн соёлтой сайхан хотуудаын нэг болохоор танд таалагдана гэж найдаж байна.

-Ноён демирис, та яагаад намайг энэ ажилд сонгов? гэж асуулаа.

-За даа, юу ч гэмээр юм бэ дээ, би өөрийгөө таны өмнө хариуцлага хүлээх ёстой хүн гэж бодож байна. Би таны нөхрийг Ноэлль Пэйжтэй танилцуулсан юм шүү дээ.

-Аа гээд Кэт дуугүй болов. Ноэлль Пэйж гэдэг нэрийг сонсоод тэр дагжин чичрэх шиг болжээ. Магадгүй Ларри түүнд ухаангүй хайртай байсан байх гэж түүнд бодогдоно.

Кэт биеэ албадан байж шөнөжин түүнийг зовоосон асуултыг зориглон,

-Тэднийг...тэгээд яаж цаазалсан бэ? гэвэл Демирис жаахан байзсанаа,

-Тэднийг буудаж хороосон гэж хариулав.

-Өө! гэж дуу алдаад Кэт хайрт хүнийх нь биенд сум хэрхэн тусаж байсныг мэдрэх шиг болов.

-Танд зөвлөхөд өнгөрсөн явдалыг бодож биеэ зовоох хэрэггүй юм шүү. Зөвхөн маргаашаа л бодох хэрэгтэй.

-Таны зөв байхаа. Би хичээе гэж Кэт шийдвэргүйхэн хариу дуугарав.

-Сайн байна. Өнөөдөр манай нэг онгоц Лондон руу ниснэ. Та аянд замд гарахад бэлтгэж амжих уу?

Кэтрин урьд нь Ларритайгаа цуг аян замд гарахдаа хичнээн баяр хөөртэй бэлтгэдэг байлаа даа. Одоо бол тэр ганцаараа явна. Тэгээд ч баярлаад байх юм алга байна.

-Бэлтгэхэд надад их хугацаа шаардагдахгүй.

-Сайн байна. Гэхдээ таны ой ухаан эргэж сэргэсэн гээд үгийн далимд санамсаргүй мэт хэлэн,

-Та өнгөрсөн амьдралынхаа тухай санасан болохоор хэн нэгэн таньдаг хүнтэйгээ уулзаж ярилцахыг хүсэж байгаа юм биш байгаа? хэмээн асуухад нь Кэтийн дотор шууд л "Уильям Фрезер" гэдэг нэр ороод ирэв. тэр түүний өнгөрсөн амьдралаас үлдсэн цорын ганц хүн. Гэхдээ л яг одоо түүнтэй уулзана гэхэд арай эртдэх байх аа. Би хуучин хэвэндээ эргэж орсон хойно ажил төрлөө хийж яваад түүнтэй өөрөө уулзана гэж бодогдлоо.

Константин Демирис түүн рүү харан хариу хэлэхийг нь хүлээнэ.

-Үгүй, би хэнийг ч санахгүй байна гэж кэт дуугарав.

Ингэж хариулсанаараа Уильям Фрезер гэдэг хүний амь насыг аварсанаа тэр огт мэдсэнгүй

өнгөрлөө.

-Би танд паспорт олох талаар санаа тавьсан гээд тэр дугтуйтай юм өгч:

-Энд таны зардалд зориулсан урьдчилгаа мөнгийг хийсэн байгаа. Байрны талаар санаа бүү зовоорой. Лондонд компаны мэдлийн байр байгаа. Та тэнд байж болно.

Энэ бүхэнд итгэхэд даанч хэцүү байх тул,

-Та дэндүү өгөөмөр сэтгэлтэй хүн юм гэхээс өөр үг олдсонгүй.

Тэр хүүхний гарыг барьж,

-Та бас намайг...гэснээ хэлэх үгээ гүйцээсэнгүй "Би болгоомжтой байх ёстой. Яарах хэрэггүй. Эс тэгвэл түүнийг айлгаж орхино" гэж бодоод үргэлжлүүлэн,

-Намайг өөрийнхөө хамгийн сайн найз нөхөр хэмээн бодохыг хүсье гэж дуусгав.

-Та үнэхээр миний хамгийн сайн нөхөр шүү.

Демирис инээмсэглэн дотроо:

"Хүлээ, бүү яар!" гэж өөртөө хэлнэ.

Хоёр цагийн дараа Константин Демирис Кэтринийг нисэх онгоцны буудал хүргэж өгөхөөр хүлээж байгаа "роллс-рой" машины арын суудалд суухад нь туслаад,

-Танд сайн сайхныг хүсье. Лондонд очсон хойно чинь би утасдана гэж хэллээ.

Таван минутын дараа Демирис утсаар Лондон ярьж,

-Тэр хүүхэн замдаа гарчихсан шүү гэжээ.

Тавдугаар хэсэг

Онгоц Элениковын буудлаас өглөөний 9 цагт нисэх байв. Энэ бол "хоукер сиддели" гэдэг онгоц байсан бөгөөд хачирхалтай нь Кэт түүний цорын ганц зорчигч байсан явдал юм. Дунд хэрийн насны аятайхан царайтай нисгэгч Пантелис түүнд таван минутын дараа хөөрнө гэж хэллээ.

-Баярлалаа гээд Кэт түүнийг хоёрдугаар нисгэгчийн хүлээж буй бүхээгт явж орохыг зүрхээ догдлуулан ажиглав. Түүний Ларри яг энэ онгоцоор ингээд л нисдэг байсан байх даа. Гэнэт ухаан алдах гэж байгаагаа мэдэрч гүнзгий амьсгаа авахдаа энэ бүхэн цөм ард хоцорсон гэдэг Демирисийн хэлдэг зөв юм хэмээн бодлоо. Одоо үнэндээ юуг ч өөрчлөх аргагүй шүү дээ. Тэгээд хөдөлгүүрийн дуу сонсон доош харвал онгоц өндөр аван хөөрч Лондоны зүг чиглэж явлаа. "Ларри, Ларри...энэ нэр янз бүрийн сайхан эсвэл аймшигтай дурсамжуудыг санагдуулах юм даа"

1940 он гарлаа. Жилийн дараа Америк дайнд оролцсон юм. Чикагогийн их сургуулийг дөнгөж дүүргээд байсан Кэтрин Александр Вашингтонд ажиллахаар ирэв.

Хөрш өрөөнийх нь охин нэг өдөр "Хөөе, би чамд сонирхолтой байж болох нэг ажлын сураг сонслоо. Нэг охин ажлаасаа гарч Техас явах гэж байгаа гэнэ. Билл Фрезерийнд ажилладаг юм л даа. Тэр төрийн яамдын ажилчидтай холбоотой ажилладаг хүн. Би энэ тухай сонсонгуутаа бусад хүүхнүүд мэдчих вий гэсэндээ чамд хэлэхээр яаран ирлээ" гэж хэлжээ. Кэтрин дорхноо тийшээ очоод тэнд арваад өрсөлдөгч охид хүлээн зогсохыг харав. "Надад ямар ч бололцоо алга юм даа" гэж бодон зогстол энэ үед Билл Фрезер өрөөнөөсөө гарч ирсэн нь шаргал үстэй, санчиг нь яльгүй бууралтсан, өндөр нуруутай эвлэгхэн царайтай нүдэнд дулаахан хүн байв. Тэрээр нэвт шувт ширтсэн гүн цэнхэр нүдтэй ажээ.

Фрезер нарийн бичгийн даргадаа хандан,

-Надад "Лайф" сэтгүүлийн гурав дөрвөн долоо хоногийн өмнөх дугаар хэрэгтэй байна. Хавтсан дээрээ Сталины зурагтай байх ёстой гэж хэлэв.

-Би одоохон захиалж орхиё, ноён Фрезер.

-Салли, би одоо сенатч Борахтай утсаар ярьж энэ сэтгүүлээс иш татаж уншиж өгөх ёстой. Тэгэхээр Салли чиний мэдэлд хоёр минут л байна гэж хэлэнгүүт өрөөндөө буцаад орчихлоо.

Өрсөлдөгч охид бие бие рүүгээ харан мөрөө хавчицгаав. Кэтрин зогсоод тархиа дайчлан бодож байлаа. Дараа нь гэнэт эргэж өрөөнөөс гарахдаа ард нь хэн нэгний "Ашгүй дээ. Нэг нь ч гэсэн хорогдлоо" гэхийг дуулжээ.

Гурван минутын дараа Кэт хавтсан дээрээ Сталины зурагтай "Лайф" сэтгүүлийн дугаарыг барьсаар орж ирээд нарийн бичгийн даргад гардуулав.

Таван минутын дараа Кэтринийг Фрезерийн өрөөнд урьж оруулжээ.

-Надад хэрэг болоод байсан сэтгүүлийн энэ дугаарыг таныг олж авчирсан гэж Салли надад хэллээ.

-Тийм ээ, эрхэм ээ.

-Та түүнийг яаж ийм хурдан олох арга сэдэв ээ? Таны цунхэнд "Лайф" сэтгүүлийн гурван долоо хоногийн өмнөх дугаар санамсаргүй байсан гэж би бодохгүй байна.

-Үгүй, эрхэм ээ.

-Та тэгээд яаж олов?

-Үсчиний газраас олсон юм. Үсчиний газар болон шүдний эмчийн хүлээлгийн өрөөнд хуучин сэтгүүлүүд байж байдгийг би гэнэт санасан юм л даа.

-Та үргэлж ийм гялалзтал сэтгэдэг хүн ү?

-Үгүй, эрхэм ээ.

-Зүгээр, бид үүнийг чинь тодруулна гэж Уильям Фрезер хэлэв.

Ингээд л тэр ажилд орсон юмсанжээ.

Фрезерийнд ажиллах нь Кэтринд таалагдаж байлаа. тэрээр их баян, Вашингтоныхон анддаггүй нийтгэгч гоонь эр билээ. тэгээд ч "Тайм" сэтгүүл түүнийг энэ жилийн хамгийн "атаархам гоонь эр" гэж нэрлэжээ.

Зургаан сарын дараа тэд бие биедээ дурласан юм. Билл Фрезер (энд бн шдээ би алдаа гаргаагүй шүү, Уильям=Билл гэж ойлгоод байгаа) , Кэтыг анх унтлагынхаа өрөөнд оруулах үед,

-Би чамд нэг зүйлийг хэлэх ёстой. Би урьд нь хүнтэй унтаж үзээгүй гэж хэлсэнд Билл үнэхээр гайхан,

-Үнэмшмээргүй юм. Би чинь Вашингтон дахь цорын ганц онгон охинтой учрах гэж байгаа юм байна шүү дээ! хэмээн дуу алджээ.

Нэгэн удаа Уильям Фрезер түүнд,

-Биднээс Голливудэд явагдаж байгаа Агаарын нисэх хүчний кино зураг авалтыг хянаж өгөхийг хүссэн. Түүнийг хийж үз. Надад Лондонд хийх юм мундахгүй их байна гэж хэлэв.

-Би юу? Билл, би чинь фото аппаратанд хальсыг нь яаж угсархыг чи мэддэггүй хүн шүү дээ. Би сургалтын кино зураг авалтын талаар юу мэдэх юм бэ? гэхэд Фрезер инээж,

-Илүү юм хэлэх шаардлагагүй. тэнд чинь зургийн дарга гэж нэг хүн бий. Аллан Бенжамин гэдэг хүн байгаа. Тэр л жүжигчдийг халж сольдог юм.

-Яагаад?

-Магадгүй цэргүүд цэргийнхээ дүрд тохирохгүй болоод тэр биз.

-Ёстой л арми байна даа.

Ингээд Кэт Голливудэд кино зураг авалт удирдахаар явжээ.

Зураг авалтын талбай хүмүүсээр дүүрэн байв. Цэргийн дүрэмт хувцас тэдний ихэнхид нэг л таарамжгүй эвгүй харагдана.

-Уучлаарай хэмээн Кэт хажуугаараа өнгөрөх гэж явсан хүнийг зогсоон,

-Би ноён Аллан Бенжамин гуайг хаанаас олж болох вэ? гэхэд,

-Бяцхан даргыг уу? Тэр байна хэмээн зааж өгөв.

Тэр нь генерал хувцастай хүнийг харан хашгичаж байлаа.

-Захирлын хэлсэнийг биелүүлдэг байх хэрэгтэй. Энд дандаа дүнхүү генералууд л байна. Гэтэл надад байлдагч хэрэгтэй. Жагсаалтын сэрэг гэж байна шүү. Бүгд л генерал болох гэж зүтгэцгээх юм. Хэн тэгээд индиан болох хэрэг вэ?

-Уучлаарай би Кэтрин Александр байна.

-Бурханы авралаар ажлаа авч үз. Энэ ажлыг чинь огт мэдэхгүй юм байна. Би Диаборнд модон эдлэлийн худалдааг редакторлаж жилд 35 мянган доллар олдог хүн. Намайг байлдагчидын холбоонд сонгоод л энэ сургалтын балай киноны найруулагчаар томилсон юм. Би кино найруулагчийн ажлын талаар юугаа мэдэх билээ дээ? За за, хүссэнээ л хий гээд тэр хүн Кэтийг ганцааранг нь орхин одлоо.

Ахимагдуу насны эрэгтэй түүнд дөхөж ирээд инээмсэглэж,

-Тусламж хэрэгтэй юу? гэхэд Кэтрин,

-Ид шид л хэрэгтэй байна. Би энд даргалах хэрэгтэй болоод байгаа мөртлөө юу хийхээ мэдэхгүй байна гэв.

Нөгөө хүн жуумалзан,

-Голливудэд тавгай морилогтун. Би найруулагчийн туслах О'Брайн гэдэг хүн байна гэж өөрийгөө танилцуулав.

-Юу хийх хэрэгтэй гэж бодож байна даа? гэхдээ Кэт түүний инээдээ арай ядан барьж байгааг анзаарлаа.

-Оролдоод үзье дээ. Би чин Вилли Уайлерын зургаан киноны зургийг авсан хүн. Бүгд л

муугүй болсон шиг санагдана. Зөвхөн зохион байгуулаад л орхих хэрэгтэй.

Кэт зургийн талбай руу хараад,

-Ихэнхид нь дүрэмт хувцас зохихгүй байна. За үүнийг засахыг оролдоцгооё, гэхэд О'Брайн зөвшөөрөн толгой дохив.

-Зөв шүү гэлээ.

Тэр хоёр бөөгнөрсөн хүмүүс рүү явж очлоо. Талбайд дуу шуугиан ихтэй байна.

-Чимээгүй байцгаа, залуучууд аа. Танилцацгаа. Энэ бол хатагтай Александр. Тэр одоо биднийг удирдах болно гэж О'Брайн чангаар орилон хэлэв.

Кэтрин тэдэнд хандан,

-Бүгдээрээ харагдахаар зогсоцгооно уу.

О'Брайн тэднийг арайхийн жагсаав. Кэт чанга ярьж инээлдэх дуугаар эргэн харвал нэг залуу хүмүүсийн дунд зогсоод түүнийг огт анзааралгүй хажуу дахь аальгүй хүүхэндээ завхай шог яриа ярьж байв. Залуугийн байдал Кэтийн дургүйг хүргэсэнд,

-Уучлаарай, та бусадтайгаа нийлэхийг хүсэхгүй байна уу? гэсэнд залуу эргэн хараад,

-Та үүнийг надад хандаж хэлэв үү? гээд зальжнаар асуухад нь,

-Тийм ээ, бид ажлаа эхэлмээр байна гэжээ.

Тэр нь өндөр нуруутай, гуалиг, гялалзсан хар үстэй, бор нүдтэй гайхалтай гоё залуу байв. Ахмадын дүрэмт хувцас түүнд үнэхээр гойд зохижээ. Харин түүний энгэр дүүрэн одонгийн гялалзсан туузнууд сүртэй харагдана.

-Энэ юун медальнууд вэ?

-Юу болов, босс оо? Болохгүй гэж үү? гэх намуухан хоолой сонсогдов.

-Наадуулаа ав.

-Яагаад? Би уг нь энэ киног хялбархаан гоёчихье гэж бодсон юмсан.

-Та нэг зүйлийг мартжээ. Өнөөдөр Америк дайтаагүй байна. Бүгд л таныг эднийгээ захаас худалдаад авчихаж гэж бодно шүү дээ.

-Таны зөв гэж тэр эвлэрэнгүй хэлээд.

-Би энэ тухай бодсонгүй. Одоохон авлаа гэхэд нь,

-Цөмийг нь шүү гэж Кэт хатуухан хэлэв.

Өглөөний зураг авалтын дараагаар үдийн цайны үед залуу түүний ширээнд ойртон ирж,

-Өглөөний зураг авалт ямар болов? Ялагчийн дүрд тоглож чадав уу? гэж асуулаа.

Иймэрхүү ая зан Кэтийн уурыг хүргэхээс өөр юмгүй байх тул,

-Танд дүрэмт хувцас өмсөөд хүүхнүүдтэй маасагнах нь л таалагддаг бололтой. Харин цэрэгт явья гэж та ер нь бодож үзсэн гэж үү? гэхэд залуу хэмжээлшгүй гайхаж байгаа янзтай,

-Яах гэж тэр вэ? Өөрийгөө алуулах гэж үү? хэмээн асуув.

-Би таныг жигшиж байна гэж Кэт биеэ арайхийн барин хэлэв.

-Яагаад?

-Хэрэв та яагаад гэдгийг өөрөө ойлгохгүй бол би танд хэзээ ч тайлбарлаж өгж чадахгүй.

-Оролдоод үз л дээ. Өнөөдөр оройн хоолны дараа танайд уулзая. Та бэлдэж амжих уу?

-Зургийн талбай руу дахин очих гэсний хэрэггүй. О'Брайнд таны ажлын хөлсийг өнөөдөт төлөөд, эндээс явуулж орхи гэж хэлье. Таны нэрийг хэн гэдэг билээ?

-Дуглас, Ларри Дуглас.

Бүдүүлэг залуу жүжигчиний тухай бодол түүнээс ер салж өгсөнгүй мартагч гэж санагч санасны гарз ажээ.

Кэтийг Вашингтонд эргэж ирэхэд Билл Фрезер тосож аваад,

-Чамгүйгээр хичнээн их уйдав даа? Чамайг мөн ч их саналаа. Чи надад хайртай юу? гэж асуухад,

-Чамдаа маш их хайртай, Билл гэж хүүхэн итгэл төгс хариулав.

-Би ч бас чамд хайртай. Өнөөдөр хоюулаа сайхан тэмдэглэнээ.

Билл түүнд гэрлэх санал тавих нь гэдгийг Кэт ойлгож байв. Тэгээд тэд янз бүрийн хүмүүс цугларсан "Жефферсон" клубт очигдоов. Хоолны үеэр танхимд Ларри Дуглас орж ирлээ. тэрээр нөгөө л одон тэмдэгээ гялалзтал зүүсэн байх бөгөөд Кэт түүнийг олж харсандаа нүдэндээ ч итгэсэнгүй гайхан ширтэж байтал Фрезертэй ирж мэндэллээ. Фрезер босож хүндэтгэн,

-Кэт, танилцаач. Энэ ахмад Лоуренс Дуглас. Ларри энэ бол хатагтай Александр. Ларри агаарын цэргийн албанд ажиллаж гавьяа байгуулсан хүн. Түүнийг Биржини мужийн нисгэгч бэлтгэх сумангийн захирагчаар ажиллахыг санал болгоод байгаа юм.

Зураг авалтын талбайд болсон явдал нүдний өмнө босоод ирлээ. Тэр түүнд одон медалиа авахыг тушааха дуртайяа цөмиг нь авч байсныг санав. Тэр өөртөө хичнээн итгэлтэй байж түүнийг өөдгүй амьтнаар нь дуудаж вхадаж байлаа даа? Одоо ичсэндээ ширээн доогуур шургаж ормоор санагдана.

Маргааш өдөр нь Ларри Дуглас ажлын өрөө рүү утасдсан боловч Кэтрин утсаа авахыг хүссэнгүй. Харин ажил тарах үеэр гарах хаалганы дэргэд тэр хүлээн зогсож байж билээ. Одоо бол бүх одон тэмдгээ аваад зөвхөн ахлах түрүүчийн пагонтойгоор инээмсэглэн зогсоно.

Тэгсэнээ дөхөн ирж,

-Ингэвэл арай дээр байна уу? хэмээн асуусанд Кэт түүнийг ширтэн,

-Жинхэнэ алдрын одон тэмдгийг зүүхийг хориглоогүй биз дээ гэлээ.

-Тийм ч юм байхгүй л дээ.

Кэт түүний нүдийг эгцэлж хармагцаа баларснаа ойлгожээ. Тэр нүдэнд хүнийг татах нэгэн ёсны соронзонгийн аугаа хүчин хадгалагдаж байжээ.

-Та надаас юу хүсээ вэ?

-Би таныг бүхлээр нь авахыг хүсэж байна!

Тэд Ларригийн дотор очиж энгэр зөрүүлцгээлээ. Өрөө, бүх дэлхий тэр чигээрээ нисэж, эхлэл төгсгөлгүй энэ мэт дурлалын цэнгэлийг тэр анх удаа эдэлсэн нь энэ. Энэ бол хэзээ ч амсаагүй аз жаргал байлаа. Хэн хэн нь дуу шуутайхан дур тайлаад хүч сульдан хэвтэхдээ энэ бүхэн аль болох удаан үргэлжлээсэй билээ гэсэн цорын ганц хүсэлдээ автан байжээ.

Таван цагийн дараа тэд Мэрилендэд гэрлэжээ.

Тэгээд одоо Лондон руу шинэ амьдрал зохиохоор онгоц дотор суугаад явж байна. "Бид ямар их жаргалзтай байлаа. Бидэнд юу гээч нь тохиолдсон юм бол доо? Дурлалын тухай өгүүлсэн дуу, кино зэрэг нь бидний сэтгэлийг хуурч бүх юм ямагт сайхнаар дуусах юм шиг санагдуулж, хэзээ ч алга болдоггүй үүрд мөнхийн дурлал байдаг гэдэгт итгүүлж орхижээ. Гэтэл тэр маань нэг л өдөр... Би түүнд саад болохоор, намайг алахад хүргэхээр юм юу хийсэн юм бол оо?"

-Хатагтай Александр...

Кэтрин бондгосхийн цочиж хаа байгаагаа гэнэт саналаа. Дэргэд нь нисгэгч ирээд зогсож байв.

-Бид газардчихаад байна. Лондонд тавтай морилно уу.

Нисэх онгоцны буудал дээр Кэтринийг хүлээн зогсох машины жолооч,

-Намайг Альфред гэдэг. Би таны ачаанд санаа тавья. Та шууд гэртээ харих уу?

"Миний гэр?!"

-Тэгнээ, тэгэлгүй яах вэ...

Кэтрин машинд санаа амран орж суучихав. Итгэмээргүй юм. Демирис түүнд онгоц бэлдэж бас байр зэхжээ. Тэр энэ дэлхийн хамгийн өгөөмөр хүн эсвэл... Үүнээс цааш тэр бодож чадсангүй. Тэр сайн хүн. Би түүнд талархал илэрхийлэх арга олох хэрэгтэй л гэж тэр бодно.

Түүнд зориулсан байр Элизабетын гудамжинд байрлах бөгөөд мөн л ганган гоёмсог аж. Өргөн уудам танхим болор дэн бүхий зочдын өрөө, хэсэг хэсэг модон тавиуртай номын сан, баялаг хүнсний зүйлээр дүүргэсэн гал тогоо, гурвын зэрэг тохилог сайхан унтлагын өрөө мөн үйлчлэгчдийн байрлах хэсэг.

Хоолон дээр Кэтийг хар өнгийн даашинз өмссөн дөч дөхсөн хүүхэн угтаж,

-Өдрийн мэнд, хатагтай Александр. Намайг Анна гэдэг. Би таны нярав байх болно гэлээ.

"Тэгэлгүй яах вэ, миний нярав."

Энэ бүх гайхамшигийг одоо Кэтрин байх ёстой юм шиг л хүлээн авах болжээ.

Жолооч Кэтийн чемоданыг өрөөнд авчирч тавиад,

-Машин таны мэдэл шүү. Хэрэв та ажил руугаа явахад бэлэн болчихвол Аннад хэлчихэж байгаарай. Би таныг хүлээж байна гэв.

"Пөөх миний мэдэлд бас машин байх нь ээ!"

-Баярлалаа.

-Би таны ачаа тээшийг янзалья. Хэрэв танд ямар нэг юм хэрэгтэй болбол шууд надад хэлээрэй гэж Анна хэлэв.

-Хэлэх юм даанч алга даа гэж Кэт үнэнээ хэлэв.

Аннаг юм хумаа янзлах хооронд Кэт өрөөндөө орж ирээд Константин Демирисын авч өгсөн шинэхэн гоё даашинзыг хараад "Яг л зүүд мөрөөдөл шиг" гэж бодлоо. Болоод байгаа бүхэн түүнд үнэн бус гэж санагдсаар л байлаа.

Ердөө л 48 цагийн өмнө тэр сүмийн хашаанд цэцэг тарьж суусан биш билүү? Тэгэхэд одоо хааны хатан шиг амьдарч байна. Ажил нь ямар байх бол оо? "Би хичээнэ ээ. Түүнийг хэзээ ч хөөдөхгүй!" гэж бодсоноо хачин их ядарсанаа мэдэрлээ. "Жаахан амрая" гэж бодоод орон дээр хэвтэн нүд анихад тэр дороо л усанд живж, тусламж дуудан хашгирч билээ. Ларри түүн рүү сэлж ирсэнээ улам живүүлэх гэж оролдоно. Дараа нь мөн л асга хадан дотор хаа сайгүй сарьсан багваахайнууд нисэлдэн, түүний үстэй зууралдан, хүйтэн нойтон далавчаараа нүүр

өөд нь алгадана. Цочин сэрж айсандаа Кэт орон дээрээ өндийн суув. "Одоо болно оо. Бүгд өнгөрсөн. энэ бүгд өчигдөр болоод өнгөрсөн явдал. Харин өнөөдөр бол өнөөдөр шүү дээ. Өнөөдөр хэн ч намайг оролдохгүй." Өрөөнийх нь үүдний ард түүний хашгирхыг дуулсан Анна чимээ намжирсаны хойно Демирис рүү утасдахаар зочдын өрөөг зүглэв.

"Грекийн худалдааны корпорацын" албан тасалгаа Пиккадиллигээс холгүй орших Бонд гудамжинд олон жилийн өмнө баригдсан хуучны барилгад байрладаг ажээ. Гадаад байдал нь уран нарийн хийцтэй харагдана.

Кэтийг явж ороход бүх албан хаагчид түүнийг хүлээж байв. Хэдэн хүн бүр хаалган дээр зогсоод тосож байлаа.

-Хатагтай Кэтрин Александр та тавтай морилно уу. Намайг Эвелин Кей гэдэг. Энэ Карл... Таке... Мэтью... Жений... түүнд бүх хүний нэр болоод зүс холилдож нэгэн зүйл болон харагдаж байлаа.

-Таны ажлыг хүлээж байна. Танд замчлахыг зөвшөөрнө үү.

-Баярлалаа.

Хүлээлгийн өрөөнд нарийн нэхээстэй хивсээр бүрхсэн честерфилд загварын буйдан, чиппендэйл маягийн сандал тавьсан нь нүд булаана. Тэд цаашаа урт хивс дэвссэн гудмаар ываж, нарсаар доторлож, голд нь өнгөлсөн ширээ тавьж савхин бүрээстэй сандлуудаар тойруулсан хурлын танхимын хажуугаар өнгөрөв.

-Гэртээ байгаа юм шиг л байгаарай.

-Ердөө л гайхамшиг гээд Кэт амандаа шивэгнэлээ.

Нэгэн булангийн ширээн дээр шинэхэн анхилуун цэцэг тавьжээ.

-Ноён Демирисээс танд явуулсан цэцэг гэхэд "Тэр бүхнийг амжуулжээ" гэж бодогдлоо.

Эвелин Кей түүнийг дагуулан явсаар дунд хэрийн насны аятайхан царайтай бүсгүй ажиллаж байгаа өрөөнд авчран,

-Хэдэн өдрийн дараа та дасна байлгүй. Гэхдээ энд тийм хэцүү хүнд дүрэм журам мөрддөггүй л дээ. Манайх бол Демирисын эзэнт гүрний мэдрэлийн гол төвүүдийн нэг. Бид олон оронд байгаа манай салбар хэлтсүүдээс ирүүлсэн тооцоог зохицуулах үүрэгтэй. Дараа нь түүнийгээ Афин руу илгээдэг. Би конторыг удирдана. Харин та миний туслах болно доо гэж танилцуулав.

-Өө за гэсэн боловч Кэт юу хийхээ ойлгосонгүй. ЭЗ-ийн судалгааны гол үндсэн шемийг зохиодог хүн. Түүний ой ухаан ямар ч компьютерээс илүү хурдан ажилладаг юм. Түүний тасалгаанд очицгооё л доо. Би таныг түүнтэй танилцуулмаар байна.

Тэд дахин гудмаар орж явсаар хамгийн булангийн хаалганд тулж очин тогшилгүй орцгоов.

Кэт өрөөнд орсоноо Уйм Вандин гэгч 30 гаруй насны туранхай эр амаа үл мэдэг ангайн их л бодлогоширсон янзтай цонх ширтэн суухыг хараад дороо зоогдсон мэт зогсож орхив.

-Уйм! Уйм! Кэтрин Александртай танилц!

Тэр эрэгтэй эргэн харсанаа,

-Екатрина 1, жинхэнэ нэр нь Марта Славронская гэдэг. 1684 онд төрсөн, зарц шивэгчин байжээ. Оросуудад олзлогдон Оросын эзэн хаан Петр 1-тэй гэрлэсэн, 1725-1727 онд хатан хаан байсан. Аугаа Екатрина немцийн гүнгийн охин, 1729 онд төрсөн, Петр 3 хаантай 1761 онд гэрлэсэн. Түүний амийг хөнөөхдөө өөрөө хатан хааны ширээг эзэлсэн. Түүнээс шалтгаалан Польшийг гурав хувааж, Туркэд 2 удаа дайн дэгдээсэн...

Энэ нэгэн хэмийн мэдээллийн урсгал эцэсгүй мэт санагдана.

Ичиж зовсон Кэтийн амнаас зөвхөн л,

-Энэ... ямар сонирхолтой хүн бэ? гэсэн үг гарав.

Уйм түүнийг бус хажууд нь байх үйл үзэгдэм зүйл ширтэн байна.

-Манай Уйм танихгүй хүнтэй тун чиг бүрэг харьцаатай хүн дээ.

"Бүрэг гэнээ?!" гэж бодоод Кэт,

-Тэр их эелдэг хүн юм. Ёстой суут хүн гэлээ.

Демирис Афин хотын Гэгээн Герондын гудамжин дахь албан тасалгаандаа Лондонгоос залгасан Альфредтай утсаар ярьж суув.

-Би хатагтай Александрыг онгоцны буудлаас байранд нь авчраад таны тушаасан ёсоор хатагтайгаас хаа нэг тийшээ явах эсэхийг асуухад тэр үгүй гэсэн.

-Түүнд гадны ямар нэг харьцаа байхгүй биз?

-Үгүй, эрхэм ээ.

Ер нь ч энэ талаар Демирис огт санаа зовохгүй байв. Анна түүнд дор нь утасдаж мэдээллэх учиртай болохоор тэр тайвшран утсаа тавив. Хүүхэн ямар их аюултай байдалд байгаага төсөөлөх ч үгүй байв. Энэ хорвоод ач санаад барамгүй Константин Демирисээс өөр талархах хүнгүй хүн. Түүнээс өөр хэнийгээ ч гэх вэ.

"Бушуухан явах хэрэгтэй. Аль болох түргэн тусмаа сайн" гэж Демирис бодов.

Кэтэд шинэ ажил нь ихэд таалагдлаа. Өдөр бүр Демирисын аугаа эзэнт гүрний үйл ажиллагааны тоо тооцоо янз бүрийн орноос ирнэ. Тэр дунд Индиан мужийн төмрийн заводын ачлагын зардал, Итали дахь автомашины шалган байцаах газрын бичиг сачиг,

Австрали дахь Демирисын хамаарлын сонины газар, алт олборлох уурхайн даатгалын компаниас ирсэн падаан бичиг зэрэг байна. Кэт Уйм Вандины мэдээллийн дагуу тэднийг дүгнэдэг байлаа. Уйм тооцооны бичиг харангуутаа л өгөгдсөн мэдээллийг яг компьютер шиг ажил хэрэгч хурдан шуурхайгаар дүгнэн гаргаж уг компани хичнээн ашиг олж хичнээнийг алдсаныг дор нь тооцоод гаргадаг байлаа.

Кэт хамт ажиллагсадтайгаа ойртон танилцаж, ажлын газрынхаа үзэмж технологийг гайхаж дуусахгүй л байв. Тэр нэг удаа Эвелинд энэ тухайгаа хэлэхэд тэдний дэргэд байсна Уйм үүнийг сонсоод,

-Энэ барилга анх улсын гаалийн газар байсан. 1721 онд ноён Н. Кристофер Урены төслөөр барьсан, Лондоны их түймрийн дараагаар К. Урен гэгээн Павел, гэгээн Михаил, гэгээн Дагины дуган орсон 50 дуган нэм бар8жээ. Тэрээр мөн хааны бирж, Букингемийн ордны төслийг зохиогч билээ. Дэлхийн 2 дугаар дайны үед засгийн газар энэ барилгыг бөмбөгдөлтөөс хоргодох байрны зориулалтаар ашиглаж байв хэмээн урсгаж гарав.

Бөмбөгдөлтөөс зугтсан хүмүүс хүнд төмөр хаалгаар хонгил руу орж нуугдда байсан гэх энэ өрөөнд Кэт орох үедээ залуу хөгшин британчууд Гитлерын бөмбөгдөлтөөс хэрхэн зугтаж байсныг төсөөлөн бодно. Хонгилд байшингийн урттай тэнцүү хэмжээгээр үргэлжилжээ. Тэнд барилгыг байнгын халаалттай байлгах бойлертой нь байнга эвгүй сэтгэгдэл төрүүлнэ. Кэт орохдоо түүнийг ямагт олж хардаг байв.

-Энэ ымаар аймар юм бэ? Дэлбэрч магадгүй яа? гэж түүнийг нэг удаа асуухад,

-Хэл чинь тасраг, хатагтай! Үгүй ээ, яалаа гэж. Тэр хамгаалалтын хаалтыг харж байна уу? Хэрэв бойлер асаад дэлбэрвэл энэ хаалт илүү паарыг нээж хялбархан шийдэгдэнэ дээ. Ямар ч асуудал гарахгүй гэснэ үг гэжээ.

Ажлын дараагаар Кэт Лондоны үлгэрийн юм шиг гоё театр, балет, дуурь үздэг байв. Гайхалтай сайхан номын дэлгүүр, эхдэн арван музей, мухлаг зоогийн газраар орно. Кэт нэрт мастеруудын чулуун баримлыг үзэж Хардродс Форт нум, Масон, Спенсерийн бүтээгдэхүүнийг худалдан авна. Харин хагас бүтэнсайнд бол "Савой"-д цай уухаар очдог байлаа.

Өдөр хоног өнгөрөх тусам өнгөрсний тухай бодол бүдгэрсээр л байлаа. Ларриг л их санагалздаг байв. Түүний дуу хоолой...үсний нь үнэр... "Үгүй ээ, өнгөрсөн бүхэн дууссан. Одоо гол нь ирээдүй!" гэж бодон тэрээр улам чангарч тэнхэрсээр байжээ.

Кэт, Эвелин Кэйтэй дотно нөхөрлөж, цаг үргэлж хамт байдаг болов. Тэд нэгэн амралтын өдөр Темза гопын эрэг дээрх зургийн үзэсгэлэн үзэж явав. Хөгшин залуу энэ олон зураачид бол зургийн галерейд бүтээлээ тавих эрх олж чадаагүй золгүй зураачид бөгөөд тэдний бүтээл энд тэндгүй дүүрэн өрөөстэй байсанд Кэт өрөвдөх сэтгэлийн үүднээс нэг зург худалдан авчээ.

-Та үүнийгээ тэгээд хаана өлгөх юм бэ? гэж Эвелин гайхан асуухад,

-Бойлерт гэж Кэт хариулсан байна.

Хэдийгээр Кэт ихэвчилэн ганцаараа байх боловч тэр удаах завгүй ажиллаж байлаа. Өдрийн жаахан ч цагийг алдалгүй өөртөө амласнаар хийж гүйцэтгэхээр шамдан ажиллана. Уйм Вандин түүний хувьд оньсого шиг санагдана. Кэт хэзээ ч ийм хүнтэй тааралдаж явсангүй. Конторт нийт хорин хүн ажилладаг бол Уйм тооны машин хэрэглэхгүйгээр тэдний хэн нь хэйдийн өртэй ба авлагатай, тэр ч байтугай тэдний даатгалын дэвтэрийн дугаарыг цээжээр мэднэ. Компанид хамрагдах бүх зүйлийг толгойдоо хадгална. Тэгээд ч аль хэлтэсийн мөнгөний асуудал ямар байгаа, таван жилийн өмнө түүнийг ажилд орох үед ямар байсан зэргийг алдалгүй хэлж чаддаг ажээ.

Уйм Вандин уншсан сонссоноо хэзээ ч мартдаггүй. Түүний мэдлэгийн цар хэмжээ хязгааргүй. Хамгийн энгийн асуултанд ч тэр бүрэн бүтэн мэдлэг олмоор хариулт хэлнэ. Харин хүмүүстэй ойртон нөхөрлөхдөө тунчиг маруухан даа. Тэгээд ч түүнийг их ганцаарддаг байх гэж өрөвдсөн Кэтрин аль болох дотно ойр байхыг эрхэмлэх болов.

Кэт Уймын мэдлэгийг гайхаад барахгүй байв. Түүний чих өвдөж үүнийгээ Уймд хэлэхэд,

-Чих нь дэлбээ, суваг, хэнгэрэгэн хальс алх, дөш, дөрөө гэх мэт жижиг яснууд хэнгэргийн хөндий, эмгэн хумс, сонсголын мэдрэлийн гуурс зэргээс тогтоно гэж хэлжээ.

Нэгэн удаа Кэтрин Эвелин хоёр Уймыг жижиг зоогийн газарт үдийн хоолонд урьжээ. Зоогийн газрын цаад буланд хүмүүс нум сум харван тоглож байв.

-Уйм чи ер нь спорт сонирхдог уу? Бейсбол тоглож үзсэн үү? гэж Кэтын асуухад,

-Бейсбол бол 9,5 дьом хэмжээтэй, хатуу резинэн биетийг утсаар ороож хийсэн, гадаргууг нь цагаан савхиар бүрсэн байна. Цохиурыг яшил модоор хийдэг. Голч нь 2,75 дьом, урт нь 42 дьомээс хэтрэхгүй гэв.

"Тэрбээр ямагт тоон үзүүлэлтүүдийг мэдэх юм. Тоглоод ямар нэгэн таашаал авч үзсэн болов уу?"

-Спортын ямар нэгэн төрлөөр хичээллэж үзээгүй юу? Жишээ н3 сагс?

-Сагсны талбайг заавал модоор юм уу бетоноор хучсан байх ёстой. Бөмбөг нь гадаргууг арьсаар бүрсэн 32 дьомын голчтой байна. Бөмбөг доторхи даралт 30 атмосфер байдаг. 20-22 унцыг даах жинтэй, 1891 онд Жеймс Найсмит зохиожээ.

Кэт үүнээс илүү хариулт шаардсангүй.

Уймын зан байдал нь хүмүүст ямагт таатай сэтгэгдэл үлдээдэг байв. Амралтын өдөр Кэт Эвелин хоёр Уймыг дагуулан Мейдоннер хэмээх цайны газар оржээ. Ширээнд үйлчлэгч дөхөж ирээд,

-Өнөөдөр манайд шинэхэн савхан хорхой бий гэж хэлэв.

Кэт Уйм руу харж,

-Чи юунд дуртай вэ? гэж асуухад

-Савхан хорхой бол урт, дугариг, нэг хүйсийн, цустай амьтан гэлээ.

Үйлчлэгч ам ангайн ширтсэнээ,

-Та захиалах уу? гэхэд,

-Савхан хорхойг тэсвэрлэж чаддаггүй гэж зэвүүрхэн хэлэв.

Хамт ажиллагсад нь Кэтэд таалагддаг байлаа. Харин Уйм нэг л онцгүй хүн байлаа. Түүний ой ухаан бусад бүх мэдэрхүйг нь дарангуйлж бусад хүмүүс шиг дурлаад, гэрлээд амьдархад нь саад болдог гэдэгт Кэт нэг л итгэж чадахгүй байв.

Нэг удаа конторын бүх албан хаагчидад "Савой"-д болох цэнгээнт үдэшлэгийн урилга ирсэн байлаа. Кэт Уймын өрөөнд ороод,

-Уйм чи бүжиглэж чадна биз дээ? гэтэл Уйм түүн рүү хараад,

-Фокстрот нь дөрвөн тактаар хөдөлнө. Эрэгтэй нь эхлээд зүүн хөлөөрөө урагш хоёр алхана. Эмэгтэй нь баруун хөлөөрөө хойш хоёр алхана. Хоёр удаан алхамын дараа хурдан алхаад тэгш өнцөгөөр удаан алхана гэж урсгалаа.

Кэтэд хэлэх үг үнэхээр олдсонгүй тул "Тэр зөв зүйтэй үгийг мэдэх юм. Даанч утгыг нь ойлгодоггүй юм байна" гэж бодов.

Кэтийг орондоо орсон хойно нилээд орой Константин Демирис утасдав.

-Саад болоогүй байгаа? Би Коста байна гэж гэмшсэн дуугаар хэлэхэд,

-Өө яалаа гэж дээ гэж түүний дууг сонсоод баярласан Кэт хариулав. Түүнтэй ярьж зөвлөхийг ихэд хүссэн байжээ. Тэгээд ч энэ бол түүний өнгөрсөн амьдарлыг мэдэх цорын ганц хүн болоод хуучны найз шиг нь дотно санагдана.

-Танд Лондон таалагдахгүй байх вий гэж айж байлаа. Та тэнд хэнийг ч танихгүй шүү дээ.

-Заримдаа ч ганцаардах л юм. Гэхдээ би таны өнгөрсөнөө март, ирээдүйгээ бодож амьдар гэж хэлсэнийг санаж явдаг шүү.

-Яг зөв. Ирээдүйгээ л бодох хэрэгтэй. Би маргааш Лондон орно. Таныг оройн хоолонд уримаар байна.

Демирис харилцуур тавиад инээмсэглэн "За ингээд хөөцөлдөөн эхлэх шив" гэж бодлоо.

Тэд "Ритц"-д хооллохоор ороход рестораны тохилог байдал Кэтэд гүнзгий сэтгэгдэл төрүүлэв.

Орчны байдал хичнээн ч дур байлаа гэсэн Кэт өмнөөсөө хараад сууж байгаа хүнээс өөр юмыг анзаарах сөхөөгүй байлаа. Хэлэх юм мөн ч их байна даа.

-Таны конторт их сайн хүмүүс ажиллах юм. Уйм их сонин хүн шүү. Би тийм хүнтэй ер дайралдаж яваагүй. Яг л...

Гэвч Демирис хүүхний ямар эмзэг турьхан, гэнэхэн хонгор вэ гэж л бодож сууснаас түүний үгийг огт сонссонгүй. "Энэ тоглоомд ялах гэж яарах хэрэг надад алга. Ноэльль, чамд болон чиний амрагт би энэ ялалтаа зориулах болно" гэж бодно.

-Та Лондонд удах уу?

-Ганц хоёр л хононо. Ажил их байгаа.

Хэдийгээр утсаар яриад л ажлаа зохицуулчихаж элбэг чадах боловч Лондонд биеэрээ ирж Кэттэй уулзаж сэтгэлийг нь өөртөө ойртуулан татахаар санаа шулуудсан байлаа.

Тэгээд түүн рүү тонгойж,

-Би танд Саудын Арабт нефтийн орд газар ажиллаж байсан тухайгаа ярьсан билүү?...гэлээ

Демирис маргааш орой нь Кэтринийг хоолонд ахин урилаа.

-Эвелин таныг ёстой сайн ажиллаж байгаа гэж надад хэлсэн. Би танд талархаж байна.

-Та нээрээ их сайхан сэтгэлтэй хүн юм. Би... гэтэл Демирис хүүхний нүд рүү ширтэн,

-Би хичнээн их сайхан сэтгэлтэй байж чадахыг та мэдэхгүй байна даа эгсэнд Кэт эвгүйрхээд явчихав. Тэгсэнээ өөрийгөө зэмлэж "Тэр зүгээр л хэтэрхий сайахн сэтгэлтэй. Түүнд өөр санаа байхгүй. Би тэнэг юм бодож байна" гэж бодлоо.

Дараачийн өдөр нь Демирис буцах болов.

-Кэт, та намайг онгоцны буудла хүргэж өгнө биздээ?

-Тэгэлгүй яахав.

Демирис одоогоор Кэтийн стэгэл санааг бүрэн эзэмдэж учиргүй сайхан сэтгэлтэй хүн шиг л санагдаж байлаа. Тэр ухаалаг, овжин, овсгоотойгоос гадна хүүхэнд ийнхүү халамж тавих нь бүр самгардуулж орхиод байв.

Буудал дээр Демирис Кэтийн хацар дээр зөөлөн үнсээд,

-Тантай цуг байхад сайхан байлаа гэв.

-Надад ч мөн адил. Баярлалаа, Коста.

Хүүхэн онгоц газраас тасарч хөөртөл харсаар зогсоно. "Ямар сайхан сэтгэлтэй хүн гээч вэ. Түүнийг байхгүйд би ганцаардана даа..."

Зургадугаар хэсэг

Константин Демирис түүний хадам ах Спирос Ламброу хоёрын харилцаа хүмүүст нягт зузаан нөхөрлөл шиг санагддаг байлаа.

Спирос Ламброу бол бараг л Демирис шиг баян, хүч чадалтай нэгэн билээ. Хэрэв Демирис дэлхийн хамгийн том ачааны хөлөг онгоцуудыг эзэмшдэг бол Спирос хэмжээгээрээ хёорт орохыг нь эзэмшдэг билээ. Демирис бүх хэвлэл, агаарын шугам, нефть олборлолт, төмрийн үйлдвэр, алтны уурхайд хяналт тавьдаг бол Ламброу даатгалын компаниуд, банк болон олонт ооны үл хөдлөх хөрөнгө, химийн үйлдвэрүүдийг мэддэг аж. Тэд хоюулаа өрсөлдөгчид болоод хамтран зүтгэгчиддээ хүчтэй сэтгэгдэл төрүүлж чаддаг байна.

-Ийм хоёр хүчирхэг хүмүүс найз нөхөд байдаг нь мөн гайхам сайхан аа! гэж хүмүүс шагшин хэлэлцэнэ.

Үнэн хэрэгтээ тэд нэг нэгнээ үзэн яддаг эвлэршгүй дайснууд байсан юм. Ламброуг 100 футын хөлөг онгоц авч амжаагүй байхад Демирис өргөн дизель, 4 хөдөлгүүртэй 30 хүний бүрэлдэхүүнтэй, бас хоёр хөнгөн завьтай цэвэр усны сан бүхий 150 футын хөлөг онгоцоо далайд тавьж байдаг.

Ломброугийн 200000 тонны түрцтэй галт онгоц дөнгөж хорийг чирч байхад Демирисын хөлөг онгоцны флот 650000 тонны түрцтэй хорин гурван онгоц эзэмшдэг байв.

Хэрэв Спирос Ламброу хурдны морь уралдуулахаар худалдан авбал Демирис түүний эсрэг морь уралдуулахаар бүхэл бүтэн сүрэг яаран авдаг байлаа.

Тэд байнга уулзалддаг бөгөөд нэг буяны байгууллагын гишүүд байсан тул үргэлж дайралдан мөн гэр бүлийн хүрээнд ч уулзах нь цөөнгүй байв. Зан чанарын хувьд ч тэд хоорондоо огтын төсгүй хүмүүс байв. Константин Демирис ядуу төрөлхийн хоосон гэр бүлд төрж баяжих энэ замыг сонгон олсон бол Спирос Ламброу язгууртны гэр бүлд төржээ. Тэрээр үргэлж цэвэрхэн хувцаслаж явдаг, өндөр нуруутай сайхан эр байлаа. Өвөг дээдэс нь болох Бавари гаралтай Отто нь цагтаа Грекийг удирдаж явсан нэгэн. Тэр цагт цөөнхийн бүлэгт хамрагддаг хэсэг хүмүүс улс төрийн эргэлт гаргаж худалдаа, далайн тээвэр, газар эзэмших эрх олж авч чадсаны нэг нь Ламброугийн төрсөн эцэг байв. Эцгээсээ Спирос энэ бүх эрх мэдэл, эд хөрөнгийг өвлөн авсан ажээ.

Олон жил Демирис Ламброу хоёр эв эйин хуурамч халхавч дор нуугдан ирсэн боловч үнэн хэрэгтээ тэд бие биенээ устган дарах гсн оролдлого цөөнгүй хийсээр ирсэн. Демирис зөвхөн амьдрах ухаан гэж ойлгодог зөн билигтээ хөтлөгдөн түүнтэй тэмцэж байсан бол Ламброу нь Мелина дүүгийнхээ төлөө өшөө өвөрлөн явдаг байв.

Спирос Ламброу ихээхэн шүтлэгтэй хүн байсан ба амьдрал түүнд аз жаргал амжилт заяасан хэйди ч бурханыг хилэгнүүлэхээс үнэнхүү айдаг байлаа. Худал хуурмагийг ухаарах сэхээ түүнд хангалттай байсан боловч нэгэн төлөгч авгай түүнийг бүр бишрүүлж орхисон юмсанжээ. Тэр авгай Мелинагийн ххүүхэд зулбаж, гэрлэлт бүтэлгүйтнэ гээд бас бус өөр олон юмыг урьдчилан тааж хэлсэн юм. Авгай Афинд амьдардаг, нэр нь Пирис хатагтай гэгч байв.

Константин Демирис сурсан зангаараа өглөө эрт Гэгээн Герондын гудамжинд байрлах албан тасалгаандаа орох үед 6 цаг болж байв. Түүний өрсөлдөгч нар дөнгөж ажилдаа ирж байх цагт Демирис дэлхийн олон оронд тархсан салбаруудтайгаа холбоо бариад хамаг ажил төрлөө амжуулчихсан байдаг байв.

Демирисын тасалгаа тэр чигээрээ дуу алдам тохилог бөгөөд асар том толин цонхоор нь үзэсгэлэнт Афин тэр аяараа харагдана. Хананд нь Леже, Баркын зурагнууд өлгөөстэй. Пикассо ч мөн байна. Шал нь хар гантиг, харин модон эдлэл нь төмөр хээтэй савхин бүрээстэй. Өрөөний голд байрласан том бичгийн ширээ төмөр болоод шилээр хийгдэж хаан ширээ л ийм байдаг болов уу гэмээр санагдана. Ширээн дээр ваар, тавиур дээр гэгээн Александрын дүрстэй маск тавьсан байх бөгөөд дор нь "Алексадроос. Хүнийг хамгаалагч" гэж бичжээ.

Энэ өглөө түүнийг өрөөндөө орох үеэр утас дуугарав.

Өрөөний утасны дугаарыг ердөө зургаахан хүн л мэднэ.

-Kalimehra.

-Kalimehra гэж харилцуурт Спирос Ламброугийн хувийн нарийн бичгийн дарга Никос Веритасын дуу сонсогдлоо.

-Тав алдуулсанд өршөөгөөрэй, ноён Демирис. Та намайг мэдээлэл олдвол ... яасан гэсэн.

-Тэгээд?

-Ноён Ламброу "Аврора интернешнл" компанийг худалдан авах гэнээ. Нью-Йоркын хөрөнгийн биржийн мэдэгдэл дээр байна. Ноён Ламброуд уг бижрийн захиргаан дахь танил нь энэ компани бөмбөгдөгч онгоцны барилга барих захиалга авсан нууцыг мэдээлжээ. Энэ тухай ил тод болбол акцын үнэ нь шууд өсөх болно...

-Надад энэ бирж дээр тоглох сонирхол алга гэж Демирис шуудхан яриаг нь таслан хэлээд:

-Танд үүнээс өөр чухал хэрэг байхгүй бол надад бүү садаа бол гэв.

-Уучлаарай ноёр Демирис. Би бодохдоо ... гэх үед Демирис аль хэдийн утсаа тасалчихсан байв.

Найман цагт Демирисын гарын туслах Жианнис Ткарос өрөөнд орж ирэхэд тэрбээр тоглой өндийлгөн,

-Нью-Йоркийн хөрөнгийн биржид хамаардаг "Аврора интернешнл" компани талаар олж мэдэж болох бүх баримт бичгийг цуглуулаад бүх сонингоор мэдээл. Мэдээллийн эх сурвалжийг нууцал, гэхдээ аль болох их далайцтайгаар тараа. Акцын үнэ унахаа зогстол үүнийгээ үргэлжлүүл. Тэгээд худалдаж аваарай. Надад хяналтын багц битүүмж бичиг хэрэгтэй байна гэв.

-Мэдлээ, эрхэм э. Гүйцээ юу?

-Үгүй ээ. Надад хяналтын битүүмжийг ирмэгц уг мэдээлэл үнэгүй байжээ гэж мэдээл. Аа тийм. Спирос Ламброу нууц мэдээ ашиглан акц худалдан авсан нь Нью-Йоркийн хөрөнгийн биржид тодорхой болоход нь анхаарвал зохино гэхэд нь Жианнис Ткарос түүнийг бодлогоширон харж,

-Ноёр Демирис, энэ чинь эрүүгийн хэрэгт тооцогддог юм шүү дээ. АНУ-д тэр л дээ гэж хэлсэнд,

-Би мэднэ гэж Демирис тайван хариуллаа.

Демирисын байшингаас милийн зайтай Синтагмын талбайд Спирос Ламброу өөрийн эрээвэр хураавар сонирхолд нийцүүлэн тохижуулсан албан тасалгаандаа сууж байв. Тэрэр өрөөгөө хагас нь франц үлдсэн нь итали модон эдлэлээр гоёжээ. Гурван талын ханандаа францын эх орончдын зургийг харин нөгөө ханандаа Ван Райселлвергаас авахуулаад Де Смета хүртэлх зураачдын бүтээл үзэгдэнэ. Хаалган дээр нь "Ламброу ба хамтран зүтгэгчид" гэсэн хаяг хадаастай байв. Харин хамтран зүтгэгч түүнд хэзээ ч байсангүй. Эцгээсээ ашигтай үйлдвэр уламжлан аваад эдэн жилийн дараа дэлхий даяар алдартай олон тооны салбар болгож дөнгөжээ. Спирос Ламброу аз жаргалтай хүн байж болох байлаа. Тэр баян, бас бие хаа чанга, амжилт ивэсэн хүн байв. Ганцхан Демирис л түүнийг аз жаргалтай байхад нь саад болж байв. Демирис алив юманд их чадвартайгаас гадна хүнийг өрөвдөх өчүүхэн ч нимгэн сэтгэлгүй болохоор спирос түүнийг хүн гэж үзэж чаддаггүй хорсож явдаг байлаа.

Энэ явдал арван жилийн өмнө эхэлжээ. Ахтайгаа үдийн хоол идэж суусан Мелина ахыгаа ингэж тэвдэж сандарсан байхыг хэзээ ч үзээгүй байжээ.

-Мелина, чи хүн төрөлхтөний өдөр бүр хэрэглэдэг ашигт малтмалын түүх мянган жилийн настай гэдгийг мэдэх үү?

-Үгүй, Спирос.

-Ирээдүйд нефтийн талаар том асуудал босож ирнэ. Тэгэхээр тээврийн онгоцнууд хүрэлцэхээ болино байх даа.

-Та ачлагат онгоц хийхээр шийдээ юу? гэж дүүгээ асуухад тэр толгой дохин,

-Онгоцоор ч зогсохгүй. Би одоогийнхоос хоёр дахин томд элхийн хамгийн том тээврийн онгоцнуудын флот байгуулна. Бүтэн сарын турш би тооцоо хийж үзлэ. Чи сонс, Персийн булангаас АНУ-ын эрэг хүртэл галлон хүхэрлэг нефть тээвэрлэхэд долоон цент байдаг юм. Харин том онгоцоор бол ердөө гурван цент байдаг. Энэ юу болохыг чи төсөөлж байна уу?

-Спирос, чи флот барих мөнгөө хаанаас олох юм бэ?

Тэр инээмсэглэн,

-Харин яг энэ чинь л миний төлөвлөгөөний гайхамшигтай хэсэг нь. Нэг ч цент зарцуулахгүй.

-Яаж тэр вэ?

-Сарын дараа би Америкт очиж нефтийн томоохон компаний эзэдтэй хэлэлцээ хийнэ. Нефтийг том онгоцоор тээвэрлэх нь тэдэнд хоёр дахин хямд тусна шүү дээ.

-Гэхдээ... чамд том онгоцнууд байхгүй шүү дээ.

Түүний инээмсэглэл бүр үргэлжилсэн инээд болон хувирч хөхрөн,

-Байхгүй ээ. Гэхдээ би нефтийн компаниудтай урт хугацааны гэрээ байгуулж чадвал банк флот байгуулах мөнгийг надад зээлдүүлэх болно. Чи энэ тухай юу гэж бодож байна? гэв.

-Чи ч их онцгой хүн юм. Үнэхээр агуу төлөвлөгөө байна!

Мелинад ахынх нь сүрхий төлөвлөгөө ихэд нөлөөлж, тэр энэ тухайгаа оройн хоолон дээр ярьчихжээ. Тэгээд яриагаа дуусган,

-Гайхамшигтай байгаа биз? гэж асуухад нь Демирис чимээгүй бодож сууснаа дараа нь,

-Ах чинь хоосон мөрөөдөгч юм. Үүнээс ашиг гарахгүй гэж хэлэв.

Мелина түүн рүү гайхан харж,

-Коста, яагаад тэр вэ? гэвэл,

-Яагаад гэвэл энэ чинь бүтэшгүй хэрэг. Нэгдүгээрт нефтийн хувьд түүний төсөөлж байгаа шиг том асуудал одоогоор байхгүй. Тиймээс энэ онгоцнуудад аших нефть олдохгүй гэсэн үг. Хоёрдугаарт, нефтийн компаниуд өөр тийм их нефть байгальд байгаа эгдэгт итгэхгүй. Гуравдугаарт, түүний саналыг сонсоод шоолох болно гэсэнд Мелинагийн царайд харамссан байдал тодрон,

-Спирос ямар их баяртай байсан гээч. Чи энэ тухай түүнтэй ярилцаач гэсэнд Демисир эсэргүүцэн тоглой сэгсэрч,

-Мөрөөдөлдөө умбаж л байг. Саяны яриагаа хэлэхгүй байсан нь дээр гэлээ.

-За, за, Коста. Хэлсэнээр чинь больё.

Маргааш өглөө нь Константин Демирис том ачлагат онгоц барих асуудал хэлэлцэхээр АНУ руу нисэж явлаа. Тэр АНУ-д аюулгүйн зөвлөлийн орнуудын эсвэл Нью-Жерси "Стандард ойл компани", Калифорны "Стандард ойл компани", Техасын компани "Галф ойл", "Сакони Ваакум", "Роял-датч-шелл" англи-иракын компани гээд долоон том компанийг АНУ-ийн нутгаас гадна байгаа нефтийн нөөцийг хянадаг гэдгийг мэддэг тул аль нэгэнтэй тохирцчихвол бусад нь энэ жишгийг дагана гэдэгт итгэлтэй байлаа.

Демирис эхлээд Нью-Жерси дэх "Стандард ойл" компаны удирдлагатай уулзахаар шийдэв. КОмпаны дөрөдөх ерөнхийлөгч Оуэн Кертистэй уулзахад,

-Ноён Демирис танд би юугаар тус болж чадах бол? гэж тэр нөхөрсөгөөр асуув.

-Танай компанид ихээхэн ашиг оруулах санал надад байгаа юм.

-Тиймээ, та энэ тухайгаа утсаар дурссан гээд Кертис цагаа харан, - Хэдэн минутын дараа би уулзалттай. Хэрэв болгоовол товчхон шиг...

-Товчхон ярья л даа. Персийн булангаас АНУ-ын хойд хүртэл галлон нефть тээвэрлэдэх долоон цент байдаг байх аа?

-Яг тийм.

-Би танд тээвэрлэлтийн хөлсийг галлон тус бүрд гурван центээр тооцоо хийе гэвэл та юу хэлэх бол?

Кертис гайхширан инээмсэглээд,

-Та яаж гайхамшигаа бүтээх юм бэ? хэмээв.

-Ачлагат онгоцны тусламжтайгаар өнөөдрийнхөөс хоёр дахин бага зардалтайгаар адил хугацаанд хүргэх болно.

Кертис түүн рүү бодлогоширон ширтээд,

-Та хаанаас тэр том галт онгоцнуудыг авах юм бэ? гэв.

-Барина.

-Уучлаарай, бид хөрөнгө оруулалтыг огт сонирхдоггүй юм.

-Би танаас нэг цент ч авахгүй гэж Демирис хэлээд:

-Надад зөвхөн танай нефтийг одоогийн жишгээс хоёр дахин хямдаар тээвэрлэх танай компаны урт хугацааны гэрээ л хэрэгтэй. Би тэр гэрээгээ банкинд үзүүлэх юм.

Тэд удаан чимээгүй сууцгаав. Дараа нь Оуэн Кертис хоолойгоо засаад,

-Дээш нь уламжилж ерөнхийлөгчтэй ярилцана гэлэ.

Ингээд бүх юм эхлэв. Бусад компаниуд Константин Демирис тэй дуртайяа тохиролцоонд хүрэв. Спирос Ламброу энэ тухай дуулах үед бүх юм хэдийнэ оройтсон байлаа. Тэгээд АНУ-д очиж хэд хэдэн компанитай гэрээ байгуулж чадсна боловч томчуул цөм Демирисын гарт орсон байлаа.

-Чиний нөхөр гэж Спирос дүүдээ хэлээд,

-Үүнийхэ хариуг хүртэх болно гэдгийг чамд андгайлъя гэж хэлжээ.

Мелина болсон явдалд ихэд цочирдсон байлаа. Тэрээр ахаасаа урваснаа ойлгон мэдэрч байв.

Энэ тухайгаа нөхөртөө хэлэхэд Демирис,

-Би үүнийг чинь тоогоогүй шүү дээ, Мелина. Тэд өөрсдөө л наддээр ирсэн. Надад татагалзах шалтгаан бий гэж үү? гээд цаашид ярилах юмгүй болгожээ.

Гэвч ах нөхөр хоёрынх нь ажил хэргийн бус ийм харьцаа ч Демирисын хувьд Мелинаг гомдоох сайхан шалтаг болдог байв. Тэгээд ч Демирисын энэ мэт олон явдлыг нүд анин өнгөрөөдөг бөгөөд цаадах нь ч Мелинаг төдийгүй Ламброугийнхны гэр бүлийг гутаан доромжилж байгаагаа огт нуудаггүй байлаа. Хамгийн том жишээ л гэхэд Ноэль Пэйж тэр хоёрын дурлал байсан юм. Бүх дэлхийн сонин хэвлэл шуугин бичиж байхад Спирос Ламброу "За яахав, харж л байя. Хэзээ нэгэн цагт..." гэж дотроо занан боддог байжээ.

Өрөөнд Ламброугийн туслах Никос Веритас орж иэв. Тэр энд ажиллаад арван таван жил болж байгаа сайн гүйцэтгэгч туслах байвч ямар ч сэтгэх чадваргүй дорой нэгэн байсан учраас ирээдүүгүй. Үүнийгээ өөрөө мэддэг тул Демирис Ламброу хоёрын дайсагнал дундаас ашиг олж болох нь хэмээн бодоод зорилгодоо ашиглах гэсэн санаагаар олсон мэдээллээ Демирис худалдаж өгөөд шан хүртдэг ажээ.

-Өршөөгөөрэй, таныг ноён АнТони Риццоли уулзъя гэж байна гэж тэр Ламброуд хандан хэлэв.

Ламброу үл мэдэг цочсоноо,

-За яахав ээ, түүнийг уриад оруулчихдаа гэлээ.

АнТонин Риццоли бол 45 настай, өндөр нуруу, монхор хамартай, хүнхэр нүдтэй тас хар үстэ, сайн бэлтгэлтэй боскчин шид шалмаг хөдөлгөөнтэй хүн ажээ. Тэрээр захиалгаар оюулсан үнэт костюм шар торгон цамц, зөөлөн арьсан шаахай өмсчээ. Хэдийгээр зөөлөн эелдэг өнгөтэй ярих боловч түүнээс ямар нэг үл ойлгогдом түгшүүр эмдэгдэнэ.

-Тантай уулзахдаа таатай байна, ноён Ламброу.

-Сууна уу, ноён Риццоли. Танд юугаар тусалж болох бол?

-Би түрүүн таны туслах Веритасаар нэг ачааны хөлөг онгоц хөлслөх хүсэлтэй байгаагаа уламжлуусан юмсан. Би Марсельд үйлдвэртэй юм л даа. Тэндээс хүдхэн хэрэгслүүд Нэгдсэн Улсад тээвэрлэх санаатай юм. Бид хэлэлцээр хийж болно шүү. Дараа нь би танд ирээдүйд их ашиг оруулах болно.

Спирос Ламброу гэдрэг налаад ярилцагчаа ширтэн байж "ой гутмаар юм" хэмээн бодов.

-Таны тээвэрлэх гээд байгаа зүйл чинь ердөө л энэ гэж үү? гэж түүнийг асууухад Риццоли хөмсөг занигдан,

-Юу гэв ээ? Ойлгосонгүй гэсэнд,

-Харин ч ойлгомжтой байх гэж бодож байна. Надад танд зориулсан хөлөг онгоц байхгүй.

-Яагаад тэр вэ? Та юу ярина вэ?

-Мансууруулах бодисыг хэлж байна. Ноён Риццоли, та бол мансууруулах бодис наймаалагч шүү дээ гэлээ.

Риццоли нүдээ онийлгон ширтэнгээ,

-Та чинь солиороо юу? Энэ чинь хов яриа гэж хэлэв.

Харамсалтай нь энэ бол хов жив огт биш байлаа. Спирос Ламброу энэ талаар нилээд сайн мэдээлэлтэй хүн. Тони Риццоли бол Европдоо томоохон наймаачин эр гэдгийг тэр юу эс андах вэ. Тэрчлэн Тони Риццоли мафийн гишүүн бөгөөд мансууруулах нодис зөөвөрлөх арга зам сүвэгчилж байгаа тухай дуулсан байлаа.

-Таныг өөр тийшээ онгоц сураглахаар ясав болох нь гэж би айж байна гэсэнд Тони түүнийг хүйтэн харцаар нүд цавчилгүй харж байснаа босож,

-За тийм байдаг байж гээд халааснаасаа нэрийн хуудас гарган ширээн дээр чулуудаад,

-Жаахан бодоод бодлоо өөрчилбөл утасдаарай гээд хурдхан гараад явчихав. Ламброу хуудсыг авч үзвэл "АнТони Риццоли: Импорт-экспорт" гэсэн нэрийн хуудас байв. Мөн Афин дахь зочид буудлын утас хаяг байв.

Туслах Никос Веритас энэ яриаг нүдээ бүлтийлгэн чихээ дэлдийлгэн чагнаж авжэ. Түүнийг гараад явахад даргаасаа,

-Үнэн юм уу? гэж лавласанд,

-Тийм ээ, Риццоли бол хар тамхи үйлдвэрлэдэг. Хэрэв бид түүнд нэг л хөлөг өгчихвөл засаг манай флотыг дор нь хураагаад авчихна гэлээ.

Тони риццоли тэдний өрөөнөөс гараад цухалдсандаа бүр амьсгаадаж байв. "Энэ муу грек новш надтай яаж харьцах нь энэ вэ. Тэр миний талаар хаанаас мэдэж авсан юм бол? Даанч энэ удаагийн бараа дэндүү том, үнэ нь олон саяас буухгүй юм даа. Ядаж мансууруулах бодистой тэмцэх тасгийн цагдаа нар Афинаар нэг дүүрэн өлбөлзөн гүйлдэж байдаг. Сициль рүү л ярьж хугацааг нь хойшлуулж өгөөч гэж гуйхаас даа". Тони Риццоли хэзээ ч бараагаа баартуулж байгаагүй аж. Одоо ч энэ удаад алдахыг хүсэхгүй байв. Тэгээд ч өөрийгөө ялагдашгүй баатар мэтээр тооцно. Орь залуу наснаасаа эхлэн герион борлуулах ажил эрхэлсэн тул одоо түүний амьдарлын нэг хэсэг болсон юмсанж.

Тонигийн хувьд герион бол жинхэнэ "алт" байлаа. Түүгээр хичнээн их мөнгө олж болох вэ! Тосгоныхонд ургуулсаны хөлс гэж ердөө л 350 доллар төлдөг боловч боловсруулалт хийсний дараагаар Нью-Йоркийн гудамжинд энэ нь 250000 долларын үнэ хүрнэ. "Хялбар арга шүү дээ. Хамгийн гол нь баларч л болохгүй" гэж тэр өөртөө хэлнэ.

Интерполоос хар тамхины наймаачидтай хийх тэмцэл ширүүсч сэжигтэй санагдсан хөлөг онгоц, илгээмж бүрийг шалгаж үзнэ. Иймээс ч риццоли Спирост хандсан нь энэ. Түүний флотыг л сэжиглэхгүй өнгөрөөж магад. Цагдаагийхан түүний ачааны хөлгүүдийг нэгжээд байх нь юу л бол. Гэхдээ энэ новш татгалзсан болохоор өөр л зам хайх хэрэгтэй. Тэгээд хурдлахгүй бол болохгүй гэж Риццлой бодов.

* * *

Гэнэт утас жингэнэн дуугарлаа.

-Кэтрин, би таныг сэрээж орхив уу даа?

Шөнө дунд болжээ.

-Үгүй, Коста. Таны дууг сонсох надад сайхан байна.

-Бүх юм зүгээр үү?

-Тийм ээ, баярлалаа, надад ажил маань маш их таалагддаг.

-Сонсоход таатай байна. Хоёр долоо хоногийн дараа би Лондон орно. Тэгээд тантай уулзая гээд дотроо "Болгоомжтой. Яарах хэрэггүй" гэж өөртөө хэлэн:

-Тантай хэдэн төвөгтэй асуудлын талаар ярилцах гэсэн юм гэхэд,

-Тэг л дээ гж Кэт уриалгахан хэлэв.

-Тавгай нойрсоорой.

-Тавгай нойрсоорой.

Харин энэ удаад хүүхэн өөрөө утасдлаа.

-Коста ... би юу хэлэхээ мэдэхгүй байна. Ийм сайхан зүүлт ... та тэгэх ёсгүй гэсэнд,

-Зүгээр ээ, Кэт минь. Анхаарал халамжийн маань илрэл шүү дээ. Эвелин надад таныг ямар их тусалж байгаа тухай ярьсан. Энэ бол таны үзүгээс их зүтгэл шүү.

"Юутай амархан юм бэ! Нэг муу өчүүхэн бэлгэнд сүйд болоод" гэж Демирис бодов. Дараа нь "Би эхнэрээсээ сална" гэж хэлнэ.

Дараачийн алхам нь "Би юутай их ганцаардана вэ" гэж хэлэх болно. Тэгээд гэрлэх тухай сэжүүр гаргаж орхиод хөлөг онгоц дээр хамтдаа арал руу аялах санал тавина. Түүний энэ систем хэзээ ч нуран унаж байгаагүй юм. "Бүх юмс гайхалтай сайхан байх биз, яагаад гэвэл энэ удаад төгсгөл нь тэс өөр, тэр хүүхэн үхэх болно" гэж бодлоо.

Түүнийг өмгөөлөгч Наполеон Чотас руу утсадахад тэр нь бөөн баяр болж,

-Чамтай уулзалгүй удлаа, Коста. Бүх зүйл тайван уу гэж дуу алдав.

-Баярлалаа. Тайван. чамаас хүсэх нэг зүйл байна.

-Би туслахдаа баяртай байх болно.

-Ноэль Пэйжийн Рафин дахь шилтгээнийг чи миний өмнөөс хэн нэгний нэр дээр худалдаад аваад өгөөч.

-Өө, энэ хцинь хэцүү уым биш байна. Надад нэг танидаг шүүгч тэнд бий.

-Үүнийг өөрөө зохицуулаарай.

-За, би энэ талаар хөөцөлдөёе гэж өмгөөлөгч удаан хэлээд утсаа таслахдаа "Шилтгээн Ноэль Пэйж, Ларри Дуглас хоёрын дурлалын цэнгээний үүр байсан. Түүгээр Демирис яах гэж байгаа юм бол?" гэж дотроо бодлоо.

Долоодугаар хэсэг

Арсакионы шүүхийн байр Афины доод хэсэгт байдаг нүсэр байшин бөгөөд Их сургууль ба Страда гудамжны уулзварыг бүрэн эзэлж байдаг. Тэр байшингийн 21, 30, 33 дугаарын өрөө нь эрүүгийн хэсгийхэнд хамрагдах бөгөөд бусад нь бүгд тэнхим байв.

Хувийн эрх ашгийн үүднээс хүн алсан гэсэн хэрэгт мөрдөгдөж буй Анастасия Саваласын хэргийг 33 дахь өрөөд шүүж байв. Өрөөний өргөн 40 фут, урт нь 300 фут. Шүүхийн ажиллагааг сонирхсон хүмүүст зориулсан талбай тус бүрдээ ес есөн сандал бүхий гурван хэсгээг бүрдэнэ. Танхимын хойморт индэр дээрх өндөр сэнтийд гурван цагдаа суужээ. Индэрийн эсрэг талд бага зэрэг өндөрлөсөн тавцан дээр ширээ бэхэлж тогтоосон гэрчүүдийн байр байна. Холгүйхэн хана дагуулан байрлуулсан сандалд арван шүүгч сууна. Хэрэгтнийг шүүгчдийн хэсгээс тусгаарлаж буй хашлагын урд өмгөөлөгчид зориулсан сандал тавиаастай байна.

Үнэндээ аллагын хэрэг шүүх явдал сонирхол татдаг нь зүй байсны дээр өмгөөлөгчийн үүргийг энэ удаад Наполеон Чотас, дэлхийн хамгийн нэртэй өмгөөлөгч гүйцэтгэж байгаа тохиолдолд бүр ч хувь илүү сонирхолтой ажээ. Чотас зөвхөн эрүүгийн хэрэг өмгөөлдөг бөгөөд ямагт ялагчаар тодрон гарна. Хүмүүсийн дам ярианаас сонсоход түүний хөлс шан харамж сая доллараар тоологдоно. Наполеон Чотас дэндүү хатингар туранхай биетэй, үрчлээтэй нүүрэн дээрх хоёр том гунигт нүд нь яг сайн үйлдрийн анч нохойг санагдуулна. Тэрбээр хувцаслалдаа огт анхаарал тавьдаггүй тэр хүний арчаагүй юм шиг гадаад төрх нь гялалзсан сэтгэлгээ, гайхамшигт ухаан, хязгааргүй хүч чадалт дотоод төрхийг нь нуун дарагдуулж үл чадна, Хэвлэл мэдээлэл Чотасын хэрэгтнийг өмгөөлөх болсон шалтгааны талаар харьцангуй бага бичиж байв. Энэ удаад түүнд ялах боломж байхгүй, тэр ялагдлаа хүлээх болно гэж хүмүүс ярина.

Яллагч Питер Демонидос урьд нь Чотастай шүүхийн танхимд учирч явсан бөгөөд түүнээс ихэд эмээдэг нэгэн. Гэхдээ энэ удаад сэтгэл зовох нь гайгүй байсны учир нь Анастасия Саваласын хэрэг нэгэнт илэрч тодорхой болсон байсантай холбоотой ажээ.

Хэргийн баримтууд бүхнийг хэлээд өгч байв. Анастасия Савалас бол маш сайхан залуу бүсгүй аж. Тэр өөрөөсөө гучин насаар ах боловч баян Жорж Саваластай гэр бүл болжээ. Анастасия залуу жолоочтойгоо учрах болсонд хүмүүс энэ тухай нөхөрт нь хэл хүргэчихжээ. Нөхөр нь уурлаж сална, гэрээслэлээ цуцлана гэж сүрдүүлжээ. Аллага болсон орой Анастасия үйлчлэгчээ явуулчихаад нөхрийнхөө оройн хоолыг өөрийн гараар бэлджээ. Жорж Савалас хоолоо идэж байхдаа ханиалгаад байхаар нь эхнэр нь түүнд ханиалга намдаах шингэн эм өгсөнд ердөө ганц балгаад л талийгаач болсон байна.

Хэрэг дэндүү илэрхий ажээ.

Гучин гурав дугаарын танхим өглөөнөөс авахуулаад хүнээр дүүрэн Анастасия хэрэгтний ширээнд суужээ. Хүүхэн бүхлдээ хар хувцас өмссөн бөгөөд ямар ч чимэг зүүлт, будаг шунхгүй атлаа үзэсгэлэнтэй сайхан харагдана.

Яллагч Питер Демонидос эхлэн ярьж шүүгчдэд хандан,

-Ноёд хатагтай нараа! Заримдаа хүн амины хэрэг дээр шүүх гурав дөрвөн сар ажиллах ч байдаг. Харин энэ хэрэг сунжирч удах явдалгүй юм. Та нар хэргийн байдалтай танилцаад зориуд хүний амь хөнөөсөн хэрэгт байна гэж нэгэн дуугаар хэлцгээнэ гэдэгт би итгэлтэй байна. Гэрчүүдийн мэдүүлэг залуу жолоочтойгоо дурлалын харьцаатай болсон тухай нөхөр нь мэдээд сална гэж сүрдүүлсэнээс болоод Анастасия Савалас нөхрөө алсныг тодорхой нотолж байгаа юм. Хэрэгтэнд аллага үйлдэх шалтгаан, боломж бодсоноо гүйцэлдүүлэх зүйл гарт нь байсныг ч баталж байна. Анхаарал тавьсанд баярлалаа гээд үгээ дуусган сандалдаа очив.

Ерөнхий шүүгч Чотаст хандан,

-Та өмгөөлөх үгээ хэлэхэд бэлэн үү? гэж асуув.

Наполеон чотас яаралгүйхэн босоод,

-Тийм ээ, эрхэм ээ гээд бэлэн гээд бохирох шахсан хөлөөр шүүгчдийн зүг үхндхэн алхаагаар ойртов. Тэрээр жаахан зогсоод өөртэйгөө ярьж байгаа мэт аяархан дуугаар эхэлж,

-Би олон жил амьдарч олон оймс элээхдээ эрэгтэй ч бай эмэгтэй ч бай ямар ч хүн түүний дотор агуулагдаж байгаа хорон муу санаагаа нууж хаах чадваргүй байсныг ойлгосон юм. Нүд бол сэтгэлийн толь хэмээн нэгэн яруу найрагч өгүүлсэн шиг би та бүхнээс хэрэгтний нүд рүү харахыг хүсэж байна. Тэгвэл та бүхэн энэ эмэгтэйг хүн алаагүй гэдгийг олж харах болно гээд Чотас үг нэмж хэлэх гэсэн шиг байдал үзүүлснээ суудалдаа очоод суучихав.

Питер Демонидос баярлан "Бурхан минь! Энэ мэдэгдэл урьд өмнө миний сонссоноос хамгийн нэмэргүй муу болох шиг боллоо. Хөгшин өнөөдөр юу ч хийж дөнгөхгүй нь дээ" гэж бодов.

-Яллагч эхний гэрчээ дуудна уу?

-Тэгье, эрхэм шүүгчээ. Би Роза Ликоургорсыг дуудмаар байна.

Дунд хэрийн насны хүүхэн үзэгчид дундаас өндийгөөд гэрч нарын суудал руу шийдмэг алхан очив.

-Хатагтай Ликоургос та юу хийдэг вэ?

-Би нярваар ... гэснээ дуу нь тасрав. Дараа нь үргэлжлүүлэн:

-Би ноён Саваласынд нярав хийдэг ...

-Жорж Саваласынд уу?

-Тийм ээ, эрхэм ээ.

-Та хэдэн жил ажиллаж байгаагаа хэлнэ үү?

-Хорин таван жил.

-Тун удаан ажиллаж байгаа юм байна. Та эзнийхээ талаар ямар бодолтой явдаг вэ?

-Тэр бол бурхан шиг хүн.

-Түүний анхны эхнэрийн үед та байсан уу?

-Байсан, эрхэм ээ. Түүнийг эхнэрээ оршуулж байх үед би булшны дэргэд зогсож байсан.

-Тэд хоорондоо сайн харьцаатай байсан гэж хэлбэл болох уу?

-Тэд бие биенээ ухаангүй хайрладаг байсан,

Питер Демонидос өмгөөлөгч тийш харж эсэргүүцэх үг хэлэх болов уу гэж хүлээв. Гэтэл Чотас бодолдоо бүрэн автсан байдалтай сууж байлаа.

-Ноён Саваласыг Анастасиятай гэрлэж байх үед та тэднийд ажилласаар л байсан уу?

-Тиймээ, эрхэм ээ гэхдээ авгай үг бүрээ ноцтой хэллээ.

-Тэдний гэрлэлт аз жаргалтай байсан гэж хэлж болох уу? хэмээгээд яллагч дахин Чотас руу харахад тэр нь ямар ч өөрчлөлтгүй хэвээр сууж байв.

-Үгүй, эрхэм ээ. Тэд муур нохой хоёроос долоон дор амьдарч байсан.

-Хэрэлдэх үед та дэргэд нь байсан уу?

-Яах ч аргагүй байгаагүй. Байшин хэдий том ч хаа сайгүй тэдний хэрүүл сонсогддог байсан.

-Үгээр хэрэлдсэн үү, эсвэл зодолдсон гэсэн үг үү? Бид үүнийг чинь хэрхэн ойлгох вэ? Ноён Савалас эхнэрээ зоддог байсан уу гэж би асуух гээд л байна л даа?

-Өө дандаа зодолдоно. Гэхдээ бүр эсрэгээр шүү. Эхнэр нь нөхрөө зоддог. Ноён Савалас нас дээр гарсан тул бие султай хүн байсан харин эхнэр нь жүжиглэн уйлж дуулна бас зодно. - Эхнэр нь нөхрөө зодож байхыг та харсан уу?

-Нэг бус удаа гэснээ Анастасия хүүхний сандал тийш баргар харцаар хялалзан харав.

-Хатагтай Ликоургос, ноён Саваласын үхдэг орой үйлчлэгч нараас хэн нь байшинд үлдсэн бэ?

-Хэн ч үлдээгүй.

Питер Демонидос гайхаж байгаагаа нуулгүй харуулан,

-Тэр том байшинд хэн ч үлдээгүй гэж та хэлэх гээд байна уу? арай ноён Саваласт шивэгчин, тогооч, ядахад бойдаа байгаагүй гэж үү? гэсэнд,

-Тэднээс хэн нь ч энд үлдээгүй гэж авгай давтан хэлэв.

Питер Демонидос баяр хөөрөө огтхон ч нуулгүй,

-Яагаад тэр вэ?

-Зарц шивэгчин байлгүй яах вэ. Гэвч тэр орой хатагтай тэднийг цөмийг гэрт нь явуулсан. Нөхөртөө оройн хоолыг нь өөрөө бэлдэж өгнө, түүнтэй дахин бал сараа тэмдэглэнэ гэж хэлж байсан гэхдээ сүүлийн хэдэн үгийг үзэн ядсан өнгөөр хэллээ.

-Тэгэхээр хатагтай Савалас бүгдийг хөөж явуулжээ гэсэнд энэ удаа ерөнхий шүүгч Чотасыг эсэргүүцэх байх хэмээн түүн рүү харцаа шилжүүлэв. Гэтэл өмгөөлөгч өөрийн бодолд автан суусаар байв.

Ерөнхий шүүгч яллагчид хандан,

-Санаа сэдсэн асуулт тавьж болохгүй гэж сануулав.

-Өршөөгөөрэй, эрхэм ерөнхий шүүгч ээ. Би асуултаа үргэлжлүүлье гээд хатагтай Ликоургросын зүг улам ойртон,

-Тэгэхээр тэр шөнө ... хатагтай Савалас нөхөртэйгөө хоюулахнаа үлдэхийн тулд бүх үйлчлэгчидээ явуулсан гэж та хэлж байна уу? гэвэл,

-Тиймээ, эрхэм ээ. Тэр хатгалгаа тусаад их хүнд байсан.

-Хатагтай Савалас нөхөртөө байнга хоол хийж өгдөг байсан уу?

-Тэр үү? Үгүй эрхэм ээ. Тэр гэртээ юу ч хийж үзээгүй.

Наполеон Чотас энэ бүгдийг ерийн нэг лекц сонсогч шиг чимээ гаргалгүй чагнасаар сууна.

-Танд гялайлаа, хатагтай Ликоургрос аа. Та бидэнд их туслалаа.

Питер Демонидос Чотас тийш харан баярлаж байгаагаа муухан нууж байв. Хатагтай Ликоургрос мэдүүлэг шүүгч нарт гүн сэтгэгдэл төрүүлж цаг мөч өнгөрөх тусам тэд хэрэгтэн рүү улам ёозгүй харц шидлэх болов. "Хөгшиний яахыг харнаа гайгүй" гэж бодоод яллагч,

-Гэрч таны мэдэлд очлоо гэж өмгөөлөгчид хэлэв.

Наполеон Чотас зовхио өргөн хараад,

-Та юу гэв ээ? Өө, надад асуулт алгаа гэлээ.

Ерөнхий шүүгч түүн рүү гайхан харж,

-Юу? Наполеон Чотас танд асууж тодруулах зүйл алга гэж үү? гэж асуусанд чотас босож,

-Алга эрхэм ээ. Гэвч энэ эмэгтэй надад үнэнч хүн шиг санагдлаа гэлээ.

Питер Демонидос ийм явдал болсонд огтхон ч итгэж өгсөнгүй. "Бурхан минү! Тэр эсэргүүцэхийг ч хичээхгүй байна. Хөгшин ч өнгөрчээ" гэж бодмогцоо бүр ялж орхисон мэт хөөрөн баясав.

Ерөнхий шүүгч яллагч руу харж,

-Дараачийн гэрчийг дуудаж болно гэв.

-Шүүхэд Жозеф Паппасыг гэрчээр дуудаж байна.

Өндөр гуалиг нуруутай аятайхан хар үстэй залуу танхимаас гарч ирээд гэрчийн суудалд суулаа. Тангараг өргөсөн хойно,

-Ноён паппас, та юу хийдгээ хэлнэ үү? гэж асуув.

-Жолооч хийдэг.

-Та одоо ажиллаж байгаа юу?

-Үгүй.

-Гэхдээ ноён Саваласыг үхэх хүртэл ажиллаж байж ээ? Сүүлчийн мөчийг хүртэл шүү дээ?

-Тэр үнэн.

-Та тэднийд хэр удаан ажиллаж байна?

-Жил жаахан илүү болж байна.

-Танд ажил чинь таалагддаг уу?

Залуу эр Чотас руу тусламж горилон харсан боловч цаадах нь чимээгүйхэн суусаар,

-Тэгэхээр танд таалагдаж байжээ дээ?

-Зүгээр гэж бодож байна.

-Та сайн хөлс авдаг байсан уу?

-Тийм ээ.

-Зүгээр ажил гэж хэлэхэд тэгэхээр багадаа нь ээ? Та хатагтай Саваласын ор дэрийг нь байнга хуваалцдаг байсан уу?

Жозеф Паппас дахиад л Чотас руу гуйсан янзтай харцаар харсан боловч тэр зүгээс тусламж ирсэнгүй.

-Би ... тиймээ, эрхэм ээ. Ерөнхийдөө тэгж хэлж болно.

Питер Демонидос зэвүүцэн,

-Та "тэгж хэлж болно" гэв үү? Та тангараг өргөсөн хүн. Тэр хүүхэнтэй дотно харьцаатай байсан уу эсвэл үгүй юу? Аль нь вэ тэгээд?

Паппас улайсан нүүрсэн дээр суусан мэт оцгононо.

-Бид амрагууд байсан.

-Та сайн хөлс өгдөг нөхөрт нь зүтгэдэг, бас гэрт нь толгой хоргоддог атлаа юу?

-Тиймээ, эрхэм ээ.

-Та тэгээд хоногийнхоо цалинг авахаар гар сунгахдаа тэр хооронд эхнэртэй нь унтаж байсан байж сэтгэл зовдоггүй юу?

-Унтах төдий холбоо байгаагүй юмаа гэвэл Питер Дымэонидос хавчилтаа улам чангалан,

-Холбоо байгаагүй гэдгээр юу хэлэх гээ вэ? Би таныг ойлгохгүй байна шүү.

-Бид ... гэс гэсэн юм. Анастасия бид хоёр гэрлэх санаатай байсан.

Танхимд байсан хүмүүс гайхан шивнэлдэнэ. Шүүгчид бүгд хэрэгтэн рүү нүдээ бүлтийлгэн харна.

-Гэрлэе гэсэн санааг та гаргасан уу, ноён Паппас?

-Үгүй, бид хоюулаа үүнийг хүссэн.

-Гэхдээ хэн эхэлж санаачилсан бэ?

-Тэр гээд залуу хэрэгтний сууж байгаа тийш харцаа шилжүүлэв. Хүүхэн нүдээ үл цавчин ширтэнэ.

-Шулуухан хэлэхэд ноён Паппас, та намайг төөрөгдүүлчихлээ. Та хоёр яаж гэрлэх юм бэ? Хатагтай Савалас нөхөртэй хүн. Та нар түүний насан эцэслэхийг хүлээх гээ юу, эсвэл золгүй явдал болоосой гэж хүсэж байв уу? Ер юу бодож байсан бэ?

Асуулт илтэд өдөөн хатгасан шинжтэй байсан тул шүүгчид нэгэн зэрэг Чотас руу харан эсэргүүцэхийг нь хүлээв. Өмгөөлөгч юу ч эс анзааран зүүрмэглэн сууна. Анастасия Савалас сандарч бачимдаж эхэллээ.

Яллагч гэрчийг улам яаруулан,

-Та миний асуултанд хариулсангүй шүү, ноё Паппас гэсэнд жолооч,

-Тодорхой юу ч хэлж чадахгүй нь, эрхэм ээ гэлээ.

Питер Демонидос чанга дуугаар,

-Тэгвэл би танд тодорхой хэлээд өгье. Хатагтай Савалас нөхрийгөө алах замаар түүнээс хагасчаар шийджээ. Хэрэв гэрлэлтээ цуцлуулбал тэр эд хөрөнгөгүй хоцорхоос айсан. Тэр ...

-Эсэргүүцэж байна! гэж хашгирсан хүн нь Наполеон Чотас биш харин ерөнхий шүүгч байсан бөгөөд тэр,

-Та гэрчээс таамаглал гаргуулах гээд байна гэснээ өмгөөлөгчийг дуугуй байгаад нь гайхан харвал тэрээр нүдээ хагас аниад сууж харагдлаа.

-Хүлцэл өчье, эрхэм ерөнхий шүүгчээ гээд зорилгоо биелүүлсэн яллагч өмгөөлөгчид хандан,

-Гэрч таны мэдэлд очлоо гэлээ.

Наполеон Чотас босоод,

-Танд талархая, ноён Демонидос. Надад асуух зүйл алга гэв.

Гурван шүүгч гурвуул түүн рүү үл итгэсэн янзтай харлаа. Тэдний нэг нь,

-Ноён Чотас, энэ гэрчийг байцаах нь таны сүүлийн боломж гэж та бодохгүй байна ууМ гэж асуулаа.

Чотас толгой дохин,

-Тиймээ, эрхэм ээ гэлээ.

-Түүний мэдүүлэгтэй холбогдуулан асуух зүйл танд алга уу?

-Алга, эрхэм ээ.

-Сайн байна. Яллагч дараачийн гэрчийг дуудаж болно.

Дараачийн гэрч нь жар гаруй насы Михалис ХариТонидес гэдэг тарган өвгөн байлаа.

Түүнийг тангараг өргөсөн хойно яллагчх,

-Та юу хийдгээ шүүхэд хэлж өгнө үү? гэж хэлэв.

-Би зочид буудлын зохицуулагч, эрхэм ээ.

-Зочид буудлын нэр?

-"Аргос"

-Хаана байрладаг юм бэ?

-Корфед.

-Энэ тасалгаан дотор байгаа хүмүүсээс танай буудалд байрлаж байсан хүн байна уу гэдгийг асуумаар байна.

ХариТонидес эргэн тойрноо хараад,

-Тиймээ, эрхэм ээ. энэ хоёр байна гэлээ.

-Гэрчийн этгээд, Жозеф Паппас, Анастасия савалас хоёрыг заасныг протоколд бичээрэй гэж яллагч цаашаа хандан хэлээд гэрчид хандан:

-Нэг бус удаа танайд өрөө авсан уу? гэв.

-Тиймээ, эрхэм ээ. Дор хаяж тав зургаан удаа.

-Шөнөжингөө нэг өрөөнд хонодог байсан уу?

-Тиймээ, тэд голдуу амралтын өдөр ирдэг байсан.

-Баярлалаа, ноён ХариТонидес гээд Чотас руу харан:

-Гэрч таны мэдэлд очлоо гэлээ.

-Асуулт алга.

Шүүгч нар Чотас тийш гайхан харж хэдэн хором шивнэлдээд өнгөрөв.

-Танд энэ гэрчээс ауух зүйл алга уу, эрхэм ээ?

-Байхгүй эрхэм ээ. Би түүний мэдүүлэгт итгэж байна. Түүний зочид буудал их аятайхан. гэхдээ би өөрөө тэнд нэг ч хоног үзээгүй.

-Дараачийн гэрчийг дуудаж болно.

-Вассилис Франжесосыг шүүхэд дуудаж байна.

Нүдэнд дулаахан өндөр эрэгтэй гэрчийн байранд ирж тангараг өргөв.

-Доктор Франжесосо эмч ээ, та аль салбарт ажилладаг вэ?

-Би дотрын эмч.

-Энэ нь гэрийн эмч гэж хэлж болох уу,

-Тэгж болно.

-Та эмч хийсээр хэдэн жил болж байна?

-Гучаад жил болж байна.

-Франжесос эмч ээ, Жорж Савалас таны өвчтөн байсан уу?

-Тийм ээ.

.Хэр удаан таны өвчтөн байсан?

-Бараг арваад жил.

-Та ноён Саваласын ямар өвчнийг эмчилж байсан бэ?

-Анхны удаа түүний даралт ихэссэн.

-Та тэгээд эмчилсэн үү?

-Тиймээ.

-Тэгээд тэр дахин тан дээр очсон уу?

-Тиймээ, үе үе бронхит нь хөдлөх юм уу эсвэл элэг нь өвдөхөөр ирдэг байсан-Гэхдээ ноцтой юм байгаагүй.

-Та ноён Саваластай сүүлчийн удаа хэзээ уулзсан бэ?

-Өнгөрсөн жилийн 12 сард.

-Үхэхийн өмнөхөн үү?

-Тиймээ.

-Тэр тан дээр үзүүлэхээр ирсэн үү?

-Үгүй. Би гэрт нь очсон.

-Та өвчтөнүүдээ гэрт нь очиж эргэдэг юм уу?

-Уг нь бол үгүй л дээ.

-Энэ удаад та гэрт нь очжээ дээ?

-Тиймээ.

-Яагаад?

-Тэр над дээр ирэх боломжгүй байсан гэж эргэлзэнгүй хэлэв.

-Тэр ямар байдалтай басайн хэрэг вэ?

-Тэр хөхөрч шалбарсан, урагдаж зүсэгдсэн, тархи нь доргисон байсан.

-Яасан юм бол? золгүй явдал болоо юм болов уу?

-Үгүй ээ, эхнэр нь түүнийг зодсон гэж тэр надад хэлсэн гэж эмч эргэлзэнгүй хэллээ.

Тэнд байгсад гайхсандаа амаа ангайв.

Ерөнхий шүүгч ууртайгаар,

-Сонссон дуулсан хов живээ гэрчийн мэдүүлгийн чанартайгаар ашиглахыг та ер эсэргүүцэхгүй гэж ээ, ноён Чотас?

Наполеон Чотас ымаар ч сонирхолгүйгээр толгой өргөн,

-Өө, баярлалаа, эрхэм ээ. Би эсэргүүцэлгүй яахав, эсэргүүцэж байна гэсэн боловч байдал одоо нилээд ноцтой болжээ. Шүүгчид одоо хэрэгтэн бүсгүй рүү илтэд дайсагнасан харцаар ширтэх болов.

-Баярлалаа, ноён Чотас. Надад өөр хэлэх зүйл алга гэсэнд яллагч Чотас руу харж хорсолтойгоор,

-Гэрч таны мэдэлд шилжлээ гэв.

-Надад асуулт алгаа.

Ингээд л баахан гэрч нар ар араасаа цувралдсаны дотор жолоочийг хатагтай Саваластай унтлагын өрөө рүү явж байхыг олон удаа харсан гэх шивэгчин, ноён Савалас эхнэрээсээ сална, өв хөрөнгө үлдээхгүй гэж заналхийлэн загнаж байхыг сонссон гэж мэдүүлсэн бойдаа ... эхнэр нөхөр хоёрын хэрүүлийг сонссон гэж мэдүүлсэн хөрш айлынхан байлаа.

Наполено Чотас нэг ч гэрчид нэг ч асуулт тавьсангүй. Байдал Анастасия Саваласын хувьд удам тусам муудсаар ...

Питер Демонидосын ялалт улам тодорхой болж тэр өөрийн зургийг маргаашийн сонины эхний нүүрэнд томоос томо нийтлэгдсэн байгаагаар аль хэдийнээ төсөөлж эхэлсэн байлаа. Энэ бол хүн амины хэргийн түүхэнд хамгийн хурдан шийдэгдсэн хэрэг болно. Бараг өнөөдөр л шүүхийн тогтоол гарж "аугаа Наполеон Чотас ялагдлаа хүлээх болно".

-Гэрч Нико Ментакисыг дуудаж байна.

Ментакис гэгч залуу хатингар эр мэдүүлэг өгөхөд бэлэн болов. Тэр тун болгоомжтой бас яраалгүй ярина.

-Та хаана ажилладагаа шүүхийн өмнө хэлж өгөхсөн болов уу?

-Тэгье, эрхэм ээ. Би хүлэмжинд ажилладаг.

-Та адуу малладаг гэсэн үг үү?

-Яалаа гэж, эрхэм ээ. Энэ бол мод цэцэг ер нь төрөл бүрийн ургамал тарьдаг хүлэмж л дээ.

-Аа ойлгомжтой. Тэгэхээр та ургамлын мэргэжилтэн юмаа даа?

-Мэргэжилтэн л байх гэж найдаж байна шүү. Би аль эртнээс үүнийг эрхэлсэн.

-Худалдаанд гаргах ёстой ургамал цэцэг эрүүл байхыг та хариуцах ёстой юу?

-Тэгэлгүй яахав, эрхэм ээ. Би түүнийг сайн гүйцэтгэдэг. Өвчилсөн ургамал үйлчлүүлэгчиддээ хэзээ ч худалддаггүй шүү. Бид голдуу байнгын худалдан авагчидтай л даа.

-Үйлчлүүлэгчид тан дээр дахин дахин эргэж ирдэг гэж та хэлэх гээд байна уу?

-Тиймээ, эрхэм ээ. Бид сайн үйлчилдэг болохоор гэх түүний дуунд бахархасан өнгө илт.

-Хатагтай Савалас таны худалдан авагч байсан уу?

-Байсан, эрхэм ээ. Тэр цэцэгт үнэхээр дуртай хүн.

Ерөнхий шөөгч яриаг таслан,

-Ноён Демонидос, энэ асуутлууд хэрэгт огт хамаагүй гэж шүүгч тооцож байна. Өөр сэдвээр ярилцах эсвэл ...

-Хэрэв шүүгч намайг асуултуудаа дуусгахыг зөвшөөрвөл та энэ бүхэн нь хичнээн чухал болохыг ойлгох болно.

Ерөнхий шүүгч өмгөөлөгчид хандан,

-Хэрэв өмгөөлөгч эсэргүүцэхгүй бол болох л юм гэв.

-Та юу гэв ээ? Өө, би огт татгалзахгүй байна гэж Чотас хэлэв.

Ерөнхий шүүгч түүн рүү үл ойлгосон янзтай хараад яллагчид хандан,

-Үргэлжлүүлж болно гэлээ.

-Ноён Метакис, 12 дугаар сард хатагтай Савалас тан дээр ирээд түүний зарим ургамалд хэцүү явдал гараад байна гэж хэлсэн гэдэг үнэн үү?

-Тиймээ, тэр надад тэгж хэлсэн.

-Түүний ургамлууд шавьжинд идэгдээд байна гэж тэр хэлсэн үү?

-Тиймээ.

-Тэгээд шавьж устгаж өгөхийг хүссэн үү?

-Тиймээ, эрхэм ээ.

-Та түүнд юу өгсөн бэ?

-Би түүнд жаахан сурьма худалдаж авахыг зөвлөсөн.

-Энэ чинь чухам юу болохыг та хэлээд өгөхгүй юу?

-Хор уым л даа. Мышякийн төрлийн хор.

Танхимд шуугиад явчихлаа.

Ерөнхий шүүгч алхаар нүдэн чимээ намтган,

-Дахиад шуугих юм бол би танхимыг чөлөөлөх тушаал өгнө шүү гээд яллагчид хандан,

-Үргэлжлүүлж болно гэв.

-Та түүнд сурьма худалдсан байх нь ээ?

-Тиймээ, эрхэм ээ.

-Энэ бол үхлийн хор гэж та хэлээгүй юу? Та түүнийг мышяктай зүйрлэсэн байх аа?

-Тиймээ. Энэ үнэхээр үхлийн хор.

-Та хуулинд заасан ёсоор үүнийг худалдсан тухайгаа бүртгүүлсэн үү?

-Тэгсэн, эрхэм ээ.

-Та түүнийгээ авчирсан уу, ноён Метакис?

-Авчирсан гээд тэр яллагчид дэвтэр сарвайлаа.

Яллагч шүүгчид ойртон очиж,

-Эрхэмүүдээ, энэ зүйлийг эд мөрийн баримтаар авч үзэхийг би хүсэж байна гэснээ гэрчид хандан,

-Надад өөр асуулт алга гэлээ.

Тэгээд Чотас руу харахад тэр толгой сэгсэрч,

-Надад асуулт алга гэв.

Демонидос санаа алдаад гол асуудалдаа орж,

-Би "Б" эд мөрийн баримт авчруулахыг хүсэж байна. Түүнийг авчирна уу гэж гүйцэтгэгчид хандан хүслээ.

Гүйцэтгэгч яаран гарч яваад хэдхэн хоромын дараа ханиадны усан эм бүхий шилтэй тавиур барин орж ирлээ. Эм шилний дундаас арай дэгүүр байгаа нь харагдана. Танхимд байгсад цөм амьсгаа даран сууж гүйцэтгэгч шилтэй шингэнийг яллагчид өгөхийг анхааралтай ажиглана. Демонидос түүнийг шүүгчдийн өмнөх ширээн дээр тавиад,

-Ноёд хатагтай нар аа. Та бүхний өмнө алуурчингийн хэрэглэсэн зэвсэг тавиастай байна. Жорж Саваласын амийг чухам үүгээр л хөнөөжээ. Энэ бол хатагтай Саваласын тэр шөнө нөхөртөө уулгаж амийг нь хөнөөсөн тэрхүү шингэн юм. Үүнд сурьма ихээр агуулагдаж байгаа бөгөөд та бүхний сайн мэдэж байгаагаар хохирогч үүнэс жаахан балгаад хорин минутын дараа амьсгал хураасан билээ гэж тод дуугаар өгүүлэв.

Наполеон Чотас суудлаасаа босоод чанга бус дуугаар,

-Эсэргүүцэж байна. Энэ шилтэйгээс нөхөртөө уулгасан гэх ямар ч баталгаа алга гэж хэлэв.

-Эрхэм хүндэт эрдэмтдийн коллегийн нөхдөд талархал илэрхийлэхийн ялдамд би миссис Савалас нөхрийгөө хүчтэй ханиалгаж эхлэхэд намдаахаар яг энэ шилтэйгээс өгсөн гэж өөрөө мэдэгдсэнийг тэмдэглэн хэлмээр байна. Шилтэй шингэнийг энэ шүүхийн танхимд авчрах хүртэл цагдаагийн газрын хатуу хяналтын дор цоожтой шүүгээнд хадгалж байсан болно. Задлангийн эмч нар Жорж Саваласыг сурьмагаар хордож үхсэн байна гэж нотолсон. Харин энэ шилэн дотор сурьма ихээр агуулагдаж байгаа юм гээд Чотас руу өдсөн янзтай харав.

Наполеон Чотас толгой сэгсрэн гайхаж байгаагаа илэрхийлээд,

-Тийм бол эргэлзэх зүйл алга гэж хэлэв.

Питер Демонидос баяртайгаар,

-Тэгэлгүй дээ. Танд баярлалаа, ноён Чотас. Байцаалт дууслаа гэсэнд ерөнхий шүүгч өмгөөлөгчид хандан,

-Эцсийн дүгнэлт гаргахын өмнө өмгөөлөлд бэлэн үү? гэж асуухад,

Наполеон Чотас суудлаасаа босож,

-Тиймээ эрхэм ээ гэлээ.

Тэгээд тэр удаан чимээгүй зогсов. Дараа нь шийдмэг бусаар шүүгчдийн зүг хэд алхаснаа хэлэх гэсэн үгээ мартаж орхисон мэт сэтгэгдэл төрүүлснээ дараа нь үгээ нарийн сонгон аажуухан ярьж эхэллээ.

-Намайг гэрчүүдэд эсэргүүцэх асуулт тавиагүйд та нарын олонх нь гайхаж байх шиг

харагдсан. Чин үнэнийг хэлэхэд ноён Демонидос сайн ажиллажээ. Иймээс ч надад тодруулан асуух зүйл байгаагүй юм.

"Хөгшин зөнөг минь, чи одоо миний талд орохоос өөр яах юм бэ" гэж Питер Демонидос дотроо тавлан суув.

Чотас шингэнийг харснаа шүүгчдэд хандан,

-Гэрчүүд цөм шударга хүмүүс шиг надад санагдсан. Гэхдээ үнэн хэрэгтээ тэд юуг ч баталж чадаагүй, тийм биз? Би юу хэлэх гээд байна вэ гэвэл ... гээд толгой сэгсрэн,

-Эдгээр хүмүүсийн ярьсаныг нэгтгэж үзвэл ямархуу дүр зураг харагдахыг бодсон юм л даа. Залуу сайхан хүүхэн түүний сэтгэл хүсэл бодолд тохироогүй хөгшин хүнтэй суужээ гээд Жозеф Паппас руу дохиж,

-Тэгээд л бүсгүй өөрийн санаанд бүрнээ нийцэх залхуу хүнийг олж авсан байна. Гэхдээ бид энэ бүхний тухай хэвлэлээс бишгүйдээ л уншсан биздээ? Энэ дурлалын түүх одоо бүгдэд ил болсон ба ноёд хатагтай бидний хэн маань ч бүсгүйн явдалыг сайшаан үзэхгүй байгаа нь мэдээж. Гэхдээ түүнийг өнөөдөр нөхрөө хуурлаа гэсэн хэргээр бус, залуу эмэгтэйн зайлшгүй зүй ёсны шаардлагаас урган гарсан явдлыг шүүж байгаа бус харин хүн амины хэрэгт тулгагдаад байгааг та бүхэнд дахин сануулъя.

Тэрээр дахиад л сингэн рүү хараа нь татагдаад болж өгөхгүй байх мэт.

"Хөгшин ингэлээ гээд юу ч олж долоохгүй" гэж Питер Демонидос сэтгэлээ хууран сууна. Тэгээд танхимын хананд өлгөсөн цагруу харвал арван хоёрт таван минут дугуу байв. "Яг 12 цагт шүүх хурал завсарлах болно. Хөгшин тэгэхээр яриагаа дуусгаж амжихгүй. Завсарлагааны талаар бодох ч ухаан түүнд алга. Би ер нь түүнээс юунд тэгтлээ айдаг байсан юм болоо?" гэж даапаалах сэтгэл төрлөө.

Энэ үед Чотас аман дотроо учир холбогдолгүй бөвтнөсөөр,

-Гэрчүүдийн мэдүүлгийг дахин авч үзье л дээ. Хатагтай Саваласын ургамал цэцэг өвчилжээ. Хатагтай ноён Ментакист хандан тусламж гуйсанд Ментакис түүнд сурьма хэмээх бодис худалдаж авахыг зөвлөж бүсгүй ч түүний зөвлөгөөг дагасан байна. Та нар үүнийг аллага гэж нэрлэж байгаа юм уу? Жишээ нь би л лав үүний төлөө бүсгүйг буруутгаж чадахгүй. Аа тийм, няравын мэдүүлэгт хатагтай Савалас нөхрийгөө баярлуулахаар оройн зоог бэлтгэж өгөхөөр бүх үйлчлэгчидээ явуулсан гэж байгаа. Харин надад бол нярав авгай ноён Саваласт өөрөө дурласан байсан шиг санагдлаа. Хэрэв хэн нэгэн хүнд гүнзгий сэтгэлтэй бишсэн бол та бидний хэн маань ч нэг хүнд хорин таван жилийн турш ажиллаж яаж чадах вэ дээ. Харин эхнэр Анастасия Саваласт бол нярав дургүй. Үүнийг та бүхэн түүний дуу хоолойн өнгөнөөс л ойлгож болно гээд Чотас зөөлөн ханиалган хоолойгоо засав. Тэгээд үргэлжлүүлэн:

-Хатагтай сэтгэлийнхээ гүнд нөхөртөө хайртай хэвээр байсан гэж бодоод үз л дээ. Тэр хайр дурлалаа эртхэн хожимдоогүй дээр нь аврахыг хүссэн бол яах юм бэ? Сэтгэлтэй гэдгээ эмэгтэй хүн эрэгтэй хүнд яаж илэрхийлэх вэ? Миний бодлоор бол түүндээ сайхан хоол хийж

өгөх л хамгийн шилдэг арга байх. Би л хувьдаа тэгж бодож байна ... гээд шилтэй шингэнийг ажиглаж эхлэв.

-Аа тийм, бас нэг арга бол өвчтэй зовлонтой үед нь асарч тойлох явдал юм.

Ханын цаг 12-т нэг минут дутуу байгааг заалаа.

-Ноёд хатагтай нараа, би шүүх хурлын эхэнд та бүхнээс хэрэгтний нүүр царайг харахыг хүссэн. Тэгвэл ийм царайтай, ийм нүдтэй эмэгтэй хүн алж чадахгүй.

Питер Демонидос хэрэгтнийг ажиж байгаа шүүгчдийн зүг харлаа. Урьд хожимд ингэтлээ үзэн ядсан царайг тэр харж яваагүй учраас шүүгчид ыөм өөрийнх нь талд байгааг ойлгов.

-Хууль бол бүхэнд ил тод билээ, ноёд хатагтай нараа. Эрхэм шүүгч нарт хэрэгтний буруутайг нотлох ганц ч нотолгоо байхгүй байхад ялын тогтоол гаргаж болохгүй. Ганц ч нотолгоо алга.

Тэгээд Чотас дахин ханиалгаснаа халааснаасаа алчуур гарган амаа таглав. Дараа нь шилтэй шингэн тавиастай байсан ширээ рүү ойртон очиж,

-Яллагч үнэн хэрэгтээ юуг ч нотлоогүй шүү дээ. Үүнээс гадна хатагтай Савалас энэ шилтэйгээс нөхөртөө өгсөн. Буруутгаад байх юм огтоос алга байна шүү дээ гэлээ.

Үгийнхээ төгсгөлд тэр дахиад л ханиалгаж эхлээд өөрийн мэдэлгүй шилтэй рүү гараа сунган уруулдаа авчраад том гэгч балгаж орхих нь тэр. Танхимд байгсад илбэдүүлсэн мэт нэгэн зэрэг дуу алдаад бүлтийн ширтэцгээв.

Хормын дараа танхим аймшигт орилооноор нүргэллээ.

Ерөнхий шүүгч сандран,

-Ноён Чотас аа? та ... гэхийн амжилгүй өмгөөлөгч шилтэйгээс дахин нэг балгаж орхив.

-Эрхэм шүүгчээ, үнэний төлөө яллагч юу ч хийж чадсангүй. Жорж Савалас энэ хүүхний гарт үрэгдээгүй. Өмгөөлөл дуусч хэргийг таны мэдэлд шилжүүллээ.

Цаг үд дунд болсныг заан дуугарлаа. Шүүгч бүрэлдэхүүн хурдхан босож ерөнхий шүүгчид яаран зөвлөлдсөнөө ерөнхий шүүгч алхаар нүдэн байж,

-Би журам сахиулахыг шаардаж байна. Завсарлагаа зарлалаа. Шүүгчид шийдвэр гаргахаар явцгаана. Хоёр цагт дахин хурлаа эхэлнэ гэлээ.

Гайхан балмагдсан Питер Демонидос байрнаасаа хөдөлж ч чадсангүй. Хэн нэг хүн шилтэй шингэнийг сольж орхисон хэрэг үү? Үгүй ээ, энэ боломжгүй зүйл. Эд мөрийн баримтыг найдвартай хадгалж байсан. Задлан шинжээчид тэгтлээ андуурсан байж болно гэж үү? Демонидос туслагч руугаа эргэн харж, нүдээрээ Наполеон Чотасыг эрсэн боловч олсонгүй.

Хоёр цагт шүүх бүрэлдэхүүн дахин цуглаж яаралгүйхэн суудлаа эзэллээ. Наполеон Чотас

танхимд харагдсангүй.

"Муу нохойн хүүн үхчихжээ" гэж Питер Демонидосын бодож дуусаагүй шахам байхад Наполеон Чотас шүүхийн танхимд цоо эрүүл саруул цовоо цалгиун янзтай орж ирэх нь тэр. Танхимд цугларагсад түүнийг байрандаа очиж суутал гайхан харцгаана. Ерөнхий шүүгч босож,

-Ноёд хатагтай нар аа, шүүгчдийн бүрэлдэхүүнээс ямар шийдвэр гаргасан болохыг асууж байна гэсэнд шүүгчдийн ахлагч босон,

-Эрхэ шүүгчээ, бид сэжигтэн буруугүй гэсэн шийдвэр гаргалаа гэж мэдэгдсэнд тэнд байгсад цөм алга нижигнүүлэн тагшлаа.

Питер Демонидос нүүр рүү нь цус гүйхийг мэдэрч "Энэ новш ахиад л намайг чадчихлаа" гэсэн бодол тархинд нь харван орохыг мэдэв. Тэгээд тэрээр толгойгоо өндийлгөн харвал Наполеон Чотас түүний зүг шоолсон янзтай мушилзаж харагдлаа.

Наймдугаар хэсэг

"Тритсис ба Тритсис" нь Грекийн хамгийн нэр хүндтэй хууль зүйн фирмийн нэг гэдэг нь эргэлзээгүй юм. Анх байгуулагчид нь аль хэдийн тэтгэвэртээ гарцгааж одоо захирлаар нь Наполеон Чотас ажиллаж байгаа юм. Фирмд хэдэн арван хамтран зүтгэгчид санаа нэгдэн ажилладаг хэдий ч гол тархи нь яалт ч үгүй Чотас мөн билээ. Хэцүүхэн хэрэгт орооцолдсон баян мөнгөтэй хүмүүс юуны түрүүнд Чотасыг санадаг юм. Жилийн жилд дээд хэмжээ заагдсан хүмүүсийг өмгөөлсөөр тэр хязгааргүй алдар нэр амжилтанд хүрч нэгэнт чаджээ. Саяхан болсон Анастасия Саваласын хэргийг өмгөөлсөн тухай сонин хэвлэлээр бишгүй шуугиж, гайхалтай аргаар чадварлаг өмгөөлөн гарсан билээ. Тэр хүн сүүлчийн аргаа шавхан амь дүйж баймааж нь амжилтанд хүрч чаддаг нэгэн. Шилтэй шингэнээс балгах үед шүүгчдийн яриагаа царай ямар болсныг санахаас инээд хүрмээр. өмгөөлсөн яриагаа үд дунд гэхэд дуусгахаар төлөвлөсөн нь бас гайхалтай тооцойтойнх. "Хэрэв шүүгч нар шүүх ажиллагааны дэс дарааг өөрчилсөн бол ... эсвэл намайг 12 цагт миний өмгөөллийг тасалдуулсан бол ..."

Ингэж бодохоос ч аймаар!

Түүнээс гадна түүний урьдчилан төлөвлөөгүй зүйл учирсан нь бараг л амь настай дүйх шахжээ. Юу гэвэл завсарлагааны дараа түүнийг хонгилоор алхаж явгал сурвалжлагчид бүчин авч тал талаас нь идэх шахам,

-Ноён Чотас, та шингэнд хор байхгүйг хаанаас яаж мэдсэн бэ? Юу гэж тайлбарлах вэ?

-Хэн нэгэн шилтэйг сольсон уу?

-Өршөөгөөрэй, ноёд хатагтай нар аа, и байгалийн жамыг дагахаас болохгүй нь. Та бүхний асуултанд дараа нь хариулья.

Тэр гудмын төгсгөл дэх жорлон руу яаран очвол хаалган дээр нь "засвартай" гэсэн бичиг өлгөөстэй байлаа.

Нэг сэтгүүлч түүний байдлыг ажиж мэдээд,

-Танд өөр бие засах газар хайх хэрэг гарах нь дээ гэсэнд Наполеон Чотас,

-Тэсэхгүй болов уу эж айж байна гэж инээмсэглээд хариулав.

Тэрээр хаалга онгойлгон орж түгжтэл тэнд түүнийг бүхэл бүтэн бригад хүлээж байв. Эмч халаглан,

-Би бүр сандарч орхилоо. Ходоод угаахад бэлд хэмээн туслахдаа хашгиран хэллээ.

-Шалан дээр хэвтэнэ үү. Энэ эмчилгээ танд эвтэйхэн байхгүй л болов уу гэсэнд,

-Үүнээс өөр арга үгүй болохоор надад тэвчихээс өөр арга даанч алга гэж Чотас инээмсэглэн

хариуллаа.

Анастасия Саваласын амь насыг аварснаараа Наполеон Чотас нэг сая доллар Швейцарийн банкин дахь өөрийн дансанд оруулж авсан юм. Чотас Афин хотын үзэсгэлэнт дүүрэгт Колонарайд том байртай, Корфа арал дээр шилтгээнтэй. Парис дахь баячуудын дүүрэгт бас сууцтай болов.

Товчоор хэлбэл Наполеон Чотаст амьдралын баяр баясгалантай байх бүх бололцоо бий. Гагцхүү нэг л бяцхан толбо сэтгэлийн гүнд харлаад байх нь шаналгаатай ...

Түүнийг Фредерик Ставрос гэдэг байлаа. Тэр "Тритсис ба Тритсис? фирмд шинэхэн ирсэн ажилтан байв.

-Наполеон минь, тэр чинь ердөө хоёрдугаар зэргийн амьтан. Манай пүүсэд түүнд багтах зай байхгүй.

-Ставрос миний ажлыг золтой л баллаад хаяж орхисонгүй. Тэр зүгээр л тэнэг амьтан юм.

-Өчигдөр Ставрос шүүх хурал дээр яасныг сонссон уу? Шүүгч түүнийг золтой л өшиглөөд гаргачихаагүй.

-Чөтгөр аваг Чи яагаад энэ тэнэг Ставросыг байлгаад байгаа юм бэ? тэр чинь эсгий хийх газар нохой хэрэггүй гэгчээр энд хэрэг алга. Тэр бидний нэр хүндийг баллаж байна.

Энэ үнэн гэдгийг Наполеон Чотас хэнээс ч илүү мэдэж байлаа. Гэтэл "Би түүнийг хөөж явуулж чадахгүй" гэж хэлэхийн оронд "Түүнд боломж олгоё л доо. Тэр амжилт гаргах ч юм билүү" гэж хэлжээ.

Гүн ухааны нэгэн сургаалд: "Өөрийн хүсэл мөрөөдөлд болгоомжтой ханд. Гэнэт тэр бүхэн биелж орхих вий" гэж айлдсан байдаг. "Тритсис ба Тритсис" фирмийн бяцхан гишүүн Ставросын хамаг хүсэл мөрөөдөл нуран унаж, тэрээр энэ хорвоогийн хамгийн зол жаргалгүй хүн болон хувирчээ. тэрээр идэж ууж, бүр унтаж ч чадахаа больж их ч туржээ.

-Фредерик, чи эмч дээр очиж үзүүлээч дээ. Харахаас аймаар юм гэж эхнэр нь үглэнэ.

-За үгүй дээ. Юу ч нэмэр болохгүй ...

Түүнд тохиолдоод байгаа азгүй явдалд ямар ч эмчийн туслалцаа ашиг болохгүй гэдгийг сайн мэдэж байжээ. Дотроо бодож сэтгэлээр шаналах явдал түүнийг амьдаар нь шатааж байлаа.

Уг нь Фредерик Ставрос тодорхой хүсэл зорилготой жинхэнэ идеалист үзэлтэй залуу байсан билээ. Тэрээр хэдэн жилийн турш Афины нэгэн ядуулаг дүүргийн тохьгүй хавчиг өрөөнд суун хөрөнгө чинээ багатай үйлчлүүлэгчдэд бараг үнэ хөлсгүй шахам ажиллаж байжээ. Наполеон Чотастай учирсан явдал түүний амьдарлыг тэр чигээр нь өөрчилсөн юм.

Жилийн өмнө Ставрос өөрийн эхнэрийг Ноэльль Пейжтэй хамтран бүрэлгэсэн хэрэгт тулгагдсан Ларри Дугласын хэргийг өмгөөлж харин Чотасыг аугаа хүчит Константин

Демирис нууц амраг асан хүүхнээ өмгөөлүүлэхээр хөлсөлж авсан байлаа. Эхнээсээ л Ставрос өмгөөллийг ганц Чотасын гарт шилжүүлэхдээ дуртай байсан билээ. Алдартай өмгөөлөгчөөс сүрдсэн хэрэг.

-Чи шүүх хурал дээр харсан ч болоосой. Гайхамшигтай. Надад тэдний фирмд ажиллах заяа байдаггүй л байх даа гэж эхнэртээ тэр хэлсэн аж.

Гэтэл хэрэг явдал төгсгөлдөө шал эсрэгээр эргэжээ. Наполеон Чотас Ноэль Пейж, Ларри Дуглас, Гредерик Ставрос гурвыг инээж байгаад түлхэж орхижээ. Тэр түүнд хэлэхдээ,

-Би шүүгчидтэй дөнгөж сая зөвлөлдөөд ирлээ. Хэрвээ тэд хэргээ хүлээх юм бол тэдэнд таван жилийн хорих ял өгнө, үүнээс дөрвөн жил нь тэнсэн байх юм гэнэ. Ингэхээр үнэн чанартаа хагас жилээс илүү суухгүй гэсэн үг гээд Ларри руу харж,

-Ларри, та америк хүн учраас таныг энэ нутгаас хөөн гаргаж Грект эргэж ирэхийг хориглоно гэжээ.

Ноэль Пейж, Ларри Дуглас хоёр түүни ямар ч зөвлөгөөг дагахад бэлэн байлаа. Арван таван минутын дараа ерөнхий шүүгч,

-Грекийн шүүх хэрэгтэн уг хэргийг хийгээгүй гэж өчүүхэн төдий л эргэлзээ байвал ялын дээд хэмжээ хэзээ ч өгж байгаагүй. Би болон миний хамтран зүтгэгчид шүүх ажиллагааны явцад яллагдагч хоёрыг буруутай гэдгээ хүлээхэд ихэд гайхсан билээ. Одоо ингээд Ноэль Пейж, Ларри Дуглас хоёрын хурлын төлөвлөгөөг сонсгоё. "Буудан алж цаазалсугай". Ялын гүйцэтгэлийг өнөөдрийг оруулаад арав хоногийн дотор гүйцэтгэсүгэй гэж зарласан юм.

Яг энэ үед л Наполеон Чотас хөөрхий хоёрыг ичгүүр үгүйгээр мэхлэж занганд оруулсныг Ставрос сайн ойлгожээ. Константин Демирис нууц амрагаа аврахын тулд Чотасыг хөлслөөгүй харин тэдэнд алах ял заалгах гэсэндээ л тэр, тэгээд ч Ставрос энэ зальт аргаа хэрэгжүүлэхэд нь Чотаст тусласнаа ойлгож байлаа. Өөрийгөө хуурсан эмэгтэйтэйгээ Демирис ийм аргаар өшөөгөө авчээ. "Би энэ явдлыг хүлцэн өнгөрөөж чадахгүй. Ерөнхий шүүгчид мэдүүлж алах ялыг өөрчлүүлье" гэж Ставрос дотроо бодсон байлаа.

Тэр үед Чотас Ставрос дээр хүрч ирээд: "Хэрэв та маргааш завтай бол хамтдаа хооллож болохгүй гэж үү? Би таныг өөрийнхөө хамтран зүтгэгчидтэй танилцуулмаар байна ..." гэж урьсан юм.

Дөрвөн долоо хоногийн дараагаар ставрос "Тритсис бас Тритсис" алдарт фирмийн бүрэн эрхт гишүүн болсон байлаа. Түүнд том өрөө өгч өндөр цалин олгодог болов. Ингэж өөрийн зүрх сэтгэлээ муу зүгийн шуламд худалдаж орхих нь тэр ээ. Гэвч түүнд энэ хэлцлийнхээ болзлыг биелүүлэх нь дэндүү хэцүү байв. Цаашид ингэж байж чадахгүй. Өөрийгөө буруутган зүхэж бас энэ байдлаасаа салж огт чадахгүй. "Би алуурчин" гэж байнга бодсоор байна. Тэрээр энэ бодолтойгоо удаан хугацааны турш тэмцэний эцэст шийдвэр гаргасан юмсанжээ. Нэгэн өглөө тэр Наполеон Чотасын өрөөнд орж:

-Леон .. гэхэд.

-Бурхан минь, чи үнэхээр аймаар харагдаж байна. Хөгшин минь, чи яагаад амардаггүй юм бэ? Фредерик, чамд л хэрэгтэй шүү дээ хэмээн Чотас дуу алдав.

Гэвч амрах төдийгөөр түүний байдлыг шийдэж орхихгүй гэдгийг мэдэж байлаа.

-Леон, миний төлөө хийсэн болгоны чинь төлөө баярлаж явдаг боловч цаашид энд үлдэж чадахгүй нь ээ.

Чотас түүн тийш гайхан харж,

-Чи чинь юугаа яриад байнаа? Бүх юм сайхан болноо шүү, харж л байгаарай гэхэд,

-За үгүй дээ ... Би ... Би бүр зовж гүйцлээ.

-Зовж гэнэ ий? Чамайг юу ингэглээ зовоогоод байгааг ойлгохгүй юм гэхэд Фредерик Ставрос түүн рүү үл итгэсэн янзтай хараад,

-Яаж ... яаж та бид хоёр нийлж Ноэлль Пейж, Ларри Дуглас хоёрыг өмгөөллөө дөө? Та ... та өөрийгөө буруутай гэж бодохгүй байна уу? гэвэл Чотасын нүд нарийхан зурвас болон хувирч орхив.

-Болгоомжтой ... Фредерик, зарим үед үнэн шударга ялахад муу арга хэрэглэх үе гардаг юм гээд инээмсэглэж,

-Бидэнд буруу байхгүй гэдэгт итгэж үз. Тэд өөрсдөө буруутай байсан.

-Бид тэднийг хуурч мэхэлсэн. Би ингэж юу ч болоогүй юм шиг байгаад байж чадахгүй болохоор халагдах өргөдөл өгье. Сарын сүүлээр гарна.

-Би чиний өргөдлийг авахгүй. Чи яагаад миний саналыг хүлээж авахгүй байгаа юм бэ? Амралтаа авч үз.

-Би ийм бодолтойгоор сайхан амарч чадахгүй. Надад их харамсалтай байна.

Түүний хатуу шүүдсэнийг ойлгосон боловч Чотас,

-За тийм байдаг байж. Чи бүр шийдэж орхисон уу? гэвэл,

-Тиймээ, надад үнэхээр харамсалтай байна Леон. Гэхдээ та бүү сандраарай. Би энэ тухай хэнд ч ярихгүй байж чадна гээд Ставрос эргэж өрөөнөөс гарав.

Наполеон Чотас удаан бодож суув. Тэгээд эцэст нь харилцуур шүүрэн авч дугаар эргүүлээд,

-Намайг өнөөдөр ноён Демиристэй уулзмаар байна гэдгийг дамжуулж өгнө үү? Яаралтай ажил гарлаа гэж хэлээрийг гэжээ.

Өдрийн 4 цагийн үед тэр Демирисын өрөөнд хэдийнэ сууж байлаа.

-Юу болоов, Леон? гэж Демирисын асуухад,

-Ерөнхийдөө сүртэй юм болоогүй л дээ гэж Чотас болгоомжтой хэлээд,

-Гэхдээ би чамд дуулгая гэж бодоод ... Өнөө өглөө Фредерик Ставрос фирмээс гарах хүсэлтэй байгаа гэдгээ надад хэлээ гэв.

-Ставрос оо? Ларри Дугласын өмгөөлөгч үү? Тэгээд?

-Тэр дотроо шаналаад явдаг гэнэ гээд чимээгүй суув.

-Ойлголоо.

-Тэр энэ тухай ... тэр өдөр шүүх хурал дээр болсон явдлын тухай хэнд ч хэлэхгүй гэж амласан.

-Чи тэгээд итгээд байгаа юм уу?

-Коста, яагаад ч юм бэ их сонин, би итгэчихсэн шүү.

Демирис инээгээд,

-За яахав. Тэгвэл ч яриад байх юм алга шивдээ, тийм үү?

Чотас санаа алдаад босож,

-Бараг үгүй шив. Чамайг мэдэж байгаасай л гэж бодсон юм.

-Тэр зөв шүү. Хамтдаа энэ долоо хоногт өдрийн хоол идэцгээе л дээ.

-Тэгэлгүй яахав.

-Би ямар нэгэн юм бодож олбол чамруу утасданаа.

-Баярлалаа, Коста.

Баасан гаригийн орой Афины захын хуучин сүмд хүнгүй хоосон байв. Тэнд амар чимэгүй байдал ноёрхоно. Буланд байгаа шүтээний дэргэд Фредерик Ставрос гэгээн эцэг Константины өмнө өвдөг сөгдөн суух ба лам толгой дээр нь эхсэгхэн даавууны өөдөс тавьж өглөө.

-Гэгээн эцэг минь, би нүгэл үйлджээ. Надад аврал алга.

-Хүү минь, хүмүүний гол зовлон бол өөрийгөө зөвхөн хүн гэж боддог байгаа юм. Чи ямар нүгэл үйлдээв?

-Би алуурчин.

-Чи хэн нэг хүний амьдарлыг сүйтгээ юу?

-Тиймээ, ариун эцэг минь. Тэгээд би нүглээ хэрхэн наминчилхаа мэдэхгүй байна.

-Юу хийхийг чинь Бурхан мэднэ. Түүнээс л асуу, хүү минь.

-Нэрэлхүү шунахай сэтгэлээсээ болоод би үнэнч шударга зангаа алдлаа. Энэ явдал нэг жилийн өмнө болсон юм. Би хүн амины хэрэгтнийг өмгөөлж байлаа. Шүүх ажиллагаа хэвийн явагдаж байв. Гэтэл Наполеон Чотас энэ үед ...

Цагийн дараа Ставрос сүмээс огт өөр хүн болоод гарч ирэв. Нуруун дээрээсээ нэг том ачаа аваад хаячихсан мэт санагдана. Он жилээр шалгарсан наминчлах гэдгэ нэртэй эмчилгээ түүний сэтгэл санааг ариусган цэвэрлэжээ. Тэрээр ламд тэр нэг өдрийн аймшигт явдалыг эхнээс нь авхуулаад дуустал нь бүгдийг ярьсны дараа л чөлөөтэй амьсгалж чадахаар болов.

"Би одоо шинээр амьдарна. Өөр хотод очоод бүгдийг шинээр эхэлнэ. Яаж ийж байгаад гэмээ цагаатгана. Гэгээн эцэг мину, бололцоо олгосон танд баярлалаа."

Хариу бүрий даруй нөмөрч Эрмос талбай бараг хоосон эзгүй, Фредерик Ставросыг булан тойрох үед ногоон гэрэл асаж таарав. Тэрээр зам хөндлөн гарахад гэрлээ унтраасан том хар машин замын дээр урсгалаар яг түүнийг чиглэн асар хурдтай давхин ирсэнд Ставрос айсандаа гайхан зоогдсон мэт зогсож орхив. Мотоорын аймшигт дуу сонсогдоод дараа нь хамаг биеийг нь няц дайрахыг Ставрос мэдрэв. Аймшигтай өвдөлт ... тэгээд л бүх юм алга болов.

Наполеон Чотас тогтмол эрт босдог зуршилтайгаараа энэ өглөө ч эрт босов. Өглөө эрт энэхүү хэсэгхэн зуурын нам тайван байдал бол хүнд хэцүү өдрийн эхлэл юм. Тэр ганцаараа сууж цайгаа уух үедээ өглөөний сонин гарчиглав. Энэ удаа сонин мэдээлэл их байх шиг санагдлаа. Ерөнхий сайд Феммистоллес таван намаас нэр дэвшигчдээс бүрдсэн олон намын засаг байгуулжээ. "Түүнд цахилгаан утас илгээх хэрэгтэй юм байна". Мөн хятадын коммунистууд Янцзын мөрний зүүн эрэгт тулж иржээ. Гарри Трумен ба Эльбен Баркли нар америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийн албанд нэр дэвшин тангараг өргөжээ. Эхний хоёр хуудсыг эргүүлсэний дараа Наполеон Чотасын хамаг цус царцаж орхих нь тэр. Дараах зүйлсийг өгүүлсэн бяцхан мэдээ түүний анхаарлыг татсан нь,

"Тритсис ба Тритсис" фирмын ажилтан ноён Фредерик Ставрос Капникарея сүмээс гарч яваад машинд дайруулжээ. Жолооч хэргийн газраас зугтаан алга болжээ. Уг хэргийг харсан гэрчийн мэдүүлгээр бол машин хар өнгөтэй бас дугааргүй байсан байна ...

Ноён Ставрос нь Ноэлль Пейж, Ларри Дуглас нарын дуулиант хэрэгт холбогдох чухал хүмүүсийн нэг байсан юм. Тэрээр Ларри Дугласын өмгөөлөгч байсан бөгөөд ...

Наполеон Чотас сонингоо нүдээ салгаж цайгаа уухаа мартан бодлогоширон сууна. Золгүй тохиолдол уу? тийм гэж үү? Константин Демирис энэ явдлыг зохион байгуулаагүй байгаа даа Демирисыг мэдэхгүй хүмүүс түүний чадварыг дутуу үнэлж ямагт алдаа гаргах юм даа гэж бодоод Чотас харилцуур авч Демирис руу залгав.

Нарийн бичгийн дарга нь түүнтэй холбож өглөө.

-Та өглөөний мэдээ уншив уу? гэж Чотас түүнээс асуув.

-Үгүй, юу гарч?

-Фредерик Ставрос үхжээ.

-Юу гэнээ? гэх түүний хоолойд үнэхээр гайхсан өнгө дуулдана. -Чи чинь юугаа яриад байнаа?

-Өчигдөр орой түүнийг махсинаар дайрч алаад жолооч нь хэргийн газраас зугтсан байна.

-Бурхан минь, надад их харамсалтай байна. Леон, жолооч нь олдсон уу?

-Одоохондоо үгүй гэнэ.

-Цагдаагийханд жоохон дарамт үзүүлээд орхиход амархан л байх даа. Одоо үед бидний хэн маань ч гэсэн бүрэн аюулгүй байдалд байгаа гэж итгэх арга алга даа. Мартсанаас пүрэв гаригт үдийн хоол хамтдаа идвэл ямар вэ?

-Тэгье, тэгье.

-Тохирлоо шүү.

Наполеон Чотас өөрийгөө хүний далд санааг таничихдаг хүн гэж ихэд тооцдог болохоор "Константин Демирисын гайхсан нь үнэн бололтой. Тэгэхээр Ставросын үхэлтэй холбоогүй байх нь" гэж бодлоо.

Маргааш өглөө нь Чотасыг ажлынхаа газарт байрладаг хувийн гараашдаа орж, хөдөлгүүрээ унтраан машинаасаа гарч цахилгаан шат руу очтол хаанаас ч юм харанхуй булангаас нэг залуу гарч ирээд гал гуйв. Чотаст түгшүүрийн дохио дэлдэх шиг санагдаад явчихлаа. Өөрт нь хандсан хүнийг тэр танихгүй, тэгээд ч гараашид юу хийж байдаг билээ?

-Байлгүй яахав гээд Чотас удаан бодсон ч үгүй тэр танихгүй хүний нүүр рүү хүнд цүнхээрээ дэлсэж орхив. Залуу өвдсөндөө орилж,

-Аа муу новш! гэж дуу алдаад халааснаасаа дуу намсгагчтай буу суга татан гаргаж ирэв.

-Энд юу болоод байна? гэх дуу гарч тэдэн рүү дүрэмт хувцас бүхий хамгаалагч хүн ирэхэд танихгүй этгээд хором хэртээ самгардсанаа онгорхой хаалга руу ухасхийн гүйв.

Хамгаалагч Чотасын өмнө тулж ирээд,

-Та зүгээр үү? Ноён Чотас ...

-Зүгээр ээ гээд Чотас амьсгаадсанаас үг хэлж бараг чадахгүй шахам байв.

-Бүх зүйл хэвийн. Тэр хүнд юу хэрэгтэйг би үнэхээр мэдэхгүй байна гэж удаанаар хариулав.

"Энэ зүгээр санаандгүй явдал байж магадгүй. Энэ этгээд намайг зүгээр л дээрэмдэх гэсэн ч юм билүү? Тэгвэл заавал дуу намсгагчтай буутай байдаг нь юу вэ? Үгүй, тэр намайг алах гэж байсан" гэж Чотас ширээндээ суунгаа бодов.

Константин Демирис Ставросын үхлийн тухай сонсоод гайхах санаа өвөрлөсөн байжээ. Би тааварлаж мэдэх ёстой байжээ. Тэр үлдсэн гэрчүүдээсээ салахаар шийдсэн бололтой. За яах вэ. "Ноён Демирис, санамсаргүй бэлэн хүлээж суу" гэж бодлоо.

Дотуур холбооны хэрэгсэл шажигнаж нарийн бичгийн дарга хүүхний дуу гарч,

-Ноён Чотас, та хагас цагийн дараа шүүх хуралд оролцох ёстой шүү гэж санууллаа.

Өнөөдөр олон дахин давтан хүн амины хэрэг үйлдсэн хүний хэргийг сонсож дуусгах ёстой байсан боловч Чотас шүүх ажиллагаанд оролцоход бэлэн бус байдалтай байв. Түүнд тэнхэл үнэхээр байсангүй.

-Шүүгч рүү утасдаж намайг өвчтэй байна гэж хэл. Фирмээс хэн нэгнээс намайг өнөөдөр орлохыг гуйгаарай гээд өрөөнөөс түүнийг гаргав.

Тэгээд ширээний шургуулганаас дуу хураагуур гарган явч удаан бодож сууснаа эцэст нь ярьж эхэллээ.

Тэр өдрийн үдээш хойш ноён Чотас улсын яллагч Пиытэр Демонидосын өрөөг зорин очиход гарт нь том гэгчийн дугтуй харагдав. Нарийн бичгийн дарга эмэгтэй түүнийг хармагцаа таньж,

-Өдрийн мэнд, ноён Чотас. Танд юугаар туслаж болохсон бол? гэлээ.

-Ноён Демонидостой уулзмаар байна.

-Одоогоор тэр хуралтай байгаа л даа. Та түүнтэй уулзана гэдгээ хэлж тохирсон юм уу?

-Үгүй ээ, түүнд намайг яаралтай хэрэг гараад ирлээ гэж хэлчихгүй юу?

-За тэгье.

Арван таван минутын дараа Чотас ноён Демонидосын албан тасалгаанд орлоо.

-Уухайс даа. Хүрээд ирдэг байж ээ? Танд юугаар тусалж болохсон бол? Өмгөөллийн талаар хэдэн үг наймаалцах гэж явна уу? гэж яллагч асуухад,

-Үгүй ээ, Питер. Би хувийн ажлаар явна.

-Суу л даа, Чотас.

Тэд сууцгаалаа. Чотас яриагаа эхлэн,

-Би танд нэгэн дугтуй орхих гэсэн юм. Түүнийг надад ямар нэгэн муу юм тохиолдоход задлах учиртай битүүмжилсэн байгаа л даа гэсэнд Демонидос түүнийг сонирхон ширтэж,

-Танд ямар нэг юм тохиолдоно гэж та бодоод байгаа юм уу? гэвэл,

-тэгж бодох үндэслэл надад байна гэв.

-Ойлгомжтой. Таны ач мэддэггүй үйлчлүүлэгчдийн нэг үү?

-Хэн гэдэг нү чухал биш ээ. Миний итгэж болох цорын ганц хүн та л байна. Төмөр шүүгээндээ үүнийг хийж орхиод хэнд ч бүү үзүүлээрэй.

-Өө тэгэлгүй яахав гээд тэр урагш тонгойн,

-Та айчихсан юм аа даа? гэлээ.

-Яг тийм.

-Манай контороор хамгаалуулж дөнгөнө гэж та хүсэж байж болох юмаа даа?

Чотас хуруугаараа дугтуй тогшин,

-Надад хэрэгтэй бүхэн энэ дотор бий гэв.

-За за. Та л тэгж хүсэж байгаа бол таныхаар болог.

-Яг үүнийг л би хүсэж байна гээд Чотас босож гар сунган:

-Efharisto. Танд би ямар их өртэй болж байгаагаа илэрхийлэх ч үг олдохгүй байна гэв.

Питер Демонидос инээмсэглэн,

-Parakalo. Та надад өртэй боллоо гэж хэлэв.

Цагийн дараа "Грекийн худалдааны корпораци"-ын конторт шуудан зөөгчийн дүрэмт хувцастай хүн ирж нарийн бичгийн дарга нарын нэгэнд хандан,

-Би ноён Демирист илгээмж өгөх ёстой байна гэсэнд,

-Нааш нь өгнө үү, би түүнд дамжуулж өгье гэлээ.

-Биечлэн гарт нь өгөхийг надад тушаасан юм л даа.

-Уучлаарай, би түүнийг үймүүлж чадахгүй нь. Хэнээс илгээсэн эд вэ?

-Ноён Наполеон Чотасаас илгээсэн юм.

-Та түүнийгээ надад үлдээж болохгүй гэж итгэлтэй байна уу?

-Итгэлтэй байна, хатагтай.

Ноён Демирис наадахыг чинь хүлээж авах эсэхийг би мэдээдэхье гээд тэр дотуур яригчийнхаа товчлуурыг дарж,

-Өршөөгөөрэй, ноён Демирис. Зарлага танд ноён Чотасаас илгээмж ирүүлж гэж мэдэгдсэнд хариуд нь,

-Нааш аваад ир, Ирен гэх дуу сонсогдлоо.

-Зарлага заавал таны гарт өгөх ёстой гээд байна.

Хэсэг чимээгүй байснаа,

-Түүнийг оруул хэмээн хэлэв. Ирен зарлагын хамтаар өрөөнд орж ирлээ.

-Та Константин Демирис мөн үү?

-Тийм.

-Илгээмж авлаа гэж энд гарын үсгээ зурна уу?

Демирис гарын үсгээ зурсаны дараа зарлага илгээмжийг ширээн дээр тавилаа. Константин Демирис тэднийг гарч явахыг хүлээн илгээмжийг хэсэг бодлогоширонгуй ажсанаа задаллаа. Дотор нь хуурцаг бүхий чихэвчний дуу хураагуур байлаа. Гайхсан Демирис товчлуурыг дарахад хуурцаг эргэж Наполеон Чотасын дуу өрөөнд дуулдаж эхэлээ.

-Хүндэт эрхэм Коста. Хэрэв чи Фредерик Ставроcыг хэнд ч ам алдахгүй гэж итгээд өнгөрсөн бол бүх юм амар байх асан. Хэрэв чи надад итгэхгүй байгаа бол их харамсалтай байна. Надад чамайг хөөрхий Ставроcын үхэлд буруутай гэдгийг нотлох нотолгоо бүрэн байгаа учраас чи одоо надтай тооцоо бодохоор шийджээ. Миний амь амьдрал надад хичнээн их үнэтэй шиг чинийх ч мөн адил шүү дээ. Би "чамайг хүндэтгэх үүднээс" чиний дараачийн золиос болохоос татгалзаж байна ... Болгоомжлох үүднээс чи бид хоёр Ноэлль Пейж, Ларри Дугласын хэрэгт ямар үүрэг гүйцэтгэснээ баримтаар нотолсон захидал бичээд дугтуйлан улмаар Улсин яллагчид өгч, надад золгүй үхэл тохиолдсон тохиолдолд задлах заалттайгаар хадгалуулсан. Тиймээс миний найз би одоо чиний тусын тулд эрүүл энх амьд мэнд байх болно.

Хальс эргэж дуусав. Константин Демирис хоосон орон зайг ширтэн хөдөлгөөнгүй суулаа.

Наполеон Чотас албан тасалгаандаа эргэж ирэхэд хэдийнээ тайвширсан байв. Константин Демирис хэдийгээр чоно шиг аюултай ч гэсэн тэр тэнэг хүн биш болохоор өөртөө гай болох юм хийхгүй. "Тэр нүүдэл хийж харин хариуд нь түүнд мад тавьж орхилоо. Пүрэв гаригийг үдийн хоол ч өнгөрөв бололтой" гэж дотроо бодоод инээд алдав.

Дараачийн хэдэн өдөр Наполеон Чотас нөхрийнхөө хоёр нууц амрагийг алсан хэрэгт тулгагдсан хүүхний хэрэг дээр ажиллав. Тэр өглөө эрт босоод эсэргүүцэх асуултуудаа

бэлтгэхээр шөнө дөл болтол сууна. Аггах сэжүүр өчүүхэн ч алга байсан боловч ялна гэдэгтээ тэр огт эргэлзсэнгүй.

Лхагва гаригт тэр мөн л шөнө болтол ажиллаад гэррүүгээ харьж явав. Шөнийн нэг цагт харшдаа хүрч очлоо. Үүдэн дээр бойдаа түүнийг угтаж аваад,

-Ноён Чотас, танд ямар нэгэн зүйл хэрэгтэй бол хэлнэ үү. Хэрэв өлсөж байгаа бол би идэх юм бэлдэх үү? гэв.

-Баярлалаа, хэрэггүй ээ. Явж унт даа гээд Чотас унтлагын өрөөндөө шууд явж оров. Маргаашийн шүүх хурлын явцыг тунгаан дахин цаг хиртэй бодол болсны дараагаар хоёр цагт арай гэж зүүрмэглэж эхлэв. Зүүдэндээ:

... Шүүх хурал дээр тэр хувцсаа гэнэт тайчиж эхлсэн гэрчид хандан,

-Та яагаад хувцсаа тайчаад эхлэв ээ? гэсэн асуулт тавихад,

-Би бүхлээрээ шатаж байна гэлээ.

Чотас танхим тийш харвал тэнд байсан бусад хүмүүс цөм хувцсаа тайчиж эхэлсэн харагдав.

Тэрээр шүүгчид хандан,

-Эрхэм ээ, би татгалзаж байна ... гэтэл шүүгч нөмрөгөө хуулж хаяад,

-Энд дэндүү халуун байна. Их чимээтэй байна.

Наполеон Чотас нүдээ нээвэл галын дөл өрөөний хаалгыг долоож өрөө бүхэлдээ утаагаар дүүрчээ. Тэр цочин сэрж өндийн сууж галын дохио яагаад ажилласангүй вэ гэж бодов. Хүчтэй галд өртсөн хаалга најигнан дуугарсанд Чотас онгорхой цонх руу утаагаар амьсгалан гүйж онгойлгохыг оролдсон ч бүтсэнгүй. Утаа улам өтгөрч амьсгалхад улам хэцүү болов. Аврагдах боломжгүй болжээ. Босгон дээр галын дөл унаж хана туурга тойрон хаа сайгүй гал дүрэлзэж авалцлаа.

Үс хувцасанд нь гал авалцахад Чотас орилж ухаанаа алдах шахан цонхруу хамаг хүчээрээ мөргөн арван зургаан фунтын өндрөөс гадагш нсиэх нь тэр.

Маргааш өдрийн өглөө Питер Демонидос Константин Демирисын өрөөнд явж орлоо.

-Kalimehra. Питер гэж Демирис инээмсэглэн мэндлээд:

-Ирсэнд чинь баярлалаа. Авчрав уу? гэсэнд,

-Тиймээ, эрхэм ээ гээд тэр Чотасын үлдээсэн биүттүүмжилсэн дугтуйг Демирист сарвайн өгч:

-Үүнийг энд хүлээн авахыг та илүүд үзэх байх гэж би бодсон юм гэлээ.

-Зөв боджээ, Питер. Өглөөний цай хамтдаа уухгүй юу?

-Efharisto. Та эелдэг хүн юм, ноён Демирис.

-Коста. Намайг зүгээр Коста гэж дуудаж байгтун. Би үргэлж таны талд зогсдог байсан. Танд их ирээдүй бий гэж би боддог. Би өөрөөсөө хамаарах бүхнийг хийнэ. Танд таалагдах уу?

Питер Демонидос инээмсэглэн,

-Тиймээ, Коста. Их таалагдаж байна гэв.

-Сайн байна. Цайн дээр үргэлжлүүэн ярилцъя.

Есдүгээр хэсэг

Лондон

Долоо хоногт нэгээс цөөнгүй удаа Демиристэй утсаар ярих явдал Кэтринд бараг зуршил болжээ. Демирис түүнд байнга бэлэг илгээж хэрэв жаахан дургүйцэж байгаагаа хэлбэл энэ бүхэн зөвхөн түүний сайн ажиллаж байгаагийн хариу шагнал гэж батлан хэлж тайтгаруулдаг байлаа. Тэр "Эвелин надад таныг Бакстертэй учраа хэрхэн олсон тухай хэлсэн" буюу эсвэл "Таны санаачлагаар тээврийн задрлаас их мөнгө хэмнэсэн тухай Эвелинээс дуулсан" гэж хэлнэ.

Үнэндээ Кэт ч өөрийн амжилтаараа бахархаж байжээ. Тэр конторт олон зүйлийг өөрчлөх хэрэгтэй бөгөөд ийм замаар контор нь илүү үр ашигтай ажиллаж болохыг анзаарчээ.

-Би танаар маш их бахархаж байна гэж Демирис түүнд байнга хэлнэ.

Кэтийн сэтгэлд тэр хүн ойр дотно сайхан санагдаж, ямар гайхалтай эелдэг хүн бэ гэж биширнэ. "Эхлэх цаг боллоо" гэж шийдсэн Демирис Ставрос, Чотас хоёрыг амжилттай үгүй хийсэн хойно тэр золгүй явдлын гэрч ганцхан Кэтрин үлдсэн гэдгийг сайн ойлгож байв. Энэхүү илэрч тодрох ымаар ч боломжгүй хэрэг боловч Чотасын хэлснээр Демирис аз туршдаг тэнэгүүдийн нэг угаасаа биш. "Үхэх үйлтэй нь харамсалтай. Ийм сайхан хүүхэн байж ... Рафин дахь шилтгээнд эхлээд очих болно."

Демирис уг шилтгээнийг худалдан авсан болохоор Кэтийг тийш нь дагуулж очоод Ларри Дуглас Ноэлл⁷тэй хэрхэн янаглаж нүгэл үйлдсэний адилаар түүнтэй зугаацах болно. Харин дараа нь ...

Цаг хугацаа өнгөрөх тусам Кэтрин өнгөрсөн амьдралаа бага багаар эргэн санасаар байв. Тэр "Лондон Таймс" дээрээс Фредерик Ставрос, Наполеон Чотас нарын үхлийн талаар уншаад хэрэв тэр хоёр Ларри Дуглас, Ноэлль Пейж нарын өмгөөлөгчид байсан гэж дурьдаагүй байсан бол юу ч анзаарахгүй өнгөрөх байлаа.

Тэр шөнөдөө Кэт дахин зүүдэллээ.

Өглөө нь сонин дээр гарсан өөр нэг мэдээ түүний сэтгэлийг бас догдлуужээ. АНУ-ын ерөнхийлөгч Гарри Трумены туслах Уильям Фрезер Британы ерөнхий сайдтай худалдааны хэлэлцээрийн талаар зөвшилцөхөөр Лондонд ирлээ гэж тэнд бичсэн байв.

Зүрх нь хүчтэй цохилохыг мэдэрсээр Кэтрин сонингоо тавьлаа. "Уильям Фрезер, тэр миний амьдралд ямар байр суурь эзлэнэ вэ! Хэрвээ би түүнийг орхиогүй бол өдийд юу болох байсан бол?"

Тэгээд мэдээг дахин нэг уншаад царай нь гэрэлтэв. Уильям Фрезер түүний хамгийн дотны хүмүүсийн нэг ба дурсан бодоход сэтгэлд нэг л таатай агаад тэр түүнд одоо хэр нь хайртай байгаагаа мэдэрч ийнхүү баясчээ. "Лондонд ирчихэж. Би түүнтэй заавал уулзах ёстой." Сонинд бичсэнээс үзвэл "Клэррик" зочид буудалд байрласан байна.

Кэт чичирсэн гараар зочид буудал руу залгав. Түүнд өнгөрсөн бүхэн дахин босоод ирэх шиг санагдана. "Тэр миний дууг сонсоод яах бол? Намайг хараад яах бол?" Холбогч эмэгтэй дуу гарч:

-Өглөөний мэнд. Клэрик зочид буудал байна гэлээ.

Кэтийн амьсгаа тасалдан байж,

-Уучлаарай, ноён Фрезертэй ярья гэв.

-Уучлаарай хатагтай. Та ноён Фрезер гэсэн үү? хатагтай Фрезер гэсэн үү?

Түүнийг цохиод авах шиг л болов.

"Би ямар тэнэг юм бэ? Яагаад энэ талаар бодсонгүй вэ? Тэр мэдээж гэрлэсэн байж таарна шүү дээ!"

-Хатагтай ...

-Би ... Үгүй, зүгээр. Танд баярлалаа гээд харилцуураа тавилаа.

"Оройтжээ. Бүх юм дуусч. Өнгөрсөн бүхэн өнгөрсөн үедээ л үлджээ гэж Костагийн хэлдэг зөв байж."

Ганцаардал гэдэг хүний сэтгэл санааг устгах чадалтай эд аж. Аливаа баяр хөөр, алдар нэр, айдас жихүүдэс болгоноо хэн нэгэнтэй хуваалцаж байх явдал хүн болгонд хэрэгтэй байх юм даа. Кэт гадны хүмүүс дунд ажиллаж, хөндлөнгөөс жаргалтай хосуудыг ажиглан инээд баясалыг нь чагнах авч өөртөө төдий л харамсаж гутарсан нь үгүй ээ. "Би чинь энэ хорвоогийн ганцаардсан цорын ганц эмэгтэй биш шүү дээ. Би чинь амьдарч явна ... амьд л байна шүү дээ!" гэж өөртөө ымаагт хэлнэ.

Лондонд ямар нэг цаг нөгцөөх зүйл заавал олдоно. Кинотеатрт нь америк кино гарч, тэдний ихэнхи нь Кэтэд таалагдана. Түүний үзсэн "Сахлын хурц хутга", "Анна ба Сиамын эзэн хаан" болон "Соёлтой эрсийн зөвшилцөөн", мөн "Гоонь эрс" дээрс тоглосон Грант түүний сэтгэлийг ихэд догдлуулсан байлаа. Гэвч ганцаардлын байдалдаа театр явахаас илүү таашаал авах нь үгүй байлаа.

Яг энэ үед Кирк Рейнольдс түүний амьдралд орж ирсэн юм. Нэгэн удаа Кэтийн өрөөнд өндөр гуалиг эрэгтэй орж ирээд,

-Би Кирк Рейнольдс байна. Та ингэхэд урьд нь хаана байсан хүн бэ? гэжээ.

-Уучлаарай, та юу гэв ээ?

-Би таныг аль эртнээс хүлээж байлаа.

Ингээд л бүх зүйл эхэлсэн юм. Энэ бол Константин Демирисын тусын тулд ажилладаг,

америк өмгөөлөгч бөгөөд олон улсын байгууллагуудыг нэгтгэх асуудал дээр ажилладаг, дөч шүргэж яваа ухаалаг эелдэг зан төрхтэй хүн байв. Түүний талаар Кэтрин Эвелинд хэлэхдээ,

-Тэр надад бусдаас илүү таалагддаг. Түүний дэргэд байхдаа л би өөрийгөө эмэгтэй хүн гэдгийг мэдрэх юм. Би эмэгтэй хүн гэдгээ мартаад хичнээн удав аа? гэжээ.

-Би яаж мэдэх вэ. Гэхдээ би чиний оронд байсан бол их л болгоомжтой байх байсан. Битгий яараарай, Кэт гэж Эвелин эргэлзэнгүй хэлжээ.

-За хэмээн Кэт түүнд амлав.

Кирк Рейнольдс Кэтийг Лондоны шүүхийн ажиллагаатай танилцуулав. Тэд "Олд Бейли" дэх шүүх ажиллагаа явагдаж байсан гол танхимд хиймэл үс, сүржин нөмрөгтэй дөнгсэр өмгөөлөгчийн хажуугаар явж өнгөрөв. Хорих ялаар шийтгүүлсэн ялтнуудыг хорьдог "Ньюгейт"-ын шорон бүр 18 зуунд баригдсан бөгөөд тийш очдог зам нь эхэндээ өргөн дардан байснаа яваандаа гэнэт нарийсчээ.

-Сонин юм. Яагаад ийм зам хийсэн юм бол? гэж Кэтрин онцлон асуухад,

-Олон түмний харж зогсоход зориулсан талбай гаргахын тулд тэр ээ. Яг энд чинь л хэрэгтнүүдийг олны өмнө цаазладаг байсан юм гэж хариулав.

Энэ үгийг дуулаад Кэтрин давхийн цочлоо. Энэ нь түүнд дэндү ихийг санагдуулж байсан юм.

Нэгэн орой Кирк Кэтрин хоёр далайн эргийн дагуу үргэлжлэх Дорнод-Энэтхэгийн замаар давхиж явлаа.

-Энд саяханыг хүртэл цагдаа нар хосоороо явдаг байж билээ. Гэмт этгээдүүд дүүрэн байдаг сан гэж Кирк хэлэв.

Орчныг харуй бүрий нөмрөхөд булан болгоны цаана аюул занал отож байх шиг Кэтэд санагдана. Тэд эртний англи гуанзны тагтан дээр орой зоог барив. Тагтан дээрээс Темза голын уудам давалгаан дунд дайвалзах ачааны хөлөг онгоц үзэгдэнэ.

Кэтрин "Чешир хатсан бяслаг", "Фальстафг" ба "Гуталт муур" гэхчилэнгийн ер бусын нэртэй лондоны мухлагуудын нэрийг ихэд таашаадаг байв. Тэд "Бүргэд" гэдэг нэртэй нэгэн уран зургийн мухлагт орж байснаа санав.

-Таныг бага насандаа энэ мухлагийн тухай дууг дуулж явсан гэж мөрийцөхөд ч бэлэн байна гэж Киркын хэлэхэд Кэтрин түүн рүү гайхан харж,

-Дуулахы? Энэ талаар би хэзээ ч юу ч сонсож яваагүй хүн шүү гэлээ.

-Үгүй ээ, та дуулж байсан. Энд нэг хүүхдийн дуу зохиогдсон гэдэг юм билээ.

-Ямар дуу вэ тэр чинь?

-Олон жилийн өмнө хотын нэгэн дүүрэгт оёдолчин үйлчид амьдардаг байжээ. Долоо хоногийн сүүлээр мөнгөө дуусахад цалингаа буутал индүүгээ барьцаанд тавьсан тухай хэн нэгэн хүн дуу зохиосон нь,

"Бүргэд рүү бас буцаад

Замын дагуу урсана.

Индүүнүүдийн хамт

Мөнгө урсан одно гэж дуулсанд Кэтрин хөхөрч,

-Бурхан минь. Та энэ бүгдийг хаанаас мэддэг юм бэ? гэвэл,

-Хуульч хүн бүгдийг мэддэг байх учиртай. Гэхдээ надад мэдэхгүй зүйл нэг бий. Та цанаар гулгадаг уу?

-Үгүй гэж айж байна. Юу гэж?

Кирк гэнэт сүрхий царай гарган,

-Сент Мориц руу би явах гэж байгаа юм. Тэнд маш сайхан цанын баазтай. Та надтай цуг явах уу? гэсэнд Кэт үүнийг дуулаад самгардан дуугуй болов. Кирк тэвчээртэйгээр хариу хүлээнэ.

-Би ... үнэндээ мэдэхгүй л байна, Кирк.

-Гэхдээ чи миний саналыг бодно биздээ?

-Тэгнээ гээд Кэт чичирч байгаагаа мэдрэв. Тэр Ларритай хэрхэн янаглаж байснаа гэнэт санажээ. Түүнд дахин тийм жаргал эдлэх учрал тохиолдохгүй юм гэж үү?

-Тиймээ, би бодъё.

Кэтрин Киркыг Уймтай танилцуулахаар шийджээ. Тэд Уймыг авахаар гэрт нь очиж түүний хамтаар "Плюш"-д хооллохоор очицгоов.

Уйм бүхэл оройн турш Кирк руу хялам ч хийсэнгүй. Янз нь хаана хэнтэй байгаагаа бараг мартсан бололтой. Кирк Кэтриний зүг нүднийхээ булангаар харвал цаадах нь "Түүнтэй ярилцаач" гэж уруулаа хөдөлгөх төдийхөн хэлэв. Кирк толгой дохиод Уймын зүг хандан,

-Танд Лондон таалагддаг уу? гэж аусулаа.

-Зүгээр санагддаг.

-Танд ямар хот хамгаас илүү таалагддаг вэ?

-Ямар ч хот тэгж таалагддаггүй.

-Ажил төрөл чинь танд ямар санагддаг вэ, тэгвэл?

-Хэвийн санагддаг.

Кирк Кэтрин рүү толгой сэгсрэн мөрөө хавчлаа. Кэтрин өөдөөс нь "Таниас гуйж бн" гэж шивэгнэн хариуллаа. Кирк санаа алдаад дахин Уйм тийш харж,

-Би амралтын өдөр гольф тоглоно. Та тоглох уу? гэв.

-Гольфын цохиур мод төмөр бариултай, бүхэлдээ төмрөөр хийгдсэн урт гонзгой, хүрз хэлбэрийн, богино ба богиносгосон гээд олон янз байдаг. Модон цохиур, зэс цохиур ... гэж түгдрэлгүй ярьсанд Кирк нүдээ анивчин,

-Та лав мэргэжлийн тоглогч байх аа гээд гайхан дуу алдав.

-Тэр тоглодоггүй юм. Уйм зөвхөн бүгдийг л мэддэг юм. Тэр тооны хувьд толгой өвдөггүй хүн дээ гэж Кэтрин хэлэв.

Кирк зовсон янзтай инээмсэглэн,

-Нээрээ юу? гэлээ. Кирк бүр залхаж орхисон байлаа. Тэр өнөө оройг Кэттэй хоюулахнаа өнгөрөөнө дөө гэж горьдсон байтал Кэт энэ нэг хачин амьтныг дагуулаад ирдэг ... Тэгээд Уймаас,

-Хоёрын тавин ес дэх зэрэг дэвшүүлэхэд хэд болохыг та арай мэдэх юм биш биз? гэж асуувал Уйм гучин секунд хэртэй ширээний бүтээлэг ширтэн чимээгүй суулаа. Кирк юм хэлэхээр амаа ангайх гэтэл,

-576 460 752 303 423 488 гэлээ.

-Бурхан минь гэж Кирк сулхан хашгираад,

-Энэ чинь яг зөв үү? гэв.

-Тиймээ, зөв гэж Уйм шүдээ ярзайлган хариулав.

Кэтрин Уйм руу эргэж,

-Уйм чи байна шүү дээ гээд Кэт таамгаар тоо сонгон,

-24 137 585-ын зургаан зэрэгт язгуураас гаргаж чадах уу? гэж асуулаа.

Тэр хёор Уймын царайг ширтэн суутал 26 секундын дараа тэр,

-Арван долоо, үлдэгдэл 16 гэлэ.

.Итгэхийн арга алга гэж Кирк гайхширан хэлэхэд нь,

-Итгэх л болж дээ гэж Кэтрин цовоо дуугаар хэлэв.

Кирк Уйм руу харж,

-Яаж ингэж чадаж байнаа? гэсэнд Уйм мөрөө хавчлаа.

-Уйм дөрвөн оронтой хоёр тоог гучин секундэд үржүүлж, таван минутанд тавин угасны дугаар цээжилж чаддаг юм. Тэгээд хэзээ ч мартаггүйгээр гээч.

Кирк бахархасан янзтай Уйм Вандиныг хараад,

-Ийм авьяастай хүн манай албан газарт л хэрэгтэй юм даа гэсэнд,

-Би ажилтай хүн гэж Уйм огцом дуугаар хэлэв.

Кирк Рейнольдс Кэтринийг гэрт нь хүргэж өгөхдөө,

-Чи Сент-Морицын талаар мартаагүй биз дээ? гэв.

-Мартаагүй гээд "Би юунд шулуухан зөвшөөрчихгүй байгаа юм бол?" гэж бодов.

Оройхон Демирис угасдахад Кэтрин Кирк Рейнольдсын тухай ярья гэснээ эцсийн мөчид бодлоо өөрчилжээ.

Аравдугаар хэсэг

Афин.

Гэгээн эцэг Константиноу Фредерик Ставросын үхлийн тухай сонингоос олж уншсан цагаасаа эхлэн түүний тухай бодол болон байж суух газраа олохоо больжээ. Хэдийгээр амьдралдаа тэр хэдэн мянган ийм наминчлал сонсож байсан боловч Фредерик Ставросын эмгэнэлт түүх түүнд тохиолдсон үхлийн гамшиг мартагдашгүй сэтгэгдэл үлдээжээ.

-Та чинь юундаа ингэтлээ санаа зовоо вэ?

Константиноу эцэг дэргэд нь зэрэгцэн хэвтэх сайхан царайтай нүцгэн залуу өөд хараад,

-Үгүй дээ, зүгээр хүү минь гэлээ.

-Надтай цуг байхад танд хэцүү байна уу?

-Үгүй гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ, Георгиос минь.

-Тэгээд юу болчихоов? Чи намайг энд байгааг мартаж орхисон юм биш биз, чөтгөр ав.

-Битгий хараал хэлээрэй.

-Намайг огт тоохгүй байхад би дургүй.

-Өршөө хонгор минь. Над дээр ирсэн хүмүүсийн нэг нь машинд дайруулж орхисон байна ...

-Бид цөмөөрөө л хэзээ нэгэн цагт үхнэ, тийм биз дээ. Тэр чинь яасан юм бэ? Дарга нартайгаа муудаа юу?

-Үгүй ээ. Тэр нэгэн аймшигт нууц мэддэг байсан нь түүнд хүнд ачаа болдог байсан юм.

-Ямар нууц вэ тэр нь?

Гэгээнтэн залуугийн өгзгийг илээд,

-Би энэ тухай ярьж болохгүй гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ. Би нүглээ наминчлагдчдын нууцыг задалж чадахгүй.

-Өө, бидэнд бие биесээсээ нуух юм байхгүй гэж би бодож байсан юм.

-Байхгүй л дээ, Георгиос минь...

-Gamoto. Эсвэл тийм эсвэл үгүй гэж хэлээч! Тэр чинь угаасаа үхсэн биз дээ? Ямар ялгаа байна?

-Ямар ч ялгаа байхгүй л дээ. Би бодохдоо ...

Георгиос Лато гэлэнд ойртон чихэнд нь,

-Надад сонин байна гэж шивэгнэв.

-Чи чихийг минь бүр ирвэгнүүлээд орхилоо.

Лато гэгээнтнийг таалж эхлэв.

-Оо ... дахиад жаахан, чамаас гуйя ...

-Тэгвэл надад хэл.

-Тэгье. Одоохон. Одоо тэглээ гээд муу юм болохоос нэгэнт өнгөрсөн байлгүй.

Георгиос Лато амьдралдаа бага сага юманд хүрчээ. Тэрээр Афины ядуусын хороололд төрөөд арван хоёр наснаасаа биеэ үнэлж эхэлжээ. Эхлээд гудамжинд гарч хэдхэн доллар олдог байв. Цэцэрлэгт архичингууд эсвэл зочид буудалд жуулчидтай явалдана. Хувь заяа түүнд сайхан зүс царай, хүдэр чийрэг бие бялдар, үзсэгэлэнтэй гадаад төрх заяасан ажээ. Түүнийг 16 настай байхад түүний зуучлагч түүнд "Георгиос минь чи хүчээ дэмий барж байх юм. Би чамд сайн хөлс мөнгө олох аргыг зааж өгье" гэжээ. Тэгээд ч хэлсэндээ хүрч түүнээс хойш Латогийн үйлчлүүлэгчид нь ямагт чухал нэд хүндтэй хүмүүс байж, үйлчилснийх нь хариуд өгөөмөр сахн харамж өгдөг болжээ.

Аугаа хүчит Спирос Ламброугийн хувийн туслах Никос Веритостой учирсан явдал Латогийн амьдарлыг эрс өөрчилсөн байна.

-Би чамд хайртай гэж Никос Веритос залууд хэлээд,

-Би чамайг ганцхан өөрийнхөө татвар эм/эр болгомоор байна. Одооноос эхлээд чи зөвхөн минийх гэнэ.

-Хэлснээр чинь л больё, Ники. Би ч бас чамд хайртай.

Веритос залууг бэлэг сэлтээр булж, түүнийг хувцаслаж, байр сууц авж өгөөд ч зогссонгүй байнгын хэрэглээнд нь зориулж мөнгө хүртэл өгдөг байв. Гэхдээ л тэр өөрийгөө эзгүйд Латог юу хийж байгаа бол хэмээн байнга сэтгэл түгшигж явдаг байлаа.

Тиймээс энэ байдлыг шийдвэрлэх арга удалгүй олж Латод,

-Би чамд өөрийн ажилладаг Спирос Ламброугийн компанид таарах ажил оллоо гэж мэдэгдэв.

-Чи намайг үргэлж мөрдөж байх гэж ... Үгүй, би зөвшөөрөхгүй ...

-За үгүй дээ, баяр баясгалан минь. Чамайгаа дэргэд минь байгаасай л гэсэндээ тэр.

Эхэндээ Лато эсэргүүцэж байснаа сүүлдээ бууж өгчээ. Гайхалтай нь шинэ ажил нь түүнд

ихэд таалагджээ. Тэрээр нийт зарлагыг хариуцах хэлтэст ажиллах болсноор ажлаас гадуур мөнгө олж, ялангуяа гэгээн Константиноу шиг талархах зантай үйлчлүүлэгчидтэй учрах өргөн боломжтой болсон байв.

Тэр өдөр Георгиос Лато гэгээн ламын орыг аз жаргалтайгаар орхин явжээ. Олж мэдсэн зүйл нь гайхалтай тул Лато үүгээрээ нилээд ашиг олж болохыг тунгн ойлгоод Никос Веритостой зөвлөж болох юм гэж боджээ. Тэгснээ дараа нь энэ бодлоо орхин илүү сайн арга олох шиг болсон нь "Энэ нууцаа шууд эзэнд өргөн баривал тэр төлсөн шиг төлнө биз" байжээ.

Маргааш өглөө нь Лато Спирос Ламброугийн хүлээлгийн өрөөнд оров.

Нарийн бичгийн дарга эмэгтэй толгой өргөн хараад,

-Хөөх чи өнөөдөр ямар эрт явна вэ, Георгиос гэж дуу алдав.

Лато толгой сэгсрэн,

-Би ноён Ламброутай уулзах гэсэн юм гэсэнд хүүхэн инээмсэглэн,

-Чи юу ярина вэ?! Түүнтэй уулзаж яах нь вэ? Чамд ажил хэргийн асуулт байгаа юм уу?

Лато тайвнаар,

-Үгүй, өөр асуудлаар гэж хариулаад,

-Би ээжийгээ нас барлаа гэсэн цахилгаан утас аваад гэртээ харих хэрэгтэй болсон юм. Тэгээд л ноён Ламброуд баярлаж байгаагаа илэрхийлэх гэсэн юм. Хэрэв тэр завгүй байгаа бол би ганцхан минут уулзаж гурван үг хэлээд явья ... гээд эргэтэл,

-Хүлээ, чамайг хүлээн авах байх гэж бодож байна гэх дуулдлаа.

Арван минутын дараа Георгиос ЛАТО Спирос Ламброугийн өрөөнд орлоо. Тэрээр ийм тансаг тохьтой өрөөг үзээгүй учир ихэд балмагдан тэвдтэл,

-Ээж чинь нас барсан байна. Жаахан гар цайлгах юм ... гэтэл,

-Баярлалаа, эрхэм ээ. Би өөр учир шалтгаанаар ирсэн юм.

Ламброу гайхан хөмсөг зангидан,

-Ойлгосонгүй гэв.

-Ноён Ламброу, надад чухал мэдээ байна. Таныг өндөр үнэлэх байх гэж найдна гэсэнд Ламброугийн царайд үл итгэсэн байдал тодорч,

-Чи юу яриад байнаа? Би их завгүй байна гэлээ.

-Константин Демиристэй холбоотой мэдээ л дээ гэж Лато хурдхан хэлэв.

-Надад нэг сайн найз байдаг юм. Тэр маань ариун лам хүн л дээ. Түүнд нүглээ наминчилсан нэгэн хүн машинд дайруулж үхсэн юм. Тэр залуу ламд Константин Демирисын үйлдсэн нэгэн аймшигт хэргийн талаар ярьсан байна. Маш аймшигтай! гэж үргэлжлүүлэн хэлээд,

-Түүнийг энэ хэргийх нь төлөө шоронд ч хийсэн болно. Хэрэв танд сонирхолгүй байгаа бол ...

Спирос Ламброу гэнэт машид их сонирхож эхлэн,

-Суу. Чамайг хэн гэдэг вэ? гэж суув.

-Лато, эрхэм ээ. Георгиос Лато.

-За тийм байж, Георгиос, эхнээс нь яриарай ...

* * *

Константин Демирис Мелина хоёрын харьцаа өдөр ирэх тусам муудсаар сүүлийн үед эхнэрийнхээ гарт ч хүрсэн нь үгүй. Энэ бүхэн Демирисийн эхнэрийнхээ найз хүүхнэтэй нууц амрагийн холбоо тогтоосноос үүдэлтэй юмсанжээ.

-Чи бүх хүүхнүүдийг янхан болгох чадвартай юм. Чиний гар хүрсэн бүгд ямагт бохир заваан ой гутам болж орхих юм гэж Мелина хашгичив.

-Чи наад бузар амаа тат!

-Чи намайг дуугуй байлгаж чадахгүй. Би чамайг ямархуу новш, өөдгүй амьтан болохыг чинь бүгдэд дэлгэх болно! Ахын зөв байж, чи бол мангас мөн! гэж Мелина хариуд нь орилов.

Демирис уурлан гараа далайн Мелинагийн хацар руу чанга алгасанд хүүхэн өрөө рүүгээ гүйн оров.

Дараачийн долоо хоногт дахин хэрэлдэх үед эхнэрээ дахин цохьжээ.

Мелина юм хумаа цуглуулж ахынхаа хувийн арал болох Аттикосыг зорин нисэв. Тэнд очоод хүүхэн уйдаж ганцаардан сүүлдээ нөхрөө санах болж түүнийг зөвтгөж өөрийгөө буруутган бодох болов. "Би л буруутай. Түүнийг биеэ барьж чадахгүй болтол нь уурлуулах хэрэггүй байсан юм. Тэр цохьё гэж цохиогүй, зүгээ рл юу хийж байгаагаа мэдэхээ больж орхисон. Хэрвээ би түүнд огт хамаагүй байсан бол тэр намайг тоож цохихгүй байх байсан биш гэж үү?"

Гэвхц Мелина сэтгэл дотроо энэ бүхэн санаанаасаа зохиосон үлгэр гэдгийг ойлгож лбайлаа. Тэглээ ч тэр гэр бүлээ сарниулах хүсэлгүй байсан тул ирэх долоо хоногт гэртээ ирсэн байлаа.

Демирис номын сандаа сууж байв.

Мелинаг явж ороход тэрээр хараад,

-Чи буцаад ирж байгаа юм уу? гэлээ.

-Миний гэр энд бий, Коста. Чи миний нөхөр, би чамд хайртай. гэвч чамд гэж хэлэхэд чи дахиад намайг цохих юм бол би чамайг ална шүү гэжээ.

Демирис хүүхний нүдийг хараад үнэн хэлж байгааг нь ойлголоо.

Энэ явдлаас хойш яагаад ч юм тэдний харилцаа сайжрав. Удаан хугацаа өнгөрсөн боловч Константин Демирис Мелинага аятай харьцахыг хичээсээр байв. Тэр хүүхэн эргүүлсэн хэвээрээ ч Мелина түүнийг болиоч гэж гуйхааргүй дэндүү бардам зантай байлаа. "Энэ муусайн янхнууд хэзээ нэгэнт цагт түүнийг залхаах болно. Тэр үед надаас өөр хэн ч өөрт нь хэрэггүйг тэр ойлгох болно" гэж дотроо бодно.

Бямба гаригийн орой Константин Демирис гарахаар хувцаслаж байтал Мелина өрөөнд нь орж ирэв.

-Чи хаашаа явах гэж байгаа юм?

-Би уулзалттай.

-Өнөөдөр оройн хоол Спиросын идэх ёстойг мартаагүй биздээ чи?

-Би мартаагүй. Гэхдээ надад түүнээс илүү чухал ажил байна.

Мелина хөшиж орхисноо биеэ барьж дийлэлгүй уурлав.

-Чамайг ымаар ажилд явах гэж байгааг чинь би мэдэж байна. Чиний тэр ажил гээд байгаа юм чинь хэн нэгэн янхантай унтаж балиар тачаалаа тайлахыг л хэлж байгаа шд.

-Амаа татаарай хө. Чи зах дээр загас зардаг авгайтай адилхан харагдаж байна шүү гээд Демирис толинд өөрийгөө тольдож эхлэв.

-Би чамайг ингэхийг зөвшөөрөхгүй!

Түүний өөртэй нь яаж доромжлон харьцах хамаагүй боловч ахыгаа доромжлуулна гэдэг хэрээс хэтэрсэн хэрэг биалаа. Хэрэв түүнийг барьж тогтоох ганц ч болов арга байвал тэр шууд л ашиглах байлаа.

-Ерөнхийдөө өнөөдөр бид хоёр хоюулаа гэртээ байх ёстой гэж хүүхэн хэлэв.

-Тийм үү? Яагаад тэр билээ? гэж Демирис хайхрамжгүй асуув.

-Чи өнөөдөр ямар өдөр болохыг мартаж орхио юу?

-Би нэг л санахгүй байх чинь гэвэл,

-Би хүүхдээ алснаас хойш яг жил өнгөрлөө. Би чиний хүүхдийг үр хөндүүлж авахуулсна юм гэж Демирисийн хүүхэн хараа нарийсч ирэхийг харан хэлэв.

-Бас тэгээд намайг хэзээ ч хүүхэдтэй болгохгүй байхад анхаарахыг эмч нараас хүссэн юм. тэд ч ажлаа сайн хийсэн шүү гэв.

Демирис биеэ барьж чадахаа болин,

-Муу шулам! гэж хашгиран хүүхний нүүр рүү хэд дараалан алгадав.

Мелина орилон өрөөнөөс зугтан гарсанд демирис түүнийг шатны дэргэд гүйцэн очиж,

-Чамайг ингэсний чинь төлөө би ална даа гэж исгэрэн хэлээд дахин цохиход хүүхэн тэнцвэрээ алдан урт шат уруудан өнхрөн унав.

Доор хэвтсэн хүүхэн өвдсөндөө эхэр татан уйлж,

-Бурхан минь! Намайг авраач! Би гэмтчихлээ гэж орилов.

Демирис хүйтэн нүдээр харж хэсэг чимээгүй зогссоноо,

-Эмч дууд гэж шивэгчинд хэлье. Би болзоондоо хожимдохыг хүсэхгүй байна шүү гэжээ.

* * *

Үдийн өмнөхөн утас дуугарлаа.

-Ноён Ламброу юу? Би доктор Метаксис байна. Таны дүү эмэгтэй надаас тан руу утасдахыг хүссэн юм. Дүү тань манай эмнэлэгт хэвтэж байна. Түүнд гай тохиолдсон болов уу гэж айж байна ...

Спирос эмнэлэг рүү яаран очиж Мелинагийн байгаа өрөөнд ороод түүн рүү айсан нүдээр ширтэв. Мелинагийн гар хугарч, тархи нь доргисноос царай нь хавдаад аймаар болсон байлаа.

Спирос зөвхөн ганц үг,

-Константин гэж хэлэхдээ хоолой нь чичрэв. Мелинагийн нүд нулимсаар дүүрч,

-Тэр ингэхийг хүсээгүй гэж шивэгнэв.

-Би түүнийг ... хийнэ гэдгээ амь амьдралаараа тангаргалая!

Спирос хэзээ ч ингэтлээ ухаанаа алдатлаа уурлаж байгаагүй билээ. Мелинаг ингэсэн гэж бодохоос л хамаг бие нь салгалан уур нь оволзоно. Түүнийг таслан зогсоох л хэрэгтэй. Харин яаж? Ямар нэгэн арга байх л ёстой. Тэр өөрөө юу ч бодож чадсангүй. Тийм болхооро урьдын адил мадам Пирисээс зөвлөгөө авахаар гэнэт шийдэв. Тэр авгай л түүнд тус болж чадна.

Түүн рүү явах замдаа Ламброу: "Миний найз нөхөд намайг төлөгч авгайтай ажил төрлөө зөвлөдөг гэж сонсвол лав шоолон инээлдэх байх даа. Даанхц өөр ымаар ч арга алга". Үнэхээр ч мадам Пирисын таамаглан хэлсэн болгон ямагт таарч тохирдогт хэргийн учир байгаа билээ. "Тэр л надад туслах ёстой" гэж тэр бодно.

Тэд муухан гэрэлтүүлэгтэй цайны газрын бүрэнхий буланд сууцгаана. Сүүлчийн уулзалтаас хойш авгай нилээд хөгширснийг Спирос ажиглав. Спирос,

-Мадам Пирис, надад таны тусламж хэрэгтэй байна гэвэл авгай чимээгүй толгой дохив.

-Юунаас эхлэх вэ? ... Байз, хагас жилийн өмнө нэг шүүх хурал болсон юм. Кэтрин Дуглас гэдэг эмэгтэйг ...

Мадам Пирисын царай хувирч,

-Үгүй ээ гэж гонгинолоо.

Спирос түүн рүү самгардан харж,

-Түүнийг тэд алсан ... гэтэл мадам Пирис ухасхийн босож,

-Үгүй! Сүнснүүд надад түүнийг үхэж байгаа гэж хэлж байна гэлээ.

Спирос Ламброу гайхан бувгнаж,

-Тэр чинь аль хэдийн үхсэн шүү дээ ... гэтэл,

-Тэр амьд! гэж дуу алдлаа.

Спирос гайхсандаа хэлэх үгээ олж ядан,

-Байж боломгүй юм! гэлээ.

-Тэр энд ирсэн. Гурван сарын өмнө над дээр ирсэн. Тэд түүнийг сүмд нууж байсан юм билээ.

Спирос ярих чадвараа алдан авгайг гөлрөв. Одоо л бүх юм байр байраа олох шиг гэнэт санагдлаа. "Тэд түүнийг сүмд нууж байжээ. Кэтрин Дугласыг алсан гэж үзсэн яг тэр тосгон болох Янинагийн сүмд Демирис даанч их өргөл барьц өгөх дуртай байдаг юм. Георгиос Латогийн өгсөн мэдээлэлтэй бүх юм давхардан тохирч байна шүү. Демирис Кэтрин Дугласыг амьд мэнд эрүүл саруул байхад нь сүмийн зузаан хананы цаана нууж орхиод огт гэмгүй хоёр хүнийг үхэл рүү нь илгээсэн байна".

Одоо Ламброу Константин Демирисыг хэрхэн устгахаа мэдэж авлаа.

"Тони Риццоли".

Тэр л одоо хэрэг болно доо.

Арваннэгдүгээр хэсэг

Тони Риццолигийн хувьд амжилтгүй явдлууд үргэлжилсээр байв. Хэдийгээр үүнд түүний буруу байх боловч Өрх-гэрийхэн бүх бурууг ганц түүнд тохох нь ойлгомжтой. Өөрийгөө хэрхэн өмгөөлөх нь тэдэнд сонин биш.

Хар тамхи тээвэрлэж авчирах эхний шат бүтэлтэй явагдсан нь байдлыг улам баргар төрхтэй болгож орхижээ. Тэрээр Афинаас Нью-Йорк орох онгоцны нэгэн үйлчлэгч залууг хахуульдаж авч амжсан боловч гай болоход тэр нь согтуугаар машин жолодоож яваад цагдаад баригдаад ажлаасаа халагдчихжээ.

Тони Риццоли өөр нөөц арга хэрэглэхээр зэхэж өөртөө нэгэн ачаа хүргэгч олсон нь Афинд байдаг охиноо эргээд буцаж яваа далан настай жуулчин эмэгтэй Сара Мерчисон ба тэрээр түүний илгэн цүнхийг Нью-Йорк хүртэл авч явахыг зөвшөөрсөн ч дотор нь харин юу байгааг нь огт төсөөлөөгүй байжээ.

-Наад дотор чинь миний ээждээ авч өгөхөөр амласан бэлэг дурсгалын зүйлс байгаа юм. Танд талархсандаа онгоцны тийз худалдан авч өгөх хүсэлтэй байна, хатагтай гэж Тони түүнд хэлэв.

-Өө, тэгэх хэрэг огт үгүй гэж Сара Мерчисон эсэргүүцэн,

-Би танд туслахдаа дуртай байна. Танай ээжийнхээс би холгүй суудаг юм байна. Түүнтэй танилцахдаа их таатай байх болно гэлээ.

-Түүнд ч мөн адил гэдэгт итгэлтэй байна хэмээн Тони зоримог хэлэв.

-Түүний бие жаахан тааруу байгаад л хамаг зовлон байгаа юм. Гэхдээ хэн нэг хүн энэ цүнхийг заавал тосож авах ёстой гэв.

Бараа зөөгчийн дүрд америк эмэгтэй сайхан зохиж байлаа.

Сара Мерчисон маргааш өглөө нь Нью-Йорк руу нисэх байв.

-Би таныг замаараа дайрч аваад нисэх буудал хүргэж өгье.

-Маш их баярлалаа, та тун халамжтай хүн залуу юм. Таны ээж хүүгээрээ тун их бахархадаг байх даа.

-Тиймээ, бид бие биедээ их дотно байдаг гэж Тони хариулав.

Гэтэл үнэн хэрэгтээ Тонигийн ээж нас бараад аль хэдийнэ арван жил өнгөрсөн байсан юм.

Маргааш өглөө нь Тониг явуулах бараагаа агуулахаас авч бэлдчихсэн хойно утас дуугарав.

-Ноён Риццоли юу?

-Би сонсож байна.

-Афин хотын төв эмнэлэгийн "Түргэн тусламж" -ын эмч Пацака ярьж байна. Манайд хатагтай Сара Мерчисон ирсэн бөгөөд тэр өчигдөр усанд унаад хөлөө хугалж орхисон юм. Тэгээд санаа зовж байгаагаа танд дуулгахыг хүссэн юм. Тэр их харамсаж байгаагаа ...

-Чөтгөр! гэж хараал урсгаад Тони харилцуураа шидэж орхив. Дахиад л бүтэлгүйтлээ. Ачаа хүргэх хүн хаанаас олох вэ?

Риццоли туйлын болгоомжтой байх болжээ. Грекийн засгийн газартай хамтарч ажилладаг мансууруулах бодис наймаалагчидтай тэмцэх албаны америкийн нэр цуутай агент Афинд ирсэн гэх цуу яриа гадуур дуулдах болсон байв. Тэд Афинаас гарч явж байгаа бүх нисэх болон усан онгоцнуудыг тогтмол шалгаж эхэлсэн байлаа.

Энэ бүхэн багадсан юм шиг бас нэг төвөгтэй асуудал гарч ирэв. Түүний мэдээлэгчдийн нэг хулгайч мансууруулах бодисын донтой этгээдийн хэлснээр бол цагдаагийнхан хар тамхи болон бусад хориотой бараа нуусан байж болзошгүй агуулах газруудыг шалгаж эхэлсэн байв. Хавчлага шахалт улам ихэсчээ. Байдлыг Өрх-гэрийхэнд танилцуулах цаг хэдийнэ болжээ.

Тони Риццоли буудлаас гарч Патисон гудамж уруудан явж хотын телефон утасны станц руу очихоор шиглэв. Тэрээр зочид буудлын утасны аппаратанд сонсох төхөөрөмж тавьсан байж магадгүй хэмээн сэжиглээд аз туршихыг хүссэнгүй.

Телефон утасны станц гэдэг нь том баганатай хүрэн чулуун байшин байв. Тони байшинд орж эргэн тойрноо ажиглавал хананы дагуу арван хоёр бүхээг бүхий кабин байх ба түүний доторхи бяц хан ширээ болгон дээр дэлхийн өнцөг булан болгоны улсуудын утасны лавлах тавиастанд байна. Өрөөний голд албан хаагчид захиалга хүлээн авах лангуу байрлана. Тэр болгоны өмнө урт дараалал үргэлжилсэн байв.

Тони нэг лангууны дэргэд дөхөн очиж ажилтанд хандан,

-Өглөөний мэнд гэв.

-Танд юугаар тус болохсон бол?

-Би олон улсын захиалга өгөх гэсэн юм.

-Та гучин минут хүлээх хэрэгтэй болно.

-Хүлээе.

-Та ярих улсынхаа нэрийг утасныхаа дугаарын хамт хэлнэ үү.

Тони Риццоли эргэлзэж эхлэв.

-Тэгье гээд хүүхэнд хуудас цаас сарвайн өгч:

-Миний ярих хүн төлбөрийг нь төлнө байх гэв.

-Таны нэр?

-Браун, Том Браун.

-Ноён Браун. Таны өгсөн дугаарт холбогдмогц би танд мэдэгдэе.

Тони хананы дэргэдэх сандалд очиж суув. "Би боодолтойгоо машинд ачаад ахиухан мөнгө төлөөд хил давуулж болох юм. Гэхдээ энэ бас л осолтой. Бүх машинуудыг шалгаж байгаа. Өөр л юм бодож олхоос..."

-Ноён Браун ... Ноён Том Браун.

Залгагч хүүхэн хоёр дахиа дуудахад л Тони сая сэхээрэн босож лангуу руу очив.

-Таны ярих хүн төлөхийг зөвшөөрсөн тул долдугаар бүхээгт орно уу.

-Баярлалаа. Та миний дугаар бичсэн хуудсыг эргүүлж өгнө үү. Тэр надад хэрэг болж магадгүй.

-Өө тэгэлгүй яахав гээд хүүхэн хуудсыг өгөв.

Тони долдугаар бүхээгт орж хаалгаа хаав.

-Сайн уу.

-Тони? Чи юу?

-Ай даа. Пит чи тэнд ямар байна?

-Үнэнийг хэлэхэд багагүй сандарч байна даа, Тони. Илгээмж замдаа гарсан гэж манай залуус найдаж байгаа шүү.

-Янз янзын саад гарч ирээд болохгүй байна.

-Илгээмж замд гараагүй юу?

-Одоо болтол үгүй л байна.

Хэсэг чимээгүй болов.

-Бид ямар нэг эвгүй юм тохиолдоосой гэж хүсэхгүй байна шүү, Тони.

-Юу ч болохгүй ээ. Харин явуулах арга л бодож олох хэрэгтэй байна. Энд чөтгөрийн муусайн мөрдөгчид хаа сайгүй холхилдоод болдоггүй.

-Арван сая долларын яриа явагдаж байгааг ойлгож байгаа биздээ? Тони?

-Мэднээ. Бүү санаа зов. Би ямар нэг юм бодож олно.

-Тэгээрэй. Хичээж үзээрэй.

Харилцуурт богино тасалдсан дуу сонсогдов.

Тониг гарах хаалга руу явахыг харсан саарал костюмтэй хүн лангууны ард суугаа эмэгтэй рүү очин,

-Сайн уу? Та тэр хүнийг харж байна уу? гэсэнд хүүхэн толгой өргөв.

-Надад тааний залгуулсан дугаар хэрэгтэй байна.

-Уучлаарай, би тийм мэдээлэл өгөх эрхгүй.

Нөгөө хүн өмднийхөө арын халааснаас түрийвч гарган дотроос нь шар өнгөтэй тэмдэг бэхэлснийг харуулан,

-Цагдаагийн газраас явна. Би мөрдөгч Тиноу гэж хэлэв.

Хүүхний царай зөөлөрч,

-Ойлголоо. Тэр надад утасны дугаар бичсэн цаас өгөөд дараа нь буцааж авсан.

-Гэхдээ та дэвтэр дээрээ тэмдэглэл хийсэн биз дээ?

-Тэгэлгүй яахав.

-Тийм бол надад дугаарыг нь өгнө үү.

-Жаахан хүлээнэ үү.

Хүүхэн дэвтрээ нээж хуудас цаасан дээр дугаар бичээд түүнд өглөө. Мөрдөгч хэсэг зуур харж байгаад улсын код 39, телефоны станц 91, итали, Палермо гэж тогтоож авав.

-Талархаж байна. Та энэ хүний нэрийг санамсаргүй тогтоож орхиогүй байгаа?

-Тогтоосон шүү, Том Браун гэсэн.

* * *

Утсаар ярьсан яриа Тони Риццолиг сэтгэлээр унагаж орхив. Тэр бие засах газарт очих яаралтай хэрэгтэй байсан тул "Энэ муу Пит Люккаг чөтгөр аваасай!" гэж бодсоор өмнө нь байх WG бичигтэй байшинг харж тэр зүг яаран алхлаа. Эрэгтэйчүүдийн адил эмэгтэйчүүд ч энэ жорлонг ашиглаж болох ажээ. "Энэ муусайн грекүүд өөрсдийгөө бас соёл иргэншилтэй улс үндсэтэн гэж боддогийг яана. Ой гутмаар юм!" хэмээн Риццоли дотроо бодно.

Палермо руу харсан уулын роойд байрлах шилэ шилтгээний тагтан дээр ширээ тойрон дөрвөн эр сууна.

-Ачаа хэдийнэ наашаа гарсан байх ёстой шүү дээ, Пит. Юу болоод байгаа юм бэ? гэж нэг нь хэлэв.

-Яг нарийн учрыг нь хэлж чадахгүй нь. Тони Риццолид л хамаг учир байгаа байх.

-Одоог хүртэл Тони хэвийн л байсан юмсан.

-Мэдэж байна ... Гэхдээ зарим үед хүмүүс шуналд автагддаг юм. Түүнийг тэнд юу болоод байгааг лавлахаар хэн нэгнийг Афин руу явуулбал таарна.

-Муу л байна даа. Тэр Тони үргэлж надад таалагддаг байсан юмсан.

Афины доод хэсэгт байрлах Стадио гудамжны 10-т орших цагдаагийн газарт зөвлөгөөн болж байлаа. Тэнд цагдаагийн газрын дарга Ливрери Дмитрий, байцаагч Тиноу, АНУ-ын төрийн яамдын гаалийн албаны агент америк эр Уолт Керри нар байлцав.

-Бидэнд мэдээ бий. Эндээс их хэмжээний мансууруулах бодис илгээхээр бэлтгээд байгаа тухай мэдээ ирсэн. Түүнд Тони Риццоли холбоотой юм байна гэж Келли хэлэв.

Байцаагч Тиноу дуугуй л байлаа. Грекийн цагдаагийн газрыхан тэдний ажилд өөр орны ажилтнуудыг ялангуяа америкчууд хутгалдахад тун дургүй. "Тэр дэндүү биедээ эрдсэн байх юм" гэж дотроо дургүйлхэнэ.

Цагдаагийн газрын дарга,

-Бид энэ хэрэг дээр ажиллаад эхэлсэн шүү, дэслэгч ээ. Тони Риццоли саяхан Палермо руу ярьсан. Чухам хэнтэй ярьсныг нь бид тодруулахаар оролдож байна. Тэгээд түүний холбоо сүлбээтэнг илрүүлэх болно гэв.

Түүний ширээд дээхр утас дуугарсанд Дмитрий байцаагч Тиноу хоёр харц солилцлоо.

Тиноу харилцуур авч,

-За яав, мэдэж чадав уу? гэж асуугаад хэсэг зуур дуугуй чагнаснаа харилцуураа тавив. Түүний нүүр царайны илрэл өөрчлөгдсөнгүй.

-За яав?

-Тэд цөмийг тодруулжээ,

-Тэгээд юу гэж байна?

-тэр хотын талбай дээрх утасны бүхээгээс ярьсан байна.

-Сайн байна!

-Манай Тони маань ихээхэн inch ескирнос юм даа.

Уолт Келли ууртайгаар,

-Би грекээр ойлгодоггүй гэж хэлэв.

-Өршөөгөөрэй. Би түүнийг "зальтай хүн" гэж хэлсэн юм дэслэгч ээ.

-Би танаас түүнд тавих ажиглалтаа хүч нэмэгдүүлээсэй гэж хүсмээр байна гэж Келли хэлэв.

"Өөрийгөө хэтэрхий их юманд бодох юм"

Дмитрий байцаагч Тиноу руу харж,

-Үүнээс ч илүү ноцтой арга хэмжээ авахад хүргэхээр баталгаа бидэнд байгаа юу?

-Үгүй, эрхэмээ. Зөвхөн хүчтэй сэжиглэж л байгаа юм.

Дмитрий шеф Келли руу эргэн,

-Бид хар тамхины наймаа хийж байгаа гэсэн сэжигтэй хүн болгоны араас мөрдөнө гэвэл хүч хүрэлцэхгүй нь мэдээж гэж айж байна гэхэд,

-Гэвч Риццоли бол ...

-Ноён Келли, бидэнд мэдээллийн эх булаг бий гэж танд итгүүлье. Шинэ юм олж мэдмэгцээ танд дуулгая.

Уолт Келли түүн рүү гайхан харж,

-Битгий л хожимдож үзээрэй дээ. Эс тэгвэл бараа бидний гараас мултраад алга болно шүү гэв.

"Рафина" харшийг авахад бүх юм номоороо болов. Үл хөдлөх хөрөнгийн наймаачин Константин Демирист хандан,

-Та харшийг тавилгатай нь худалдаж авна гэл үү, гэвч та хүсвэл тавилгыг нь сольж болно шүү гэхэд,

-Үгүй. Ямар байсан тэр янзаараа л байж байг гэж хэлэв.

Түүний үнэнч бус амраг Ноэлль нууц амраг Ларридаа зориулж зассан тэр л янзаараа бүх юм харагдаж байх ёстой.

Тэрээр зочдын өрөөнд оров "Магадгүй тэд яг энэ шалан дээр нүглээ үйлдэж байсан байх? Эсвэл өрөөнд үү? Гал тогоонд ч байж магадгүй?" гэж бодсоор Демирис унтлагын өрөөнд орвол буланд нь том гэгчийн ор тавиастай байв. Тэдний ор байх нь. Дээр нь Ларри нүцгэн хэвтэх Ноэллийн бие хааг илж таалан тэнд л Демирисын байх ёстой бүхнийг хулгайлан авсан байна. Дуглас хийсэн болгоныхоо хариуг нэг удаа төлсөн. Гэвч одоо дахин нэг удаа төлөх

болно. "Эхний удаад би Кэтийг яг энд эзэмдэнэ дээ. Дараа нь бусад өрөөнд, гэхдээ өрөө болгонд..." гэж тэр дотроо бодно.

Тэр харшаас Кэтрин руу залгалаа.

-Сонсож байна.

-Би таны тухай бодож байлаа.

* * *

Сициллээс Тони Риццоли дээр гэнэт хоёр зочин иржээ. Тэд шуудхан өрөөнд нь ороод ирсэн тул Тони шууд л аюулыг сэтгэлээрээ мэдэрч эхлэв. Альфредо Манкузо бол аварга бахим эр байсан бол Жино Лавери нь бүр ч том биетэй эр билээ.

Манкузо шууд яриандаа орохоор шийдэн,

-Биднийг Пит Люкка явууллаа гэлээ.

Риццоли сандарснаа нуухыг оролдон,

-Сайн байна. Афинд тавгай морилогтун. Юу тушаах бол? гэхэд,

-Жүжиглэхээ больж үз, Риццоли. Пит чамайг ямар тоглоомоор наадаад байгааг чинь мэдэхийг хэсэж байгаа гэв.

-Тоглоом гэнээ? Чи юу ярина вэ? Би түүнд бэрхшээл гараад байна гэж тайлбарласан шүү дээ.

-Тэгээд л бид энд ирлээ. Чамд туслуулахаар биднийг явуулсан юм.

-Хүүхдүүд ээ, жаахан азна л даа. Барааг найдвартай газар нуусан байгаа. Хүссэн ...

-Пит барааг нуухыг хүсэхгүй байгаа. Тэр түүнийг мөнгө болгох хүсэлтэй байгаа гээд Лавери Риццолиг сандал руу түлхэж суулган:

-Алив би чамд нэг сиан ойлгуулаад өгье. Хэрэв нунтаг Нью-Йоркын гудамжинд хүрчихсэн байсан бол Пит аль хэдийнэ мөнгөө олж аваад дахиад нэг эргүүлж болох байсан юм. Одоо сэхээрэв үү! гэлээ.

"Би энэ бичнүүдийг ч дөнгөх л байх л даа" гэж Тони дотроо бодсон ч тэднэтэй биш Пит Люкатай зодолдох болсноо ухаарч байв.

-Чиний ярьж байгааг би ойлгож байна. Гэхдээ энд байдал хурцдаад эргэн тойрон грекийн цагдаа нар, дээр нь ядаж Вашингтоноос хар тамхитай тэмцэх албаны ажилтан ирж нэмэгдчихээд байна л даа. Гэвч надад төлөвлөгөө байгаа.

-Питэд ч бас төлөвлөгөө байгаа гэж Лавери үгийг нь таслан хэлээд:

-Ямар гэдгийг нь мэдэх үү? Хэрэв бараа энэ долоо хоногтоо багтаж замд гарахгүй бол чамаар өөрөөр чинь мөнгө олуулна гэж тэр дуулгаарай гэсэн.

-Хүүе хүүе. Надад тийм их мөнгө байхгүй. Би ...

-Байхгүй гэдгийг Пит мэдэж байгаа. Тэгээд ч тэр чамаар заавал төлүүлэх өөр арга олохыг бидэнд тушаасан юм.

Тони Риццоли гүнзгий амьсгаа аван,

-За за. Бүх юм хяналтын дор байгаа гэдгийг цаадахдаа хэлж үз гэв.

-Тэгье. Би түүнд чалчаа үгийг чинь дамжуулъя. Чамд ганц долоо хоног л бий шүү.

Тони Риццоли үд дундаас өмнө хатуухан юм хэзээ ч амсахгүй гэж өөртөө амласан боловч сициличүүдийг явмагц виски задлан хоёр ч том балгаж орхив. Хэдийнээ доторо халавч санаа нь өчүүхэн ч болов дээрдсэнгүй,

"Юу ч тус болохгүй нь. Муу хөгшин намайг яагаад ад үзэх болов доо? Би бараг л хүү шиг нь байдагсан. Гэтэл тэр надад ганц долоо хоног өгж ч байх шиг. Надад ачөө зөөгч хэрэгтэй. Казино орё, тэндээс л эрэхээс гэж тэр бодлоо.

Оройн арван цагт Пиццоли Афинаас баруун тийш тавин милийн зайтай орших цуутай казино руу явлаа. Тэрээр "Лоутраки" хэмээн казиногийн шуугиант танхимаар удаан алхлан хүмүүсийн хэрхэн тоглохыг ажиглана. Хамаг мөнгөө шавхан тоглоод хожигдож байгаа хүн ч үзэгдэнэ.

Хэдий чинээ их мөнгө алдаж аргаа барах тусам тийм хүн түүний арганд амархан автах болно. Тони рулета тоглож буй ширээний дэргэд очоод өөрийн золиос болох хүнийг шууд л олж танив. Энэ бол шувуун царайтай жижигхэн туранхай тавь хэрийн насны буурал өвгөн байсан бөгөөд нусны алчуур гарган хөлөрсөн духаа байнга арчина. Хожигдох тусмаа улам их хөлөрнө.

Риццоли түүнийг анхааралтай ажиглав. Энэ бүх шинж тэмдэг түүнд хэдийнэ танил санагдана. Хүн хичнээн хожигдох тусам биеэ барьж дийлэхгүй улам саарах энэ сонгодог тохиолдлыг тэр сайн мэднэ.

Тэр хүний өмнө нэг ч хасаагүй болоход тоглуулагчид хандан,

-Би ... би зээлээр дахиад хасаа авмаар байна гэлээ.

Тоглуулагч эзэн рүүгээ харахад цаадах нь,

-Өг өг. Сүүлчийн удаа шүү гэлээ.

"Тэд түүнийг хэдээр шатаасна бол, сонин оо?" гэж Тони залхуутайяа бодон зэрэгцэн суугаад тоглож эхлэв. Рулета ёстой эргүү хүний тоглоом байсан боловч Риццоли овоо сайн тоглодог

болохоор түүний өмнөх хасаа овоорч нөгөө хүнийх багассаар байлаа. Тэр хүн бүх хасаагаа ширээгээр тараан өнгө, дугаараар нь тавьж орхиход "Тэр юу хийж байгаагаа өөрөө ч мэдэхгүй байна" гэж Тони бодов.

Сүүлчийн хасаануудаа алдаж дуусаад үл таних эр хөшсөн мэт гөлийн сууснаа хасаа хураагчийг ширтэн,

-Би дахиад ...? гэхэд тэр нь толгой сэгсрэн,

-Өршөөгөөрэй гэлээ.

Нөгөө хүн санаа алдаад бослоо. Риццоли түүнтэй зэрэг шахуу босоод,

-Аз таарсангүй юу? гэж өрөвдөнгүй хэлээд,

-Би харин жаахан хожсон болохоор таныг дайлмаар байна гэвэл нөгөө эр гайхан хоолой нь чичирч,

-Та тун эелдэг хүн юм, эрхэмээ гэлээ.

"Би ч бараа тээгчээ олов бололтой" гэж Риццоли бодно. Энэ хүнд мөнгө хэрэгтэй нь эргэлзээгүй. тэр мэдээж гэмгүй нэгэн боодолтой юмыг Нью-Йоркд хүргэж өгөөд хэдэн доллар олохыг дуртайяа зөвшөөрөх нь мэдээж.

-Намайг Тони Риццоли гэдэг.

-Виктор Коронцис.

Риццоли Коронцисыг дагуулан баар руу хөдлөв.

-Юу уух вэ?

-Би ... надад мөнгө байхгүй.

Тони мушилзаад,

-Би даая гэв.

-Хэрэв зөвшөөрвөл надад рецины захиана уу.

Риццоли үйлчлэгчид хандан,

-Надад мөстэй виски гэж захиллаа.

-Та жуулчин уу? гэж Коронцис маш эелдэгээр асуулаа.

-Тиймээ, би амарч байна. Сайхан орон юм.

Коронцис мөрөө хавчин,

-Магадгүй.

-Танд энд таалагддаггүй юм уу?

-Өө зүгээр, энд сайхан гэдэг үнэн л дээ. Харин бүх юм их л үнэтэй дээ. Бүх барааны үе өссөн болохоор та саятан л биш бол гэр бүлээ тэжээхэд тун бэрх. Ялангуяа эхнэр дөрвөн хүүхдтэй бол ... хэмээн тэр гаслав.

"Байдал дээрдээд л, дээрдээд л ..."

-Виктор, та юу хийдэг вэ? гэж Тони аяархан асуула.

-Би Афины улсын музейд судлаач хийдэг,

-Нээрээ юу? судлаач хүн юу хийдэг юм?

Коронцисын хоолойд үл ялиг бахархал тодрон,

-Би грекийн нутаг дэвсгэрээс олдсон бүх олдворуудыг судалдаг юм гээд аягтайгаас том балгав.

-Гэхдээ мэдээж бүгдийг биш л дээ. Акрополь, Үндэсний архелогийн музей гээд өөр бусад музейнууд бий гэхдээ хамгийн үнэтэй нь манайд хадгалагддаг юм гэж тэр яринхад сэтгэл нь овоо сэргэснийг Тони ажиглав.

-Хэр зэрэг үнэтэй байх вэ? гэсэнд Коронцис мөрөө хавчаад,

-Ихэнхи нь үнэлж баршгүй үнэтэй дээ. Эртний олдворыг хил давуулахыг хуулиар хориглосонбайдаг боловч манайх жижиг урлантай. Тэнд дуурайлган хийдэг юм.

-Үнэн гэж үү? Сайн дуураймал байх уу даа? гэхэд Риццолигийн толгой тархи жинхэнэ ёсоор ажиллаж эхлэв.

-Өө гайхалтай эд дээ. Зөвхөн шинжээч нар л жинхэнийг нь дуураймалаас нь ялгаж чаддаг юм.

-Дахиад уугаач дээ гэж Риццоли ятгав. Түүний тархины бүх эрэг шураг зохих ёсоор ажиллана.

-Баярлалаа, гэвч би танд хариу тус хүргэж чадахгүйдээ харамсаж байна.

Риццоли инээмсэглэн,

-Энэ талаар бүү санаагаа зовоо гэлээ.

-Гэхдээ та надад ямар нэг талаар тусалж чадах болов уу гэж бодно. Би танай музейг үзмээр байна. Та тун сонирхолтой зүйл ярилаа.

-Тэнд үнэхээр сонирхолтой шүү гэж Коронцис сэтгэл хөдлөн хариулаад,

-Манайх чинь дэлхийн хамгийн сонин музейн нэг шүү дээ. Би танд хүссэн цагт чинь дутайяа үзүүлэх болно. Та хэзээ завтай вэ? гэв.

-Тэгвэл маргааш өглөө болох уу?

Тони Риццоли бараа тээгчээс хамаагүй илүү ашиг орлоготой хүн олчих шиг санагдлаа.

Афины улсын музей Синтагма талбайд Афины төв дунд оршдог эртний сүмийн хийцтэй нүүрэн талдаа дөрвөн том баганатай сүрлэг байшинд байрлах ажээ. Өндөр дээвэр дээр нь грекийн далбаа намирах бөгөө чулуу ухаж урласан дөрвөн дөрс чимнэ.

Музейн танхимд грекийн түүхийн ыназ бүрийн үеийн архелогийн олдвор төрөл бүрийн үзмэрүүд шилэн хоргоны цаана тавьсан байгаа үзэгдэнэ. Тэндий дотор алтан аяга, хааны титэм, эрдэнийн чулуу шигтгэн гоёсон илд сэлэм мөн дарсны сав зэрэг үндэт эдлэлүүд ч байлаа. Хоргонуудын нэгэнд дөрвөн алтадмал, "Үхэгсдэд зориулсан" баг, болон нөгөөхөд нь эртний уран баримлуудын хагархай хэлтэрхийнүүдийг нандигнан хадгалсан байна.

Виктор Коронцис өөрийн биеэр Тони Риццолиг музей дотуур дагуулан явж тайлбарлан өгөв. тэрээр мансууруулагч намуу цэцгэн титэм толгойдоо өмссөн дагины баримлын өмнө очиж зогсоод,

-Энэ бол намуу цэцгийн дагина юм гэж шивэгнэн тайлбарлаад,

-Энэ гөрмөл цэцгэн титэм нь зүүд зөн, далдыг харах шид, үхлийг бэлэгдэж байдаг юм гэлээ.

-Энэ тэгээд ямар үнэтэй эд вэ?

Коронцис инээмсэглэн,

-Түүнийг худалдах болдог юмаа гэж бодоход олон саяын үнэ хүрнэ гэв.

-Нээрээ юу?

Давжаа биет судлаач зочиндоо өгүүлшгүй бахадсан байдлаар үнэлж баршгүй эрдэнэсүүдээ үзүүлэн байж,

-Энэ бол МЭӨ 530 оны үеийн толгой. Энэ бол МЭӨ 1450 оны орчимд амьдарч байсан Афины Палладын толгой коринфын дуулган дотор байгаа нь ... харин энэ бол бараг уран зөгнөлийн гэмээр үзмэр юм юу гэвэл микены хаадын булшнаас олдсон алтан баг, дараагийх нь харин Агамены баг л даа гэж ярив.

-Та юу хэлчихэв ээ!

Виктор Тониг дагуулан өөр нэг хоргоны өмнө аваачив. Тэнд гоёмсог цом тавиастай байв.

-Энэ бол миний хамгийн дуртай эд дээ гэж Коронцис үнэнээ хэлээд,

-Эцэг эх нь хүүхдүүддээ ялгаварлан үздэггүйг би мэднэ л дээ, гэхдээ л ингэхгүй байж чаддаггүйм юм. Энэ цом ... гэсэнд,

-Минийхаар бол ваар шиг л ваар байна шүү дээ гэж Тони гайхав.

-Тиймээ, тэгэлгүй яахав. Түүнийг Коноссос дахь малталтын үеэр хааны өргөөнөөс олсон юм. Түүн дээр торны тусламжтай бухыг номхруулж байгааг үзүүлсэн зураг дүрслэгдсэн бий. Эрт цагт тэдний ариун цусыг цаг нь болоогүй байхад урсгахгүйн тулд бухыг ийм аргаар торлож барьдаг байжээ тэгээд ...

-Ямар үнэтэй эд вэ? гэж Тони яриаг нь тасалж асуув.

-Арван сая орчим доллар хүрнэ гэж бодож байна.

Тони хөмсөг зангидан,

-Энэ үү дээ?! гэж гайхав.

-Тиймээ! Энэ чинь МЭӨ 1500 оны орчим үе буюу хүрэл зэвсгийн үеийн сүүл хавьцаа хамаарах эд эгдгийг битгий мартаарай даа.

Тони архелогийн олдвороор дүүрэн байгаа шилэн хоргонуудыг сонирхол дүүрэн ажиглан явна.

-Эд чинь ийм их үнэтэй гэж үү?

-Өө мэдээж үгүй. Зөвхөн эртний бөгөөд жинхэнэ нь л тийм их үнэтэй юм. Эд нар чинь цөм цор ганц ширхэг байдаг бөгөөд эрт дээр цагт хүмүүс хэрхэн амьдарч байсны соёл иргэншлийн бяц хан боловч төсөөллийг бидэнд өгнө шүү дээ. Та үүнийг хар л даа.

Коронцисын хамтаар Тони танхимын буланд байрлуулсан хорго тийш очив.

Виктор хоргон доторх ваар тийш зааж,

-Энэ манай хамгийн үнэтэй олдвор. Түүний дээр авиа зүйм тэмдэгтүүдийг бэлэгдэн дүрсэлсэн бий. Энэ төрлийн анхны олдвор нь энэ юм. Энэ хэрээс бүхий тойрог дүрс бол хүн төрөлхтөний нэн эртний анхны "сансар" хэмээх ойлголтыг илэрхийлсэн дүрс. Дэлхий дээр зөвхөн л ...

-Хэд байдаг нь надад ёстой пад алга. Нулимж орхино, харин ямар үнэ хүрэх эд вэ? гэж Тони шаардангуй асуув.

Коронцис санаа алдан,

-Үнэ нь тоо тоомшгүй, хязгааргүй үнэтэй гэсэн үг гэлээ.

Музейгээс эргэж ирээд Тони өглөөжингөө зүүдэндээ ч үзээгүй тийм их баялгийг тооцож суув. Тэрээр энэхүү зүгээр хэвтэж байгаа алтыг ямар нэг аргаар олж эзэмшихийг л жинхнээсээ мөрөөдөж байлаа. Өөртөө ачаа зөөгч удаан эрсэн атал бас эрднэсийн сангийн түлхүүрийг олоод авдаг байжээ. Геройн зарлаа гээд түүнийг зургуул хувааж авах болно. Өрх-гэрийхэнтэй тоглох аюултай гэдгэ нь тодорхой. Хэрэв тэр грекээс энэ бүгдийг гаргаж дөнгөвөл бүх орлого зөвхөн түүнийх облно. Мафи үүнд савра дүрж чадахгүй. Тонигийн сэтгэл санаа ихэд өндөр байв. "Загас барьдаг шиг л амархан юм. Ачаа зөөгчийг дараа л бодъё" гэж тэрээр бодлоо.

Тэр оройдоо Тони шинэ найзтайгаа тоглолтын дараагаар хэн нь ч гэсэн таны өвөрт дуртайяа шургах бүжигчин хүүхнүүдийн сонголт ихтэй нэгэн шөнийн цэнгээний газар очив.

-Алив хоёр сайхн хүүхэн олж аваад амрах уу даа гэж түүнийг санал болгоход,

-Би гэртээ харих ёстой. Түүнээс гадна би ийм юм хийж чадахгүй байх гэж айж байна гэж Виктор эсэргүүцлээ.

-Та миний зочин. Манай фирм энд зээлийн данстай. Надад нэг ч цент төлөх хэрэг гарахгүй.

Риццоли нэг хүүхэнтэй тохиролцсон ба Коронцисыг суудаг зочид буудалдаа урьжээ. Коронцис гайхан,

-Та явахгүй юм уу? гэсэнд,

-Надад бага сага ажил байна. Алив суугаад хөдлөөрэй. Бүгдийн үнийг төлсөн байгаа гэлээ.

Маргааш өглөө нь Тони музей оржээ. Тэнд жуулчид шилэн хоргон доторховоолсон эрдэнэс тийш амаа ангайн гайхширан харж зогсоно. Коронцис Тног өрөөндөө оруулан ихэд ичиж зовсон шинжтэй байлаа.

-Би ... өчигдөр оройн хувьд танд яаж баярлаж байгаагаа хэлж мэдэхгүй байна. Тони, ай ... тэр хүүхэн ёстой гайхалтай байсан шүү гэхэд Риццоли инээж,

-Найз нөхөд гэдэг чинь юуны тулд байдаг билээ дээ, Виктор? гэлээ.

-Гэхдээ би танд бас л юугаар ч тусалж чадахгүй нь байна.

-Надад чамаас хүсэх юм байхгүй гэж Риццоли сайхан сэтгэл гарган хэлээд,

-Чи надад таалагдаж байна. Чамтай хамт байхад их сайхан юм. Өнөөдөр нэгэн зочид буудалд покер тоглоом зохион байгуулах юм гэсэн. Би тоглох бодолтой байгаа. Чи цуг явах уу? гэвэл,

-Баярлалаа, их хүсэж байгаа ч ... Хэрэггүй биздээ гэлээ.

-Зүгээр дээ. Мөнгөнд санаа зовж байгаа бол би чиний төлөө тавья.

Коронцис толгой сэгсрэн,

-Та үнэхээр эелдэг хүн юм. Хэрэв би хожигдчихвол танд тооцоогоо төлөхгүй гэсэн үг үү? гэвэл,

-Хэн таныг хожигдоно гэсэн юм? Танд бүх зүйл гарын дор байна гэв.

-Гарын дор гэнэ ээ? Энэ чинь юу гэсэн үг юм? Би ... нэг л ойлгохгүй байна гэв.

-Миний найз Отто Делтон тоглоомыг удирдана. Мөрийтэй тоглоомд хорхойтой баян америк жуулчид хотоор дүүрэн байна. Отто бид хоёр тэднийг болгож тавих санаатай.

Коронцис түүн рүү ндүүэ бүлтийлгэн хараад,

-Юу гэнээ? Та ... тэднийг болгож тавина гэсэн үү? Би ... ийм юмаар оролддоггүй гэж хэлээд уруулаа долоолоо.

Риццоли өрөвдсөн янзтай толгой дохин,

-Ойлгож байнаа. Хүсэхгүй бол хэрэггүй ээ. Би чамайг тэндээс хоёроор гурван мянган доллар смаардаж орхих болов уу гэж бодсон юмсан гэвэл нүд нь бүр томрон,

-Хоёр гурван мянга ий? гэхэд,

-Тиймээ, түүнсээ ч илүү байж мэднэ гэлээ.

-Би ... би ... энэ чинь аюулгүй юу тэгээд? хэмээн Коронцис уруулаа шилэмдэн арай гэж хэлэв.

Тони Риццоли инээн,

-Аюултай байсан бол би юунд ийм юмаар оролдох вэ дээ? Бүх юм тун хялбархан. Отто энэ талын мэргэжилтэн. Тэр багц хэзрийг дээр доор дундаас нь бас тараадаг, олон жил ингэж тоглохдоо нэг ч удаа балраагүй юм шүү.

Коронице түүнийг дуугуй ширтээд,

-Тоглоом эхлэхэд надад хэд хэрэгтэй вэ? гэж асуув.

-Ойролцоогоор 500 доллар. Гэхдээ чамд л гэж хэлэхэд энэ хэрэг даанч найдвартай учраас би чамд 500 доллар зээлдүүлж орхиё. Хэрэв чи хожигдвол надад түүнийг буцааж өгөхгүй байж болно.

-Таны зүгээс туйлын найрсаг хэрэг Тони ... гэвч яагаад миний төлөө энэ бүгдийг хийгээд байгаа юм бэ?

-За яах вэ, би хэлье л дээ гээд Тонигийн хоолой үнэмшилтэй нь аргагүй уурласан өнгөтэй болж,

-Би чам шиг ийм журамтай, ажилсаг, улсын нэгэн томоохон музейд судлаачаар ажилладаг бөгөөд улс тэр хүнд гэр бүлээ тэжээхэд нь хангалттай мөнгө төлдөггүй хүмүүстэй учрахаараа, Виктор минь, энэ бүхэн надад таалагддаггүй гэдгийг би чамд хэлэх гэсэн юм. Хамгийн сүүлд чиний цалинг хэзээ нэмсэн? гэсэнд,

-Манайд цалин нэмдэггүй юм шүү дээ гэж нөгөөдөх нь гайхан хариулав.

-За тэр, харав уу! Шийд л дээ, Виктор минь. Өөрөө л мэд. Чи надаас хэдхэн доллар аваад хэдэн мянган доллар хожмоор байна уу? үүгээр чи хангалттай сияхан амьдарч чадна, эсвэл бүхэл амьдарлынхаа турш хоногийн хоолтой арай гэж залган амь зуумаар байна уу, шийдэж үз.

-Би .. би эмдэхгүй байна, Тони. Би тэгэх ёсгүй...

Тони Риццоли босож,

-Ойлгож байна. Хоёр жилийн дараа би Афинд эргэж ирж магадгүй. Тэгвэл уулзамз. Танилцахада таатай байлаа, Виктор гэсэнд Коронцис,

-Хүлээгээрэй. Би ... би өнөө орой тантай хамт тийшээ очно гэлээ.

"Ингээд миний дэгээг үмхэх шив дээ!"

-За тэр гайхал минь, хэцүү цагт чамд туслахад надад таатай байна.

Короницс бага зэрэг эргэлзэн,

-Би таныг зөв ойлгосон гэдэгтээ итгэлтэй баймаар байна. Би 500 доллар танаас авч тоглоод алдчихвал буцааж өгөх албагүй гэж та хэлэв үү? гэхэд,

-Яг тийм. Яагаад гэвэл чи хожигдохгүй. Тэнд бүх юм сияхан зохицуулагдсан байгаа.

-Тоглоом хаана явагдах юм бэ?

-"Метрополь" зочид буудал, 24 дүгээр өрөө. Оройн 10 цагт шүү. Авгайдаа ажил дээрээ оройтно гэж хэлээрэй.

Арван хоёрдугаар хэсэг

Тони Риццоли, Виктор Коронцис хоёроос гадна өөр дөрвөн хүн буудлын өрөөнд цугласан байв.

-Миний нөхөр Отто Делтонтой танилц гэж Тони хэлээд,

-Энэ бол Виктор Коронцис гэлээ.

Эрчүүд гар барилцав.

Тони бусад хүмүүс рүү асуусан янзтай харж,

-Бусад жентельменүдтэй би танил юм шиг санагдана гэлээ.

-Детройтоос ирсэн Перри Бреслаур, Гудзоноос ирсэн Марвин Сеймор, Нью-Йоркоос ирсэн Сэл Пирззи ...

Виктор Коронцис зөвхөн толгой л дохихоос өөр юмгүй дуугархаасаа ч айн суув.

Отто Делтон бол бууралтаж яваа, хатингар биетэй жар гаран насны биеэ зөв авч явдаг хүн байв. Перри Бреслаур арай залуухан боловч зовж зүдэрсэн царайтай ажээ. Харин Марвин Сеймор мөн л туранхай боловч нүдэнд дулаахан эр байлаа. Сэл Приззи аварга том биетэй царс модыг санагдуулан ажээ. Нүүрэн дээрээ хөндлөн сорвитой бөгөөд жижигхэн хүйтэн харцтай нүдээ гялалзуулсан эр байлаа.

Риццоли урьд нь Викторт тоглоом ямар болохыг хэлж амжсан байжээ. "Тэд маш их хөрөнгөтэй залуус. Оло удаа хожигдсон ч цаадуул чинь хоосрохгүй. Сеймор бол худалдааны компаны эзэн хүн. Бреслаур нэгдсэн улса даяар машин наймаалдаг хүн. Харин Приззи бол Нью-Йорк дахь том эвслийг удирддаг." гэж тайлбарлан ойлгуулсан байв.

-За жентельменүүд ээ, эхлэх үү дэ? Цагаан хасаа таван доллар, цэнхэр нь арав, улаан нь хорин тав, хар нь тавин долларынх. Одоо мөнгөө үзүүлцгээнэ үү? гэж Отто Делтон тэдэнд хандан хэлэв.

Короницс Риццолигоос зээлсэн таван зуун долларыг гаргаж ирэхдээ "Үгүй ээ, зээлдүүлсэн бус зүгээр л өгсөн" гэж дотроо бодов. Тэгээд Риццоли тийш харж инээмсэглэн "Юутай сайн найз вэ!" хэмээн бодов.

Бусад нь ч бас багц мөнгө зузаан боодол доллар гарган тавьцгаалаа.

Короницс гэнэт санаа нь зовов. Хэрэв тэр 500 доллар алдахад хүрвэл яах вэ? энэ бодлоо тэр таягдан хаялаа. Түүний найз Тони бүгдийг бодсон байгаа. Тэр хожвол ... Гэнэт хүчтэй давалгаа түүнийг нөмрөн авах шиг болжээ.

Тоглоом эхлэв.

Делтон өөрөө тараав. ТАвил их багаас эхэллээ. Тэд таван хүн тутамд долоон хөзөр их бага гараар тараан стад-покер тоглов.

Эхлээд цөмөөрөө л тэнцүүхэн хожиж явснаа байдал өөрчлөгдөж эхлэв. Короницс, Тони хоёр гайхамшигтай сайн явж эхлэх шиг санагдав. Тэдний гарт ямагт том хөзрүүд ирж бусдад нь тааруухан мод таарч байлаа. Виктор Короницс аз дайрсанд итгэж ядан сууна. Тоглоом дуусахад тэр хоёр мянгаад доллар хожсон байлаа. Үлгэрт л гардаг шиг санагдана.

-Хүүхдүүд ээ, та хоёр үнэхээр азтай байна гэдгийг хэлэх хэрэгтэй гэж Марвин Сеймар дуугарав.

-Үүнээс илүү яах вэ. Маргааш даагаа нэхье гэвэл юу гэх вэ? хэмээн Бреслаур нэмж хэлэв.

-Би утасдана аа гэж Риццоли амлав.

Бүгд явсны дараагаар Коронцис дуу алдан,

-Итгэмээргүй юм. Хоёр мянган доллар! гэлээ.

Тони инээн,

-Юу ч биш. Би чамд Оттог энэ талаар мэргэжилтэн гэж хэлээгүй юу. Энэ залуус биднээс хариугаа авахаар байж ядаж байгаа. Дахих уу, чи юу гэж бодож байна?

-Бас асуунаа! гээд Коронцис маасайтал инээв.

Дараачийн орой Виктор Виктор Коронцис 3000 доллар хожив.

-Гайхмаар юм! Тэд юу ч сэжиглэхгүй байгаа хэрэг үү? гэж дуу алдав.

-Мэдээж үгүй. Маргааш тэд биднээс тавилаа өндөрсгөө гэж санал болгоно гэж мөрийцсөн ч болж байна. Алдсан мөнгөө эргүүлж авах гэж оролдох нь мэдээж. Чи тоглох уу?

-Тоглолгүй яахав, Тони. Би тоглоно.

Тэднийг ширээнд сууцгаасны дараагаар Сэл Приззи хэлэв.

-Бид үндсэндээ хожигдож яваа болохоор тавилаа өндөрсгөвөл ямар вэ? гэлээ.

Тони Коронцис руу нүд ирмээд ирмээд,

-татгалзахгүй. Харин та нар яамаар байна? Тгэсэнд бүгд зөвшөөрч байгаагаа илэрхийлэн толгой дохив.

Отто хасаануудыг өөрчилж цагаан нь тавин доллар, цэнхэр нь зуу, улаан нь таван зуу, хар мянга гэж тогтоолоо.

Виктор Коронцис сандран Тони руу харвал Риццоли урамшуулах байртай толгой дохино. Виктор тавилыг ийм өндөр байх юм гэж бодсонгүй аж.

Тоглоом эхлэв.

Бүх юм хуучнаараа давтагдаж эхлэв. Коронцисын гарт ямагт лут сайн мод ирж зогсоо зайгүй хожсоор байв. Тони хожсон ч түүнийг гүйцсэнгүй.,

-Энэ модуудыг чөтгөр аваасай гэж Приззи харагаад,

-Алив хөзрөө сольё гэв.

Отто Делтон дуулгавартайяа шинэ хөзөр задлав. Коронцис Тони руу харж инээмсэглэв. Ингээд ч ялгаагүй гэдгийг тэр мэдэж байлаа.

Шөнө дунд тэд цай ууж зөөлөн боов идэцгээн арван таван минут завсарлалаа.

Тони Риццоли Коронцисыг хажуу тийш нь дуудан,

-Би Оттод цаадуулыг жаахан дулаацуулаадах гээд хэлчихлээ гэж шивэгнэв.

-Юу эгсэн үг вэ?

-Тэдэнд жаахан хожих боломж өгье. Тэд байнга хожигдоод байвал тоглоомыг орхин явцгаана шүү дээ.

-Аа ойлголоо. Мөн ч ухаалаг санаа байна.

-Тэднийг жаахан сэхээ аваад эхэлмэгц бид дахин хожиж эхлэх болно.

-Тони, би олон удаа хожлоо. Одоо ингээд боливол яасан юм бэ? гэж Виктор эргэлзэнгүй хэлбэл Тони нүд рүү нь халз ширтэж байгаад,

-Чи халаасандаа тавин мянган доллартай эндээс гарах тухайд юу гэж бодож байна? гэж зальжнаар асуулаа.

Тоглоом шинээр эхэлмэгц Бреслаур, Сеймар, Приззи гурав хожих болсонд Коронцисын гарт муугаас муу мод ирэх болов. "Отто ч ёстой гайхалтай хүн юм" гэж бодоод хөзөр тараахыг нь нарийн ажиглавч юу ч олж ахрж чадсангүй.

Тоглоом үргэлжилсээр. Коронцис хожигдсоор байлаа.

Гэвч тэр сандарсангүй. Ганц хоёр минутын дараа л ... юу гэмээр юм бэ дээ? ... Тэднийг "хийж орхиход" дахин зууш үмхэх болно.

Сэл Приззи гийгээд явчихлаа.

-Ах дүү нараа, аз бидний зүг эргэчихлээ гэж санагдаж байх чинь.

Тони гунигтайгаар тоглой сэгсрэн,

-Тийм л бололтой, тийм үү? гэж хэлээд ихээхэн учиртай царайгаар Коронцисын зүг харав.

-Байнга аз таарна гэж хаанаас байх вэ хэмээн Марвин Сеймор дэмжлээ.

-Хэрэв татгалзахгүй бол бооцоогоо дахиад нэмбэл яасан юм бэ? гэж Перри Бреслаур дундуур нь ороход Тони бодож байгаа дүр эсгэн,

-Үнэндээ мэдэхгүй байна гээд Коронцис тийш тээнэгэлзсэн янзтай харан,

-Та юу бодож байна, Виктор? гэлээ.

"Халаасандаа тавин мянган доллар хийгээд харивал ямар вэ? Үүгээр гэр бүлээрээ амралтанд явж шинэ байшин худалдан авч, машинтай болж болно ..." гэж бодмогц Коронцис догдолсондоо чичрээд инээмсэглэн,

-Яагаад болохгүй гэж? гэлээ.

-За тийм бол мөнгөө ширээн дээр гаргаж тавьцгаая. Эргэж буцах явдалгүй шүү гэж Сэл Приззи хэллээ.

Таван хөзрөөр стад-покер эхэллээ.

-Би тавилаа нэрлэлээ. Эхний тоглоомд таван мянга гэж Бреслаур хэлэв.

Виктор Коронцисын гарт хоёр хатан ирэв. Дахиад гурван мод авгал тэдний дунд бас нэг хатан байж таарлаа.

Риццоли хөзрөө харангаа,

-Би мянгаар нэмлээ гэвэл Марвин Сеймор модоо үзээд,

-Хүлээж авъя, дахин хоёр мянгаар өсгөлөө гэхэд,

-Надад арай их санагдана гээд модоо шидлээ. (энэ хэсгийг ойлгоогүй хэн хэлээд шидээд бгааг, хаха)

Сэл Приззи тоглоомоос гарсангүй.

Бүх банкыг Марвин авчээ.

Дараачийн удаад Коронцист найм, ес, арав, гилийн боол таарчээ. Дахиад нэг мод сугалбал стрит-флаш! Хожил ирнэ дээ.

-Мянгыг тавья гэж Делтон хэлэв.

-Хариуд нь дахиад мянга гэж Сэл Приззи дэмнэлээ.

Одоо Коронцисын ээлж болов. Хэрэв түүнийх стрит-флаш болбол тэр хожлоо гэсэн үг. Нэг мод нэмэх хэрэгтэй байлаа.

-Авлаа гээд тэр өөрт нь өгсөн нэг хөзрийг авч дээш нь харуулалгүй тавилаа.

Бреслаур хөзрөө дэлгээд,

-Хоёр нь дөрөвт мод, хоёр нь аравт гэсэнд Приззи модоо дэлгэн,

-Гурван долоо гэлээ.

Цөмөөрөө Коронцис тийш харсанд тэр гүнээ санаа алдаад таных боллоо гээд модоо шидчихэв.

Бан өссөөр л байлаа.

Виктор Коронцист хасаа бараг үлдсэнгүй. Тэр гүнзгий амьсгаа аваад Тони Риццоли руу харвал тэр нь урамтай нь аргагүй инээмсэглэв.

"Санаа зовох шалтгаан алга" гэсэнтэй адил байлаа.

Риццоли дараагийн удаа банк нээж хөзөр тараалаа.

-Мянгыг тавья.

Перри Бреслаур,

-Мянгаар нэмлээ.

-Би хоёр мянгыг нэмлээ гэж Марвин Сеймор хэлэв.

-Таныг хоосон сүржигнэж байна гэж бодож байна. Би таван мянгаар дээш нь ихэсгэлээ гэж Сэл Приззи дуугарна.

Виктор Коронцис хөзрөө харсан ч үгүй. "Энэ бүхэн хэзээ дуусах юм бэ?" гэж дотроо асуусаар байна.

-Виктор, та?

Коронцис модоо аажуухан өргөж хуруугаараа имрэн салгавал тамга, бас дахиад хоёр тамга, дараа нь ноён, аравт байлаа. Судасных нь цохилт түргэсч,

-Тоглох уу? гэсний нь хариуд дотроо инээд алдан "Арай гэж нөгөө дулаацуулалат дуусах шив" гэж бодон дараачийн удаа ноён авна гэдэгтээ бүрэн итгэлтэйгээр аравт модоо шидээд аль болох хайхрамжгүй дуугаар,

-Би тоглолоо. Дахиад нэгийг өгнө үү гэлээ.

-Хоёрыг авья хэмээн Отто хэлээд модоо харснаа,

-Мянгаар ихэсгэлээ гэв.

Тони Риццоли толгой сэгсрэн,

-Би өнжлөө гээд модоо хаяв.

-Тоглоно оо, таван мянгаар гэж Приззи хэлээв.

Марвин Сеймор модоо хаян өнжиж буйгаа зарлалаа.

Тоглогчдоос Коронцис Приззи хоёр л үлдлээ.

-Чи авах уу? Тийм бол дахиад таван мянгыг шидэж орхи гэж Приззи хэлэв.

Коронцис хасаагаа хараад ердөө л таван мянга үлдэж буйг ойлгон хожигдож болохгүй гэж бодно. Тэр дахин модоо харав. Ялахгүй байхын аргагүй байлаа. Тэр хасаагаа ширээний голд овоолоод хэзэр авлаа. Тавь мод байв. Гэвч тэгсэн тэгээгүй түүнд гурван тамга бий. Модоо дэлгэн,

-Гурван тамга гэсэнд Приззи модоо дэлгэн,

-Дөрвөн туг гэж дуугарлаа.

Гайхсан Коронцис Приззиг хэрхэн мөнгөө хамж авахыг харна. Найз Тонигоо баллаж орхих шиг мэдрэхүй түүнд төрлөө.

Приззигийн хэзэр тараах ээлж боллоо.

-Долоон модоор наадна. Тус бүрд нь мянгыг тавилаа гэж тэр мэдэгдэв.

Бусад нь цөм бооцоогоо тавьцгаасанд Коронцис арчаагаа алдсан янзтай Тони руу харж,

-Надад байхгүй ... гэж дуугарсанд,

-За яах вэ гэж Тони бусаддаа хандан хэлээд,

-Виктор өнөөдөр үүнээс илүү бэлэн мөнгө авчраагүй юм байна, гэвч түүнд найдаж болно гэдгийг баталъя. Зээлээр тоглуулаад орой тооцоогоо бодчихъё гэж хэлэв.

-Байзаарай! Энэ ямаз мангуунуудын цуглаан бишдээ. Би чиний наад Коронцисыг чинь Адамын хошногоноос нэг их ялгахгүй л байна шүү. Төлбөрийн чадвартай ч юм уу үгүй ч юм уу хэн мэдлээ? гэж Приззи уурласанд,

-Би ам өгье. Отто миний үгийг батална гэж Тони хэлэв.

-Хэрэв Тони Коронцисыг дажгүй гэж байгаа бол дажгүй л гэсэн үг гэж Отто Делтон хэллээ.

Сэл Приззи мөрөө хавчин,

-За яахав, зөвшөөрлөө гэв.

Отто Коронцис руу эргэн,

-Танд хэдийг зээлдүүлэх вэ? гэж асуусанд,

-Түүнд арван мянгыг өгч орхи гэж Тони хажуугаас нь хэлэв.

Хоёр жилийнхээ хөлсийг дуулаад Коронцис гайхан харсан ч Риццоли юу хийж байгаагаа мэдэж байгаа биз.

-Тиймээ надад болно гэж хоолойдоо тээглэсэн бүлхийг залгин өгүүлэв.

Түүний өмнөх ширээн дээр дахиад л хасаан овоо бий боллоо.

Энэ үдэш Виктор Коронцисын аз нь харьжээ. Хасааны тавил өндөрсөх тусам түүний өмнөх уул овоо шиг хасаанууд нь улам багассаар байлаа. Тони ч мөн хожигдсоор байлаа.

Шөнийн хоёр цагт тэд завсарласанд Коронцис Тониг хажуу тийш аавачин,

-Юу болж байгааг та мэдэж байна уу? Бурхан минь, би зөндөөг алдлаа гэж шивэгнэсэнд,

-Битгий зовдоо, Виктор минь. Би Оттод дохио өгчихнө. Түүнийг хөзөр хуваагаад эхлэхээр бүх зүйл өөрчлөгдөнө гэв.

Тэд дахин суудлаа эзэлцгээв.

-Миний найзад дахиад хорин таван мянгыг зөөлдүүлж өгөөч гэж Тониг гуйсанд Марвин Сеймор үрчилсэн,

-Наадах чинь үргэлжлүүлэн тоглох хүсэлтэй байгаа юм уу? гэж асуув.

Коронцис эргэлзсэнд Тони түүнрүү харан,

-Чи өөрөө л шийд гэв.

-Би тогломоор байна гэхдээ "Би Оттод дохио өгнөө" гэснийг нь санав.

-За яахав гэсэнд түүний өмнө дахин хорин таван мянган долларын хасаа овооров. Тэр өмнөх хасаануудаа ширтэн суухдаа энэ удаад аз дайрахыг мэдэрч байв,

Отто Делтон хөзөр хуваав.

-За жентельменүүд ээ, таван модоор наадъя. Эхний тавил мянга гээ гэлээ.

Тоглоомчид хасаагаа ширээний голд атвьцгаалаа. Отто хүн болгонд 5 ширхэг хөзөр тараав.

Коронцис модоо үзэлгүйгээр,

"Аз ирэхийг хүлээж л байя" гэж бодлоо.

-Бооцоогоо тавиарай.

Делтоны баруун талд сууж байсан Марвин хамгийн түрүүнд,

-Би өнжлөө гэлээ.

Дараа нь Сэл Приззи,

-Авлаа, дахиад мянгыг тавья гээд хасаагаа ширээний гол руу түлхэв.

Перри Бреслаур модоо мушилзан харж,

-Аанхан, дахиад таван мянгаар ихэсгэлээ гэлээ.

Коронцис тоглоомыг үргэлжлүүлэхийн тулд зургаан мянгыг тавих хэрэгтэй боллоо. Тэгээд модоо авч аажуухан имэрч салган бариад нүдэндээ ч итгэсэнгүй. Түүний гарт гайхалтай сайхан стрит-флаш буюу тав, зургаа, долоо, найм, есөн бундан байх нь тэр. Бахдам сайхан мод байна. Тонин үнэн хэлжээ. "Бурханы аврал!" хэмээн бодон Коронцис догдлолоо арайхийн нууж.

-Тавилыг хүлээн авлаа, дээр нь дахиад таван мянгыг нэмлээ гэж хэлэхдээ дотроо "Энэ моднууд намайг баян болгоно" гэж бодов.

Делтон модоо хаяж,

-Хэрэг алгаа, өнжлөө гэлээ.

-Одоо би л шийдэх болох нь шив гэж Приззи хэлээд,

-Хонгор минь чи хоосон баярлаж байна шүү. Хүлээн авч дээр нь дахиад таван мянгыг нэмье гэж дуугарав.

Виктор Коронцис тэнгэрийн умдаг атгалаа л гэж бодож сууна. Ийм мод хүний амьдралд ганц удаа л тохиолдоно. Энэ бол өнөө оройн хамгийн том хожил боллоо доо гэхчихлэн бодсоор,

Перри Бреслаур ялсан дүртэй модоо дэлгээд,

-Гурван ноён гэж хэлсэнд Коронцис "Би хожлоо" гэж бодоод чангаар,

-Муугүй шүү, гэхдээ л бага байна. Миний "стрит-флаш" гээд модоо ширээн дээр тавьж мөнгө

рүү гараа сунгав.

-Байзаарай! гэж Сэл Приззи түүний гарыг барьж,

-Чи хожигдчихлоо, надад ноёны флаш байна. Арваас тамга хүртэл дан гил гэлээ.

Виктор Коронцисын царай зэвхийрэн ухаанаа алдаж унах гэж байгаагаа мэдэрлээ. Зүрх нь цээжээ дэлдэнэ.

-Төрсөн эх минь ээ! гэж Тони Риццоли дуу алдаад,

-Нэг тоглолтонд хоёр флаш байх гэж! Чөтгөр та нарыг аваасай! гээд Коронцис руу эргэн,

-Над их харамсалтай байна даа, Виктор. Би юу хэлэхээ мэдэхгүй байна. Би ... гэв.

-Өнөөдрийн хувьд боллоо, жентельменүүдээ гээд Коронцист хуудас цаас үзүүлэн,

-Та жаран таван мянган доллар төлөх боллоо гэв ээ.

Балмагдаж цөхөрсөн Коронцис Тони руу дуугүй аврал эрэн ширтсэнээ дараа нь нусны алчуураа гарган нүүрнийхээ хөлсийг арчлаа.

-Ямар хэлбэрээр төлөх вэ? Чекээр үү, эсвэл бэлнээр үү? гэж Делтон асуув.

-Чекээр авахгүй ээ гээд Приззи Коронцис руу хараад,

-Бэлнээр тушаа хэмээв.

-Би ... би ... гэж нэг ч үг хэлж чадахгүй байснаа,

-Надад ... надад байхгүй ... гэж чичирсэнд Приззийн царай харлан,

-Юу байхгүй гээд байгаа юм бэ? хэмээн хашгирав.

-Жаахан хүлээгээрэй хэмээн Тони яаран дундуур нь ороод:

-Виктор одоохондоо тийм хэмжээний мөнгө биедээ авч ирээгүй гэж хэлэх гээд байгаа юм. Би түүнийг итгэж болох залуу гэж хэлээд байна шүү дээ.

-Наад үгээр чинь миний халаас дүүрэхгүй, Риццоли. Мөнгөө л төлөг цаашаа.

-Чи мөнгөө авнаа. Гэхдээ хэд хоногийн дараа л гэж Риццоли батлан хэлсэнд Сэл Приззи мөрөө хавчаад,

-Битгий донгос чи! Би тийм буянтай сэтгэл гаргаж чадахгүй. Мөнгөө тэр маргааш л авчирч өгөг гэж уурласанд,

-Зовох хэрэггүй ээ. Өгнө гэлээ.

Виктор Коронцис өөрийгөө мултрах аргагүй занганд орсноо мэдэрч хөдлөх ч чадваргүй суух тул бүгд гарцгааж Тони эр хоёрыг хоюулхныг үлдээснийг чи анзаарсангүй.

Яг л манан дунд өхвж байх шиг санагдана.

Тийм их мөнгийг би ... би цуглуулж дөнгөхгүй. Хэзээ ч дөнгөхгүй! гэж гаслан дуугарсанд Риццоли мөрөн дээр нь гараа тавин,

-Юу хэлэхээ мэдэхгүй байна, Виктор. Ийм юм болно гэж бодсонгүй. Би ч бас чамаас дугахгүй хожигдчихлоо гэлээ.

Коронцис нүдээ арчаад,

-Гэвч ... гэвч та өөртөө үүнийг зөвшөөрч болно, Тони. Би бол болохгүй ээ. Тэдэнд би юугаар ч төлж чадахгүй гэдгийг хэлэх болох нь дээ гэвэл,

-Виктор, би л чиний оронд байсан бол сайтар бодох байсан юм гэж Тони хэлээд,

-Сэл Приззи бол Дорнод эргийн далайчдын эвслийг удирддаг хүн. Тэд ширүүн залуус гэж би дуулсан юм байна гэв.

-Яах ч арга алга даа. Мөнгө байхгүй л бол байхгүй гэсэн үг. Тэр намайг яах юм бэ? Хоосон хүнээс хоёр чихийг нь авахгүй шүү дээ.

-Би чамд олигтойхон шиг тайлбарлаад өгье. Тэр өөрийн залуустаа чиний өвдөгний нүд рүү буудахыг тушааж ч магадгүй. Тэгвэл чи явж чадахаа болино. Эсвэл чиний нүд рүү хүчил асгаж болно. Тэгвэл чи хараагүй болно. Дараа нь чамайг ийм байдалтайгаар амьд үлдээх үү эсвэл алах уу гэдгээ шийдэж болно шүү дээ,

Виктор Коронцисын царай хувхай цайн,

-Чи ... чи тоглож байна уу? гэв.

-Тийм юм шиг санагдаад байна уу. Миний буруу л дааа, Виктор. Би чамайг Сэл Приззи шиг хүнтэй тоглохыг зөвшөөрдөггүй л байсан юм. Тэр чинь алуурчин хүн.

-Бурхан минь! Би яанаа?!

-Чи нээрээ тэр мөнгийг олж чадахгүй гэж үү?

Коронцис галзуурсан аятай хөхөрч,

-Тони ... миний авдаг цалин гэр бүлээ тэжээхэд хүрэлсдэггүй шүү дээ гэсэнд,

-Тийм бол хотоос явах л зам үлдэж дээ. Энэ улсаас ч явах хэрэг гарч мэднэ. Приззи л чамайг олохгүй газар руу явах хэрэгтэй гэлээ.

-Үгүй ээ, би чадахгүй гэж гаслан,

-Би эхнэр дөрвөн хүүхэдтэй хүн. Та бүгдийг зохицуулсан бид хожигдох аргагүй гэж хэлсэн биз дээ? Та ...

-Мэдэж байнаа. Тэгээд ч надад үнэхээр харамсалтай байна. Урьд нь бүх юм үргэлж болоод байдаг байсан юм. Ер нь Приззи л хамаг хэргийг баллаж орхилоо.

Коронцис жаахан сэргэж,

-Тэр баллаж орхисон юм бол би заавал төлөх албагүй биз дээ? гэж горьдон асуув.

-Виктор минь ээ, ийм хялбар бишдээ гэж Риццоли тэвчээртэйгээр тайлбарлан,

-Чи түүнийг луйвар хисэн гэж тулгавал тэр чамайг ална, бас түүнд мөнгийг нь өгөхгүй төлөхгүй бол мөн л чамайг алах болно гэлээ.

-Бурхан сахиус минь ээ! Тэгвэл би ч дуусчээ! хэмээн Коронцис гонгинолоо.

-Ийм таагүй байдалд орсон нь надад их эвгүй байна. Чи үнэхээр яагаад ч төлж чадахгүй гэж үү?

-Би зуун удаа амьдарч байж л төлж магадгүй. Мянга ч байж магадгүй. Надад юу ч байхгүй юм чинь би хаанаас олох юм бэ?

Яг энэ үед Тони Риццолигийн толгойд мэргэн санаа төрж,

-Хүлээгээрэй, Виктор, музейд байсан тэдгээр новш бөөн мөнгө хүрнэ гэж чи хэлээгүй билүү? гэсэнд,

-Тиймээ, гэвч үүнд ямар хамаатай юм бэ? гэж юу ч ойлголгүй асуув.

-Надад үгээ дуусгах боломж олго л доо. Хуулбар нь жинхнээсээ бараг муугүй гэж хэлээ биз дээ?

-Тиймээ, ямар ч мэргэжлийн ...

-Байз, байз. Хэрэв олдвор алга болж оронд нь дууриамалыг тавьж орхиход яах бол? Тэнд баахан жуулчид байхыг би харсан. Жишээ нь тэд ялгах болов уу?

-Үгүй л болов уу ... би ... би таныг хааш нь түлхээд байгааг ойлгохгүй байна. Үгүй ээ, үүнийг би чадахгүй.

-Ойлгож байна, Виктор гэж Тони аргадан хэлээд,

-Зүгээр л бодоод үзэхэд музейн тэр олон үзмэрүүдээс ганц нь алга боллоо гээд юу ч боллоо аж гэж санагдах юм.

Виктор Коронцис толгой сэгсэрч,

-Би энд судлаачаар ажиллаад хорин жил болж байна. Тэр талаар бодоч чадахгүй нь.

-За өршөөж үз дээ. Би чиний төлөө л чамайг аврах арга замыг л хайж байна. Тэглээ ч хэтэрхий орой болжээ. Чиний эхнэр хүүхдүүд чинь чамайг алга боллоо гэж сандарч байгаа байлгүй гээд Тони бослоо.

Коронцис түүнээс нүд үл слган ширтэж,

-Амь аврах гэнэ ээ? Яаж тэр вэ? гэж асуулаа.

-Маш амархан. Ямар нэгэн эртний эдлэл аваад л нада өгч орхи. Би Призид мөнгийг чинь төлж орхино. Түүнтэй хугацаа нь тохирч болно гэж найдаж байна. Ингэж л чамайг дэгээнээс мултлах юм даа. Чи мэдээж ойлгож байгаа байх. Би ч чамайг эвгүй юманд орооцолдуулчихсан болохоор чамд туслах ёстойгоо л ойлгож байна. Чиний хэрэгт орооцолддог нь миний буруу гэв.

-Та их сайн нөхөр юм. Би таныг бруутгахгүй. Хэн ч намайг тогло гэж албадаагүй. Та надад туслах л гэсэн.

-Мэднээ. Ийм юм болсонд харамсаж байна. За, одоо явж амарцгаая. Маргааш тавтай уулзья. Сайхан нойрсоорой, Виктор.

-Тавга нойрсоорой, Тони.

Маргааш өглөө музейн тасалгааны утас хангиналаа.

-Коронцис уу?

-Сонсож байна.

-Би Сэл Приззи байна.

-Өглөөний мэнд, ноён Приззи.

-Би нөгөө л жаран таван мянган долларынхаа бяцхан хэргээр утасдаж байна. Та миний мөнгийг хэзээ төлөх гэж байна?

Виктор аймшигтай хөлөрч байгаагаа мэдэрлээ.

-Би ... надад одоо мөнгө байхгүй, ноён Приззи.

Утасны нөгөө үзүүрт хорлонтой чимээгүй болсноо эцэст нү Приззи,

-Чи юунд надаар даажигнаад байнаа, чөтгөр алгад? гэх дуулдав.

-Надад итгээч. Би тоглоогүй байна ... Би ...

-Тэгвэл новшоо, мөнгийг минь өгөөд орхи. Ойлгов уу?

-Мэдлээ, эрхэмээ.

-Музей хэдийд хаадаг вэ?

-Зургаад ... оройн зургаан цагт.

-За тийм бол би зургаад очно. Мөнгө олоогүй байх юм бол наад оромжийг чинь ровонгоор нь эргүүлж орхино гэж мэдээрэй. Ясыг чинь хугачаад өгөхөө дахин хөл дээрээ зогсоно гэж бүү найдаарай!

Тэгээд Приzzi утсаа тасалж орхилоо.

Виктор Коронцис бүр балмагдаж орхив. Нуугдаж орхих юмсан. Гэхдээ хаана тэр вэ? Тэр байж болох бүх л "хэрвээ" гэсэн болгоныг бодож, хэрэв би тэр орой казинод ороогүй бол ... хэрэв би Тони Риццолитой хэзээ ч уулзаагүй бол ... хэрэв би эхнэртээ дахин хэзээ ч тоглохгүй гэж амласнаа биелүүлсэн бол хэмээн бодох тусам толгой сэгсэрч "хурдхан шиг ямар нэг юм хийх хэрэгтэй" гэж бодлоо.

Яг энэ мөчид түүний өрөөнд Тони Риццоли орж ирэв.

-Өглөөний мэнд, Виктор.

Оройн зургаа хагас болоход музей хаагдаад хагас цаг болсон тул ажилчин албан хаагчид гэр рүүгээ явцгаажээ. Виктор Коронцис, Тони Риццоли хоёр гол хаалга руу харан сууцгаасан байв.

Коронцис улам улам сандран,

-Хэрэв тэр зөвшөөрөхгүй заавал өнөөдөр өг гэж шаардаад байвал яана? гэж асуув.

-Түүнтэй тохиролцохыг хичээе. Надад бүү саад болооч гэж Тони хэллээ.

-Тэр хэрэв ирэхгүй бол яах вэ? Зүгээр л ... шууд алахаар алуурчин илгээвэл яана? Тэр яана гэж чи бодож байна вэ?

-Түүнд мөнгөө олж авах бүрэн боломж байгаа цагт хэзээ ч тийм юм хийхгүй гэж Тони итгэлтэй хэлэв.

Эцэст нь долоон цаг болж Сэл Приzzi ирлээ.

Коронцис яаран хаалга онгойлгоод,

-Оройн мэнд гэв.

Приззи Риццоли руу хараад,

-Чи энд юугаа хийж байгаа юм бэ? гэж асуугаад,

-Энэ бидний хэрэг шүү гэж нэмэн хэлэв.

-Тавширч үз дээ. Би туслах л гэсэн юм гэж Риццоли хэлэв.

-Надад тусламж хэрэггүй, мөнгө хэрэгтэй. МИний мөнгө хаана байна? гэж асуугаад
Коронцис руу харав.

-Би ... надад байхгүй. Гэхдээ ...

Приззи түүнийг багалзуурдан авч,

-Сонс, муу новш минь. Хэрэв чи надад өнөөдөр мөнгө олж өгөхгүй юм бол би чамаар загас
хооллоно доо гээд түлхэж орхив.

-Хөөе, чи байз л дээ. Чи мөнгө авнаа гэж Тони дундуур нь оров.

-Чамайг битгий оролц гэж хэлсэн байхаа. Чамд падгүй хэрэг мэдэв үү гэж Приззи архирав.

-Надад ч хамаатгүй шүү. Виктор бол миний найз. Түүнд одоохондоо бэлэн мөнгө байхгүй
байгаа ч тэр олно.

-Энэ чинь юу гэсэн үг юм? чөтгөр алгад гэж. Түүнд тэгээд мөнгө байгаа юм уу эсвэл үгүй
юу?

-Байгаа ч гэж болно, үгүй ч гэж болно хэмээн Тони хэлээд гараа томоор алдлан эргэн
тойрноо харуулаад,

-Энэ бүгд цөм тэр чигээрээ мөнгө зоо шүү дээ гэлээ.

Сэл Приззи тасалгааг тойруулан хараад,

-Хаа байна? гэв.

-Хоргонд. Тэд цөм хуучных ...

-Эртнийх гэж Коронцис өөрийн эрхгүй засаж хэлэв.

-... эдлэлүүд бөгөөд асар их үнэтэй эд. Саяар л яригдана шүү.

-Тийм үү? гээд Приззи хорго тийш очин харж,

-Музейн цоожтой хоргонд байгаа юмс надад ямар ашитай юм бэ? Надад бэлэн мөнгө л
хэрэгтэй байна.

-Бэлэн мөнгө авнаа. Бүр хоёр дахин ихийг шүүү. Зөвхөн жаахан тэвч, тэгээд л болоо. Виктор бол өөдгүй луйварчин биш. Түүнд хугацаа хэрэгтэй. Түүний юу бодож олсныг би чамд ярья. Тэр эдгээр хуучны ... бишээ эртний эдлэлүүдээс нэгийг нь аваад зарах болно. Мөнгө олмогцоо л чамтай тооцоо дуусгана гэж Тони Риццоли түүнд итгүүлэн хэлэв.

Сэл Приззи толгой сэгсрэн,

-Надад энэ чинь нэг л таалагдаж өгөхгүй байх чинь. Энэ хуучны эдийн талаар надад ямар ч мэдэх юм алга.

-Чамд ойлгох хэрэг байхгүй. Коронцис бол дэхийн хамгийн сайн мэргэжилтэнгүүдийн нэг байгаа юм гээд Тони нэгэн хоргоны дэргэд очин гантиг чулуугаар хийсэн тэргүүн тийш занган:

-Жишээ нь энэ ямар үнэтэй эд вэ, Виктор гэж асуулаа.

Коронцис шүлсээ залгин,

-Энэ дагины толгой МЭӨ 14 зууны үед харьяалагддаг юм. Наад захын хуучны эд цуглуулагч л үүнд хоёроос гурван сая доллар дуртай өгнө гэлээ.

-За тэр харж байна уу гэж Риццоли Приззи руу харж хэлээд,

-Би чамд юу гэж хэллээ? гэж дуу алдлаа.

Приззи баргар царайлан хөмсөг зангидаад,

-Мэдэхгүй л юм даа. Хэр удаан хүлээх хэрэгтэй юм бол? гэвэл,

-Чи хоёр дахин их мөнгө авна гэж бодоод сар хүлээхэд л болно.

Приззи жаахан бодол болоод толгой дохин,

-За яахав. Хэрэв би сар хүлээх юм бол арай илүү хоёр зуун мянга гэе л дээ. Би хоёр зуун мянгыг л авмаар байна.

Тони дуртай толгой дохих Коронцис руу хараад,

-Болж байна. Тохирлоо гэж хэлэв.

Сэл Приззи давжаа биет судлаачид ойртон очоод,

-Чамд гуч хоног өглөө. Мөнгө олоогүй бол өөрийгөө талийгаач болсонд тооцоорой. Ойлгов уу? гэсэнд Коронцис шүлсээ залгин,

-Тиймээ, эрхэм ээ гэлээ.

-Гуч хоног ... санаж яваарай.

Приззи Тони Риццоли руу анхааралтай харцаар харж,

-Надад нэг л биш санагдаад байна даа гэснээ эргэж гарч явлаа.

Тэд түүнийг дуугүй харцаар үдэж гаргалаа.

-Бурхан минь! гээд сандалд пидхий унаж алчуураар хөлсөө арчиж,

-Та энэ гуч хоногт бид мөнгө олч чадна гэж нээрээ бодож байна уу? хэмээн асуувал Тони,

-Ямар ч асуудал алга. Чамд зөвхөн эдлэлүүдээс нэгийг нь аваад ронд нь дууриамалыг олж тавих л хэрэг гарлаа гэж хэлэв.

-Та яаж хилээр гаргана гэж бодож байна? Баригдвал шоронд сууна шүү дээ.

-Мэдэж байна. Гэвч би чиний төлөө л амь дүйж байгаа юм. Би чиний төлөө энэ зэргийн юм хийх ёстой хүн шүү дээ, Виктор минь гэж тэр ширүүхэн хэлжээ.

* * *

Цагийн дараа Тони Риццоли, Сэл Приззи, Отто Делтон, Перри Бреслаур ба Марвин Сеймор нар цөмөөрөө Делтоны өрөөнд юм ууцгаан сууна.

-Бүх зүйл алга урвуулах мэт амархан бүтлээ. Тэнэг амьтан айснаасаа болоод үнхэлцэг нь хагарах шахсан даа гэж риццоли өөрийгөө магтав.

Сэл Приззи инээмсэглэн,

-Би түүнийг сайн айлгасан биз, тийм үү? гэв.

-Чи намайг хүртэл айлгаж дөнгөсөн шүү. Чи ёстой сайн жүжигчин болж болох байжээ, чөтгөр ав! гэж Тони хэлэв.

-Одоо яах вэ? гэж Марвин Сеймор тэднээс асуув.

-Тэр надад хуучныхаа юмсаас нэгийг авч өгье гэж амласан. Би тэрнийг Грекээс авч гараад борлуулна. Тэгээд мөнгөө хуваах л үлдэнэ дээ.

-Гайхалтай гэж Перри Бреслаур дуу алдаад,

-Надад таалагдаж байна гэв.

"Одоо ингээд би байнгын тэжээгчтэй болж байгаа юм. Коронцис нэг удаа хулгай хилээ бол өнгөрч байгаа нь тэр. Миний гараас гарахгүй болно. Буцах зам түүнд байхгүй. Би түүгээр тэр новшийн музейг бүр мөсөн цэвэрлүүлж орхиж дөнгөнө" гэж Риццоли дотроо бясалгаж суув.

-Чи тэгээд яаж энэ улсаас гаргана гэж бодож байна? гэж Марвин Сеймор асуув.

-Нэг юм бодож олно доо. Заавал олох болно хэмээн Риццоли хэлэв.

Тэр заавал бодож олох хэрэгтэй байсан юм. Аль болох хурдхан шиг. Эс тэгвэл Альфредо Манкузо, Жино Лавери нар шиг юмнууд хүлээнэ гэдгийг мэддэггүй юм чинь.

Арван гуравдугаар хэсэг

Стадиоу гудамжин дахь цагдаагийн газарт онцгой зөвөлгөөн болж байв. Хэлтсийн нэг өрөөнд цагдаагийн газрын дарга Дмитрий, байцаагч Тиноу, америк агент Келли, мөрдөгч Николино бас тав зургаан мөрдөгчид цугларчээ. Урьд өдрийнхтэй харьцуулбал цугларагсдын сэтгэл санаа огт өөр байлаа.

Мөрдөн байцаагч Николино,

-Одоо бидэнд таны мэдээллийг үндэслэлтэй гэж үзэх бүх үндэслэл байн, ноён Келли. Манай мэдээлэгчдээс Тони Риццоли их хэмжээний герион Афинаас гаргахыг завдаж байгаа гэсэн мэдээ ирсэн. Түүний ачуулах хүртлээ бараагаа хадгалж байгаа агуулахыг олох ажилдаа бид орсон.

-Та нар Риццолиг мөрдөх ажиллагааг зохицуулсан уу?

-Бид өнөө өглөө туршуулуудынхаа тоог арав хүртэл нэмэгдүүлсэн гэж цагдаагийн газрын шэф мэдэгдэв.

Уолт Келли хүндээр санаа алдан,

-Та нарыг хожимдоогүй байгаасай л хэмээн бурханд залбирья гэлээ.

Мөрдөн байцаагч Николино өөрийн хүмүүсийг хоёр бүлэг болгон зохион байгуулж мөрдөх үүрэг өгсөн боловч Тони Риццолиг тэрээр үнэндээ дутуу үнэлжээ. Үд дунд гэхэд л Тони араас нь сүүл дагаад байгааг анзаарсан байв. Зочид буудлаас гараад явмагц хэн нэгэн хүн араас нь байнга дагана. Мэргэжлийн хүмүүстэй учирснаа Тони ойлгосон боловч энэ нь түүнд таалагдаж байв. Түүнийг сүрхий тоож байгаагийн шинж юм.

Одоо Афинаас зөвхөн герион төдий биш бас үнэлж баршгүй үнэтэй эдлэл авч гарах хэрэгтэй болно. Манкузо Лавери нар хүзүүн дээр сандайлчихаад байхад бас цагдаа нар эргэн тойронд минь жоом шиг л гүйлдэх юм. Хэн нэгнийг яаралтай олох хэрэгтэй. Түүний толгойд орсон цорын ганц нэр бол Ромын хөлөг онгоцны эзэн тийм чиг нэр төртэй биш боловч Иво Бругги гэгч байлаа. Урьд нь ч түүнтэй ажиллах хэрэг гарч байсан билээ. Түүнээс ашиг гарах нь юу л бол. Гэвч оролдоод үзэх хэрэгтэй.

Риццоли утасны яриаг чагнаж байгаа гэдгийг мэдэж байв. Энэ асуудлыг хэрхэн шийдвэл зохих тухай удаан боджээ. Эцэст нь босож гадагш гараас эсрэг талын өрөөний хаалгыг тогшив. Гунигтай царайлсан хөгшин хүн хаалга онгойлгон өгөн,

-Юу болоо вэ? гэснэд Риццолид хамаг лэ елдэг царайгаа үзүүлэн,

-Өршөөгөөрэй. Таныг түйвээсэндээ сэтгэл зовж байна. Би танай хөрш өрөөнд суудаг юм. Танайд ганц минут ороод гарахыг зөвшөөрнө үү гэсэнд тэр хүн ихэд сэжиглэнгүй харж,

-Эхлээд хаалгаа онгойлгож үзүүлээдэх гэв.

-Болноо гээд Тони инээж өөрийн хаалга руу дөхөн очиж түлхүүрээ хийн онгойлгов. Хөрш нь толги дохин,

-За яах вэ, ор ор гэв.

Тони өрөөнийхөө хаалгыг хааж орхиод араас нь дагаж өрөөнд оров.

-Танд юу хэрэгтэй вэ?

-Надад жаахан хувийн хэрэг гараад таныг сандаргаж орхив уу даа. Үнэнийг хэлэхэд би эхнэрээсээ салж байгаа юм л даа. Тэгтэл тэр маань намайг мөрдөж дагаад утсанд минь хүртэл сонсох төхөөрөмж тавьж орхисон байх юм гэвэл,

-Шуламнууд гэж хөрш нь дуу алдав.

-Бүгдийг нь чөтгөр аваасай. Би ч бас эхнэрээсээ өнгөрсөн жил салсан. Уг нь арван жилийн өмнө тэгэх байсан юм гэв.

-Тийм үү? Товчхондоо гэвэл таны утасны дугаарыг би найз нартаа өгж болох уу? Танд андгайлахад бэлэн байна тэд байнга залгаж таныг зовоохгүй л дээ гэсэнд,

-Би зөвшөөрөхгүй. Надад төвөг болно ...

Тони халааснаасаа зуун долларын дэвсгэрт гарган ирж,

-Танд төвөг удсандаа уучлал гуйж байгаа юм шүү гэхэд хөрш уруулаа шүлсдэн,

-Тэгвэл одоо яаы гэхэв дээ. Энд санаа зовоод байх зүйл алга гэж бодож байна. Нөхрийн зовлонгоос хуваалцахдаа таатай байна.

-Таны зүгээс их эелдэг хэрэг. Нар дуу утасдах юм бол хаалгыг минь цохино уу. Би голдуу гэртээ байдаг юм.

-Тохиролцлоо.

Маргааш өглөө нь эрт боссон Риццоли телефоны сатнц руу очин Иво Бруггитэй ярихаар захиалга өглөө.

Риццоли зочид буудлын залгах төхөөрөмжийн дугаарыг хөршийнхөө утасны дугаартай хамт хэлж өгөөд, буудалдаа буцаж ирэв.

Дараачийн хоёр өдөр Риццоли хаалга цохихыг хүлээн өрөөндөө өнжлөө. Хоолоо хүртэл өрөөндөө захиж авчрууллаа. Дуудлага гэвч ирсэнгүй. "Иво Бругги хаачив аа, чөтгөр аваг!" гэж тэрээр бодно.

-Риццоли хоёр өдөр гэрээсээ гарсангүй гэж мөрдөгч Николино Уолт Келли нарт туршуулууд мэдэгдэнэ.

-Түүнийг тэнд байгаа гэдэгт итгэлтэй байна уу?

-Тийм ээ, эрхэмээ. Үйлчлэгч түүнийг өглөө орой цэвэрлэгээ хийхдээ хардаг юм.

-Утсаар ярьсан уу?

-Нэг ч удаа яриагүй. Одоо бид яах вэ?

-Ажиглалтаа үргэлжлүүл. Эрт орой хэзээ нэгэн цагт тэр хөдлөх болно. Сонсох төхөөрөмж ажиллаж байгаа эсэхийг шалга.

Маргааш өдөр нь Риццолигийн өрөөний утас хангиналаа. "Новш! гэж Бругги түүний өрөө рүү залгах ёсгүй. Тэр хөршийн утас руу залгуулж байхаар зохицуулсан юмсан. Болгоомжтой байх хэрэгтэй." гэж бодоод харилцуураа авав.

-Сонсож байна.

-Тони Риццоли юу? гэх дуу Иво Бруггийнх биш болох нь илт байв.

-Хэн бэ?

-Хэдэн хоногийн өмнө таныг ажил хэргийн санал тавьж ирэхэд би татгалзсан билээ. Гэвч өнөөдөр энэ тухай дахин ярилцахаар шийдлээ, ноён Риццоли.

Риццоли ийнхүү тэнгэрийн умдаг атгах нь тэр ээ.

"Спирос Ламроу! Тэгэхээр энэ хүндэт хүн гуай зөвшөөрч орхих нь энэ гэж үү!". Риццоли аз дайрсанд итгэж чадахгүй байв. Ингээд асуудалгүй боллоо. Геройны ч музейн хуучин эдлэлийг ч нэг зэрэг тээвэрлэх бололцоотой болох нь тэр.

-Тэгэлгүй яахав. Би их баяртай байна. Хэзээ бид уулзаж болох вэ?

-Өнөөдөр үдийн хоолны дараа.

"Тэр яарч байна гэсэн үг. Энэ муусайн шуналт баячууд бүгд л адилхан. Тэд хичнээн их хөрөнгөтэй ч үргэлж чамлаж суудаг улс даа".

-Болж байна. Хаана вэ?

-Та манай контор ирж чадах уу?

-Очноо гээд Тони харилцуураа өлгөв. Сэтгэл нь маш өндөр болжээ.

Зочид буудлын үүдний өрөөнд сандарсан мөрдөгч цагдаагийн газар руу яаран илтгэсэн нь,

-Риццоли руу дөнгөжсая утасдлаа. Конторт уулзая гэж болзсон боловч ярьсан хүн нь нэрээ хэлээгүй учраас бид хаанаас ярьсныг нь тогтоож чадсангүй гэв.

-За тийм байж. Түүнийг сайн дага. Хаашаа явсныг нь надад илтгээрэй.

-Мэдлээ, эрхмээ.

Арван минутын дараа Тони Риццоли зочид буудлын арын подвалын цонхоор хүнгүй хоосон нарийн гудамж руу гарч хоёр ч удаа такси сольж, араасаа сүүл дагаж байгаа эсэхийг сайтар шалгасны эцэст Спирос Ламброугийн хаягийг жолоочид хэлж өглөө.

* * *

Эмнэлэгт Мелинаг эргэж очсоноосоо хойш Ламброу дүүгийнхээ өшөөг заавал авна гэж дотроо тангаргалжээ. Гэвч Константин Демирисыг хангалттай цээрлүүлэх аргаа нэг л олж чадахгүй байжээ. Георгиос Латогоос сонссон зүйл мадам Пирисээс дуулсан сонин нийлээд дүүгийнхээ нөхрийг чадах найдвартай зэвсэг болох нь ойлгомжтой байв.

-АнТони Риццоли ирлээ, ноён Ламброу гэж нарийн бичгийн дарга хүүхэн хэлснээ,

-Таныг түүнтэй уулзана гэж хэлээгүй болохоор түүнийг би оруулсангүй гэж нэмж өгүүлэв.

-Түүнийг оруул.

-Мэдлээ, эрхэмээ.

Риццоли нүүрэндээ инээмсэглэл тодруулан итгэлтэй алхан өрөөнд орж ирэв.

-Ирсэн явдалд баярлалаа, ноён Риццоли.

-Талархах явдалгүй. Та тэгээд надтай хамтран ажиллахаар шийдээ юу?

-Үгүй ээ.

Риццолийн инээмсэглэл хоромхон зуур алга боллоо.

-Та юу хэлэв ээ?

-Би үгүй гэж хэллээ. Таны саналыг хүлээж авахгүй гэсэнд гайхсан Риццоли нүдээ томруулан түүнийг хараад,

-Тэгвэл ямар чөтгөрөө хийж намайг дуудсан юм? Надад тавих санал байна гэж хэлээ биздээ?!

-Зөв өө. Та Константин Демирисын онгоцыг ачаагаа тээвэрлэхэд ашиглахыг хүсэхгүй байна уу?

Тони Риццоли зөөлөвчит сандалд зүгээр л уначихав.

-Константин Демирис гэв үү? Та чинь өөрийн ухаантай байна уу? Тэр хэзээ ч ...

-Тэр зөвшөөрнө. Тэр таны саналыг зөвшөөрөхөөр барахгүй ямар ч болзолтойгоор зөвшөөрөх

болно.

-Яагаад? Тэр юу хожих юм бэ?

-Юу ч хожихгүй.

-Тийм бол яалаа гэж тэр зөвшөөрөх юм бэ?

-Энэ тухай асуусанд чинь баярлалаа гээд Ламброу дотуур яригчийнхаа товчлуурыг дараад,

-Бидэнд кофе авчирч өгнө үү гэснээ Тони руу харж,

-Та ямрыг уух вэ? гэхэд Тони:

-Э .. хэмээн төгдчээд,

-Чихэргүй хар кофе ууя гэв.

-Ноён Риццолид чихэргүй хар кофе гэж ЛАмброу цааш дамжуулан хэлээд нарийн бичгийн дарга эмэгтэйг захиалгыг тавиад гарсны дараагаар,

-Би танд нэг түүх ярьж өгье, нёон Риццоли гэвэл,

-Тэгж үз гэж Тони хайхрамжгүйхэн хэлэв.

-Константин Демирис миний дүүтэй гэрлэсэн юм. Тэр Ноэль Пейж гэдэг нууц амрагтай байжээ.

-Жүжигчин биз дээ?

-Тийм ээ. Тэр нууц амраг нь түүнийг Ларри Дуглас гэдэг хүнтэй нөхцөж мэхэлсэн бөгөөд тэд нар Дугласын эхнэрийн амийг нь егүүтгэсэн хэрэгт тулгагджээ. Нууц амраг Ноэллийн өмгөөлөгчөөр Демирис, Наполеон Чотасыг хөлслөн авчээ.

-Би энэ тухай уншсан юм байна.

-Сонин дээр хэргийн учрыг бүрэн нийтэлж чадаагүйд учир байгаа юм. Миний хүндэт хүргэн өөрийн хуурамч нууц амрагийнхаа амийг аврахын тулд бус харин түүнд ялын дээд хэмжээ өгүүлэхийн тулд л өмгөөлөгч хөлсөлж авсан юмсанжээ. Шүүх хурлын эцэст Чотас хэрэгтэнд хэргээ хүлээх юм бол ял чинь хөнгөрнө хэмээн итгүүлсэнд нөгөө хоёр нь хуурамчаар хэргээ хүлээгээд үүнийхээ хариуд буудан алах ял заагдсан юм. Өмгөөлөгч нь тэднийг мэхэлж орхисон юмсанжээ.

-Чотас үнэн хэрэгтээ тэднийг аварч чадна гэж бодсон байх ...

-Надад үгээ дуусгах боломж олгоно уу... Кэтрин Дугласын цогцосыг олоогүй өнгөрсөн билээ. Тэр хүүхэн амьд байсан гэсэн тун энгийн шалтгаанаар тэр бүсгүйн шарил олдоогүй юм.

Константин Демирис түүнийг нууж орхисон байсан юм.

Тони Риццоли түүнээс нүд салгасангүй.

-Хүлээгээрэй. Тэгэхээр хүүхнийг амьд байсаар атал Демирис хүүхэн залуу хоёрыг цаазын тавцанд аваачсан болж таарах нь уу?

-Яг тийм. Би хуулийханд танил тал багатай, гэхдээ л энэ тухай ил тод болох юм бол миний хүргэн олон жилийг өргөст хананы цаана өнгөрөөх хэрэгтэй болно доо. Багаар бодоход л тэр баларч нурна гэсэн үг.

Тони энд ирээд сонссонзүйлдээ их хүч гарган бодож сууна. Нэг л биш санагдаад болж өгсөнгүй.

-Ноён Ламброу, харин та яагаад энэ бүгдийг надад яриад байгаа юм бэ?

Ламброугийн уруулд инээмсэглэл маягийн жимийлт бий болсноо,

-Би хүргэндээ бага сага өртэй юм. Түүн рүү очигтун. Тэр танд хөлөг онгоц дуртайяа гаргаж өгнө гэдэгт би итгэлтэй байна гэв.

Арван дөрөвдүгээр хэсэг

Түүний сэтгэлд шуурга шуурч, тэр яаж ч чадахгүй байлаа. Дотор нь мөстөн хөлдөж, ямар ч гэгээн дурсамж үгүй болсон шиг. Энэ бүхэн жилийн өмнөөс буюу хуурамч зангийх нь төлөө Ноэллигээс өшөөгөө авсан цагаас эхэлсэн юм. Тэднийг цаазалж орхихоор л бүх юм нам жим болж дарагдан мартагдана гэж бодож байсан боловч түүни оюун санааны амьдралд Кэтрин хүүхнийг шинээр оролдоогүй байгаа цагт ямар нэг үр дагавар гарна гэж бодсон ч үгүй. Гэтэл Фредерик Ставрос болон Наполеон Чотасаас хагацах хэрэг гарсан. Тэд амьддаа бус үхсэн хойноо түүний эсрэг тоглоом өрнүүлсэн боловч тэд нэгэнтээ ялагдсан. Хурц иртэй хутганы ирмэгээр алхах мэт осолтой зүйл хийх нь өөрт нь хичнээн их таашаал авчирч байгааг Демирис хамгаас илүү гайхна. Тэрээр бизнесийг ихэд анхааран сонирхдог байсан бол тэр нь одоо үхэл болоод амьдралтай холбоотой тоглоомд дарагдан бүдгэрч сааралтаад иржээ. "Би алуурчин" гэж Демирис бодсоноо:

-Үгүй алуурчин биш харин "зандалчин" гэж өөртөө хэллээ. Энэ бодол түүнд аймшигтай санагдах ёстой атал харин ч ер бусын гайхалтай сэрэл төрүүлэх нь гайхалтай.

Демирис зөвхөн Кэтрин Александрт зориулан долоо хоногийн амралт авжээ. Одоо хүртэл бүх зүйл ёсоороо явагдаж байна. Үндсэндээ тэр хүүхэн хамт ажилладаг хүмүүстэйгээ л уулздаг харилцаатай байдаг. Кэт заримдаа Кирк Рейнольдстой уулздаг гэж Эвелин мэдэгдсэн боловч тэр нь бас Демирист ажилладаг учраас эндээс ямар нэгэн асуудал урган гарах нь юу л бол. "Магадгүй хүүхэн ганцаардсан байлгүй" гэж Демирис бодов. "Рейнольдс залхуутай амьтан. Хууль шүүхээс өөр юу ч ярьж тэр чадахгүй. Тэгэх тусмаа л сайн. Кэтрин хэдий чинээ ганцаардана түүнд төдий чинээ сайн. Би Кирк Рейнольдсд харин ч баярлалаа гэж хэлэх ёстой".

* * *

Кэтрин Кирктэй улам улам уулзах болж тэгэх тусам түүнд улам их дассаар байв. Тэр нэг их царайлаг биш хэдий ч аятайхан залуу байв. "Гоо сайхан гэж юу байдгийг би Ларригаас бишгүйдээ суралцсан. Гоо сияхны таашаалаа би түүнтэй цуг алдсан. Хүмүүсийн ярьдгаар гаднаа гяланцаг дотроо паланцаг гэдэг үнэн үг" гэж хүүхэн бодно. Кирк бол халамжтай болоод найдаж болох хүн. "Би түүнд итгэж блох юм. Гэхдээ би одоо гал халуун тачаалд автахаасаа нэгэнт өнгөрсөн. Ларри л намайг ийм болгосон. Намайг хүндэтгэж төвшин байлгаж чадах хүнийг л би хүсэж байна" гэж бодлоо.

Тэр намайг яаж орхих бол гэж айхгүй л боллоо.

-Энэ долоо хоногт би Сент-Мориц руу явна. Та миний саналыг бодож үзэв үү? гэж Кирк түүнд хэлэв. Кэтрин энэ тухай зөндөө боджээ. Кирк өөрт нь дурласныг тэр мэдэж байлаа. "Надад ч бас тэр таалагдаж байна. Гэвч би түүнд хайртай гэсэн үг биш, энэ хоёр тэс өөр утгатай үг. Эсвэл би дэндүү хийсвэр бодолтой хүн үү? Би бас нэг Ларриг хүлээгээд байгаа юм болуу? Эхлээд миний толгойг эргүүлж дараа нь өөр хүүхэнтэй холбогдон намайг алах гэж оролдох хүнийг үү? Кирк сайн эр нөхөр болно. Би юунд эргэлзээд байгаа юм болоо?"

Тэр үдэш Кирк Кэтрин хоёр "Мирабель" зоогийн газарт хооллов. Амттан авчирч тавьсны

дараа Кирк түүнд,

-Кэтрин, чи миний юу хэлэхийг мэдэж байна уу? Би чамд хайртай, тэгээд чи миний эхнэр болоосой гэж би хүсэж байна гэв.

Кэтрин гэнэт балмагдан сандарч орхив.

-Кирк ... гээд үгээ олохгүй дуугүй болов. "Одоо миний хэлэх үг л миний амьдарлыг шийднэ. Ингээд л зөвшөөрч орхих гэж үү? Бүх юм давтагдах уу? Бүх насаараа айж явах хэрэг үү? Гэхдээ би энэ боломжыг алдаж бас болохгүй".

-Кэтти ...

-Кирк, бид Сент-Мориц руу хамт явж яагаад болохгүй гэж.

Кирк баярлан гийж,

-Чи ... хэлэх гээ юу? гэж асуулаа.

-Очоод л хараарай. Намайг цанаар хэрхэн гулгахыг хараад л эхнэрээ болгох хүсэл чинь алга болох вий.

-Энэ хорвоо дээр миний хүслийг юу ч боож чадахгүй. Би хичнээн аз жаргалтай байгааг чи мэдэж байна уу? Гай Фоксын төрсөн өдөр 11 сарын 7-ны өдөр явцгаая.

-Гай Фокс гэж хэн юм бэ?

-Өө, энэ тухай гайхалтай сонон түүх байдаг юм. Жеймс хаан Католик шахсны эсрэг бодлого баримталдаг байжээ. Католик шашны нэр цуутай хүмүүс нэгдэж засгийн газрыг унагаах зорилготой хуйвалдаан зохион байгуулж байсан ба тэр үед хуйвалдааныг Испаны дүрвэгч Гай Фокс гэдэг цэрэг толгилж байв. Тэрээр 36 боошиг буюу бараг тонн шахуу хууриа дарь олж аваад ордны хонгилд нууж, өглөө нь дэлбэлэхээр тогтсон байсан боловч нэгэн урвагч тэднийг илчлэн барьж өгснөөр энэ хэрэг нурсан юм. Гайг эрүүдэж тамласан ч тэр ам алдаагүй гэдэг. Тэгээд хуйвалдаанд оролцогчдыг цөмийг цаазалжээ. Үүнээс хойш одоог хүртэл Англид энэ хуйвалдааныг илчилсэн өдрийг тэмдэглэж түүдэг гал асааж мануухай хийж баярладаг болсон юм гэж Кирк ярив.

Кэтрин толгой сэгсэрч,

-Ямар гунигтай баяр вэ? гэхэд,

-Бидний баяр гунигтай байхгүй гэдгийг чамд амлачихая гэлээ.

Явахын өмнөх орой Кэтрин толгойгоо угааж хоёр ч удаа усанд орж, хувцас ачаа сэлтээ зэхэв. Одоо хүртэл хоёр л эр хүнтэй ойр дотно харьцаатай байсан ба энэ нь нэг нь Уильям Фрезер нөгөөх нь түүний нөхөр байжээ. "Сонин юм. Одоо хүмүүс дотно харьцаа гэж ярьдах болж дээ. Бурхан минь, би үүнийг хэрхэн үйлддэгээ бараг мартжээ. Дугуйгаар явахыг мартах

аргагүйн адил үүнийг мартаж болохгүй гэдэгсэн. Орон дотор ороод би түүнд таалагдахгүй байж магад. Янз бүрийн юм бодолгүй унтахыг хичээе" гэж бодно.

-Ноён Демирис үү?

-Тийм байна.

-Өнөө өглөө Кэтрин Александр Сент-Мориц руу явсан.

Хэсэг чимээгүй болов.

-Сент-Мориц гэнээ?

-Тиймээ, эрхмээ.

-Ганцаараа юу?

-Үгүй, эрхмээ. Кирк Рейнольдсын хамт.

Энэ удаа чимээгүй байдал илүү удаан үргэлжлэв.

-Танд баярлалаа. Эвелин гээд Демирис утсаа тавьлаа.

"Кирк Рейнольдс! Ингэнэ гэж хэн санах билээ? Түүний юу нь Кэтэд таалагддаг байнаа? Яарах хэрэгтэй байсан юм. Би дэндүү удаан хүлээлээ. Ямар нэг юм бодож олохгүй болохгүй нь ... Би ..."

Нарийн бичгийн даргын дуу гарч,

-Ноён Демирис, тантай АнТони риццоли уулзъя гэж хүсэж байна. Гэхдээ та түүнтэй уулзахаар тохиролцоогүй болохоор ...

-Тэгвэл та юунд надад төвөг удаад байгаа юм бэ?

-Төвөг удсанд өршөөгөөрэй. Гэхдээ Риццоли танд ноён Ламброугаас чухал мэдээтэй ирлээ гэж зүтгээд байгаа юм.

"Ламброугаас гэнээ? Сонин л юм даа. Тэр яагаад өөрөө ярьсангүй вэ?"

-Түүнийг оруул.

-Мэдлээ.

Тони Риццоли Демирисын өрөөнд ороод эргэн тойрноо гайхан харж дэндүү тохилог, Ламброугаас хамаагүй илүү өрөөнд суудгийг нь дотроо ойшоов.

-Танилцахад таатай байна, ноён Демирис.

-Танд хоёрхон л минут өгье.

-Спирос намайг тан руу явууллаа. Бидэнд ярилцах юм бий гэж тэр бодсон бололтой.

-Тэгээд? Юу юм бэ?

-Суухыг зөвшөөрнө үү?

-Таныг тэгтлээ удах хэрэгтэй гэж би бодохгүй байна.

Тони Демирисын өөдөөс харж суугаад,

-Ноён Демирис, би нэг үйлдвэртэй юм. Тэгээд бараагаа дэлхийн өнцөг булан бүрт хүргэмээр байгаа юм.

-Ойлгомжтой. Та миний хөлөг онгоцнооц нэгийг нь хөлслөх санаатай байгаа юм у?

-Яг тийм.

-Яагаад Спирос таныг над руу явуулдаг билээ? Яагаад тэр өөрөө онгоц өгөөгүй юм бэ? Төөний хоёр онгоц үргэлж сул зогсдог юм шүү дээ.

Тони бүү мэд гэсэн янзтай мөрөө хавчаад,

-Магадгүй миний бараа түүнд таалагдаагүй бололтой гэв.

-Ойлгосонгүй. Ямар бараа юм бэ?

-Хар тамхи. Геройн гэж Тони сулхан хэлэв.

Константин Демирис чихэндээ ч итгэсэнгүй.

-Тэгээд та намайг яана гэж бодоо вэ? Алив, эндээс одоохон зайл. Эсвэл би цагдаа дуудлаа шүү.

Риццоли утас руу цохиж,

-Тэг л дээ гээд түүнийг утас руу гараа сарваймагц,

-Надад ч гэсэн тэдэнтэй ярилцах зүйл бий. Ларри Дуглас, Хоэлль Пейж нарын шүүх хурлын талаар ярина даа гэсэнд Демирисын гар хөдөлгөөнгүй болон хөшив.

-Та юу хэлэв?

-Одоо хэр нь амьд мэнд байгаа эмэгтэйг алсан хэрэгт тэд цаазлуулсан.

Демирисын царай шоо шиг цайж орхив.

-Ноён Демирис, цагдаагийнхан үүнийг сонирхохо болов уу, та юу гэж бодож байна? Хэрэв тэд сонирхдоггүй юм бол хэвлэлийнхэн уухай гээд шүүрэн авна даа. Таны зураг сонины эхний нүүрэнд гарсан байгаагаар нь би төсөөлж байна. Би таныг Коста гэж дуудаж болно биз дээ? Таны найз нөхөд таныг ингэж дууддаг гэж Спирос надад хэлсэн юм. Сайн найзууд нэг нэгнээ хөөддөггүй биздээ? Бидний бяцхан нууц эндээ лү лдэг. Бид найзууд болох ёстой гэдэгт итгэж байна.

Демирис хөдөлгөөнгүй гөлийн сууна. Тэгээд эцэст нь сөөнгөтсөн дуугаар,

-Та надаас юу хүсээд байгаа юм бэ? гэж асуув.

-Би таны онгоцнуудын нэгийг хөлслөн авмаар байна. Нэгэнт бид найз нөхөд болсон болохоор та надаас лав хөлс нэхэхгүй байлгүй, тийм үү? Тусыг тусаар гэдэг шүү дээ.

Демирис хүндээр амьсгаадан,

-Би үүнийг танд зөвшөөрч чадахгүй. Хэрэв хар тамхи зөөсөн маань илэрвэл би бүх флотоо алдана гэсэнд,

-Энэ тухай хэн мэдэх юм бэ? Хэн ч мэдэхгүй. Бид ажлаа зар суртчилгаагүйгээр явуулдаг хүмүүс. Бүгдийг чимээгүй гүйцэтгэнэ гэлээ.

Демирисын царай ширүүн болж,

-Та том алдаа хийлээ дээ. Намайг сүрдүүлэн шаха хэрэггүй байсан юм. Миний хэн болохыг та мэдэх үү? гэж асуув.

-Та юу? Миний шинэ хамсаатан. Коста минь, чи бид хоёр одоо тун удаан хамтран зүтгэх болно, яагаад гэвэл чамайг татгалзвал би цагдаагийн газар руу даруйхан утасдаж сонин хэвлэлийнхэнд мэдэгдэнэ. Тэгвэл чиний алдар нэр аугаа эрх мэдэл зэрэглээ мэт хоосон болно.

Демирис удаан чимээгүй суув.

-Спирос энэ тухай хаанаас мэдсэн юм бол?

Риццоли инээж,

-Ямар ялгаа байна? Хамгийн гол нь би одоо чинээ төмсөгнөөс бариад авсан хойно чи тайган амьтан болох нь тэр. Үлдсэн амьдралаа шоронд өнгөрөөх хэрэг гарах байх шүү гээд цаг харснаа,

-Бурхан минь, нөгөө хоёр минут нь өнгөрч орхисон байна гээд босож,

-Чамд жаран секунд өгье. Тэгээд шийдэж үз. Би эсвэл чиний хамсаатан хамтран зүтгэгч болоод эндээс гарна эсвэл чи өөртөө гомд доо гэлээ.

Энэ хэдхэн секундэд Константин Демирис арван жилээр хөгширч орхих шиг болов. Царайд нь ганц ч дусал цус үлдсэнгүй. Нөгөө гайтай шүүх хуралтай холбоотой болсон явдлын тухай мэдээ гадагшаа халин гарна гэдэгт тэр өчүүхэн ч эргэлзсэнгүй. Хэвлэлийнхэн түүний гэдсийг цувуулах болно доо. Бүгд түүнийг аймшигт алуурчинд тооцох болно. Аягүй бол цаашлаад бүр Ставрос, Чотас хоёрын үхлийн шалтгааныг эрэх бодол хэн нэгэн саваагүй амьтны толгой орж л таараа.

-Таны бодох хугацаа дууслаа.

Константин Демирис уданаар тоглойд дохиж,

-За яахав гэж шивэглэв. Тони түүнийг харан хөгжилтэй инээж,

-Чи ч тэнэг биш юмаа гэлээ.

Демирис аажуухан босож,

-Чамд нэг удаа буулт хийе. Энэ бүгдийг хэзээ яаж амжуулахыг чинь мэдэхийг ч үхсэхгүй байна. Яах вэ нэг хөлөг онгоц гаргаж өгье. Гүйцээ гэв.

-Тохирлоо гэж Тони Риццоли чангаар хэлээд дотроо "Чи тийм ч ухаалаг хүн бас биш бололтой. Хориотой бараа ганц удаа тээвэрлэхэд л чи ингээд дэгээнд орлоо гэсэн үг. Коста минь, одоо чи миний гараас хаашаа ч гарахгүй" гэж бодсон боловч,

-Тиймээ тохирлоо гэж чангаар давтан хэлэв.

Тони Риццоли зочид буудалдаа ихээхэн баяр хөөртэйг эргэж ирлээ. Мансууруулах бодистой тэмцэх агентынханы толгойнд Константин Демирисын хөлөг онгоцыг шалгах бодол орох ч үгүй. Бурхан минь. "Ёстой гялалзсан амжилт! Тэгэхээр одоотүүний нэг ч хөлөг онгоц миний барааг тээвэрлэхгүйгээр явахгүй дээ, Мөнгийг ч ургуулж гарна даа. "Нунтаг" бас дээр нь хуучны бишээ, уучил Виктор минь эртний гэх гэсэн юм" гэж бодоод чангаар хөхрөв.

Риццоли Стадоу гудамжин дахь утасны бүхээгнээс хоёр ч тийшээ утсаар ярив. Эхнийх нь Палермо руу Пит Люкатай ярьсан байлаа.

-Энэ бичнүүдээ татаж аваачээ. Байх ёстой амьтны хүрээлэнд нь аваачиж хий. Ачаа замд гарахад бэлэн болсон. Далайгаар шүү гэж түүнийг хэлэхэд,

-Бэлэн гэдэгт чи итгэлтэй байна уу гэж Люка итгэлгүйхэн асуув.

-Английн банкнаас ч найдвартай гэсэн үг. Уулзаад яримз. Бас өөр нэг сайхан мэдээ байна. Үүнээс хойш бүр долоо хоног болгон бараа илгээж чадахаар болсон.

-Сайн байна, Тони. Чамд итгэж болно гэдгийг би мэднэ.

"Би чамд итгэдэг шиг л чи надад итгэдэг байлгүй, өмхий ямаа" гэж Тони бодов.

Дараа нь Ламброу руу талгаж,

-Бүх зүйл ёсоор болсон. Би одоо хамаатны тань хамтран зүтгэгч болсон гэсэнд,

-Танд баяр хүргэе. Сонсоход таатай байна, Тони гэв.

Харилцуур өлгөж байхдаа Спирос Ламброу "Мансууруулах бодистой тэмцэх тасгийнхан ч бас энэ тухай дуулаад баяртай байх болно" гэж бодон инээмсэглэлээ.

Константин Демирис шөнө болсон хойно өрөөндөө суусан хэвээр тулгарсан төвөгтэй асуудлыг эргүцүүлэн бодлоо. Ноэллиэс өшөөгөө авсан атал тэр хүүхэн дахиад авснаасаа өндийж эхэллээ. Тэгээд Демирис ширээний нүднээс Ноэллийн жаазтай зургийг гарган өмнөө тавьж, "Мэнд үү, миний бяцхан хонгор. Бурхан минь, чи ямар сайхан хүүхэн гэж санана! Намайг устгахаар шийдээ юу. Тийм бол харж л байж больё. Тиймээ, харж л байж больё" гэж шивэгнэн хэллээ.

Арван тавдугаар хэсэг

Сент-Мориц үнэхээр үзэсгэлэнтэй газар байлаа. Олон арван миль үргэлжилсэн цанын зам, явган аялагчдад зориулсан зөрөг, чарганы болон усны положийн тэмцээн гээд л байдаг болгонд зориулагдсан газар ажээ. Кэтрин амьдралдаа анх удаа Альпын нурууны бэлд Этадай хөндийн тунгалаг уст нуурын хөвөөнд байрласан бяц хан тосгоныг хараад сэтгэл хөөрөн баярлажээ.

Тэд газар газрын жуулчдаар дүүрсэн "Палац" зочид буудалд байрлав.

-Кирк Рейнольдс захиалсан өрөө аль вэ? гэж асуухад Кэтрин нүүрээ улайлган хуримын бөгж зүүдэг байж гэж бодов. Дэргэд байгаа хүмүүс цөмөөрөө л түүнийг хараад мэдээд байх шиг санагджээ.

-Байнаа. 215 дугаар өрөөг захиалсан байна гээд жижүүр түлхүүр өгч,

-Намайг дагаад явна уу. Би хүргэж өгье гэв.

Гайхамшигтай, үзэсгэлэнтэй уул тийш харсан цонхтой өрөө таарчээ. Түүний явж одсон хойно Кирк,

-Би ямар их аз жаргалтай байгаагаа хэлж ч чадахгүй байна гэвэл Кэт,

-Би чиний урмыг хугалж орхихгүй болов уу гэж найдаж байна. Энэ бүхэн маш эрт болсон ... Кирк гэлээ.

-Би чамайг яаруулахгүй. Тэгэхээр бүү зов доо.

"Тэр ямар сайхан зөөлөн сэтгэлтэй хүн бэ! Гэхдээ тэр миний өнгөрсөн амьдралыг дуулаад юу гэх бол?". Тэр түүнд Ларригийн тухай, шүүх хурал мөн өөрт тохиолдсон аймшигт явдуулдын тухай яриагүй. Яагаад ч юм бэ, сэтгэлд дотно ойр байдаг хүн гэж бүрэн итгэж найдахад нь ымаар нэгэн хүчин саад болоод байх шиг санагдана.

-Би юмаа янзлая даа гэж Кэтрин хэлэв.

Хүүхэн удаан тэгэхдээ хэтэрхий удаан юмаа янзалж байгаагаа гэнэт мэдэрч хийх юмаа олж ядан зүгээр л болох гэж байгаа зүйлийг бодохоос ч айн цаг уаяж байгаагаа ойлголоо. Нөгөө өрөөнөөс Киркын дуу гарч,

-Кэтрин ... гэлээ.

"Бурхан минь. Тэр гэнэт орондоо орцгооы гэвэл яана?" гэж бодоод биеэ арай гэж хүчлэн,

-Өөв гэж дуугарсанд,

-Бид гадаа гудамжинд грач юм сонирхож яагаад болохгүй билээ гэж Кирк хэлэв.

Кэтрин сэтгэл хөнгөрөн баяртайгаар,

-Сайхан санаа байна гэж хэлж дуусмагцаа "Би юу болоод байнаа? Ийм сайхан газар, надад дурласан сэтгэлд таатай эртэй хамт байгаа мөртлөө юунаасаа айгаад чичрээд байнаа?" гэж өөрийгөө зэмлэн бодов.

Рейнольдс түүнийг нэг л сонин харж,

-Чи зүгээр үү? гэв.

-Зүв зүгээр байна гэж аль болох хөгжилтэй хэлбэл,

-Чиний царай сандарсан шинжтэй байх юм гэлээ.

-За үгүй дээ ... Зүгээр л цанаар гулгана гэж бодохоос л ... Хүмүүс их аюултай гэж ярилцдаг юм билээ.

-Өө зовох хэрэггүй. Бид маргаашнаас эхлэнэ. Алив явцгаая гэж хэлэн Кирк инээв.

Тэд хувцаслаад зочид буудлаас гарлаа. Агаар цэвэр тунгалаг ариухан үнртэнэ.

-Ямар сиахан юм бэ! Энд надад аймаар таалагдаж байна, Кирк.

-Юу ч үзээгүй байж уу? Зун бол ямар гоё гээч, бүр хамаагүй дээр шүү.

"Зун бас надтай уулзах гэж бодож байгаа байх нь уу? Эсвэл би бүр урмыг нь хугалж орхих болов уу? Яагаад би огт тайвширч чадахгүй байгаа юм бол?"

Сент-Мориц тосгон үнэхээрийн үзэсгэлэн төгс газар ажээ. Альын сүрлэг нурууны бэлд тараан байрлуулсан бяц хан мухлаг, дэлгүүр, зоогийн газар үлгэрийн юм шиг үзэгдэнэ.

Тэд дэлгүүрээр явж Уйм, Эвелин хоёрт бэлэг авлаа. Дараа нь бяц хан цайны газар орж шарсан мах идэцгээлээ.

Өдрийн хоёрдугаар хагасыг тэд Киркын олж авчирсан сайхан хээр морь хөлөглөсөн чаргаар, даваа гүвээн дундуур сүлжсэн цасан замаар гулгаж өнгөрүүлэв.

-Таалагджа байна уу? гэж Кирк асуув.

-Гойд гэж хэлэхдээ Кэтрин "Би өнөөдөр чамайг аз жаргалтай байлганаа. Чи өнөөдөр жаргах болно" гэж бодов.

Тэр оройдоо л тэд эртний модон барилгыг санагдуулам зоогийн газарт Стибулид хооллов.

-Энэ байшин 1480 онд баригдсан гэдэг хэмээн Кирк сонирхуулан ярив.

-Тийм бол талх захиалахаа ч болих уу даа?

-Юу?

-Хошигносон юм, уучлаарай гэж Кэт инээн хэлэв.

"Ларри үргэлж миний хошигнолыг ойлгодог байсан. Би яагаад цаг ямагт түүнийг боддог юм болоо? Яагаад гэвэл би өнөө шөнийн тухай бодмооргүй байна. Би яг л цаазын тавцан дээр зогсож байгаа Мария-Антуанетта шиг санагдаад байна. Амттан зооглох үед л бялуу идэхээ больё".

Хоол хэдийгээр дөжгүй сайхан байсан боловч сэтгэл тавгүйтсэн Кэт үүнийг ажигласангүй,
Хооллож дуусаад Кирк,

-Дээшээ гарах уу даа? Би чамтай маргааш л цанаар гулгаж эхлэхээр тохирсон байхаа? Өглө эрт босох хэрэгтэй гэж хэлэв.

-Тэгэлгүй яахав. Сайхан байна.

Шатаар өгсөх үед Кэтийн зүрх түг түг цохилж байлаа. "Одоо л орондоо орцгооы гэх байх даа. Үгүй яагаад тэгж хэлэхгүй байгаа юм бэ? Үүний тулд л бид хамтдаа байгаа биз дээ? Үгүй гэж үү? Цанаар гулгах гэж л ирээгүй дэг" гэж бодно.

Тэд өрөөнд ороход Рейнольдс үүд хаагаад гэрлээ асаав. Унтлагын өрөө рүү орохдоо Кэтрин бараг өрөө дүүргэсэн том өргөн орыг хараад дальдчив. Кирк түүн рүү анхааралтай харж,

-Чи ямар нэгэн юманд санаа зовоод тайвангүй байх шиг? гэж асуусанд,

-Юу? гээд аяархан инээж,

-Үгүй, яалаа гэж би зөвхөн гэв.

-Зөвхөн юу гэж?

-Үгүй дээ, зүгээр бүх юм ёсоороо байна.

-Тийм бол хувцасаа тайлаад орондоо орцгоох уу даа?

"Яг ингэнэ гэж би бодож байсан юм. Заавал ингэж хэлэх хэрэг байсан юм болов уу? Уг нь үтгүйгээр бүгдийг хийж болох сон. Бүх юмыг нэрээр нь нэрлэж ... нэг л болхи юм аа"

-Чи юу гэв ээ?

Кэтрин чангаар яриад байгаагаа анхандаа ойлгосонгүй, дараа нь,

-Зүгээр ээ гэв.

Тэр ор руу дөхөж очив. "Ийм том ор байх гэж. Зөвхөн дурласна юм уу гэрлэсэн хосуудад л зориулагдсан нь илт. Унтахад биш янаглахад зориулсан. Энэ ор бол ..."

-Чи хувцасаа тайлах гэж байна уу, хонгор минь?

"Хамгийн сүүлд би хэзээ эрэгтэй хүнтэй унтлаа? Жил гариун өмнө шүү дээ. Тэр хүн миний нөхөр байсан"

-Кэтти ...

-Юу гэв?

"Намайг тайчаад оронд орж хэвтэхээр чиний урам хугарч орхих болно. Кирк ээ, и чамд хайргүй. Чамтай унтаж чадахгүй нь" гэж бодоод,

-Кирк ээ гэж дуудлаа.

Хагас нүцгэлээд байсан Кирк түүн рүү эргэн,

-Юу? гэж асуусанд,

-Кирк ээ, намайг уучлаарай ... Би ... Чи надад дургүй чинь хүрэх байх гэхдээ би чадахгүй нь. Надад их харамсалтай байна. Чи магадгүй бодох байх, би ... гэж дээр дээр нь давхцуулан хэлээд залуугийн урмыг хугалж орхисоноо харан дуугуй боллоо. Гэвч Кирк инээмсэглэхийг оролдон,

-Кэтти, би чамд тэвчээртэй хандана гэдгээ хэлсэн шүү дээ. Чи бэлэн болж амжаагүй байгааг би ойлгож байна .. гэсэн ч энд бид сайхан байна шүү дээ гэв.

Кэтрин баярлан хацар дээр нь үнсээд,

-Баярлалаа чамд, Кирк. Их инээдэмтэй харагдаж байгаагаа би ойлгож байна. Юу болоод байгаагаа өөрөө ч ойлгохгүй нь.

-Чи зүгээр л байна шүү дээ. Би ойлгож байна гэж Кирк тайвшруулав.

Кэтрин түүнийг тэвэрч,

-Чи ёстой сайн эр хүн юм. Ямар сайхан сэтгэлтэй хүн бэ гэж магтлаа.

-Тэгэхээр одоо би зочдын өрөөний буйдан дээр хажуулах болох нь гээд этр санаа алдав.

-Өө үгүй шүү. Миний л буруугаас энэ бүхэн болж байгаа учраас би чамайг тавтай байлгах талаар санаа тавих ёстой. Би буйдан дээр харин чи энд орон дээрээ унт гэлээ.

-Эрс татгалзаж байна!

Кэтрин хэвтээд Рейнольдсын талаар удаан бодов. "Би хэзээ нэгэн цагт ер эр хүнтэй унтаж чадна гэж үү? Эсвэл Ларри миний хамаг баяр жаргалыг бүрмөсөн аваад явчихсан юм уу? Тодорхой бодолтойгоор намайг алах гэж оролдсон ч байж болох юмаа даа?". Эцэст нь арай

гэж унтаад өглөө.

Шөнө дундын үед Кирк Рейнольдсыг хашгирах дуу сэрээв. Тэрээр өндийн суугаад чагнасанд хашгирах дуу үргэлжилсээр байсан тул унтлагын өрөө рүү гүйн оров.

Кэтрин орон дээрээ нүдээ чанга анин хэвтэнэ.

-Үгүй, хэрэггүй, хэрэггүй ... намайг тавиач!

Кирк өвдөг дээрээ сөхрөн түүнийг тэвэрч авав.

-Чимээгүй, зүгээр, тайвшир. Бүх юм хэвийн байна гэж тэр шивэгнэв.

Тэгээд Кэтрины чичирч салгалсан биеийг тэвэрсээр суулаа.

-Тэд намайг живүүлэх гэсэн.

-Чи зүүдэлсэн байна шүү дээ. Жирийн муухай хар дарсан зүүд.

-Үгүй. Энэ зүүд биш. Бүх юм үнэн. Тэд намайг алахыг оролдсон юм.

Кирк түүн рүү гайхан харж,

-Хэн чамайг алах гэсэн юм бэ?

-Миний нөхөр нууц амрагтайгаа хамт ...

Тэр толги сэгсэрч,

-Кэтрин чи зөвхөн аймшгийн зүүд үзжээ гэсэндм

-Миний ярьж байгаа бол үнэн. Тэд намайг алах гэж оролдсон, тэгээд цаазлуулсан юм гэхэд Киркын царайд үл итгэсэн байдал тодорч,

-Кэтрин ... гэж дуу алдав.

-Би урьд нь чамд энэ тухай яриагүй юм. Яагаад гэвэл надад санахаас аймаар байдаг.

Хүүхний үнэн яриад байгааг Кирк гэнэт ойлгов.

-Юу болсон юм бэ?

-Би Ларригаас салахыг зөвшөөрөөгүй, харин тэр ... тэр өөр хүүхэнд дурласан байсан. Тэгээд л тэд намайг алахаар шийдсэн юм.

Кирк машид анхааран,

-Хэзээ болсон хэрэг вэ? гэж асуув.

-Жилийн өмнө.

-тэгээд тэд яасан?

-Тэднийг цаазалсан.

Кирк гараа өргөн,

-Байз. Чамайг алах гэж зөвхөн оролдсоны нь төлөө л тэднийг цаазаар авсан гэж чи хэлэх гээд байна уу?

-Тиймээ.

-Би Грекийн хуулийг сайн мэдэхгүй л дээ. Гэхдээ грекэд хүн алах оролдого хийсэн төдийгөөр хуулийн дээд хэмжээ олгодоггүй. Энд ямар нэгэн андуурал гач. Надад Афинд нэг танил бий, тэр Улсын яллагч хүн. Маргааш өглөө л түүн рүү ярьж бүгдийг тодруулж үзье. Түүнийг Питер Демонидес гэдэг юм гэлээ.

Өглөө Киркыг сэрэхэд Кэтрин унтсаар байлаа. Тэр чимээ гаргалгүйхэн хувцаслаад өрөөнөөс гарахдаа үүдэнд очсоноо зогсон эргэн хараад "Би түүнд хайртай. Үнэн хэрэгтээ ямар хэрэг гарсныг тодруулж мэдээд түүнийгээ энэ ёрын айдсаас салгах хэрэгтэй" гэж бодлоо.

Кирк Рейнольдс танхимын гудам руу бууж Афинтай ярих захиалга өглөө.

-Би Питер Дименидосын хувийн утсанд залгуулмаар байна гэж тэр холбогчид хандан хүсэв.

Хагас цагийн дараа түүнийг холбож өгчээ.

-Ноён Демонидос уу? Кирк Рейнольдс байна. Та намайг таних бол ...

-Танилгүй яах вэ. Та Константин Демирист ажилладаг биз дээ?

-Тиймээ.

-Танд юугаар тус болохсон бол?

-Төвөг удаж байгааг минь өршөөгөөрэй. Би нэг хачирхалтай юм олж мэдлээ. Грекийн хуультай холбоотой.

-Грекийн хуулийг бага сага мэднэ шүү гэж Демонидос хөгжилтэй хэлээд,

-Танд тус болохдоо таатай байна гэлээ.

-Хүн алахыг завдсан хэрэгт дээд хэмжээ цааз өгдөг хууль байдаг болов уу?

Хэсэг чимээгүй болсноо,

-Энэ талаар юунд сонирхож байгааг тань мэдэж болохсон болов уу?

-Би Кэтрин Александр гэдэг эмэгтэйтэй танил юм л даа. Түүний нөхөр нууц амрагийнхаа хамтаар өөрийг нь алах гэж ойролдсон шалтгаанаар цаазлагдсан гэж хөөрхий эмэгтэй бодоод байгаа юм. Энэ нэг л биш санагдаад байна, та намайг ойлгож байгаа биздээ?

-Тэгэлгүй яахав гэх Демонидосын дуу нэг л хачин сонсогдов.

-Таны юу гэх гээд байгааг ойлгож байна. Та одоо хаа байна, ноён Рейнольдс?

-Цент-Мориц дахь "Палац" зочид буудалд.

-Би бүгдийг шалгаад тан руу утасданаа.

-Тэгвэл танд гүнээ талархах байна. Хэргийн учир нь Кэтрин Александр хоосон юм бодоод сэтгэлээ зовоогоод байх шиг байна. Тэгээд л би төөнийг тайвшруулах санаатай байгаа юм.

-Ойлгож байна. Би заавал эргэж утасдана гэж амлаж байна.

Цэвэр агаарт гараад Кэтрин урд шөнийн аймшгийг мартагнав.

Тосгонд хооллосны дараа Кирк,

-Одоо уул руу өгсөж чамайг цасан эмгэн болгоод орхиё гэв. Тэр Кэтриныг эхлэн суралцагсдын хэсэгт хүргэж өгөөд зааварлагчаар нэг хүн хөлслөн авав. Тэгээд,

-Би хайрн өнөөдөр Фуоркл-Гришийн өндөрлөгөөс буух гэж роолдоод үзье гэлээ.

-Гришийн оргил нилээд эгс шүү дээ. Юу ч гэсэн биеэ халаахын тулд та Корвигли Стэндрд Маргинсаас эхэлбэл танд ямар байна? гэж зааварлагч санал болгов.

-Муугүй санаа байна. Би тэр ёсоор болгоы. Хонгор минь хоюулаа зочид буудалдаа уулзаад оройн хоолоо хамт идэцгээнэ шүү.

-Тохирлоо гэж Кэтрин хэлж, Кирк гараа даллан дохиод явлаа.

-Цагийг сайхан өнгөрүүлээрэй гэж хүсье. Захидал бичихээ мартав аа хэмээн Кэт араас нь тоглоомоор хашгирсанд,

-За ажилдаа орох уу даа гэж сурган зааварлагч түүнд хэллээ.

Хамгийн сонирхолтой нь энэ спортын төрөл Кэтринд таалагдсан явдал байв. Ёстой гайхалтай өдрийг өнгөрөөсөндөө баярласан тэрээр гриль бааранд орж Киркыг хүлээж эхлэв. Хүйтэн жаварт хацар нь улайж ягаарсан Кирк'удалгүй дэргэд нь сууж,

--За яав? гэж асуусанд,

-Гайхамшигтай байлаа. Би онцын их хугарал гэмтэл аваагүй бас тэгээд дөнгөж зургаахан удаа

унасан гээд бодчих. Хичээлийн төгсгөлд би бүр гайгүй сайжирсан болохоор сургагч маань намайг Олимпын тоглолтонд зайлшгүй орох хүн юм гэсэн гээч,

Рейнольдс инээмсэглэн,

-Сайн байна гэж Питер Демонидостой ярьснаа хэлж санааг нь зовоогоод яахав гэж бодов.

-Би өрөөндөө очлоо. Жаахан унтмаар байна гэж Кэтыг хэлэхэд,

-Зөв санаа шүү. Эндхийн агаар хүнийг эрүүлжүүлдэг дэндүү цэвэрхэн болохоор амархан ядардаг юм гэлээ.

-Чи яах гэж байна, Кирк?

Кирк алсын оргилын оройг ширтэн,

-Би Гришийн оргилыг оролдоод үзмээр байна. Урьд нь тийшээ очиж байгаагүй гэлээ.

-Кирк, өчигдөр оройн хувьд намайг уучлаарай. Би ч харамссан. Би ... би алдаагаа засахыг хчихээнээ.

-Энэ тухай мартаад өрөөндөө очиж унт даа.

-Явлаа, явлаа.

"Ёстой сайн хүн шүү. Над шиг ийм мангуу амьтны юунд нь болдог юм бол доо?" гэж хүүхэн бодов.

Кэтрин ямар ч зүүд зүүдлээгүй тайван унтлаа. Түүнийг сэрэхэд оройн 6 цаг аль хэдийнэ болжээ. Удахгүй Кирк ирнэ. Удахгүй орой болно гэдэг бодол санаанаас нь гарч өгсөнгүй. "Үгүй орой биш харин шөнө, түүнд л сайхан байх юм болгоныг хийе" гэж Кэтрин өөртөө хатуу шийджээ.

Долоон цаг болсонд Кирк ирээгүй л байв. "Ухаангүй гулгаж яваа байх даа. Ийм харанхуйд болмооргүй л юм даа" гэж бодсоноо тэр юм уухаар бааранд орсон гэж мөрийцөхөд ч бэлэн байна гэж дуугарав.

Тэгж байтал утас дуугарлаа.

Кэтрин инээмсэглэн,

-Миний зөв байжээ. Тэр намайг буугад ир гэж хэлэх гэж байна гэснээ харилцуур авав.

-За яав? Цасны хүнтэйгээ уулзав уу? хэмээн баясан асуусанд үл таних эрэгтэйн дуу гарч,

-Хатагтай Рейнольдс уу? гэлээ.

-Тиймээ, би байна.

-Танд таагүй мэдээ дуулгах болсондоо зовж байна, хатагтай. Таны нөхөрт золгүй явдал тохиолдсон.

-Өө яалаа гэж дээ! Тэгээд ... их аюултай юу?

-Тийм гэж бодож байна.

-Би одоохон очлоо. Харин хаана ...

-Надад их харамсалтай байна, хатагтай. Гэвч таны нөхөр нас барсан. Тэр уулын уруу бууж яваад хүзүүгээ хугалсан байна гэжээ.

Арван зургадугаар хэсэг

Грек.

Тони Риццоли тэр хүүхнийг угаалгын өрөөнөөс гарч ирэхийг ажиглаад "Грек хүүхнүүд яахаараа ийм том бөгстэй байдаг байнаа" гэж бодов.

Хүүхэн түүний оронд шурган орж тэвэрснээ шивнэж,

-Чи намайг сонгосонд би баяртай байна. Чамайг би анх хараад л шууд хүссэн гэхийг дуулаад Тони золтой л тачигнатал инээчихсэнгүй.

-Тэгэлгүй яахав. Би ч гэсэн охин минь.

Тони түүнийг Каллари гудамжин дахь "Нью-Йоркер" цэнгээний газраас олж авчээ. Хүүхэн грекүүдийн жишиж хэлдэгээр "ульж буй ноход"-ын нэг бөгөөд тэр клуб дэх дууч хүүхнүүдийн нэг ч авьяастай гэж хэлэхийн аргагүй ажээ. Тэд ямар ч авьяасгүй боловч харин үйлчлүүлэгчид хэнийг нь ч дагуулаад явж болдог байж. Хар үстэй, сайхан ч 24 настай болохоор Тонигийн хувьд арай хөгшдөх аж. Гэвч Тони Афинд хэнийг ч танихгүйгээс гадна сонгоод байх юм байхгүй байлаа.

-Би чамд таалагдаж байна уу? хэмээн Хелена тоглон асуув.

-Тиймээ тийм, чи намайг галзууруулах нь гээд хүүхний хөхийг үнсээд таалсанд дорхноо хатуурахыг мэдэн жаахан чимхээд авав.

-Хөөе охин минь. Алив доошоо болоодхооч.

Хүүхэн эрс дургүйцэн,

-Би ийм юм хийдэггүй гэлээ. Риццоли түүнийг ширтэн харж,

-Юу хэлчихэв ээ? гэснээ гэнэт үсдэн аваад сэгсчив.

Хелена чарлан,

-Болиоч ээ гэж хашгирав. Риццоли хүчтэй алгадан,

-Ахиад дуугарвал хүзүүг чинь мушгиж орхино шүү гээд үснээс нь улам хүчтэй угзран салтаа руугаа шахаж,

-Тэр тэнд байгаа, охин минь. Алив түүнд минь баяр баясгалан хайрлаач гэлээ.

-Тавь гэж хүүхэн хоолой шахан хэлээд,

-Өвдөж байна шүү дээ гэлээ.

Риццоли дахин үсдэж аван,

-Хөөе, чи намайг хараад ухаан алдаж байснаа мартав уу гэснээ гараа сулруулахад хүүхэн толгой өргөн нүдээ гялалзуулан хараад,

-Тонил цаашаа гэлээ. Гэвч Тони гийн царай түүнийг дуугуй болоход хүргэв. Энэ хүн нэг л биш ээ. Үүнийг яагаад урьд нь ажигласангүй вэ.

-Хэрэлдэх хэрэг байна гэж үү гэж хүүхэн аргадангуй хэлээд,

-Бид ... гэтэл Тони бахим гараараа хүзүүг нь базаж аваад,

-Хэлэлцээр хийсний төлөө чамд мөнгө төлөх болох нь уу гээд нүүр рү нь дэлсэж,

-Амаа татаад ажлаа хий гэж зандарлаа.

-Өө тэгэлгүй яхав, хонгор минь гэж Хелена яаран хэллээ.

Риццоли ханаж цадахаа мэдэхгүй байсна болохоор Хелена хамаг хүчээ шавхаж дуусчээ. Хүүхэн түүнийг унтаж, дахин өөрийг нь зовоохоо больсон гэдэгт нь бүрэн итгэтлээ хэвтэв. Тэгээд дараа нь чимээ аниргүй босож хувцасаа өмсөв. Өөр үед бол хөлсөө авалгүй яхав нь бүү хэл түрүүвчнээс нь мөнгөө аваад дээр нь овоо ахиухан гарын мөнгө нэмж аваад талийж өгдөгсөн. Харин энэ удаа нэг муу зөн совин түүнийг мөнгөнд гар хүрэлгүй явахад хүргэв.

Цагийн дараа Тони хаалгаа чанга нүдэх чимээнээр сэрж өндийн суугаад цагаа харвал өглөөний дөрвөн цаг болж байв. Дэргэд нь хүүхэн алга.

-Хэн бэ? гэж түүнийг асуухад хаалганы цаана,

-Хөрш чинь байна. Таныг утсаар ярья гэж байна гэв.

Риццоли алгаараа духаа үрээд,

-Очлоо гэв.

Тэгээд халаад нөмрөн сандал руу ойртож очин түрийвч юугаа шалгавал мөнгө бүрэн бүтнээрээ байлаа.

"Тэнэг охин биш юм байж" гэж бодоод зуутын дэвсгэрт сугалж аван үүд рүү очив.

Хөрш нь халаад гэрийн шаахайтай гудамд зогсож байв.

-Ямар их удаг юм бэ? гэж тааламжгүйхэн дуугараад,

-Та надад хэлэхдээ ... гэх үед нь Риццоли зуун доллар сарвайлаа.

-Би их санаа зовж байна. Гэхдээ хрудхан шиг яринаа гэж зулгуйдан хэлбэл уур нь хэдийна

гарсан хөрш,

-За зүгээр дээ. Өглөөний 4 цагт утасдахыг бодоход чухал хэрэгтэй болоод тэр байлгүй гэлээ.

Риццоли хөршийнхөө өрөөнд орж харилцуур авав.

-Риццоли сонсож байна.

-Нэг асуудал гарч ирээд байна, ноён Риццоли гэх дуу гарав.

-Ямар хэрэг болов?

-Би Спирос Ламброугийн даалгавраар ярьж байна.

-Өө! гэж Тони дуу алдахад таагүй бодол сэтгэлийг нь эзэмдэн авч,

-Юу болж орхив оо, тэгээд? гэж сандран асуулаа.

-Константин Демирис тэй холбоотой юм.

-Тэгээд?

-Түүний нэг хөлөг онгоц одоо Марсельд байгаа.

-Цааш нь?

-Ноён Демирис түүнийг Афинд ирэхийг тушаасан байна. Онгоц ням гаригийн өглөө боомтод ирж зогсоод орой нь замд гарах юм байна. Константин Демирис уг онгоцоор явах гэнэ.

-Юу?!

-Тэрээр зугатахыг санаархаж байгаа юм байна.

-Демирис танаас хагацах аргаа олтлоо АНУ-д нуугдаж байх бололтой гэсэн мэдээг танд уламжлахыг надад ноён Ламброу тушаасан юм.

"Зальтай муу чонын бэлтрэг юм даа!"

-Ойлгомжтой. Ноён Ламброуд миний нэрийн өмнөөс талархаарай. Их баярлалаа хэмээн хэлнэ биз дээ гээд харилцуураа тавив.

Утасны яриаг бодох тусам сэтгэл улам тэнийсээр байлаа. Зугтах нь гэж сонсоод ямар их айв аа. Одоо түүнтэй харьцахад улам хялбар боллоо. Ням гариг хүртэл хоёр хоногийн зай байна.

Риццоли болгоомжтой байх ёстойгоо мэдэж байв. Түүнийг хаашаа ч явсан сүүл дагах боловч "Муусайн цагдаа нар. Цаг нь болохоор би та нарыг нэг л мөчид сэгсэрч орхино доо" гэж Тони жигшин бодно.

Маргааш нь өглөө эрт босоод Тони Кифиссиас гудамжны бүхээгнээс Афины Улсын төв Музей руу залгав. Бүхээгний шилний цаанаас гадагш харвал дагаж явсан хоёр сүүлний нэг нь дэлгүүрийн шилэн хорго тийш харан зогсох ба нөгөөх нь цэцгийн худалдагчтай яриа үүсгэсэн харагдана. "Та нарт амжилт хүсье" гэж Риццоли тавлав.

-Шинжээчийн өрөө байна. Танд юугаар туслах бол?

-Виктор уу? Би Тони байна.

-Ямар нэг юм болоо юу? гэх Викторын сандарсан дуу сонсогдлоо.

-За үгүй дээ гэж Тони түүнийг тайвшруулаад,

-Бүх зүйл хэвийн. Чи нөгөө гоё хэлбэртэй ваарыг санаж байна уу? гэвэл,

-"К" амфорыг хэлж байна уу? гэв.

-Ай даа. Би түүнийг өнөөдөр авмаар байна.

-Өнөөдөр үү? Би ... би мэдэхгүй байна, Тони гэнэт ямар нэгэн юм болбол ... гэхэд,

-За яах вэ, нөхөр минь. Энэ тухай март. Зөвхөн чиний үүргийг л сануулах гэсэн юм. Тийм бол чи Сэл Приззи руу утасдаад мөнгө байгүй гэдгээ хэл л дээ. Тэр чамайг яахыг харах юмсан гэлээ.

-Үгүй, Тони ... хүлээ ... За ... би гээд хэсэг чимээгүй болсонд Тони,

-Чи ингэхийг хүсээгүй биз дээ, Виктор? Хүсэхгүй байвал хэл л дээ. Би ямар ч асуудалгүй зүгээр л Нэгдсэн улс руу явж одмоор санагдаж байна. Чиний энэ бэрхшээл надад ямар ч хамаагүй шүү дээ.

-Үгүй, үгүй. Би чиний тусыг ихэд үнэлж байгаа. Чиний зөв юм байна, Тони. Өнөөдөр гэж тохиръё.

-За тийм бол музей хаасны дараа чи жинхэнийг нь дууриамалаар сольж орхи.

-Хамгаалагчид явахдаа бүгдийг шалгадаг юм л даа.

-Тэд чинь урлаг судлаачид биш биздээ?

-Үгүй л дээ.

-Сонсож бай, Виктор. Чи дууриамал бэлэг дурсгалын зүйл авах тасалбар бичүүлээд түүнийг сольж цаасан уутанд хий эмдэв үү?

-За, би ойлголоо ... Бид хана уулзах вэ?

-Уулзах хэрэггүй, Зургаан цагт музейгээс гарч явахад чинь үүдэнд хөлсний тэрэг хүлээж байх болно. Ууттай зүйлээ бариад таксид сууж жолоочид "Британика" зочид буудал орно гэж хэлээрэй. Хүргэж өгтөл нь чи чимээгүй явах ёстой. Буухдаа ууттай зүйлээ машин дотор үлдээгээд зочид буудал руу орж бааранд ямар нэг юм авч уугаад дараа нь гэртээ харьж болно.

-Нөгөө ...

-Тэр зүйлдээ санаа зовох хэрэггүй. Тэр найдвартай гарт орсон байх болно.

Виктор Коронцисын хамаг хөлс нь цувна.

-Би хэзээ ч ийм юм хийж яваагүй, Тони. Амьдралдаа ...

-Мэдэж байнаа. Би ч гэсэн адилхан. Чамд л туслах гэсэндээ ... гэхэд Коронцисын хоолой зангиран,

-Тони, та үнэхээр сайн найз юм. Надад ийм найз хэзээ ч байгаагүй гээд жаахан тайвшрах шиг болсноо,

-Ойролцоогоор хэзээ би мөнгөө авах бол? гэв.

-Удахгүй байх. Тэр цагт чамд зовох юм үгүй болно гэж Тони хэлээд дотроо "НАдад ч мөн адил, зовох зүйл үүрд үгүй болно" гэж боджээ.

Боомтод хоёр ч хөлөг онгоц зангуу хаяж зогссон тул музей жуулчдаар дүүрэн байлаа. Коронцист энэ улсуудыг харан хэн нь хаанахын хүн болохыг тааж суух зугаатай санагддаг байв. Тэдний дотор америк, англичууд олон үзэгдэх бөгөөд бас бус хүмүүс ч харагдана. Харин өнөөдрийн хувьд түүнд элдэв хүн харж бодох сөхөө байсангүй.

Тэрээр худалдахад зориулсан дуураймал эдлэлүүдийн дэлгэв лангуу руу харж суув. Түүний дэргэд хүмүүс бужигналдах бөгөөд хоёр худалдагч арай гэж амжин үйлчилж байлаа. "Хэрэв тэд цөмийг нь худалдан авч орхивол Риццолигийн даалгасныг гүйцэтгэж чадахаа болино" хэмээн Коронцис горьдон бодож байв. Гэвч музейн хонгилд хэдэн арван дуураймал байгаа учир түүний горьдлого талаар өнгөрөх нь ойлгомжтой.

Риццолигийн хулгайлахаар төлөвлөсөн цом музейн гол үзмэрүүдийн нэг юм. Хар дэвсгэр дээр үлгэрийн баатруудыг улаанаар дүрсэлсэн уг амофр МЭӨ 15 зууны эд билээ. Хамгийн сүүлд 15 жилийн өмнө Коронцис түүнийг шилэн хорго дотор мөнхөд байрлуулахаар суурилуулсан юм. Гэтэл одоо түүнийг хулгайлах гэж байна. "Бурхан минь, намайг ивээгээч" гэж дотроо залбиран мөргөв.

Бүхэл өдрийн турш Коронцис ваарыг хулгайлах мөчийг түгшин хүлээж яг л манан дунд төөрсөн хүн шиг дүйнгэтжээ. "Би ингэж чадахгүй нь. Өөр ямар нэг арга байдаггүй л юм байх даа? Гэвч ямар?". Түүнд бэлэн мөнгө олох өчүүхэн ч боломж байхгүй. "Мөнгийг минь төлөхгүй бол бол би чамайг загасны хоол болгож орхино шүү" гэсэн Призигийн заналт үг чихэнд нь байнга хангинаж одоо хүртэл сонсогдсоор байв. Энэ хүн лав ёстой жинхэнэ

алуурчин гэдэг нь мөн байх. Тэгхээр өөр арга алга даа.

Зургаад эхдэн минут дутуу байхад Коронцис өрөөнөөсөө гарлаа. Дуураймал эдлэл худалддаг дэлгүүр хаах гэж байв.

-Худалдагч аа! Өнөөдөр миний нэг сайн найзын төрсөн өдөр юм. Тэгээд би ямар нэгэн бэлэг дүрсгалын зүйл авч бэлэглэхээр шийдчихлээ гээд тэр лангуу руу ойртон очиж сонирхох дүр үзүүлэв.

Тэнд элдэв дээдийн ваар сав, цом, ном, гурвалжин дүрснүүд дүүрэн байсанд юу сонгож авахаа мэдэхгүй байгаа дүр үзүүлэн удаан шинжиж зогсов. Эцэст нь улаан амфорын дуураймалыг заан,

-Энэ л таарах юм шиг байна гэв.

-Эргэлзэх юм байхгүй шүү гэж хүүхэн хэлээд түүнийг үзмэрийн цонхноос гарган Коронцист өглөө.

-Тооцооны хуудас өгнө үү.

-Тэгье, ноён Коронцис. Сайхан боогоод өгөх үү?

-Хэрэггүй биз дээ. Зүгээр л ууганд хийнэ үү.

Тэгээд амфорыг хэрхэн ууталж тооцооны тасалбар дотор нь хийхийг ажиглан зогсов.

-Баярлалаа.

-Таны найзад таалагдана гэж байдаж байна.

-Би ч бас тэгэх болов уу гэж горьдож байна гээд өрөө рүүгээ эргэв.

Өрөөндөө орж хаалгаа түгжээд тэрээр худалдаж авсан зүйлээ уутнаас нь гарган ширээн дээр тавингаа "Одоохондоо би гэмт үйлдэл хийгээгүй байна. Болиход хожимдоогүй байна" гэж бодон шийдэж ядан тарчилна. Толгойд нь янз бүрийн аймшигт бодол хөвөрсөөр. Эхнэр хүүхдээ хаяад нэг тийшээ зугатах уу? Эсвэл амиа хорлох уу? Цагдаагийн газарт мэдэгдэх үү? Тэгсэн ч намайг яаж ийж байгаад л алах болно. Гарах зам алга. Мөнгө өгөхгүй л бол Приззи алахаас буцахгүй. "Надад Тони шиг найз байгаад бурханд талархах хэрэгтэй. Тэр байгаагүй бол би аль хэдийнэ хүүр болсон байгаа" гэж бодон цагаа харлаа.

Босоход өвдөг нь чичирч байв. Гүнзгий амьсгаа авч жаал сэхээрэхийг оролдов. Алга нь хөлс даахыг мэдэрч цамцандаа арчлаа. Дараа нь ууттай дуураймалыг аваад үүд рүү зүглэв. Хаалганы дэргэд нэг хамгаалагч хүмүүсийг гаргаж дуусаад явахад бэлэн нөгөө хамгаалагчаа хүлээн зогсоно. Нөгөөх нь танхимыг шалгадаг бөгөөд яг энэ үед хамгийн сүүлчийн хэсэгт явж байв. Коронцис тэр хоёрын дунд зургаа долоон өрөө зааглаж байна.

Коронцис өрөөнөөсөө гараад хамгаалагчтай халз мөргөлдөж орхилоо. Тэр огт санамсаргүй

байсан болохоор бондгосхийтэл цочив.

-Өршөөгөөрэй, ноён Коронцис. Таныг яваагүй байгаа гэж мэдсэнгүй.

-Тиймээ, би яг явах гэж байлаа...

-Би танд ямар их атаархаж явдгийг та мэдэх болов уу?

"Чи намайг мэдсэн ч болоосой!"

-Яагаад? ямар учраас тэр билээ?

-Та энэ олон гайхамшигт зүйлсийн талаар өчнөөн их мэдлэгтэй хүн. Энэ бүгд чинь хүн төрөлхтөний түүхийн нэг хэсэг мөн биздээ? гэтэл би эдний талаар юу ч мэдэхгүй явна. Та надад нэг завтай өдрөө тайлбарлаж өгөөрэй гэж гуйя. Би...

Энэ муу тэнэг дуугуй байж өгөхгүй нойто хамуу шиг наалдаад салахгүй нь ээ.

-За за, тэгнээ.

Өөдөөс харсан танхимд шилэн хоргон доторх ваар түүнд сайн харагдаж байв.

Хамгаалагчийг эндээс холдуулах арга хэрэгтэй.

-Тэнд, хонгилд хамгаалалтын системд гажиг суусан шиг билээ. Та түүнийг нэг шалгана байгаа?

-Тэгэлгүй яахав. Энд хадгалагдаж байгаа бүх зүйл...

Яг одоо шалгаадахгүй юу? Би шалгаж итгэсэн хойноо явмаар байна.

-Тэгье, ноён Коронцис. Би хонгил руу явлаа.

Коронцис түүнийг нүднээс далд ормогц ваар тавиастай байгаа хорго руу яаран очив. Түлхүүр гаргаж ирэх зуураа "Би шийдлээ. Одоо хулгайлна" гэж бодтол түлхүүрээ алдаж тэр нь шалан дээр жингэсэнэс дуу гарган унала. "Энэ чинь намайг хориглосон дохио юм биш байгаа?!" Хөлс нүүр рүү нь цутгана. Тэрээр тонгойн шалан дээрээс түлхүүрээ аваад хоргыг онгойлгож ваарыг авахад үнэхээр гайхамшигт хосгүй бүтээл болох нь илт харагдана. Мянга мянган жилийн өмнөөс л түүнийг үе уламжлан хадгалж хямгадсаар иржээ. Энэ бол түүхийн нэг тасархай гэж хэлдэг хамгаалагчийн зөв өө. Ингэж болохгүй. Коронцис нүдээ анин татавс хийв. Эргэн тойрноо ажиглавал хэн ч алга байсанд болгоомжтойгоор ваарыг сольж тавив. Тэгээд хором хэртэй хуурамч эдлэл тийш хараа тавив. "Сайхан хийгджээ" гэж бодсон хэрнээ түүний туршлагатай нүдэнд "Дуураймал шүү дээ" гэж харагдана. "Хараажаар дуураймал, гэхдээ надад болон хэдэн нарийн мэргэжилтэн л үүнийг хуурамч гэж мэднэ" хэмээн бодов. Ялгааг нь өөр хэн ч олж харахгүй, Тэгээд сольж орхино гэж хэний санаанд орохов дээ?

Коронцис хийх бүхнээ хийсэн тул алчуур гарган нүүрнийхээ хөлсийг арчлаа. Цагаа харвал

долоод 10 минут дутуу байв. Яарах хэрэгтэй.

Түүнийг хаалга руу эргэтэл хамгаалагч өмнөөс нь гарч ирээд,

-Би хамгаалалтын системийг шлгасан боловч ямар ч гажиг олсонгүй, нёон Коронцис гэлээ.

-Сайн байна. Гэхдээ л байнга шалгаж байх илүүдэхгүй шүү.

Хамгаалагч инээмсэглэн,

-Таны зөв үү. Та явах нь уу?

-Тэглээ баяртай.

-Баяртай.

Хоёр дахь хамгаалагч хаалганы дэргэд байрандаа зогсоод Коронцисын гар дахь ууттайг харж инээмсэглэн,

-Шалгах хэрэгтэй. Тийм журамтай юм гэв.

-Бололгүй дээ гэж Коронцис яаран хариулаад ууттайгаа сарвайлаа.

Хамгаалагч доторхийг шагайж хараад тасалбар тулгаж уншихад,

-Бэлэг авсан юм. Найз маань инженер хүн л дээ гэж тайлбарлав.

"Би юунд энэ тухай яриад байнаа? Түүнд ямар хамаа байнаа. Байдгаараа л байх хэрэгтэй".

-Сайхан л юм гээд хамгаалагч түүнд ууттайг эргүүлэн өглөө. Коронцис гэнэт хагалчих вий хэмээн айж цээжиндээ уугаа чанга шахаж тэврэв.

-Баяртай.

-Баяртай гээд саяар үнэлэгдэх хосгүй эдлэл барьсан Виктор Коронцис гадаа гараад цэвэр агаар цээж дүүрэн амьсгалж авав. Гэхдээ л тэр эх орноосоо урваж, түүхийн нэгэн хэлтэрхий болох зүйлийг харийн хүнд өгч байгаадаа жигших сэтгэл төрсөөр байв. Хаалганы дэргэд Риццолигийн хэлснээр хөлсний тэрэг зогсож байсанд Коронцис хаалгыг нь онгойлгон ороод суучихав.

-"Британика" зочид буудал руу гэж жолоочид хэлээд хүч нь барагдан суудал дээр сульдан унав. Хүнд тулаанаас дөнгөж гарч ирсэн мэт санагдана.

Сонин юм.

Тэр ялсан болов уу? Ялагдсан болов уу?

Машин буудлын өмнө ирж зогсоход Коронцис: "Жаахан хүлээнэ үү" гэж хэлээд ууттай руу

сүүлчийн удаа харснаа бууж явлаа. Хаалга татан орохын өмнө эргэн харвал хөлсний тэргэнд нэг эрэгтэй орж суусан үзэгдэнэ. Хормын дараа машин явж одов.

Ингээд дууслаа. "Дахиад ийм явдал давтагдахгүй. Хэзээ ч ! Энэ аймшиг үүгээр дуусаг !" гэж тэр бодов.

* * *

Ням гаригийн өдрийн гурван цагт Риццоли зочид буудлаасаа гарч Омони талбайг зүглэн алхлаа. Тэр хурц улан өнгийн дөрвөлжин хээтэй пиджак, ноосон өмд өмсөж улаан хүрэн өнгийн малгай тавьжээ. Түүний араас хоёр мөрдөгч даган хөдөллөө. Тэдний нэг нь Тониг хараад "Ийм хувцастайгаар тэр циркэд байвал яг тохирно" гэж боджээ. Метакс гудамжнаас Тони хөлсний тэрэг авч суув. Мөрдөгч холбооны хэрэгслээ залган,

-Объект такси авч баруун зүг хөдөллөө гэж мэдэгдсэнд хариуд нь,

-Харж байна. Бид одоо дагана. Та нар буудал руугаа буц гэлээ.

-Мэдлээ.

Хуучивгар сараал өнгийн "Седан" холгүйхэн зай барин таксиг дагаж Монастиракийн дэргэдүүр гаран өмнө зүг эргэлээ. "Седан" дотор мжолоочийн дэргэд суусан мөрдөгч гартаа мөн холбооны хэрэгсэл барьжээ.

-Төв үү? Дөрөв илтгэж байна. Объект таксигаар Фил хеллион гудамжаар явж байна. Хүлээгээрэй. Бид Пета гудам руу эргэлээ. Плакыг зорин яваа бололтой. Тэнд хүрээд алдаж магадгүй тул мөрдөх хүн явуулна уу.

-Дөрөв өө. чамд туслах хүч явууллаа. Хэрэв тэр Плакад хүрээд буувал араас нь дага.

-За. Объект улаан дөрвөлжин хээтэй пиджак, ногоон хүрэм, улаан хүрэн өнгийн малгайтай. Ажиглахад төвөг багатай. Байз ... хөлсний тэрэг зогсчихлоо. Тэр буусан шүү.

-Таны мэдээг бүгдэд мэдэгдэе. Бүгд түүнийг дагаад. Та одоо чөлөөтэй боллоо. Холбоо салгая.

Плакад хүрээд машинаас бууж байгаа хүнийг хоёр мөрдөгч ажиглана.

-Тэр хаанаас ийм хувцас олж авдаг байнаа? гэж нэг нь гайхав.

Тэд түүнд ойрхон хуучны заваан гудамжин дахь бөөн хүмүүс дундуур хөдөллөө. Бохир балиар гудамжаар цаг орчим ямар ч зорилгогүй байж дэлгүүр, мухлаг, жижиг галерей орчмоор тэнэлээ. Тэр Анафиотик гудамжаар уруудах зах руу орж сав суулга, гэрлий суур, керосин дэн, дуран харан явна.

-Ямар чөтгөрөө хийж тэр энүүгээр яваад байнаа?

-тэр зүгээр л зугаалах санаатай байх шиг байна. Зогс. Өнөөх чинь тэр байна.

Тэрвээр Геронда гудамж руу эргэн "Коннос" зоогийн газар руу чиглэв. Мөрдөгчид холхон зогсоод түүнийг хоол захиалахыг ажиглав.

Тэд бүр залхаж гүйцжээ.

-тэр хурдхан шиг ямар нэг юм хийгээсэй. Гэртээ харих юмсан. Унтмаар болоод байх чинь.

-Тэвчиж үз! Түүнийг алдвал Николино толгой тасдана шүү.

-Яалаа гэж алдахав дээ? Тэр чинь шөнийн сар шиг л сондгой харагдаж байна шүү дээ.

Хоёр мөрдөгч түүн рүү нүдээ томруулан харж,

-Чи юу гэв ээ? гэв.

-Би хэлэхдээ ...

-Явцгаая гэх түүний дуунд түгшүүр илэрнэ.

-Чи царайг нь харсан уу?

-Үгүй.

-Би ч бас үгүй. Явцгаая!

Тэд зоогийн газарт яаран орж ширээ рүү дөхөж очив.

Өмнө нь огт танихгүй хүн сууж харагдах нь тэр.

Байцаагч Николиногийн уур хилэн гэж хязгааргүй.

-Риццолигийн араас бүтэн гурван бригад тавьсан байтал та нар яаж тэнэглэхээрээ түүнийг алдаж орхидог байнаа?

-Байцаагч аа, тэр биднийг хуурч дөнгөжээ. Эхний хэсгийхэн түүнийг таксид суухыг харсан...

-Таксиг хараанаасаа алдсан гэж хэлэх гээ юу?

-Түүний буухыг бид харсан. Яг л түүнийг мөн гэж бодсон. Тэр чинь маш этгээд содон хувцасласан байсан юм. Такси дотор өөр нэг зорчигч байж, түүнтэй хувцасаа сольж өмссөн байх. Бид буруу хүний араас яваад байж.

-Риццоли, тэгээд такситай яваад өгсөн болох нь уу?

-Тиймээ, эрхмээ.

-Машины дугаарыг бичиж авсна уу?

-Эрхмээ, тэгэх бидэнд илүү ажил шиг санагдсан юм, та ойлгоно уу.

-Тэгээд та нарын барьсан тэр хүн юу мэдүүлэв дээ?

-Тэр боп Риццолигийн суудаг зочид буудлын үйлчлэгч юм. Риццоли түүнд хэн нэгэнтэй тоглохоор шийдсэн гээд зуун доллар өгсөн гэдгээс өөр юу ч хэлж чадахгүй байгаа. Тэр хүү...

Байцаагч Николино гүнзгий амьсгаа аван,

-Миний ойлгож байгаагаар одоо Риццолиг хаа байгааг хэн ч мэдэхгүй болж таарах нь ээ?

-Тийм л болов уу гэж айж байна, эрхмээ.

Грек улсын Салоники, Патры, Волос, Игуменица, Кавала, Ираклион, Пиреус гээд долоон том боомттой ажээ.

Пиреус боомт Афинаас баруун урагш долоон милийн зайтай орших ба грек төдийгүй Европтоо гол чухалд тооцогдох боомт байв. Пиреус дөрвөн зогсоолтой бөгөөд үүнээс гурав нь аялал жуулчлалд зориулагдсан жижиг далбааг онгоцнуудынх харин дөрөв дэх нь буюу Гераклес нь шууд хилээр гаргадаг ачаа тээвэрлэдэг ачааны том том хөлөгт зориулагддаг байна.

"Теле" хөлөг Гераклес зогсоолд зогсож байв. Энэ нь тэнгисийн бүлээн усанд шургаж нуугдсан аварга том биет усны үхэр шиг асар хүчтэй ачааны хөлөг онгоц байлаа. Том Риццоли дөрвөн хүн дагуулан зогсоол дээр ирэв.

Том хөлөг онгоцыг Риццоли хараад:

"За тэгэхээр онгоц энд байна. Одоо миний хүндэт найз Демирис энд ирсэн эсэхийг шалгаад орхиё" гэж бодов.

Тэгээд дагалдагсдаа хандан,

-Хоёр нь эндээ үлдээд онгоцноос хүн гарч явах эсэхийг нууцаар ажигла. Үлдсэн хоёр нь надтай цуг яв.

-Гүйцэтгэе.

Риццоли хоёр эрийг дагуулан олсон шат руу очлоо. Тэднийг авирч эхлэхэд тэдэнд нэг далайчин дөхөж ирээд,

-Та нарт юу хэрэгтэй вэ? гэж асуулаа.

-Бид Демирис тэй уулзмаар байна.

-Ноён Демирис өрөөндөө байгаа. Тэр таныг хүлээж байгаа юм уу?

"Мэдээ үнэн байх нь" гэж бодсон Риццоли инээд алдан,

-Тэгэлгүй яахав. Хүлээж байгаа. Та нар хэдэн цагт хөдлөх вэ? гэлээ.

-Шөнө дундад. Би таныг дөхүүлээд өгье.

-Баярлалаа.

Тэд далайчныг даган тавцан дээгүүр явж доошоо орсон шат руу хүрч очлоо. Шатаар доош буугаад тав зургаан өрөө өнгөрч эцсийн хаалганд тулж очоод далайчин тогших гэсэнд Риццоли түүнийг түлхэж орхин,

-Бид өөрсдөө болгоё гээд хаалгыг түлхэн орлоо.

Өрөө Риццолигийн санаснаас хамаагүй том ажээ. Тэнд ор, диван, зөөлөвчит сандал хоёр ширхэг, бичгийн ширээ ч байна. Ширээний ард Демирис сууж байснаа Риццолиг орж ирэхэд нь арай гэж өндийлөө.

Царай нь хувхай цайжээ.

-Та ... та чинь энд юу хийж яваа юм бэ? гэж сонсдох төдий асуулаа.

-Би найз нарынхаа хамтаар чамд аян замдаа сайн явахыг ерөөхөөр ирлээ, Коста.

-Та ханаас мэдээ вэ... Би...таныг хүлээж байсангүй гэх гэсэн юм...

-Юу үнэн тэр үнэн гээд усан цэрэг тийш харан "Баярлалаа найз аа" гэлээ. Усан цэрэг гараад явчихав.

-Та чинь нөхөдтэйгөө салах ёс ч хийхгүй замд гарах нь уу?

-Үгүй, яалаа гэж, үгүй байлгүй яахав гэж Демирис яаран хэлээд,

-Би энд бага сага юм шалгахаар өглөө ирсэн юм. Онгоц маргааш өглөө хөдөлнө.

Риццоли ойртон очиж,

-Коста, хүү минь. Чи дэмий хийлээ дээ. Ямар бодол санаа агуулж зугатах гэж байгаа юм бэ? Зугатах газар чамд байхгүй шүү дээ. Бид чинь тохиролцсон биз дээ? Эсвэл чи мартчихаа юу? Үгэндээ хүрээгүй хүмүүс яадгийг эрхбиш мэднэ биз дээ? Тэд удаан зовж байгаад үхдэг юм гэлээ.

Демирис хоолойгоо засаад,

-Би... би тантай хоюулахнаа яримаар байна гэсэнд Риццоли дагуулууддаа хандан,

-Гадна хүлээж бай гэв. Тэднийг гармагц Риццоли,

-Чи намайг гомдоож байна шүү, Коста гэхэд,

-Би ийм юм хийж чадахгүй нь ээ. Би танд мөнгө төлье. Таны мөрөөддөгөөс ч илүүг өгье гэж Демирис хэлэв.

-Яалаа гэж тэр вэ?

-Энэ хөлгийг орхин явж намайг тайван байлгаач гэх дуунд цөхөрсөн өнгө тодорно.

-Та надтай ингэж харьцаж таарахгүй. Засгийн газар миний бүх флотыг хурааж авна. Би баларна шүү дээ, гуйя. Таны хүссэн болгоныг би өгье.

Тони Риццоли инээмсэглэн,

-Надад хэрэгэй бүхэн маань бий. Чамд хэдэн ачааны онгоц бий вэ? Хорь уу? гуч уу? Би тэр бүгдийг ажилдаа ашиглана. Өөр бас хоёр боомтонд хүрэх шаардлагатай байгаа юм,.

-Та юу... юу ярьж байгаагаа ч төсөөлөх ч үгүй байна.

-Нөгөө аймшигт нүглээ үйлдэхээсээ өмнө л энэ тухай бодох хэрэгтэй байсан юм. Чи ахмадтайгаа ярилцах хэрэгтэй. Түүнд чи бид Флоридын эрэг хавьцаа нэг илүү буудал хийх хэрэгтэй болно гэж хэл! гээд Тони өндийлөө.

Демирис эргэлзсэнгүй,

-За тэгье. Би таныг өглөө наашаа ирэхэд... гэвэл Риццоли хөхөрч,

-Энэ тоглоомоо орхиж үз. Чи шөнө дундад хөдлөнө шүү дээ. Тийм бол би ч бас чамтай цуг явдаг хэрэг ээ. Бид хэлэлцсэн ёсоор геройн бас Улсын төв Музейн нэгэн эрднэсийг хамт авч явна. Чи тэднийг надад зориулж нууцаар хил давуулан Америкийн эрэгт хүргэж өгөх болно. Намайг маллах гэж оролдсоны чинь шан болог.

Демирис балмагдаж,

-Магадгүй ямар ч гэсэн... би чадахыг больё гэсэнд Риццоли мөрийг нь алгадан,

-Ухаан ор л доо. Миний хамсаатан байх чамд таалагдана гэж амлая гэв.

Риццоли ингэж хэлээд хаалга руу ойртон онгойлгож,

-Боллоо ачиж болно гэж хэлэв.

-Бид ачааг чинь хаана байрлуулдаг билээ?

Хөлөг дээр кокайн нуучих газар зөндөөн байсан боловч Тони илүү зүйлд ухаан зарахаас төвөгшөөн Константин Демирисын флот эргэлзээ төрүүлэхгүйг ойлгож байлаа.

-Түүнийг шуудайтай төмсний дор хийж тэмдэг тавиад онгоцны хөндий руу шургуулчих гэж зааварлан,

-Ваарыг харин ноён Демирист аваад ир, түүний хамгаалалтанд өгье гээд Демирис руу эргэн жигшсэн харцаар харж,

-Татгалзахгүй биз дээ? гэлээ.

Демирис нэг юм хэлэх гэсэн боловч амжсангүй Тони Риццоли,

-Алив залуус аа, шалавцгаая гэж хашгирав.

Дараа нь тэр зөөлөвчит сандлын нэгэнд тухлан сууж,

-Муугүй өрөө юм. Чамайг эндээ үлдээхийг зөвшөөрье, Коста. Би нөхөдтэйгөө өөр өрөө олно гэсэнд,

-Танд гялайлаа гэж Демирис эвлэрэнгүй дуугарав.

Шөнө дундад чиргүүлийн хоёр том хөлөг задгай тэнгист гарлаа. Геройныг онгоцны хөндийд харин цаарыг Демирисын өрөөнд оруулж тавьсан байлаа.

Тони туслахуудынхаа нэгийг хажуу тийш аваачин,

-Радио хэрэгслийн өрөөнд очиж бүх утас холбоо сэлтийг тасал. Демирисыг эрэгтэй холбоо бариасай гэж би хүсэхгүй гэлээ.

-Чамайг ойлголоо, Тони.

Хэдийгээр Демирис түүний мэдэлд бүрэн орсон боловч Тони азаа туршихыг бодсонгүй.

Далайд гаран гартлаа Тони хүссэн болгон нь ийнхүү сэтгэлчилэн бүтсэнд итгэж чадахгүй санаа зовсоор байв. Урьдчилан хараагүй нэг тотгор гараад ирэх вий. Дэлхийн хамгийн баян нөлөө бүхий хүмүүсийн нэг Константин Демирис түүний хамтран зүтгэгч. "Хамтран зүтгэгч... Үнэндээ тэр бүх талаараа миний атганд байна! Түүний хараал идсэн бүх флот ч тэр шүү. Тиймээ, би хүссэнийхээ хэрээр геройн тээвэрлэнэ. Надаас бусад нь нунтаг тээж авах гэж үйлээ үзэж яс махаа баран зүтгэж байхад миний бүх зүйл амжилттай болох шив. Дээр нь музейн энэ ховор эд байна. Аз гэдэг нь л энэ байх даа. Залуус үүнийг мэдэх хэрэг үгүй" гэж бодно.

Тони унтаад алтан хөлөг онгоцнуудын бүхэл бүтэн флот, орд харш, олон сайхан охид шивэгчингүүдтай боллоо хэмээн зүүдлэв.

Өглөө сэрээд нөхдийн хамтаар өглөөний унд уухаар хоолны өрөөнд явж орвол хөлгийн багийн хэдэн хүн тэнд цугласан байлаа. Үйлчлэгч ширээнд дөхөн ирж,

-Өглөөний мэнд гэж мэндлэв.

-Ноён Демирис хаа байна? Тэр өглөөний цау уухгүй юм уу? гэж Риццоли түүнээс асуулаа.

-Тэр өрөөндөө байгаа, ноён Риццоли. Та болон таны нөхдийн хүссэн болгоныг ёсоор болгож өгөхийг бидэнд тушаасан.

-Тун сайхан хэдэг гээд Тони:

-Надад жүржийн ундаа, шарсан өндөгтэй гахайн мах авчирч өгнө үү. Харин та нар яах вэ, залуус аа гэлээ.

-Муугүй сонсогдож байна шүү.

Риццоли нөхөддөө,

-Та нар нэг их яриа хөөрөө үүсгээд байх хэрэггүй. Аль болох сэжиг авахуулахгүй хөдөлж бай. Эелдэг найрсаг харьцаатай байх нь зүй шүү, Бид ноён Демирисын зочид гэдгээ бүү март гэж захиална.

Өдрийн ч оройн ч хоолонд Демирис үзэгдсэнгүй. Риццоли түүнтэй жаал дэмий ярихаар өрөөнд нь явж орвол тэрээр цонх руу ширтэн сууж байлаа.

Царай нь ядарч цонхийсон байх нь ядарч хөгширсөн юм шиг санагдуулна.

-Чи юм идэж хүч чадлаа сэлбэх хэрэгтэй шүү, найз минь. Чи өвчилж мэднэ шүү. Бидэнд хийх юм их бий. Би оройн хоол нааш нь авчир гээд хэлчихсэн,

-Хэрэггүй дээ, би зүгээр байна. Явахыг хүсье гэлээ.

-За, за явлаа. Хоолоо идээд унтаарай. Чи аймаар харагдаж байна шүү.

Өглөө нь Тони хөлгийн ахмад руу очлоо.

-Би Тони Риццоли, ноён Демирисын зочин байна.

-Би мэднээ. Ноён Демирис таныг надтай уулзана гэдгийг сануулсан. Явах замд жаахан өөрчлөлт гарсан тухай ярих шиг болно билээ.

-Тиймээ. Би цаг нь болохоот чамд хэлнэ. Бид хэзээ Флоридын эрэгт хүрэх вэ?

-Ойролцоогоор гурван долоо хоногийн дараа, ноён Риццоли.

-Сайн байна. Би дахиж ирнээ.

Риццоли хөлөг дээгүүр жаахан тэнүүчлэхээр шийдлээ.

Тиймээ, энэ бол түүний хөлөг, флот ч тэр чигээрээ түүнийх! Хэзээ ийм аз жаргалтай байснаа тэр санахгүй байлаа!

Тэд далайгаар тайван аялж явав. Риццоли Демирисын өрөөнд байн байн орно.

-Чи хөлөг онгоц дээрээ хүүхэн авч явдаг баймаар юм. Мартсанаас грекүүд хүүхэн хэрэглэдэггүй гэж сонссон юм байна, энэ үнэн үү? гэж тэр нэгэн удаа асуужээ.

Гэвч Демирис түүний энэ доромжлолыг сонсоогүй дүр үзүүлэх нь дээр юм гэж шийдэв.

Өдөр сунжран өнгөрч Тони Риццолигийн хүсэл мөрөөдөл биелэх мөч бага багаар ойртсоор л байв. Тэрэр тэсэж ядсандаа байж ядан догдолно. Долоо хоног, дараа нь бас нэг долоо хоног өнгөрч тэд Америкийн эрэгт дөхөж явна.

Бямба гаригийн орой риццоли хөлөг онгоцны тавцан дээр зогсон далайг ажиглан байтал хурц цахилгаан цахиж хөлөг тэр чигээрээ гэрэлтлээ. Ахмадын туслах түүнд дөхөж ирээд,

-Цаг агаар муудах нь шиг байна. Таныг далайн өвчинд ажирдаггүй гэж найдаж байна, ноён Риццоли гэлээ.

Риццоли мөрөө хавчин,

-Би юунаас ч айдаггүй гэв.

Далайн шуурга эхэллээ. Хөчит хөлөг хамараараа давалгаа зүсэн урагшлахад шуурга түүний хажуу бөөрөөс дэлдэнэ.

Риццолигийн дотор нь муухайраад ирсэнд "Би чинь далайн өвчнөөс айх нь уу даа? За, ер ямар ялгаа байна?" гэж бодон инээлээ. Үнэндээ ертөнц яаж ч дүрээ хувиргасан түүнд падгүй байжээ. Тэгээд ч өрөөндөө эргэн ирж эртхэн шиг хэвгэж амрахыг бодов.

Дахиад л зүүдэнд автагдсан боловч энэ удаа алтан онгоц, аазгай хөдөлгөм нүцгэн шивэгчингүүдийн аль нь ч алга. Тун муухай зүүд байлаа. Дайн дажин болж зэр зэвсэг хангинан байна гэнэ. Тэр дэлбэрэлтэнд өртлөө.

Зүүд биш харин өрөө тэр аяараа дайвалзан ганхаж байх нь тэр. Хөлөг онгоц хар шуурганы төвд орж тал болгон дуу шидэгдэн заадас заадсаараа салж унах нь уу гэмээр санагдана. Хонгилоор гүйлдэх хүмүүсийн хөлийн чимээг сонсоод ингээд өнгөрөх үү? гэж л бодов.

Түүнийг хурдан босож хувцаслаад гарч орхиход шал гэнэт баруун тийш гулган тэнцвэр алдахгүйн тулд арай гэж тогтлоо. Тэгээд гүйн ирж яваа нэг усан цэрэгт хандан,

-Юу болоо вэ? гэвэл,

-Дэлбэрэлт болоод бид живж байна, Тавцан дээр гарсан нь дээр гэж хариуллаа.

"Живж байна гэнэ үү?". Тони чихэндээ ч итгэсэнгүй. Бүх юм ингээд балрах гэж үү? "Нулимж орхи. Би энэ удаагийн барааг алдлаа ч дахиад олон удаа зөөх юм чинь. Энэ бараа ёстой хамаа алга. Харин Демирисыг л аврах хэрэгтэй. Түүнгүйгээр албан явахгүй. Аврах алба SOS-ны дохиог дуудах хэрэгтэй" гэж бодсоноо саналаа.

Риццоли арайхийн тэнцвэрээ хадгалан шат руу зүглэн явав. Түүнийг тавцан дээр гарч ирэхэд шуурга зогссон, далай тавширч сар бүрнээ гийжээ. Гэнэт ардхан талд нь дахин дэлбэрэлт болж онгоц бүр их хазайлаа. Тал болгоноос нь ус халин орж ирсэнд усан цэргүүд аврах хоолой усанд буулгах гэж оролдсон боловч хожимджээ. Хөлөг онгоц нь тэр аяараа хуйхлам халуун галд өртлөө- Константин Демирис хаачив аа?

Энэ мөчид хаа нэгтээ дээр моторын дуу хүнгэнэх чимээ сонсогдсонд Риццоли толгой өргөн харвал онгоцноос арваад фут орчмын өндөрт нисдэг тэрэг дүүжигнэн харагдлаа. "Бид аврагдлаа" хэмээн Риццоли баярлан дуу алдаад байдаг чадлаараа гараа даллан дуудлаа. Нисдэг тэрэгний цонхоор хүний царай харагдахад энэ нь Демирис болохыг Риццоли эхлээд ойлгосонгүй. Тэрээр инээмсэглэх бөгөөд дээр өргөсөн гарт нь хосгүй үнэт амфор нь үзэгдэнэ. Тони Риццоли түүнээс нүдээ салгаж чадахгүй юу болоод байгааг эрэгцүүлэхийг оролдож эхэллээ. Энэ түнэр харанхуй шөнөөр тэр хаанаас нисдэг тэрэг олдог байнаа?

Гэнэт бүх зүйл түүнд ойлгомжтой болж зүрх нь зогсчих шиг боллоо. Константин Демирис түүнтэй хамсан ажиллахыг хэзээ ч бүр ганц ч минут бодоогүй байх нь. энэ өлөгчиний хүү бүгдийг эхнээс нь бодож төлөвлөсөн байж. Тэр өглөөний дуудлага, Демирис оргохоор завдаж байна гэдэг мэдээг өгсөн хүн нь Ламброу биш Демирис өөрөө байж шүү! Тэр түүнд урхи тавьж хөлөг дээрээ гаргасан харин Риццоли адгийн тэнэг адил урхинд өөрөө яваад орчихсон.

Хөлөг онгоц усанд хурдан авгаж далайн хүйтэн ус хөлийг нь норгон улмаар өвдгөөр нь татахыг тэр мэдэрлээ. Энэ новш түүнийг хаана ч хэзээ ч хэн ч юу болсныг мэдэхээргүй газар орхих шив!

Тэрээр: "Зогс! Буцаач. Би чиний хүссэн болгоныг үгье" гэж цөхөрсөн дуугаар орилсон боловч салхи түүний энэ аврал эрсэн үгийг хийсгэн оджээ.

Хөлөг онгоц тэр чигээрээ хөмөрч усанд далд орохын өмнө Риццолигийн олж харсан сүүлчийн үзэгдэл бол гэрэлт дугираг сарны дэвсгэр дээр тодхон үзэгдэх нисдэг тэрэг байжээ...

Арван долоодугаар хэсэг

Сент-Мориц

Кэт шокын байдалд ороод байлаа. Тэр өрөөнийхөө буйдан дээр суугаад цанын баазын аврах багийн дарга Ганс Бергманы яриаг сонсоно. Киркын үхлийн тухай тэр ярьж байлаа. Бергманы үг түүнийг ташуурдаад авах шиг болох хэдий ч тэр үнэндээ нэг ч үг ойлгохгүй байв. Сэтгэл нь хөдөлж галзуурахад ганц л хуруу дутуу байх шиг. "Миний ойр дотно хүмүүс цөм үхсэн" гэж тэр айдаст автан бодно. "Ларри үхсэн, одоо Кирк. Бас миний амьдралд тохиолдсон тэр Ноэлль Пейж, мөн Наполеон Чотас, Фредерик Ставрос ..." "ямар гээчийн аймшиг вэ!"

Гашуудал зовлонгийн битүү хар шуурган дундаас Ганс Бергманы,

-Хатагтай Рейнольдс ... гэж дуудахыг арайхийн сонсож толгойгоо өргөлөө.

-Би хатагтай Рейнольдс биш гэж ядрангуй дуугараад,

-Намайг Кэтрин Александр гэдэг. Кирк бид хоёр найзууд байсан юм гэлээ.

-Ойлголоо.

Кэтрин хүндээр санаа алдан,

-Яаж ... яаж байгаад тэр вэ? Кирк цанаар гулгахдаа сиан шүү дээ гэхэд,

-Мэднээ. Тэр энд нэг бус удаа ирж байсан. Үнэнийг хэлэхэд хатагтай Александр яагаад ийм юм болсоныг би ч ойлгохгүй байна. Бид түүнийг Лагалпед өнгөрсөн долоо хоногт орсон цасан дотроос олсон. Магадгүй салхи зүг чийиг нь алдагдуулсан ч байж болно. Надад туйлын их харамсалтай байна.

"Харамсалтай ... ямар утгагүй тэнэг үг вэ!"

-Хатагтай Александр, та оршуулгын ажлыг зохион байгуулах уу?

үхэл тэгэхээр хорвоогийн төгсгөл биш байх нь ээ? Үхлээр бүх юм дуусдаггүй байх нь уу? Оршуулах гэж бас нэг ажил байдаг байх нь. Авс, газрын зөвшөөрөл удахгүй энэ тухай мэдэх төрөл төрөгсөд ... Кэтринд орилж чарлах хязгааргүй хүсэл төрлөө.

-Хатагтай Александр ...

Кэтрин түүн рүү гайхан ширтлээ.

-Би Киркын ар гэрийхэнд мэдэгдье.

-Баярлалаа.

Лондон руу замын туршид тэр хагас ухаарлын байдалтай байлаа. Тэрээр шинэ сайхан амьдралын үүд хаалгыг нээхээр Кирктэй ийш ирсэн. Тэр надад ямар их тэвчээртэй эелдэг, үнэн сэтгэлээсээ хандаж байв аа? "Би түүнд буулт хийх ёстой байсан юм. Түүнд зөвшөөрөх хэрэгтэй байж. Гэвч ингэлээ гээд эцсийн үр дүнг өөрчлөх байсан юм гэж үү? Ер юуг ч өөрчлөхгүй биз. Надад нэг л муу ёрын хараал шингэсэн байсах. Надад л ойртсон болгонд би үхэл авчрах юм" гэж бодогдоод салж өгсөнгүй.

Шуудхан ажилдаа орно гэхэд хэтэрхий ядарч сульдсан цөхөрч гунихарсан байсан тул өрөөндөө хаалгаа түгжээд хэнтэй ч уулзахыг хүсэхгүй нярав Аннагийн бэлдэж авчирч өгсөн хоолыг ч идэж чадахгүй байлаа.

-Та ямар нэг юм идэх хэрэгтэй, мисс Александр.

Гэвч тэр нөгөө муу ёрын бодлоосоо салж огт чадахгүй байв.

Маргааш нь бүр дордлоо. Цээжинд нь тугалга цутгасан юм шиг хүндэрч, амьсгалахад бэрхтэй байлаа. "Цаашид ингэж байж болохгүй. Ямар нэг юм хийх хэрэгтэй. Ямар ч гэсэн..."

Эвелинтэй ярилцаж үзэх бодол толгойд нь оров.

-Болсон явдалд би л буруутай.

-Чи утгагүй зүйл ярьж байна, Кэтрин.

-Би мэдэж байна. Гэвч өөрийгөө яаж ч чадахгүй юм. Ямар ч гэсэн би л буруутай гэж санагдаад байна. Хэн нэгэнтэй уулзах хэрэгтэй юм болов уу? Сэтгэл зүйч эмчтэй уулзах уу?

-Би нэг гайхалтай сайн эмч танина гэж Эвелин түүнд хэлээд,

-Мартсанаас Уйм түүн дээр хааяа очдог юм. Түүнийг Алан Гамильтон гэдэг. Надад нэг найз охин байсан маань амьдралаас залхаж, амиа егүүтгэхийг ямагт оролдох болсон, харин тэр эмчид үзүүлэх болсноос хойш энэ тухай бодлоо мартсан шүү. Чи түүнд үзүүлмээр байна уу? гэж асуув.

"Тэр эмч нь намайг галзуу өвчтэй хүүхэн байна гэвэл яана? Би нээрээ үнэн хэрэгтээ галзуурсан бол яах вэ?"

-Тэгмээр байна гэж Кэтрин нэг л дуртай бус хэлэв.

-тэр их зав муутай хүн учраас би түүнтэй уулзах талаар ярьж тохирьё.

-Баярлалаа, Эвелин. Чи их сайхан сэтгэлтэй хүн юм.

Кэтрин Уймын өрөөнд орлоо. "Би түүнд Киркын талаар ярихгүй бол тэр гомдож орхино" гэж хүүхэн боджээ.

-Уйм, чи Крик Рейнольдсыг санаж байна уу? Хэдэн хоногийн өмнө тэр цанаар гулгаж

байгаад нас барсан.

-Тийм үү? Вестминстер, 0471 гэсэнд Кэтрин,

-Юу? гэж дуу алдав. Тэгснээ Уйм түүний утасны дугаарыг хэлснийг гэнэт ойлголоо.

Уйм хүмүүсийг ер нь юу гэж боддог хүн юм бэ? Төмөр шүүгээний дугаар гэж арай боддоггүй л байлтай. Түүнд ер нь сэрэл сэтгэхүй гэсэн юм байна уу? Дурлах, үзэн ядах, харамсах гэдгийг тэр мэддэг болов уу?

"За магадгүй надаас лав дээр байлгүй дээ. Дор хаяад л бидний мэдэрдэг тэр бүх аймшгийг мэдэрдэггүй биз"

Эвелин доктор Гамильтонтой ярилцаж ирэх баасан гаригт Кэтринийг үзүүлэхээр тохирчээ. Кэтри Демирист руу утасдан болсон бүх явдалыг түүнд ярих гэснээ дмэйи баахан зүйлэр үймүүлж түвдсэнгүй тул болихоор шийджээ.

Алан Гамильтоны эмнэлэгт Уймрол гудамжинд байрладаг эжээ. Кэтриний хувьд энэ гудамжаар анх удаа явж байгаа бөгөөд нэг л муу совин татаад болж өгөхгүй байв. Тэр хүн өөрийг нь юу гэж хэлэх бол гэхээс айж мөн огтын танихгүй хүнээс тусламж горилж яваадаа уур нь хүрч, бас алив асуудлаа өөрөө бие даан шийдэх чадваргүй болсондоо цөхөрч явав.

Лавлах цонхны цаана сууж байсан эмэгтэй түүнийг хараад,

-Доктор Гамильтон таныг хүлээж байгаа мисс Александр гэлээ.

Гэтэл би түүнтэй уулзахыг хүсэж байгаа юм болов уу? гэж эргэлзэн бодоод Кэтрин "Энд би юугаа хийж байгаа юм бол оо? Өөрийгөө бурхнаас дээгүүр тавьдаг хэн нэгэн сэхүүн амьтныг бишрэх хэрэг байна уу?" гэж бодохтой зэрэг сандралд орж эхлэв.

-Би ... би бодлоо өөрчиллөө. Надад үнэндээ эмч хэрэггүй л дээ. Би ингэж төвөг удсаныхаа хариуд мөнгө төлөхөд бэлэн байна гэж хэлэв.

-Нээрээ юу? Жаахан хүлээгээрэй.

-Гэхдээ ...

Хүүхэн түүний үгийг гүйцэд хэлүүлэлгүйгээр хаалганы цаагуур орон алга болов.

Хэдхэн хоромын дараа хаалга онгойж Алан Гамильтон эмч гарч ирсэн нь дөч орчим насны, өндөр нуруутай, гүн цэнхэр нүдтэй, цайвар шаргал үстэй бөгөөд тайван амгалан төрхтэй нэгэн байлаа. Тэрээр Кэтриныг харан инээмсэглэж,

-Та надад аз авчирлаа гэж үү гэсэнд Кэтрин гайхан,

-Ямар утгаар? гэвэл,

-Би өөрийгөө ийм гялалзаж яваа эмч гэж бодсонгүй. Гэтэл та миний үүдний ч өрөөнд орж амжилгүй сайжирч орхилоо. Спортын дээд амжилт тогтоодогтой л ижил юм уу даа.

Кэтрин биеэ өмөөрөхийг оролдон,

-Уучлаарай, би алдаа гаргаж. Надад ямар ч эмч хэрэггүй гэв.

-Сонсоход таатай байнаа. Миний бүх өвчтөнүүдэд тийм байгаасай гэж үхсмээр байн. Мисс Александр, та нэгэнт энд ирчихсэн юм чинь ядаж ганц аяга кофе уугаад явбал юу нь болохгүй байх билээ? Ганц л минут шүү.

-Үгүй, баярлалаа. Би ... үгүй.

-Зогсоогоороо ганц аяга кофе шүү дээ. Би удаан барихгүй гэж амлая.

Кэтрин эргэлзэн,

-За яахав, ганц л минут шүү гэв.

Хүүхэн түүнийг даган өрөөнд нь оров. Өрөө нь энгийн боловч маш тохилог, аятайхан, эмчилгээ хийдэг гэхээсээ илүү зочдын өрөөтэй адилхан байв. Хананд нь тайван амьдрал, аж байдлын сэдэвгэй зураг өлгөж, сэтгүүлийн ширээн дээр хүүхэд тэвэрсэн гоолиг эмэгтэйн жаазтай зураг тавьсан харагдана. "За ямар ч гэсэн сайхан өрөөтэй бас дур булаам эхнэртэй хүн юм байна" гэж бодов.

-Би таны цагийг дэмий үрмээргүй байна, эмчээ. Би...

-Энэ талаар санаа бүү зов гээд тэр сандал дээр сууж Кэтринийг анхааралтай ширтэв.

-Та амьдралдаа олон юм үзэж амсчээ гэж өрөвдсөн янзтай хэлэв.

-Та яаж мэдээ вэ? хэмээн ширүүн дуугарахад үүнийг мэдэж орхисонд нь машид дургүйцэж байгаа өнгө хоолойд нь илэрхий мэдэгдэж байв.

-Би эвелинээс асуусан юм. Тэр надад Сент-Морицод болсон явдалыг ч бас хэлсэн. Би тун их харамсаж байна.

"Бас л нөгөө харамсал..."

-Нээрээ юу? Та ийм гайхалтай эмч болохоор Киркыд дахиад амьдруулж лав чадах байх тээ?

Түүнийг гэнэт нөмрөн авсан гаслант сэтгэл хоромхон зуур аймшигтай давалгаалан оргилж, юу юугүй эхэр татан уйлах нь гэдгээ Кэтрин эмдэрлээ.

-Намайг тайван байлгаад өгөөч. Тайван орхи гэж хашгирав.

Гамильтон эмч түүнийг дуугүй ажиглан сууна. Цурхиран уйлах Кэтрин хүүхэн больж ядарсан

дуугаар,

-Намайг уучлаарай. Надад их ичгэвгэр байна. Би явах хэрэгтэй гээд босож үүд рүү алхав.

-Хатагтай Александр, би танд тусалж чадна гэдэгтээ тийм ч итгэлтэй биш байна л даа, гэвч оролдоод үзмээр байх юм. Гэхдээ миний баталж чадах цорын ганц зүйл бол энэ бүхэнд та ямар ч буруугүй гэдгийг л хэлье.

Кэтрин шийдмэг бусаар үүдний дэргэд тээнэгэлзэн зогсоно. Эргэж харахад нүдэнд нь нулимс дүүрээд ирэв.

-Би юу болоод байгаагаа ойлгохгүй байна гэж тэр шивэгнэн хэлээд,

-Би өөрийгөө ойлгохоо бүр больсон гэлээ.

Доктор босож түүн рүү дөхөж очоод,

-Та юу болоод байгааг бид хамтдаа мэдэж болохгүй гэж үү? Сууцгаая. Кофе юу болж байгааг би харчихад ирье гэлээ.

Түүнийг эзгүй байсан энэ таван минутанд Кэтрин яаж байгаад энэ хүний үгэнд автаж орхисноо бодлоо. Түүний амгалан тайван бодь байдал нөлөөлсөн үү? Түүнд итгэх ямар нэгэн үндэс байгаа бололтой. "Надад нээрээ ч тусалж магад" гэж гэнэт бодов.

Алан Гамильтон өрөөнд хоёр аяга кофе барин орж ирэв.

-Та сахар юм уу эсвэл сүү хийлгэх үү?

-Үгүй, баярлалаа.

Эмч өөдөөс нь харан суулаа.

-Миний ойлгож байгаагаар таны найз цанаар гулгаж байгаад амь насаа алдсан юм биз дээ?

Энэ бүхнийг дахин сонсоход үнэхээр хэцүү байлаа.

-Тиймээ, тэр хаалттай байсан талбайгаас олдсон гэсэн. Салхи л зүг чигийг нь өөрчилсөн бололтой гэж надад хэлсэнэ.

-Энэ таны ойр дотны хүмүүсийн хувьд анхны үхэл үү?

"Энэ асуултанд яаж хариулах вэ?"

"Өө үгүй дээ. Миний нөхрийг нууц амрагтай нь хамт, намайг алах оролдлого хийснийх нь төлөө цаазалчихсан. Миний эргэн тойронд байгаа хүмүүс цөм л үхэх юм .. Энэ хүн хариулт хүлээгээд л сууж байна. Түүнийг тэгж баярлуулахгүй шүү. Миний амьдрал бол миний л амьдрал, миний хувийн явдал болохоос энэ хүнд хамаагүй". Түүнийг үзэн ядаж эхэллээ.

Хүүхний царай уурласан төрхтэй болж ирэхийг эмч ажлаа. Тэгээд ярианы сэдвийг өөрчлөхөөр яаран,

-Уйм ямаршуухан байна даа? гэж асуув.

Асуулт Кэтринийг мэгдүүлж орхив.

-Уйм уу? Тэр зүгээр ээ. Эвелин түүнийг таны өвчтөн гэж хэлсэн.

-Тиймээ, үнэн.

-Та түүний тиймэрхүү байдлыг юу гэж тайлбарлах вэ?

-Уйм анх над дээр ирэхдээ ажлаас байнга халж байна гэж ирсэн юм. Тэр бол хүнийг төрөлхийн үзэн ядах сэтгэлтэй ховорхон хүн. Нарийн яриад ч яах вэ дээ, гэвч тэр хүмүүсийг үзэн яддаг. Энэ л хамгийн гол нь байгаа юм. Тэр хүмүүстэй хэвийн харьцаатай байж чадахгүй.

"Түүнд мэдрэмж байхгүй. Хэнд ч тэр сайхан хандаж чадахгүй" гэж Эвелины хэлснийг Кэтрин саналаа.

-Гэвч Уйм бол тооны ухаанд төгс хүн хэмээн Алан Гамильтон үргэлжлүүлэн,

-Одоо тэр өөрийн авьяасыг гаргаж чадах ажилтай болсон гэлээ.

Кэтрин зөвшөөрөн толгой дохиж,

-Тийм хүнтэй хэзээ ч учирч яваагүй гэлээ.

-Мисс Александр, тан шиг байдалд орсон хүний хувьд ганц л зам байдаг юм. Зөвхөн урагшаа. Дахиад нэг уулзалт товлоё, тэгэх үү? Түүний дараагаар та намайг бүр их үзэн ядаж эхлэх юм бол энэ бүхнийг цэглэж орхиё.

-Би таныг үзэн ядаагүй. Зүгээр л жаахан ...

Доктор дур булаам инээмсэглэдэг ажээ.

Тэр хуанлигаас үзвэл бүх өдөр хүмүүс хүлээн авахаар товлосон ажээ. Тэгээд,

-Даваа гаригийн нэг цагт гэвэл болох уу? гэж асуулаа.

Түүний үдийн хоолны цаг байвч энэ сайхан хүүхэдн туслахын тулд тэрээр үдийн хоолоо золиослоход ч бэлэн байв.

-Тохирлоо.

-Сайн байна. Би таныг хүлээж байх болно. Тэрнээс наана танд миний хэрэг гарвал энэ утсаар

утасдаарай гээд гэр ажлын утса бичсэн нэрийн хуудас өгч,

-Ичиж зовсны хэрэггүй шүү гэлээ.

-Баярлалаа, би даваа гаригт ирнээ.

"Ийм сайхан, эмзэгхэн бүсгүй мөрөн дээрээ дааж давшгүй хүнд ачаа үүрч явахад би заавал туслах ёстой. Болгоомжтой байх хэрэгтэй" гэж түүнийг гарч явахад доктор бодоод "Энэ тухай Анжела юу гэх бол?" гэж бодон ширээнд ээрх жаазтай зураг тийш харлаа.

Шөнө дунд утас дуугарав.

Константин Демирис харилцуур авч зүйргүй гайхсан дуугаар,

-"Теле" хөлөг минь живсэн гэнэ? Байж боломгүй юм. Арай үгүй байлгүй дээ гэлээ.

-Тэр үнэн шүү, нёон Демирис. Тэнгисийн эргүүлүүд үлдэгдэлийг нь олсон байна.

-Аврагдсан хүн байна уу?

-Байхгүй, эрхмээ. Үгүй гэж айж байна. Багийхан тэр чигээрээ амь үрэгдсэн.

-Аймшигтай юм! Юу болсныг мэдсэн хүн байна уу?

-Бид үүнийг хэзээ ч мэдэж чадахгүй болов уу гэж айж байна. Бүх юм далайн ёроолд живсэн шүү.

-Далай ... даанч энэрэлгүй юм даа!

-Одоо бид даатгалаа хөөцөлдөх үү?

-Ийм олон хүн хохирсон байхад даатгал шүүд хөөцөлдөх хэцүү л юм гэж Демирис хэлээд,

-Тиймдээ, даатгалаа хөөцөлдье гэлээ.

Хосгүй үнэт ваар харин түүний цуглуулгад орох нь тэр.

Одоо хадам ахтайгаа тооцоо хийх цаг боллоо...

Арван наймдугаар хэсэг

Спирос Ламброу Константин Демирис хүр дүүгийнхээ баривчлагдсан тухай мэдээг тэсэж ядан хүлээж өрөөнийхөө радиог огт хаахгүй сонсох боловч одоо болтол чимээ алга байсанд гайхлаа. "Яагаад сонингууд ядаж шуугихгүй байгаа юм бол? Цагдаа нар түүнийг аль хэдийнэ баривчилсан байх ёстой доо" гэж тэр бодно.

Демирис "Теле" хөлөг дээрээ геройн ачаад хөдлөх боллоо гэж Риццолигийн мэдэгдсэний дараагаар Ламброу шууд тэнгисийн гаалийнханд утасдаж энэ тухай мэдээллэсэн билээ. "Тэд түүнийг баривчилсан байх ёстой" гэж гайхав.

Дотуур яригч энэ үед ажиллаж,

-Ноён Ламброу, тантай ноён Демирис ярья гэж байна гэв.

-Демирисын нэрийн өмнөөс ярьж байгаа юм уу?

-Үгүй, Демирис ноёнтон өөрөө тантай ярих гэж байна.

Энэ үг түүнийг цохиод авах шиг болжээ. Сонин юм. Санаанд оромгүй явдал! ламброу цухалдан харилцуур авч,

-Коста юу? гэж асуулаа.

-Сайн уу, Спирос гэж Демирис баяртай нь аргагүй дуугаран,

-Ажил хэр байна? гэлээ.

-Сайн л байна. Чи хаанаас ярьж байна?

-Афинаас.

-Юу? Тийм үү? Уулзалгүй удлаа шүү гэхдээ амьсгаа давчдахыг мэдрэв.

-Тийм шүү. Ажлаас их юм алга. Өнөөдөр цугтаа хооллож болох юм. Чи завтай юу?

Ламброу уг нь чухал уулзалттай байлаа.

-Тиймээ, чамтай уулзахдаа баяртай байна.

-Тэгвэл тохирлоо. Клубт хоёр цагт уулзъя.

Ламброу салгалсан гараар харилцуураа тавилаа. Юу болох нь энэ вэ? Тэр юу болсныг тун удахгүй мэдэх болно...

Ламброу Демирисыг бараг хагас цаг гаруй хүлээлээ.

Эцэст нь тэр ирж,

-Хожимдсонд уучлаарай гэж товчхоон хэлэв.

-Зүгээр.

Спирос Демирисыг анхааралтай ажиглан харж царайнаас нь саяхан болж өнгөрсөн өөдгүй явдлын ул мөрийг харах гэсэн боловч амжилт олсонгүй.

-Юм идмээр байх чинь гэж Демирис хөгжилтэй хэлээд,

-Чи өлсөж байна уу? Алив өнөөдөр тэд бидэнд юу өгөхийг нь харцгаая. Өө, хавчнаас эхэлбэл яасан юм бэ, чи юу гэж бодож байна? гэхэд,

-Үгүй дээ, би юм идмээргүй байна гэв.

Түүний хоол идэх дур алга болжээ.

Хоол захиалсны дараа,

-Чамд талархснаа хэлэх гэсэн юм, Спирос гэлээ.

-Яалаа гэж тэр билээ?

-Юу яалаа гэж? Ноён Риццоли шиг сайхан үйлчлүүлэгч олж өгсөнд чинь л байхгүй юу.

Ламброу уруулаа шилэмдэн,

-Тэгэхээр ... чи түүнтэй уулзжээ? гэж асуулаа.

-Тэгэлгүй яахав. Цаашид ажил их байх болно гэж тэр амласан байтал түүний өөрийнх нь хувьд муугаар төгссөн дөө гэж санаа алдан хэлэв.

-чи юу гэх гээд байна? гэж Ламброу цочин хэлбэл,

-Үүгээр би Тони Риццоли үхсэн гэж хэлэх гэсэн юм гэж эрс дуугаар хариулав.

-Яаж тэр вэ? Юу болсон юм бэ?

-Золгүй ялвал болсон, Спирос. Надаар даажигнах гэсэн хүн болгонд тохиолддог л явдал болсон.

-Би ойлгохгүй байна. Чи ...

-Ойлгохгүй байна гэнээ? Чи намайг харин устгах гэсэн юм биш үү? Бүтсэнгүй. хиний төлөвлөгөө биелсэн бол чи бүр гялайх байсан биз.

-Чиний ырайаг би ойлгохгүй байна.

Тийм гэж үү? удахгүй ойлгоноо. Гэвч эхлээд би чиний дүүг устгана гэж хэлээд инээмсэглэв.

Хавчны мах авчирч өглөө.

-Сайхан харагдаж байна шүү. Тавгай хооллоорой, Спирос гэж Демирис хорсолтой хэлэв.

Сүүлд нь Демирис энэ уулзалтын талаар санах бүрдээ сэтгэл хөдлөн баяр баяслаар дүүрч байлаа. Ламброуг дарамталж сандралд оруулж дөнгөсөн. Түүнийг дүүдээ ямар их хайртайг мэдэх учраас тэдний хэн хэн нь цээрлэл хүлээх ёстой!

Хойшлуулж болшгүй бас нэг хэрэг байсан нь Кэтрин Александр байлаа. Киркыг нас барсны дараагаар тэр сэтгэл хямарсан байдалтайгаар утасдаж,

-энэ бүхэн ... маш аймшигтай юм гэж хэлжээ.

-Надад их харамсалтай байна, Кэтрин. Кирк чамд таалагддагийг би мэднэ. Хэн хэний маань хувьд хүнд гарз боллоо гэж Демирис түүнд хэлжээ.

"Төлөвлөгөөгөө өөрчлөх хэрэгтэй. "Рафина"-д очих талаар бодсоны ч хэрэггүй. Ноэль Пейж, Ларри Дуглас хоёрт тохиолдсон явдлын талаар мэдэх цорын ганц хүн нь Кэтрин. Түүнийг амьд байлгаад байж болохгүй. Тэр үхэж орхивол бүрэн аюулгүй болно" гэж Демирис бодов.

Демирис харилцуураа авч нэг дугаарт залгаад хариу дуугарахыг сонсоод,

-Би даваа гаригт Коулунд очно. Хүрээд ир гээд хариу хүлээлгүй утсаа тасаллаа.

Хотын хуучны хэсэгт оршдог Демирисын байранд хоёр хүн уулзлаа.

-Золгүй явдал шиг харагдахаар хийгээрэй. Чадна биз дээ? Чи!

Мөн их доромжилох нь ээ. Золгүй явдал байшин дотор явагдаж болно. Тэгвэл яг Марселийн бүжигчин шиг шатнаас хийсч хүзүүгээ хугалж эсвэл нөгөө Гстаадын өв залгамжлагч шиг усанд ордог онгоцондоо согтуугаар живж нас бас болно. Бас энэ эмэгтэй геройн хэрэглэхдээ хэтрүүлж орхисон ч байж болно. Энэ аргыг тэр гурван ч удаа хэрэглэсэн юм. Мөн цогтой янжуураа тэврээд унтаж орхисон байхыг үгүйсгэх аргагүй. Энэ аргаар тэр Парисын нэг зочид буудалд Шведээс ирсэн мөрдөгчтэй тооцоо бодож билээ. Эсвэл золгүй явдал цэвэр агаарт явагдаж ч болно. Автын осол юм уу онгоцны осол, эсвэл далайд живж алга болохын аль нь таны санаанд илүү нийцэх бол? гэж эгдүүцэхдээ хэлчих дөхлөө.

Гэвч тэрээр юу ч хэлсэнгүй. Өөдөөс нь хараад сууж байгаа энэ хүний талаар аймшигт балмад явдал олон сонсогддог бөгөөд үүнд итгэх үндэслэл байсан болохоор тэр айж байжээ.

-Тиймээ, эрхмээ. Би золгүй явдал шигээр зохион байгуулж чадна. Хэнц х хэзээ ч үнэн учрыг мэдэж чадахгүй.

Демирис хүйтэн саарал нүдээрээ түүнийг шинжиж сууснаа эцэст нь,

-Сайн байна, яаж хийхээ өөрөө мэд гэлээ.

-Тэр эмэгтэй Коулунд байгаа юм уу?

-Лондонд байгаа. Кэтрин Александр гэдэг. Лондон дахь миний нэг конторт ажилладаг юм.

-Хэн нэгэн хүн намайг түүнтэй танилцуулбал зүгээр байна.

Демирис бодолхийлснээ,

-Би ажилчдынхаа группыг ирэх долоо хоногт Лондон явуулна. тэдэнтэй цуг яваарай гээд урагш болсноо,

-Бас нэг зүйл байна гэв.

-Сонсоё, эрхмээ.

-Түүний хүүрийг хэн ч танихгүй болгоорой.

Арван есдүгээр хэсэг

Константин Демирис Кэтрин рүү утасдаж,

-Өглөөний мэнд. Та өнөөдөр хэр байна? гэвэл,

-Сайн байна, баярлалаа Коста гэлээ.

-Бие чинь дээрдэв үү?

-Тиймээ, тэгсэн.

-Энэ тухайд сонсоход таатай байна. Би хэсэг ажилчдыг сургахаар Лондон явуулж байгаа юм. Би танаас манай ажлчдын тэдгээр төлөөлөгчдийг харж хандах анхаарахыг гуйх гэсэн юм.

-Дуртайяа тэгье. Хэзээ ирэх хүмүүс вэ?

-Маргааш өглөө очно.

-Чадах бүхнээ хийх болноо.

-Танд найдаж болно гэж би мэдсэн юмаа Кэтрин.

-Баярлаж талархах хэрэггүй дээ.

"Үүрд баяртай, Кэтрин" гэж дотроо бодоод Демирис утсаа тавив.

За ингээд хамаг хэрэг бүтлээ. Демирис бодолдо автаж удаан суув. Кэтрины үхэлтэй цуг түүний бүх аюул зовлон арилна. Одоо л хонгор эхнэр, хүргэн ах хоёртойгоо тооцоо хийх бүрэн боломжтой болно.

* * *

-Өнөөдөр манай компаны хэсэг ажилчид зочилж ирнэ. Тэднийг зохих ёсоор хүлээж аваарай.

Сүүлчийн удаа нөхрийнхөө зочдыг хүлээж авснаас хойш хичнээн их цаг хугацаа өнгөрөө вэ!
"Тэр засарч байж болох биш үү!" гэж Мелина горьдон бодлоо.

гэвч тэр оройн зоог юуг ч өөрчилсөнгүй. Гурван эрэгтэй хүн ирж хооллоод ываахд Мелинагийн хувьд будан дотор байх шиг л болж өнгөрчээ.

Түүнийг зочдын өмнө ёс төдий суулгаж орхиод Коста зочдоо басамжлан харьцахыг ажиглахад хүргэжээ. Ер нь Коста аятайхан байхдаа ямаршуухан байдгийг одоо Мелина бараг мартжээ. Нөхөр нь элдэв дэмий балай хошин үг ярьж зочдоо багьсган тэдний зүгээс магтаал хүртэн суусан бол зочид ч аугаа их хүний гэрт зочлон ирээд байгаагаа нуусангүй. Мелинад ганц ч атугай үг хэлэх бололцоо олдсонгүй. ам ангаймагц нь л Коста тас дайран ярих тул дэмий л дайрсан үгийг нь сонсон номхон сууж дотроо "Би энд байх нь түүнд ямар хэрэгтэй

юм бол доо" гэж бодлоо.

Зочдыг явахаар босоход Демирис,

-Маргааш өглөө би эрт Лондон ниснэ. Та нар бүхнийг зохих ёсоор хийнэ биз гэж хэлэх сонсогджээ.

Тэгээд зочид тэднийхээс явцгаав.

Маргааш өглөө нь төлөөлөгчид Лондонд ирлээ. энэ нь өөр өөр улсын иргэн болох гурван хүнээс бүрдэж байв.

Жерри Хейли бол тамирчин шиг бие хаатай, өндөр нуруутай аятайхан царайтай, хүрэн нүд бүхий эд. Түүний гар шиг том гарыг Кэтрин энэ яваа насандаа үзээгүй байв. Кэтриний сэтгэлд америк эрийн хэзээ ч хөдөлгөөнгүй байхыг үл мэдэх аварга хоёр гар таалагджээ.

Франц эр Ив Ренард бол америк эрийн яг эсрэг дүр гэлтэй дугуй царай, бяц хан хүйтэн нүдтэй агаад Кэтринийг нэвт шувт ширтээд байх шиг эвгүй санагджээ. Тэр хүн хүмүүсийг байнга эвгүйцүүлж өөрөөсөө холдуулан түлхэх байдалтай ажээ. Тэр үргэлж л ямар нэг юмнаас болгоомжилж, хяналт тавиад байх шиг сэтгэгдэл төрүүлнэ. "Яагаад юм бол?" гэж Кэтрин өөрөөсөө асуув.

Гурав дахь нь Дино Матусси гэгч найрсаг хөгжилтэй зан төрхтэй итали эр байна. Тэрээр хүүхэнд хандан,

-Ноён Демирис таныг их үнэлэх юм билээ гэж хэлэв.

-Өө, та намайг бүр хөөргөх нь.

-Тэр хэлэхдээ Лондонд биднийг харж хандах хүн бол таныг гэсэн юм. Би танд жаахан бэлэг авчирсан гээд Гермесын марк бүхий боодолтой зүйл өгөв. Дотор нь хачин гоё хүзүүний ороолт байсанд Кэтрин,

-Баярлалаа. Та тун эелдэг хүн юм гэлээ. Тэгээд бүгдэд хандан,

-Та нар өрөөгөө үзэх үү? гэж асуулаа.

Тэдний ардхан талд ямар нэг хүнд юм унах чимээ гарсанд тэд эргэн харцгаавал арван тав зургаа орчим насны хөвгүүн шалан дээр чемодан унагачихжээ.

-Бурханыг бодож тээштэй минь болгоомжтой харьцаач гэж Ренард зандрав.

-Миний буруу. Намайг өршөө гэж хөвгүүн дуугараад,

-Хааш нь аваач гэж тушаахсан бол? гэлээ.

-Хаач нь ч байсан хамаа байж уу гэж залуу цухалдан хариулаад,

-Бид наадхыг чинь дараа ирж авна гэлээ.

Кэтрин хүү рүү асуусан янзтай харж байв. Эвелин түүнд туслан,

-Тэр Афинд зарлага хийдэг юм. Бидэнд энд ч бас зарлага хэрэгтэй гэж хэлэв.

-Чамайг хэн гэдэг вэ? гэж Кэтрин асуулаа.

-Атанас Ставич гэхдээ хүү уйлах шахаж буй нь илэрхий.

-Бүх юм хэвийн байна, Атанас. Тэр гудмын төгсгөлд байгаа өрөөнд ачаа тээшээ аваачаад тавьчих. Наадуулыг чинь эмхэлж янзал гэж би хэлнээ.

-Баярлалаа, хатагтай.

Кэтрин дахиад л зочид руугаа хандан,

-Ноён Демирис та бүхнийг манай ажлын арга барилтай танилцах юм гэж хэлсэн. Хэрэв ямар нэг юм хэрэгтэй болбол надад хандаарай. Би чадах бүхнээ хийнэ. Харин одоо, намайг дагаад явна уу? Би та бүхнийг Уйм болон бусад ажилчидтайгаа танилцуулъя.

Тэд гудмаар явж байгууллагын хэн нэгэнтэй танилцахын тулд байн байн зогсож явлаа. Эцэст нь Уймын өрөөнд явж орцгоов.

-Уйм аа, энэ бол ноён Демирисын явуулсан төлөөлөгчид. Танилц, ноён Ив Ренард, Дино Маттуси, Жерри Хейли. Тэд дөнгөж сая Грекээс ирсэн юм.

Уйм тэдэн рүү харж,

-Грекийн хүн ам долоон сая зургаан зуун гучин мянга гэлээ.

Эрчүүд гайхан өөд өөдөөсөө харцгаав. Кэтрин түүнийг хараад анх яаж гайхсан яг тийнхүү нөлөө үзүүлэхийг хараад инээд нь хүрч,

-Та нарын өрөө бэлэн болсон. Намайг дагаад явна уу? гэлээ.

Тэднийг гудманд гарах үед Жерри Хейли,

-Ямар учир ургаад байнаа, чөтгөр алгад. Түүнийг чухал нөлөөтэй хүн гэж ярьцгаагаад байх шиг байсан гэв.

-Тийм шүү. Уйм бүх салбаруудын санхүүгийн үйл ажиллагааг хянадаг юм.

-Би түүнд өөрийнхөө муурыг ч даатган орхиж чадахгүй гэж Хейли эгдүүцэн хэлэв.

-та түүнийг илүү сайн мэддэг болохын цагт ...

-Түүнийг илүү сайн мэддэг болох өчүүхэн ч хүсэл алга..

-Би та нарт зориулж зочид буудалд өрөө захиалсан. Миний ойлгосноор та нар өөр өөр буудалд байрлана гэсэн байх аа?

-Энэ үнэн гэж Магтуси хариулав.

Кэтрин нэг юм хэлэх гэснээ болив. Тэдний юу гэж шийдэх хэнд хамаатай билээ?

Тэрээр Кэтринийг ажиглан харж, "Түүнийг ийм сайхан хүүхэн байх гэж огт бодсонгүй. За яах вэ, тэгэх тусмаа л сонирхолтой биз. Хараажаар зовлон үзсэн бололтой. нүднээс нь илт байна. Өвдөх гэдэг ямар гайхалтай болохыг би түүнд үзүүлэх болно. Бид хамтдаа үзэж жаргах болно. Тэгээд намайг дуусахын цагт тэр өвдөлт зовлон гэж юу байдгийг мэдэхгүй газар руу очно. Бурхан руу эсвэл өөрөөр нэрлэдэг ч юм болов уу? За ямар ялгаа байнаа" хэмээн бясалгана.

Кэтрин залуусыг тус тусынх нь байранд оруулж орхиод гэрээдээ явахаар эргэлээ. Гудмаас франц эрийн,

-Энэ чинь миний чемодан бишээ, тэнэг минь. Минийх тэр хүрэн өнгөтэй нь. Хүрэн гэж байна, ойлгов уу? Чи англиар ер нь ойлгодог хүн үү? гэж хашгичих дуулдлаа.

-Тиймээ, эрхмээ. Намайг өршөө гэх дуулдав.

"Энэ залуугийн талаар ямар нэг юм бодож олох хэрэгтэй" гэж Кэтрин боджээ.

-Хэрэв чамд тусламж хэрэгтэй бол хэлээрэй. Намайг хаанаас олохыг мэдэх үү гэж Эвелинийг хэлэхэд,

-Та их эелдэг хүн юм, Эвелин. Таныг би хэзээ ч мартажгүй ээ.

Хэдэн минутын дараа Атанас Ставич Кэтриний өрөөний үүдээр явж өнгөрөх гэтэл Кэтрин түүнийг дуудаж манай өрөөгөөр ороод гараач гэж хүсэв.

Хөвгүүн түүнийг сүрдсэн царайтай харснаа,

-Мэдлээ, хатагтай гээд түүнийг харааж загнаж эхлэх вий гэсэн шиг зөөлөн алхлан орлоо.

-Хаалгаа хаачих.

-Мэдлээ, хатагтай.

-Суу, Атанас. Атанас гэдэг байх аа?

-Тиймээ, хатагтай.

Кэтрин түүнийг тайвшруулах гэж оролдсон боловч ерөөсөө амжилт олсонгүй.

-Энд айх юм байхгүй.

-Тиймээ, хатагтай.

Кэтрин түүнийг гайхширан ажиж суухдаа түүнийг ингэтэл нь айлгаж орхих ямар явдал болсон юм бол доо гэж өөрөөсөө асуулаа.

Тэгээд дотроо энэ хөвгүүний өнгөрсөн амьдралын тухай сайн мэдэж авья гэж бодов.

-Атанас, хэрэв хэн нэгэн нь чамайг харааж загнах юм уу гомдоовол над руу ирээрэй. Ойлгов уу?

-За, хатагтай гэж тэр сулхан шивэгнэв.

Гэвч түүний зориг хүрэхгүй гэдгийг Кэтрин сайн мэдэж байв. Хэн нэгэн нь хэзээ ч юм бэ түүний зориг зүрхийг үүрд үгүй хийж орхисон бололтой.

-Бид дахиад уулзанаа гэж Кэтрин түүнд хэллээ.

Ирсэн төлөөлөгчдийн бичиг баримт тэднийг Демирисийн эзэнт гүрний энд тэндхийн салбар хэлтсүүдэд янз бүрийн хугацаагаар ажиллаж байсныг гэрчилж байв. Иймээс тэд энэ байгууллагын ажлын талаар хангалттай мэдлэгтэй хүмүүс байлаа.

Тэд нарын дотроос соёлтой итали эр Дино Маттуси Кэтринд ихэд анхаарал тавина. тэрээр хүүхнээс албан ажилтай холбогдолгүй элдэв асуулт дээр дээрээс нь давхцуулан тавьж хариултыг нь авахаар салахгүй дагах нь төвөгтэй.

-Та нөхөртэй юу?

-Үгүй.

-Гэхдээ нөхөртэй байсан биз дээ?

-Тийм.

-Салсан юм уу?

Кэтрин яриаг дуусгахыг оролдон,

-Би бэлэвсэрсэн гэхэд Маттуси инээвхийлэн,

-Таныг эрэгтэй найзтай гэж мөрийцөхөд ч бэлэн байна. Миний юу хэлэх гээд байгааг ойлгож байна уу?

-Хэлэх гэснийг чинь би ойлгож л байна гэж хариулаад дотроо: "Энэ чиний хэрэг биш" гэж бодсоноо,

-Харин та эхнэртэй юу? гэж асуулаа.

-Тиймээ. Би эхнэр дөрвөн хүүхэдтэй. Намайг эзгүйд тэд маань их санадаг юм.

-Та их аялдаг уу, ноён Маттуси?

Тэр гомдсон дүр үзүүлэн,

-Дино шүү дээ, намайг Дино гэж дуудагтун, ноён Маттуси гэдэг чинь миний аав байхгүй юу. Тийм ээ, би их аялдаг гэж Кэтрин рүү тонгойн нам дуугаар,

-Гэхдээ намайг аялж явахад ганцаардах үе бишгүйдээ л тааралдах юм. Та миний юу хэлэх гээд байгааг ойлгож байна уу? гэвэл Кэтрин инээн,

-Үгүй гэв.

Нэг цаг арван тавд Кэтрин Гамильтон эмчийн өрөөнд оржээ. Гайхалтай нь тэр даваа гаригийг тэсэж ядан хүлээгээд болмогц нь яаравчлан ирсэн нь энэ. Анх уулзахдаа ямар их сандарсан байснаа санаж байв. Одоо бол тэр учир битүүлэг нэг л сайхан юм хүлээж байгаа мэтээр санаж байлаа. Гамильтон түүнийг хүлээж байв. Лавлах өрөөний хүүхэн үдийн цайндаа явжээ.

-Ор, ор гэж эмчийн урьсанд Кэт өрөөнд нь орж заасан сандалд нь суув.

-Долоо хоног тэгээд яажшуухан өнөгөрөв дөө?

"Яаж өнгөрөв гэнээ? Яаж ч биш". Тэр тархи толгойноосоо Кирк Рейнольдсын тухай бодлоо авч хаяж чадахгүй байлаа.

-Хэвийн өнгөрсөн. Ажил ихтэй байлаа гэж эцэст нь хариулав.

-Ажил тустай зүйл шүү. Та Константин Демирист ажилладаг болоод удаж байна уу?

-Дөрвөн сар болж байна.

-Ажил чинь таалагддаг уу?

-Элдэв юм бодохгүй байхад минь тусладаг юм ... Би ноён Демирист их өртэй хүн. Тэр хүн миний төлөө хичнээн их зүйл хийснийг хэлж барахгүй гэж Кэтрин даруухнаар инээмсэглээд,

-Ингэхэд энэ тухай ярих хэрэг байна уу? гэв. Алан Гамильтон эмч толгойгоо дохиж,

-Та ярихыг хүсэж байгаа зүйлээ л ярь гэхэд, Кэтрин хэсэг чимээгүй сууснаа ярьж эхэллээ.

-Миний нөхөр Константин Демирисийн нисгэгчээр ажилладаг байсан юм л даа. Харин надад нууранд золгүй явдал тохиолдож би ухаан алдсан байсан. Би ой тогтоолтоо алдаж нэг хэсэгтээ өөрийн хэн болохыг мэдэхээ больсон. Ой ухаан маань эргэж ирсэний дараа л ноён Демирис надад ажил олж өгсөн юм.

"Би тэр аймшигт явдлын талаар ярихыг хүсэхгүй байна уу эсвэл мини нөхөр намайг алахаар оролдсон гэж хэлэхэд ичгүүртэй байгаа юм болов уу?"

-Өнгөрсөн амьдралаа ярихад бидний хэнд маань ч хүнд байдаг шүү дээ.

Кэтрин түүнийг чимээгүй харан суув.

-Та ой тогтоолтоо алдсан гэв үү?

-Тиймээ.

-Бас нууранд явж байхад золгүй явдал тохиолдсон гэж хэлэв үү?

-Тиймээ гээд хүүхэн уруулаа жимийв. Тэр түүнд аль болох бага зүйл ярих гэж бүхий л хүчээ дайчлан оролдсон бололтой санагдана. Тэгээд эмчид бүх зүйлээ ярьж тусламж гуйхаар хүсэх яг энэ үед мөн юу ч яримааргүй санагдан тайван орхиоч гэж гуймаар санагдах нь зовлонтой.

Алан Гамильтон түүнийг бодлогоширон харж сууснаа,

-Та хоёр салсан юм уу?

"Тиймээ, буудуулсан учраас" хэмээн дотроо бодсон боловч,

-Тэр ... миний нөхөр нас барсан гэлээ.

-Хатагтай Александр. Таныг Кэтрин гэвэл татгалзахгүй биз дээ? гэж асуулаа.

-Үгүй.

-Намайг Алан гэж дуудна уу. Кэтрин та юунаас айгаад байгаа юм бэ?

Хүүхэн хөшсөн мэт болсноо,

-Та яагаад намайг ямар нэг юмнаас айгаад байна гэжб одоов? гэхэд,

-Тийм биш гэж үү? гэж суув.

-Үгүй.

Энэ удаад чимээгүй байдал улам удаан үргэлжилж, Кэтрин хүүхэн өөрийн бодол санаанд байгаа зүйлийг үгээр илэрхийлэн гаргахаас эмээж байснаа,

-Миний эргэн тойронд байгаа хүмүүс ... цөмөөрөө үхээд байна гэлээ.

Эмч гайхсан байж болох хэдий ч ямар ч гэсэн гаднаа гайхсан байдал огт үзүүлсэнгүй,

-Тэгээд энэ бүгдэд өөрийгөө буруутгаад байгаа юм уу?

-Тиймээ. Үгүй. Би мэдэхгүй. Бүр будилж орхиод байна.

-Бусдад тохиолдсон бүхэнд өөрийгөө буруутгадаг нь бидний гэм биш зан. Хэрэв эцэг эх нь салсан бол хүүхдүүд өөрсдийгөө буруутгаж, хэрэв хэн нэгн нөгөөгөө харааж орхиод тэр нь үхчихвэл мөн л өөрийгөө буруутгадаг. Ер нь ийм л байдаг шүү дээ. Та ...

-Ганц энэ ч биш ...

-Өөр юу байна? хэмээн эмч анхаарал тавин сонсоход бэлтгэв.

-Миний нөхрийг болон ... түүний нууц амрагийг алсан юм. Тэднийг өмгөөлсөн хоёр өмгөөлөгч хоюулаа бас үхсэн гээд хүүхний хоолой чичрэн,

-Тэгтэл одоо бас Кирк үхлээ гэв.

-Энэ бүх үхлийн цаад хариуцлагыг та өөртөө үүрээд байгаа хэрэг үү? Таны хүч хүрэхгүй шүү дээ.

-Би ... гай гамшиг авчирдаг хүн шиг санагдаад байна. Хэн нэг эрэгтэй хүнтэй холбогдохоос үнэхээр их айж байна. Хэрэв дахиад ямар нэг юм тохиолдвол би лав тэсэхгүй ...

-Та хэний төлөө амьдарч байгаа юм, Кэтрин? Өөрийнхөө л төлөө амьдарч байгаа шүү дээ. Бусдын өмнөөс амьдарч байгаа биш болохоор бусдын амьдрал болоод үхэл танаас хамаарна гэдэг утгагүй хэрэг. Ойлгооч.

"Та буруугүй. Энэ болсон бүх хүний үхэлд та ямар ч хамаагүй. Кэтрин эдгээр үгийн утгыг ойлгохыг оролдон сууна. Энэ үгэнд итгэхийг тэр хичнээн их хүсэж байна вэ? Тэр хүмүүс өөрсдөө л буруутай болохоос Кэтрин ямар ч буруугүй. Гэтэл Киркэд тохиолдсон явдал золгүй явдал төдий юм гэж үү?".

Алан Гамильтон эмч түүнийг дуугүй ажиглана. Кэтрин түүнийг харж "Энэ ёс журамтай хүн юм" гэж бодсоноо "Энэ хүнтэй эртхэн дайралдаагүй нь юутай харамсалтай" гэсэн бас нэгэн бодол тархинд нь харван орж ирэв. Тэгээд ширээн дээр тавьсан Аланы эхнэрийн зураг руу гэмшингүй харав.

-Баярлалаа., танд. Итгэхийг хичээе. Энэ бодолдоо дасахыг оролдоод үзье гэж хэлэхэд, Алан инээмсэглэн,

-Хамтдаа дасацгаая л даа. Та дахиад ирнэ биз дээ?

-Та юу гэнээ?

-Өнөөдрийнх чинь туршилтын уулзалт биз дээ. Та над дээр ирж байх эсэхээ одоо нэгмөсөн шийдэх хэрэгтэй байна.

Кэтрин нэг хоорм ч эргэлзэлгүйгээр,

-Тэгнээ, Алан. Би ирнэ гэж хариулжээ.

Түүнийг явсны дараагаар Алан Гамильтон эмч саяын ярианы талаар удаан бодлоо.

Энэ олон жилийн турш олон сайхан хүүхэн түүнээс тусламж хүсэн ирцгээж нилээд олон нь түүнийг эмч гэхээсээ илүү эр хүнийх нь хувьд сонирхдог байж билээ. Гэвч Гамильтон тэднийг уруу татахааргүй сайн эмч байжаа. Түүн шиг мэргэжлийн хүмүүст өвчтөнгүүдтэйгээ дотно харьцаатай байх явдал хамгийн чухал байсан боловч ёс суртахууны хувьд урвасантай ижил болох байлаа.

Алан Гамильтон эмч хүний гэр бүлд төржээ. Мэс заслын эмч аав нь сувлагч хүүхэнтэйгээ гэрлэсэн бөгөөд эмэг эх нь ч мөн зүрхний нэртэй эмч байсан байна. Хар багаасаа л Алан эцэг шигээ мэс заслын эмч болохыг мөрөөддөг байв. тэр анагаах унаахы коллеж төгссөнийхөө дараа мэс заслын талаар судалж эхэлжээ.

Түүнд мэс засалчын өвөрмөц онцгой авьяас заяасан байв. Гэвч 1939 оны 9 сарын 1-нд Гуравдугаар Рейхын арми Польшийн хил руу халдан довтолж гурав хоногийн дараа Англи ба Франц улс дайнд орсноо зарласнаар дэлхийн хоёрдугаар дайн эхэллээ.

Алан Гамильтоныг армид мэс засалчаар илгээв.

1940 он 6 сарын 22-нд Фашистууд Норвеги, Польш, Чех болон хэдэн орныг эзлээд байсан үедээ Франц руу дотвлон, дайны хамаг хүнд хүчир нь Англи улсад тохогдоод байлаа. Эхлээд зуун онгоц Британы арлууд дээр бөмбөг хаяж удалгүй хоёр зуу, сүүлдээ бүр ымангад хүрчээ. Энэ цуст дайныг төсөөлөхөд ч бэрх. Эргэн тойрон үхэгсэд шархдагсад. Хот дүрэлзэн шатаж байсна эхдий ч Гитлер англичуудыг дутуу үнэлж байсан юм. Бөмбөгдөлт зөвхөн тэдний дайчин сэтгэлийг бэхжүүлэн, эх орон эрх чөлөөнийхөө төлөө амиа өгөхөөс буцахгүй болгон хатуужуулжээ.

Аланы хувьд эцэс төгсгөлгүй хагалгаа хийж өглөө оройгүй ажиллан унталгүй жаран цаг болох энүүхэнд байлаа. Тэрээр хүн тогтохын аргагүй нөхцөлд ажиллаж хагалгаа хийж асан эмнэлийг бөмбөгдөх үед шархтнуудаа агуулахад зөөн оруулж тоо тоомшгүй олон хүний амь ансыг үхлээс аварч ч явсан билээ.

Аравдугаар сард бөмбөгдөлт эрс нэмэгдэж байн бай агаарын түгшүүр зарлан хүмүүс хоргодох байр рзз арайхийн орж амжина. Нэг бөмбөгдөлтийн үеэр Алан хагалгаа хийж байж таарсан бөгөөд өвчтөнгөө орхиод хоргодог байр руу гүйх санаа төрсөнгүй, бөмбөгдөлт ойртсоор байлаа.

Туслах эмч нь,

-Чөтгөр ав. Эндээс зайлах хэрэгтэй гэж тэсгэлгүй хашиграв.

-Одоохон гэснээ Алан Гамильтон шархтны цээжний хөндийгөөс бөмбөгний хэлтэрхий гарган авлаа.

-Алан!

Гэвч Алан хагалгаагаа үргэлжлүүлэн эмнэлгийн бүр хажууд онгоц дүнгэнэхийг анзаарсангүй. Эмнэлгийн байшин дээр бөмбөг унахыг ийнхүү сонссонгүй ээ.

Зургаа хоног ухаангүй байгаад гар хөлөндөө олон тооны шарх олоод зогсохгүй баруун гарын хуруунууд нь бяцарч гэмтсэн байдалтайгаар сэргэжээ. Эмч нар чадах бүхнээ хийж хүн харахад аятайхан болгосон эхдий ч түүний хувьд мэс засал дахин хийх хөг нэгэнт өнгөрсөн байв.

Түүнд тохиолдсон энэ их гарз хохиролтойгоо эвлэрэхэд олон жил шаардлагатай болсон ажээ. Түүнийг ыханалтандаа авсан сэтгэл зүйч эмч нэгэн удаа,

-Өөрийгөө өрөвдөж харамсахаа больж одоо амьдралаа бодож үз.

-Би юу хийх юм бэ?

-Хийж байснаа л хий, гэхдээ арай өөрөөр.

-Ойлгосонгүй.

-Алан, чи бол ид шидтэй анагаагч хүн. Чи хүний бие махбодыг сэргээн засдаг байсан бол одоо түүнийгээ болиод хүний сэтгэл зүрхийг эмчилдэг бол. Чи их сиан чадварлаг сэтгэ зүйч болох байх шүү. Чи чадвартай ухаалаг, зовлон гэж юу байдгийг үзсэн хүн. Энэ талаар сайн бодоорой.

Ийнхүү амьдралдаа хамгийн азтай ч байж мэдэх сонголт хийжээ. Шинэ ажил нь түүнд хязгааргүй таалагдлаа. Тэрээр хүмүүсийг бие махбодын шаналгаат өвчнөөс салгаж байснаасаа илүү сэтгэлийн зовлонгоос салгахдаа хачин сайхан аугаа гэмээр их таашаал авдаг болжээ. Тэгээд мэргэжилдээ амжилт хурдан олж сүүлийн гурван жилд шинэ өвчтөн авахаас татгалзахад хүрсэн билээ. Тэр Кэтриныг хүлээн авсны учир бол түүнд өөр эмч хэрэгтэй гэж ятгал ойлгуулахын тулд байсан бол сүүлдээ Кэтрин нэг л сэтгэл хөдөлгөм сонин санагдаж "Би түүнд туслах ёстой" хэмээн бодох болжээ.

Алан Гамильтонтой уулзаад эргэж ирмэгцээ Кэтрин Уймын өрөөнд орж очин,

-Би өнөөдөр Алан Гамильтон эмчтэй уулзлаа гэвэл,

-Тийм үү? Сэтгэл зүйч эмчийн нийгэмд үзүүлэх тусламж гэр бүлийн хүнээ алдсан хүмүүст 100 хувь, гэр бүлээсээ салсан хүмүүсийн 73 хувь, эрчүүдэд хаягдсан эмэгтэйчүүдийн 65 хувь, ял эдэлж буй хүмүүсийн 63 хувь, ойр дотныхоо хүмүүсийг алдсан хүмүүсийн 63 хувь, хүндээр өвчилсөн буюу гэмтэл авсан хүмүүсийн 53 хувь, ажлаасаа хөөгдсөн хүмүүсийн 47 хувьд нь хэрэг болдог ... гэж дуржигнуулав.

Кэтрин түүний үгийг дуугүй сонсож зогсохдоо "Яахаараа хүн бүх юмс үзэгдлийг зөвхөн тоон ухагдахунаар нь харж болдог байнаа? Хүмүүсийг амьд биет шигээр хэзээ ч үзэхгүй, амьд хүмүүсийн дунд найз нөхөдтэй хэзээ ч болоохгүй гэдэг аймшиг аа. Гэрлээд удсан облов уу,

сонин оо?" гэж эргэцүүлэн боджээ.

Хорьдугаар хэсэг

Афин

"Чи намайг устгах гэж оролдсон боловч чадсангүй. Хэрэв төлөвлөгөө минь биелсэн бол чамд хол дээр байх байжээ эгдгийг би чамд батлаад өгье. Гэхдээ би эхлээд чиний дүү хүүхнийг чадна" гэж хэлсэн Константин Демирисын үг Ламброугийн шихэнд хангинасаар байлаа.

Демирис сүрдүүлээгүй, үүнийгээ заавал хэрэгжүүлнэ эгдэгт тэр огт эргэлзсэнгүй. Бурхан минь, Риццолид юу тохиолдож орхив оо? Ингээд бүх юм эргэж орхих гэж. Тэр бүгдийг нарийн нямбай тооцоолсон юмсан. Одоо хамгийн гол нь дүүдээ эмдэгдэх хэрэгтэй.

Өрөөнд нарийн бичгийн дарга орж ирэн,

-Арван цагт тантай уулзахаар тохирсон хүн ирээд байна, оруулах уу? гэж асуулаа.

-Үгүй. Уулзалтыг хойшлуул гэж хэллээ.

Тэр таван минутын дараа гэхэд дүү хүүхнийх рүүгээ хурдлан давхиж явав.

Мелина ахыгаа цэцэрлэгтээ хүлээж байв.

-Сайн уу, Спирос минь! Утсаар зовсон шинжтэй ярьсан. Ямар нэгэн юм болоо юу?

-Ярилах хэрэгтэй байна гээд дүү охиноо дагуулан усан үзмийн ороонго модны доорхи сандал руу очиж сууцгаав. Тэгээд дүүгээ ажиглан харж, "Юутай үзэсгэлэн төгөлдөр харагдана вэ! Учирсан болгондоо аз жаргал авчран байсан даа! Даанч тийм хувь заяа түүнд тохиосонгүй" гэж бодлоо.

-Чи тэгээд юу болсныг хэлэх үү?

Ламброу гүнзгий амьсгаа аван,

-Хонгор минь, чамд хэцүүхэн юм хэлмээр байна.

-Чи намайг айлгаж орхилоо.

-Үгүй ээ, би одоо л чамайг айлгах гээд байна. Чиний амь насанд аюул учраад байна.

-Яагаад? Хэн намайг алах гээд байгаа юм бэ?

Тэр үг бүрээ цэгнэн,

-Коста чамайг алах гэж оролдоод байх шиг санагдана гэхэд Мелина түүн рүү харан гайхсандаа амаа ангайж орхив.

-Чи тоглоогүй ...

-Үгүй, би үнэнгээсээ ярьж байна.

-Хонгор минь, Коста мэдээж бурхан шиг хүн биш боловч тэр алуурчин бол бүр биш. Тэр тэгж чадахгүй ...

-Чи алдаж байна. Тэр хэдийнээ хүн алсан.

Мелинагийн царай цонхийж,

-Чи юу яриад байнаа? гэв.

-Мэдээж өөрийн гараар биш л дээ. Тэр чинь иймэрхүү ажилд хүн хөлсөлж авдаг юм.

-Би итгэхгүй байна.

-Кэтрин Дугласыг санаж байна уу?

-Нөгөө нэг алагддаг эмэгтэй ...

-Түүнийг хэн ч алаагүй. Тэр амьд байгаа.

Мелина итгэж ядсан янзтай толгой сэгсэрч,

-Байж боломгүй юм. Түүнийг алсан хүмүүсийг чинь тэгээд ... цаазаар авчихсан шүү дээ.

Ламброу дүү охиныхоо гараас барьж,

-Мелина минь, Ларри Дуглас, Ноэлль Пейж хоёр чинь Кэтринийг алаагүй. Шүүх хурал явагдаж байх үеэр Демирис түүнийг нууж орхисон байсан юм гэлээ.

Мелина балмагдсан байдлаар үг хэлэх чадвараа алдан гэртээ хал8т харсан хүүхнийг гэнэтхэн саначихлаа.

"-Үүдний өрөөнд надтай дайралдсан хүүхэн юун хүүхэн бэ?

-Миний ажиж төрлийн холбоотны маань найз бүсгүй байгаа юм. Тэр Лондонд миний конторт ажиллах юм.

-Тэр хүүхэн чинь чиний нэг нисгэгч байсан залуугийн эхнэрийг надад сануулчихлаа. Гэвч тэд түүнийг алж орхисон болохоор тийм байх боломжгүй л дээ.

-Тиймээ. Тэд түүнийг алчихсан."

Мелина энэ яриаг өөрийн мэдэлгүй эргэн санав. Тэгээд эцэст нь үг хэлэхтэйгээ болж,

-Спирос ах аа, би тэр хүүхнийг гэртээ байхыг харсан. Тэр үед Коста надад худал хэлсэн байна гэж хэллээ.

-Нөхөр чинь галзуу хүн. Чи минь тэр галзуугаас л холдож бушуухан нэг тийшээ одвол зохилтой байна.

-Үгүй дээ, энэ бол миний гэр гэж хүүхэн аяархан хэлэв.

-Мелина минь дээ, хэрвээ чамд ямар нэг муу юм тохиолдвол би л лав үүнийг давж гарж чадахгүй байх.

Хүүхний хоолойд төмөр мэт хатуу өнгө цухалзан,

-Та зовох хэрэггүй дээ. Надад юу ч тохиолдохгүй. Коста тэнэг хүн биш болохоор надад муу юм хийвэл их үнээр төлнө гэдгээ сайн ойлгож байгаа гэж шийдмэг хэлэв.

-Тэр хэдийгээр чиний нөхөр боловч чи нөхрөө даанч таниагүй хүн юм даа. Би л чиний төлөө айх юм гэж дэмий л хэлээд ах нь дүүгээ сэнхрүүлж огт дөнгөөгүйгээ ойлголоо.

-Хэрэв чи эндээс явахыг хүсэхгүй байгаа бол түүнтэй хоюулахнаа хэзээ ч үлдэхгүй гэж надад амлаач.

-Амлая л даа гэж хэлээд хүүхэн ахынхаа хацрыг илбэсэн боловч амлалтаа яг таг биелүүлнэ гэсэн санаагүй байлаа.

Константин Демирис тэр орой гэртээ ирээд эхнэр нь хүлээж байхтай таарав. Тэр толгой дохин унтлагынхаа өрөө рүү ороход Мелина араас нь дгаан орж,

-Ярилцах хэрэгтэй болоод байна гэвэл Демирис цагаа харамхийлснээ,

-Надад ердөө хэдхэн минутын л зав байна. Уулзалтанд хожимдмооргүй байна.

-Чи чинь яаж орхих нь энэ вэ? Өнөөдөр хэн нэгнийг бас алахаар завдаж байгаа юм биш биз?

-Чи юундаа уурлаад байгаа юм бэ?

-Спирос өнөө өглөө ирсэн.

-Чиний тэр өөдгүй ахад миний гэрээс холхон бай гэж хэлэх хэрэгтэй юм байна л даа.

-Энэ чинь миний ч гэр Коста! Тэгээд ч бид ярилцах хэрэгтэй шүү.

-Нээрээ юу? Тэгээд юун тухай тэр билээ?

-Чиний тухай. Кэтрин Дугласын тухай бас Ноэль Пейжийн тухай.

Нөхрийнх нь харцанд сонирхсон байдал тодрохыг тэр ажлаа.)-Хуучны явдал байна даа.

-Тийм гэж үү? Тэр хоёр гэмгүй хүнийг цаазалсан гэж Спирос хэлсэн.

-Ах Спирос чинь мангуу хүн гэдгийг чи одоо болтол мэдээгүй юм уу?

-Тэр хүүхнийг би энд гэртээ харсан шүү дээ, Коста.

-Чамд хэн ч итгэхгүй биз. Тэгээд ч чи түүнийх дахиад харахгүй. Би тэр талаар санаа тавьсан байгаа.

Яг тэгэхэд л Мелина гэрт нь оройн хоол зооглохдоо ирсэн гурван хүнийг саналаа. "Та нар маргааш өглөө эрт Лондон нисэцгээнэ. Тэнд очоод хэрэгтэй бүхнийг сайн биелүүлнэ гэдэгт би итгэлтэй байна" гэж Демирис тэднийг явахад хэлж байсан билээ.

Демирис Мелина руу тонгойн аяархан дуугаар,

-Би чиний тэр ах болон чамаас бүр залхаж гүйцсэнийг мэдэж байна уу? гээд гарыг нь чанга барьж,

-Спирос намайг бүх юмнаас минь салгах гэж оролдсон. Тэр намайг бүр алахыг хүссэн. Тэгээд чадаагүйдээ та хоёр хоюулаа харамша болно доо гэвэл,

-Болиоч, өвдөж байна гэж хүүхэн гонгинов.

-Хонгор эхнэр минь, чи одоохондоо өвдөлт гэдэг юу болохыг хараахан мэдээгүй байна гээд гарыг нь тавьснаа,

-Би чамаас сална. Надад жинхэнэ эмэгтэй хүн хэрэгтэй болохоос чи биш. Гэвч би бас чамайг мартажгүй ээ. Надад найдсаны хэрэг байхгүй. Чи болон чиний ахад зориулсан сайхан төлөвлөгөө надад байгаа. За за ерөнхийдөө бид ярилцчихлаа. Одоо чамайг болгоовол би хувцасаа сольж өмсмөөр байна. Хатагтай нарыг хүлээлгэх зохисгүй хэрэг гэв.

Демирис ингэж хэлээд хувцасныхаа өрөөний хаалгаар орж харагдахаа болив. Мелина зүрхнийхээ цохилтыг чагнан зогссоор хоцрохдоо "Тэр үнэхээр солиотой хүн юм байна. Спирос зөв хэлжээ" гэж бодлоо.

Хэдийгээр хүүхэн яаж ч чадахгүйгээ мэдсэн боловч өөрийнхөө төлөө лав өчүүхэн ч айж сүрдсэн юмгүй байв. "Юуны төлөө ч гэж амьдрах билээ?" гэж тэр гунигтайгаар бодов. Нэр төр удам угсаагаа дээдлэх сэтгэлийг нөхөр нь түүни хувьд үгүй хийж өөрийнхөө түвшинд аваачсан. Гадны хүмүүсийн дэргэд өөрийг нь хэрхэн доромжлон басдагийг Мелина саналаа. Найз нөхөд танил хүмүүс нь түүнийг ихэд өрөвддөгийг тэр мэднэ. Үгүй ээ, тэр өөрийнхөө төлөө одоо айхгүй болсон байв. "Би үхэхэд бэлэн байна. Гэвч би түүнд Спиросыг баллахад нь саад болох ёстой!". Түүнийг барьж тогтоохын тулд юу хийвэл зохилтой вэ? Спирос хичнээн хүчирхэг байлаа ч Демирис түүнээс илүү. Хэрэв өөрөө л ямар нэгэн арга бодож олохгүй бол нөхөр нь сүрдүүлгээ хэрэгжүүлнэ гэдэгт Мелина эргэлзсэнгүй. "Түүнийг яаж ийгээд зогсоох хэрэгтэй. Харин ямар арга байна? Яаж зогсоох вэ?"

Хорин нэгдүгээр хэсэг

Афинаас ирсэн төлөөлөгчдөд Кэтрин бүхий л цаг заваа зарцуулж байв. Тэр Лондон дахь үйл ажиллагааны журамтай танилцуулахаар ажилчидтайгаа уулзалт маягийн юм зохион байгуулжээ. Тэд ч Кэтрины ажил хэрэгч чанарыг үнэлж, аль ч салбарын талаар мэдлэг сайтайг нь биширч байлаа.

Кэтрин өглөөнөөс орой болтол ажиллах бөгөөд хувийн амьдралынхаа талаар бодох ч зав түүнд байсангүй. Төлөөлөгчидтэй энэ хооронд ойр дотно танилцаж тэдний талаар багагүй зүйл мэдэх болжээ.

Жерри Хейли гэрийнхэн дотроо өөдгүй амьтанд тооцогддог байжээ. Эцэг нь баян нефтийн үйлдвэрийн эзэн харин өвөг эцэг нь хүндтэй шүүгч хүн байв. Жерри харин машины хулгай, хүчингийн хэргээр 3 жил шоронд суугаад гарчээ. Гэрийнхэн нь түүнээс салахын түүс болж Европ руу явуулсан боловч тэрээр бүх хуучин муу зуршлаа орхиж амьдралаа шинээр эхлүүлсэн гэж Кэтринд сайрхан ярьсан билээ.

Ив Ренард бол гомдомтгой нэгэн. Кэтрин түүний тухай эцэг эх нь түүнээс татгалзаж, тэр холын хамаатныдаа өссөн бөгөөд бүгд л түүнийг дарлан доромжилдог байсан тухай мэдэж авав. Хамаатных нь Вишигийн ойролцоо нэг фирмтэй ба түүнийг өглөөнөөс орой болтол борви бохис хийлгэлгүй зарцалдаг байснаас арван таван насандаа тэндээс оргон зайлахад хүрчээ.

Амьдралын баяр баясгалан дүүрэн итали эр Дино Маттуси Сицилид төржээ. Түүний эцэг эх нь гайгүй хангалуун хүмүүс байжээ. 16 насандаа тэр өөрөөсөө арав гаруй эгчмэд хүүхэнтэй нөхцөж томоохон дуулиан дэгдээжээ.

-Өө ! Тэр ёстой гайхамшигтай байсан!

-Тэгээд дараа нь юу болсон бэ? гэж Кэтрин асуув.

Тэр санаа алдан байж,

-Тэр нөхрийнх нь уур хилэнгээс намайг аврахын тулд Ром руу гэрт маань буцаасан.

Кэтрин инээмсэглэн,

-Ойлгомжтой. Тэгээд та хэзээнээс ноён Демирисынд ажиллах болсон юм бэ? гэвэл тэр хариулахаас булзав.

-Нилээд сүүлд. Би олон л юм оролдож үзсэн. Есөн жорын ажил хийж үзлээ. Талхаа олох гэж юу эсэ хийв дээ.

-Дараа нь та эхнэртэйгээ танилцсан уу? гэсэнд,

-Энд эхнэр маань алга байна шүү дээ хэмээн Дино Кэтрины нүд рүү ширтэн харж хэлжээ.

Тэр хүн түүнийг харж, түүнтэй ярилцаж, дуу хоолойг нь сонсож сүрчигний нь үнэрийг үнэрлэж байв. Тэр хүүхний талаар цөмийг олж мэдэх юмсан гэж бодно. Хөдөлж аяглах нь юутай таатай гэж бодоод тэр хүн ямар ч хувцасгүй нүцгэн байгаагаар хүүхнийг төсөөлнө. Удахгүй түүний нүцгэн биеийг хоёр нүдээрээ харах болно. Тун удахгүй харна. Бушуулаасай билээ!

Кэтриний өрөөнд Жерри Хейли орж ирэн,

-Кэтрин, та театрт очих дуртай юу? гэж асуулаа.

-Тиймээ, гэхдээ ...

-Өнөөдөр "Файнианы солонго" дуурийн анхны тоглолт болно. Очиж үздэг юм билүү гэж бодож байна.

-Танд би биьлэт захиалаас өгөх үү?

-Ганцаараа явах дургүй хүн л дээ, би. Та надад хань болохгүй биз?

-За тэгье гэж Кэтрин эргэлзсэн янзтай дуугараад түүний байнга саваагүйтэн хөдлөх аварга том гарыг өөрийн эрхгүй ширтлээ.

-Яасан сайн юм бэ! Тэгвэл долоон цагт миний өрөөнд ирнэ үү.

Тэрний үг тушаал шиг сонсогдлоо. Түүнийг гарч одсоны дараа Кэтрин "Сонин хүн юм. Ямар ч л гэсэн нөхөрсөг илэн далангүй санагдах юм" гэж бодлоо. "Би хуучны хамаг муу зуршилаа орхисон" гэсэн үгийг эргэн санаад Кэтрин түүний аварга том гарыг дахин дурслаа.

Жерри Хейли Кэтриныг "Савой" зочид буудлын амрах өрөөндөө хүлээж байв. Тэр театр руу лимузин машинаар хамтдаа явцгаалаа.

-Лондон ч аугаа сайхан хот юмаа. Би наашаа ирэх болгондоо баярладаг. Та харин энд амьдраад удаж байна уу? гэж Хейли асуухад Кэтрин,

-Хэдэн сар л болж байна гэсэнд,

-Та Нэгдсэн улсаас ирсэн үү? гэв.

-Тиймээ, Чикагогоос.

-Бас л сүрлэг сайхан хот доо. Би тэнд цагийг муугүй өнгөрүүлдэг байсан.

"Хүүхэн хүчирхийлж явсан байх даа?" хэмээн Кэтрин дотроо бодлоо.

Жүжиг дуусаж тэд гадагш гарлаа.

-Сайхан үдэш байна. Машинаа явуулж орхиод Хайд паркаар явган алхая гэж Хейли Кэтринд

санал болгов.

-Би маргааш өглөө эрт ажилтай болохоор дараа больё гэж Кэт хариулсанд Хейли гайхалтай сонин инээснээ,

-Тэгэлгүй яахав. Цаг олдоно гэж хариуллаа.

Ив Ренард музей ихэд сонирхоно. Франц эр Кэтринд,

-Парис хот олон сайхан музейтэй шүү. Та Луврт очиж үзсэн биз дэ? гэхэд нь,

-Үгүй шүү. Би Парист хэзээ ч очиж үзээгүй гэж Кэтрин хэлэв.

-Харамсалтай юм. Тийшээ заавал явах хэрэгтэй шүү. Би Лондоны музейг үзэж сонирхомоор байна. Бямба гаригт тийшэ явцгаавал ямар вэ?

Контор дахь ажил нь хөглөрч бямба гариг хүртэл ажиллахаар төлөвлөж байсан Кэтрин хүүхэн зочдоо харж хандахыг хүссэн Демирисийн гуйлтыг санаад,

-Тэгье ээ. Бямба гаригт больё.

Түүнд энэ франц эртэй цуг музей үзэж сонирхох хүсэл байсангүй. "Тэр их уйтгартай байх юм. Одоо болтол гомдсоор л явдаг юм байх даа?" гэж хүүхэн бодно.

Сайхан дөрө байв. Тэд эртний үзмэрүүд бүхий музейн танихмуудаар орж явсаар. Ив Ренардын юу нь ч юм бэ Кэтриний сэтгэлийг ихэд зовоож чухам юу болохыг мэдэх хүртлээ бас нэг цаг өнгөрчээ.

Тэд адмирал Нильсоны гарын үсэгтэй бичгийн дэргэд очиход,

-Миний бодлоор хамгийн сонирхолтой үзмэр бол энэ. Энэ бичиг баримт тулааны өмнө бичигдсэн бололтой. Нильсон өөрийгөө бүрэн эрхтэй гэдэгтээ итгэдэггүй байсан, та ойлгож байна уу гэж Кэтрин ярив.

Хүүхэн гэнт дагуул нь түүний яриаг огт сонсохгүй байгааг мэдэрлээ. Бас тэнд байгаа үзмэрүүдийн нэг нь ч тааний сонирхлыг татахгүй байгааг ч мэдэж авав. "Тэгээд яах гэж музей үзмээр байна гэсэн бол доо?" гэж Кэтрин гайхан бодов.

Дараа нь тэд Викториа ба Альбертин музейд очлоо. Тэнд бүх зүйл урьдынхтайгаа адил давтагдав. Ив Ренард танхимуудаар орж үзэхээс гадна дуу алдан бишрэх боловч санаа бодол нь огт өөр газарт нисэж явааг Кэтрин ойлгож авчээ.

Дууссаны дараа Кэтрин түүнд,

-Вестминстерин сүмд очих уу? гэж санал болгосонд зөвшөөрчээ.

-Өө, тэгье, тэгье. Тэгэлгүй яахав гэж Ив Ренард дуртайяа зөвшөөрчээ.

Тэд бүх дэлхийд алдартай сүмд очицгоон түүхэн алдартай хүмүүс, яруу найрагчид, улс төрийн зүтгэлтнүүд, хаад ноёдын бунхан тэргүүтнийг үзэж сонирхлоо.

-Хараач, энд Роберт Браунингийн бунхан байна гэж Кэтрины дуу алдахад Ив Ренард хөл доорхоо хараад,

-Өө Браунинг уу, цааш явья гэжээ.

Кэтрин тэндээ зоогдсон мэт зогсоод араас нь харан "Тэр юугаа эрсэн юм бол?" гэж гайхширчээ.

Буцах замдаа Ив Ренард,

-Танд гялайлаа, хатагтай Александр. Надад маш их таалагдлаа гэв.

"Тэр худлаа ярьж байна. Гэвч яах гэж тэр вэ?"

-Солсбери орчимд бойлолтой Стоунхенж гэдэг сонин газар байдаг гэж би сонсож байсан юм байна.

-Тийм газар бий гэж Кэтрин батлан хэлэв.

-Дараачийн бямба гаригт тийшээ очмоор байна гэхэд нь сонирхолтой байна гэдэгт нь эргэлзэж байсан хэйд ч Кэтрин,

-Дуртайяа очъёо хэмээн зөвшөөрлөө.

Дино Маттуси бол ёстой нэг хоолонцор хүн байлаа. Нэг удаа тэр гартаа хотын түүх дурсгалт газруудыг тэмдэглэсэн зургийг барьсаар орж ирээд,

-Энд Лондоны хамгийн сайн зоогийн газруудыг бас тэмдэглэсэн байна. Та үүнийг юу гэж бодож байан? хэмээн асуув.

-Ерөнхийдөө би...

-Сайн байна. Өнөөдөр "Коннот"-д оройн хоол идье.

-Өнөөдөр би...

-Ямар ч шалтаг хэрэггүй. Би таныг авахаар 8 цагт ирнэ.

-Тэг дээ гэж Кэтрин эргэлзэнгүй хэлэв.

Хоол ер бусын амтлаг байж таарав. Зууш идэж эхлэх үед Маттуси,

-Та сэтгэл татам сайн хүн юм даа, Кэтрин. Би америк хүүхнүүдэд хачин их дуртай гэж хэлэв.

-Тийм үү? Таны эхнэр америк хүн үү?

-Үгүй, итали эмэгтэй. Гэхдээ л бүгдийг ойлгодог юм.

-Та азтай хүн юм.

-Тиймээ, их азтай шүү.

Амттан зооглох үеэр л Дино зориглон асуусан нь,

-Та хотоор аялах дуртай юу? Миний найз машинтай. Ням гаригт жаахан аялбал яанамв?

Кэтрин татгалзахыг завдсанаа гэнэт Уймыг санагуут түүний үнэхээр их ганцаарддагийг бодон,

-Сайхан сонсогдож байна гэлээ.

-Таныг стэгэл хангалуун үлдэнэ гэдгийг амлаж орхиё.

-Бид Уймыг аваад явбал татгалзахгүй биз дээ?

Маттуси толгой сэгсрэн,

-Тэр машин багтаамж их муутай гэж толгой сэгсрэн хариулав.

Афинаас ирсэн зочид их олон янзын шаардлага тавих тул Кэтринд ажлаа амжуулах цаг зав бараг олдохгүй байжээ. Хейли, Ренард, Маттуси гурав хэдэн удаа Уймтай уулзаж дараагаар нь түүнд хандах тэдний хандлага өөрчлөгдсөнийг Кэтрин анзаарчээ.

-Тэр тооны машин огт хэрэглэдэггүй юм уу? гэж Хейли гайхав.

-Хэзээ ч хэрэглэхгүй.

-Ийм юмтай учирч явсангүй.

Кэтрин Атанас Ставичыг л харах болгондоо хачирхан гайхдаг байжээ. Өглөөд бүхнээс эрт ирж оройдоо хамгийн сүүлд явна. Тэрээр үргэлж инээмсэглэн тал засахад бэлэн байдаг нь Кэтринд дагжин чичирсэн бяц хан гөлгийг ямагт санагдуулна. Магадгүй түүнтэй хэрцгий харьцаж хэзээ ч сэргэхгэйгээр зүрх сэтгэлийг нь үхүүлсэн бололтой. Алан Гамильтон эмчтэй түүний талаар заавал ярилцана гэж Кэтрин дотроо шийджээ. Өөртөө итгэлтэй болоход нь Алан заавал туслах байх"

-Хөөе, хөвгүүн чамд дурлаж орхижээ гэж нэг удаа Эвелин түүнд хэлэв.

-Чи хэнийг хэлээд байнаа?

-Атанасыг хэлж байна. Тэр чамайг яаж хардгийг чи ажаагүй гэж үү? Хаягдсан золгүй амьтан шиг чамайг үргэлж дагаж явдаг шүү.

-Чамд л тэгж санагдсан байлгүй дээ гэж Кэтрин хөхрөн хэлэв.

Нэг удаа хүүг өрөвдөн зоогийн газарт хоолонд уривал,

-Зоогийн газарт ... гэнээ?

-Тэгэлгүй яахав.

Хөвгүүний царай улайж,

-Мэдэхгүй байнаа, хатагтай Александр. Хэрэв та бид хоёрыг хамтдаа байхыг хүн харвал танд эвгүй байх байх даа гээд ноорхой хувцас руугаа зовсон янзтай харлаа.

-Би хүмүүсийг өмссөн хувцасаар нь дүгнэдэггүй. Би ширээ захиалчихсан шүү гэлээ.

Кэтрин хөвгүүнийг дагуулан холгүйхэн орших зоогийн газарт орвол харсан болгоноо баахдсан хүү,

-Би насандаа ч ийм газар ирж үзээгүй. Энд ямар гоё юм бэ гэлээ.

Кэтриний сэтгэл хөдөлж,

-Юу дуртайгаа захиал л даа гэв.

Хүү цэсийг харж хэсэг сууснаа толгой сэгсрэн,

-Хэтэрхий үнэтэй юмаа гэсэнд Кэтрин инээмсэглэн,

-Энэ талаар бүү санаа зов. Чи бид хоёр чинь маш баян хүнд алба хашдаг шүү дээ. Биднийг сайн хооллоод авахад тэр хүн лав дургүйцэхгүй байх гэлээ.

Хоолны үнийг өөрөөсөө төлөх гэж байгаагаа Кэтрин түүнд хэлсэнгүй.

Атанас хөнгөн зууш, шарсан дэгдээхүй төмстэй бас амттан гэхээр шоколадтай бялуу, мөхөөлдөс захиаллаа.

Түүний идэж байгааг Кэтрин гайхан харна.

-Чи бүгдийг нь идэж орхио юу?

-Би хэзээ ч таргалж тэнхрэхгүй байхаа хэмээн хүү хулчиганан дуугарав.

-Атанас, чамд Лондон таалагдаж байна уу?

-Ямар ч гэсэн энд миний харсан болгон надад таалагдлаа.

-Чи Афинд зарлага хийдэг байсан юм уу?

-Ноён Демирисийнд хэмээн толгой дохиход хоолойд нь гуниг тодорлоо.

-Ажил чинь чамд таалагддаг биз дээ?

-Би ингэж ярих ёсгүй ч байж мэднэ, тиймээс өршөөгөөрэй, гэвч надад ноён Демирис тийм ч сайн хүн шиг санагддаггүй. Тэр надад таалагдаггүй гээд хэн нэгэн хүн сонсож орхих вий хэмээн эмээсэн янзтай эргэн тойрноо харснаа,

-Тэр ... за за, зүгээр дээ гэлээ.

Кэтрин ярианы сэдвийг өөрчлөн,

-Чи Лондонд яах гэж ирсэн юм бэ? гэж асуухад Атанас маш аяархан ярьсан тул Кэтрин юу ч олж сонссонгүй.

-Чи юу гэв ээ?

-Би эмч болох хүсэлтэй.

Хүүхэн сонирхосон янзтай харвал,

-Тиймээ, хатагтай. Мэдээж их тэнэг сонсогдож байгаа л даа гээд жаахан тээнэглзсэнээ үргэлжлүүлэн,

-Би Македонд төрсөн хүн. Тэгээд л амьдрал туршдаа манай тосгонд туркууд хэрхэн дайран орж хүмүүсийг алж талж байсан тухай сонсож байлаа. Тэнд шархтнууд тоогүй олон харин эмч огт байгаагүй гэдэг. Тэгээд л би эмч больё гэж шийдсэн. Одоо тосгон ч гэр маань байхгүй болсон хэдий ч дэлхий дээр шархтан олон хэвээр болохоор би тэдэнд туслах хүсэлтэй гээд доош харан,

-Магадгүй та намайг солиорчээ гэж бодож байгаа байлгүй гэлээ.

-Үгүй гэж Кэтрин аяархан хэлээд,

-Ёстой сайхан санаа гэж би бодож байна. Тэгэхээр чи Лондонд анагаах ухаан судлахаар ирсэн юм биз дээ?

-Тиймээ, хатагтай. Би өдөр нь ажиллаад орой нь суралцана. Заавал эмч болно гэх дуунд нь хатуу шийдсэн өнгө тодорно.

-Би чамд итгэж байна. Бид энэ талаар дахин ярилцана аа. Чамд туслах найз надад бий. Дараачийн долоо хоногт уулзаж ярилцаж болох сайхан зоогийн газар би мэднэ гэж хөвгүүнд хэлэв.

Шөнө дундад Спирос Ламброугийн харшид бөмбөг дэлбэрлээ. Дэлбэрэлтэнд байшингийн нүүрэн тал өртөж хоёр зарц амь үрэгджээ. Ламброугийн унтлагын өрөө тэр чигээрээ тоос болон агаарт дэгдсэн боловч тэр эхнэртэйгээ хотын даргын хүлээн авалтанд явахаар эцсийн

мөчид шийдсэн нь л амьд үлдэх ганц боломж болжээ.

Маргааш өглөө нь "Капиталистуудад үхэл" гэж бичээд доор нь "Грекийн хувьсгалт нам" гэж гарын үсэг зурсан бичиг албан тасалгаанд нь иржээ.

-Тэд яагаад чамайг оролдох болов оо? гэж сандарсан Мелинаг асуухад,

-Тэдэнд ингэх учир байхгүй. Энэ бол Костагийн гараар хийгдсэн ажил гэж Спирос сүртэй хэлэв.

-Чамд... чамд баталгаа байхгүй.

-Надад тэр чинь огт хэрэггүй. Ямар хүнтэй сууснаа чи одоо ойлгов уу?

-Би ... юу бодохоо ч мэдэхгүй байна.

-Энэ хүнийг амьд байгаа цагт чи бид хоёрын амьдрал байнга аюулд байх болно. Түүнийг юу ч зогсоохоос өнгөрсөн.

-Тэгвэл цагдаагийн газар мэдэгдээч.

-Нотолгоо байхгүй гэж чи өөрөө хэлээ биз дээ. Тэд нүүрэн дээр минь шоолон инээцгээх болно гээд дүүгийнхээ гарыг барьж:

-Чамаас гуйя. Эндээс холдож яваач гэлээ.

Мелина дуугүй зогсож байснаа дараа нь нэгэн шийдвэр гаргав бололтой.

-За тэгье, Спирос минь, би яах ёстой вэ түүнийгээ л хийе.

-Сайн байна. Санаа зовох хэрэггүй, Бид түүнийг заавал зогсоох арга олно.

Олон өдөр хоногийн турш Мелина өрөөндөө суугаад байдлыг эргэцүүлэн боджээ. Нөхөр нь түүнийг ахтай нь хамт устгахаар эрс шийдсэнийг ойлгов. Тэр үүнд нь саад болох ёстой. Тэдний төдийгүй Кэтрин Дугласын амьдралд ч аюул нүүрлээд байна. "Тэр Демирисийн Лондон дахь конторт ажилладаг" гэж хэлсэн. Түүнд мэдэгдэх хэрэгтэй. Гэхдээ би үүнээс илүү зүйл хийж чадна. Би Костаг зогсоох ёстой. Тэр дахиад хэнд ч хор хүргэж чадахгүй болно. Харн яаж тэр вэ?

Мелина гэнэт энэ асуултынхаа хариуг олоод,

-Тэгэлгүй яахав, яагаад энэ санаа урьд нь төрсөнгүй вэ? гэж гайхан бодлоо.

Хорин хоёрдугаар хэсэг.

Задруулахыг хориглоно.

Кэтрин Дугластай хийсэн ярилцлагын хуулбар.

К: Хоцорсонд уучлаарай, Алан. Манай конторт хурал хийгээд сая л дууслаа.

А: Зүгээр дээ. Афинаас ирсэн төлөөлөгчид Лондонд байсаар л байгаа юм уу?

К: Тиймээ, тэд дараачийн долоо хоногийн сүүлээр явна.

А: Таны сэтгэл хөнгөрсөн аястай байх юм. Тэдэнтэй байх хэцүү юу?

К: Хэцүү биш л дээ, зөвхөн... Нэг л тийм санагдаад...

А: Хачин гэн ээ?

К: Тайлбарлахад хэцүү байна. Тэнэг сонсогдох боловч тэд нэг л сонин хүмүүс юм.

А: Тэд ямар нэг хийгээ...

К: Үгүй дээ. Тэдэнтэй хамт байхад би тайван биш байх юм. Шөнө би дахиад л хар дарсан.

А: Таныг живүүлэх гэж оролдоод байсан тэр зүүд үү?

К: Нэг хэсэг би энэ тухай зүүдлээгүй байснаа одоо дахин зүүдэллээ. Гэхдээ арай өөрөөр.

А: Ямраар гэж?

К: Илүү бодитойгоор. Урьд нь дуусдаг байсан газраа дуусалгүй цааш үргэлжжилсэн.

А: Таныг живүүлэхийг оролдсон үеэс хойш болсон явдлыг та саналаа гэж үү?

К: Тиймээ, тэд намайг живүүлэх гэж оролдсоны дараа би аюулгүй газарт очсон байх юм.

А: Сүмд үү?

К: Тийм ч их итгэлтэй биш байна. Цэцэрлэгт бололтой, эрэгтэй хүн намайг гар дээрээ өргөн явж байсан. Урьд нь зүүдэндээ би түүний царайг огт харж чаддаггүй байсан. Энэ удаад бол тод харсан.

А: Та түүнийг таньсан уу?

К: Тиймээ. Константин Демирис байсан.

А: Тэгэхээр таны зүүдэнд...

К: Алан! Энэ зүүд биш харин жинхэнэ дурсамж. Константин Демирис надад алтан зүү бэлэглэхийг би санасан.

А: Энэ бүгдийг бодитой болсон явдал гэж хэлэх гээд байна уу? Та...

К: Би мэднэ. Демирис сүмд байхад надад алтан сүлбээр зүү бэлэглэсэн юм.

А: Нуурын уснаас гэлэнмаа нар таныг аварч авчирсан гэж та урьд нь ярьсан байх аа?

К: Тиймээ, үнэн.

А: Кэтрин, таныг сүмд байсныг хэн нэгэн хүн мэдсэн үү?

К: Үгүй, тэгэж бодохгүй байна.

А: Тэгвэл таны тэнд байсныг Демирис л мэдэж байжээ?

К: Мэдэхгүй ээ. Тийм л байсан. Би айсандаа цочоод сэрсэн. Энэ зүүд надад сануулга юм шиг гэнэт санагдсан. Ямар нэгэн аймшигтай юм болох гээд байгааг би мэдэж байна.

А: Заримдаа хар дарсан зүүд бидэнд тэгж нөлөөлдөг шүү дээ. Шөнийн аймшиг бол хүний эртний дайсан. Үлгэр домогт бол эгрийн онгон сахуйс буруутай бөгөөд өглөө дөрвөн цагаас хойш зүүдэнд ордог юм.

К: Тэгээд та үүнийг жинхэнэ болсон явдалтай холбоотой гэж бодохгүй байгаа юм уу?

А: Заримдаа тийм л байдаг. Колриж бичихдээ "Зүүд үргэлж хоосон зүйл байдаггүй харин үнэн бодит амьдралын золгүй явдал" гэж бичсэн байдаг.

К: Магадгүй би дэндүү хурцаар хүлээж аваад байх шиг байна. Хэрэв энэ аймшигт зүүд үгүй сэн бол миний бүх юм хэвийн сайхан байхсан. Өө тийм, би танд нэг хүний талаар ярих гэсэн юм.

А: Хэний тухай?

К: Түүний нэрийг Атанас Ставич гэдэг. Лондонд анагаах ухаанд суралцах гэж ирсэн залуу байгаа юм. Түүний амьдрал их хэцүү байсан бололтой. Би таныг түүнтэй уулзаж зөвлөгөө өгөх байх гэж бодож байна. Танд би солиотой хүн шиг санагдахгүй байна уу?

А: Бидний сэтгэл зүрх хүнийг эрүүл ухаантай байна уу үгүй юу гэдгийг ялгадаггүй юм.

К: Ноён Демирис надад алтан сүлбээр зүү өгч байна гэж зүүдлэх үед...

А: Тэгээд?

К: Би "Тэр чамайг ална" гэх дууг сонссон.

"Энэ бол азгүй тохиолдол байх ёстой. Хэн ч түүний хүүрийг таних ёсгүй". Түүнийг янз бүрийн аргаар алж болно. Бэлтгэлээ эхлэх хэрэгтэй. Тэрээр оронд хэвтээд сэрэл тачаал нь хөдөлтөлөө энэ талаар бодлоо. Аллага бол хамгийн хүчтэй дур ханалт. Эцсийн эцэст яаж хөдлөхөө тэр бодож олов. Маш энгийн.

Таних нь бүү хэл цогцос ч үлдэхгүй гээч. Ноён Демирис үүнд сэтгэл хангалуун үлдэх болно...

Хорин гуравдугаар хэсэг

Демирисийн далайн эргийн байр Пирейгээс хойд зүгт гурван миль орчимд орших далайн яг эрэг дээрх хэдэн акр газрыг эзэлнэ. Демирис оройн долоон цагт тийш очиж машинаасаа буугаад байр руугаа алхав.

Ойртож амжаагүй байхад нь хаалга нь онгойж танихгүй хүн гарч ирээд түүнд,

-Оройн мэнд, ноён Демирис гэлээ.

Үүдний өрөөнд өөр зургаан цагдаа байхыг Демирис олж харав.

-Энд юу болоод байна? гэж Демирис ширүүн дуугаар асуув.

-Би цагдаагийн дэслэгч Теофинос байна. Би...

Демирис түүнийг түлхэж орхиод байшинд оров. Зочны өрөө тэр аяараа эмх замбараагаа алджээ. Хараажаар нүсэр зодоон болсон нь илт. Ширээ сандлууд онхолдон унаж шалан дээр Мелинагийн уранхай даашинз хэвтэнэ. Демирис түүнийг авахдаа юу ч ойлгоогүй байдалтай харагдана.

-Миний эхнэр хаа байна? Би түүнтэй энд уулзах ёстой байсан юм.

-Тэр энд алга гэж дэслэгч хэлээд:

-Бид байшин доторхийг нэгд нэгэнгүй нэгжиж шалгасан. Одоо шарлагын газар л үлдээд байна. Танай эдлэнд дээрэмчид халдсан бололтой.

-Тийм байна, харин Мелина хаа байна? Тэр өөрөө та нарыг дуудсан уу? Тэр энд байсан болов уу?

-Тиймээ, эрхэмээ. Байсан гэж бодож байна гээд түүнд эмэгтэй хүний цаг үзүүлэв. Цагны шил харгарч зүү нь гурван цаг дээр зогсчээ.

-Энэ таны эхнэрийн цаг мөн үү?

-Мөн шиг байна.

-Ар таган дээр нь "Хайрт Мелинад. Коста" гэж бичжээ.

-Тэгвэл түүнийх мөн байна. Төрсөн өдрөөр нь бэлэглэсэн юм.

Дэслэгч Теофинос хивсэн дээрх цусан толбыг зааж,

-Энд цус дуссан байна гээд шалан дээрээс хутгыг ишинд нь гар хүргэхгүйг хичээн авлаа.

-Та энэ хутгыг таних уу, эрхэмээ?

Демирис хутгыг харж,

Үгүй. Та нар түүнийг үхсэн гэж хэлэх гээд байна уу?

-Бид тэгж хэлэх гээгүй байна. Гэхдээ цусны дусал далайн эрэг хүртэл үргэлжлээд ус руу орж алга болсон байна.

-Бурхан минь! гэж Демирис дуу алдав.

-Хутганы ишин дээр хурууны тодхон хээ байна.

-Тэгвэл та нар алуурчныг барьж чадах нь.

-Манай бүртгэлд түүний хурууны хээ байвал бид амархан барьчихна. Өрөөөгөөр хаа сайгүй хурууны хээ байна. Таныг зөвшөөрвөл би таны хурууны хээг бас авч орхиё, ноён Демирис. Таныхыг бусад хүний хээнүүдээс ялгаж авмаар байна.

-Тэгэлгүй яахав.

-Тэр түрүүч дээр та очно уу.

Гартаа хурууны хээ буулгавч зөөлөвч барин зогсох түрүүч рүү Демирис явж очлоо.

-Эрхмээ, та хуруунуудаа энд тавина уу. Та зөвөөр ойлгоорой. Энэ зөвхөн ёс төдий зүйл шүү.

-Ойлгож байна.

Дэслэгч Теофилос Демирист нэрийн хуудас сарвайж,

-Та энэ зүйлийн талаар юу мэдэх вэ, ноён Демирис? гэж асуув.

Демирис түүнийг харвал: "Мөрдөх товчоо "Кателанос" Хувийн захиалга авна" гэсэн бичиг байлаа. Тэрээр хуудсыг буцаан өгч,

-Үгүй. Энэ тэгээд их чухал уу? гэлээ.

-Мэдэх юм алгаа. Зүгээр, бид шалгах болно.

-Та бүхнийг буруутныг олоход бүх хүчин чармайлтаа дайчилна гэдэгт итгэж байна. Эхнэрийн талаар ямар нэг юм олж мэдвэл надад мэдэгдээрэй.

Дэслэгч Теофилос түүн рүү харж толгой дохиод,

-Та бүү санаа зов. Заавал мэдэгдэнэ эрхмээ гэлээ.

Мелина алтан шаргал үстэй, эелдэг танхилхан зугаатай бас ухаалаг бүсгүй байлаа.

Эхэндээ бүх зүйл ямар гайхалтай байв. Дараа нь тэр гэдсэн дэх хүүгээ алж үүнийхээ төлөө

өршөөл уучлал хүртэлгүй байсаар зөвхөн үхэл л түүний бурууг цагаатгахад хүрчээ.

Маргааш өглөө нь Константин Демирисийг зөвлөгөөнд сууж байтал нарийн бичгийн дарга нь,

-Өршөөгөөрэй, ноён Демирис гэлээ.

-Надад битгий саад бол гэж би хэлсэн шүү дээ.

-Тиймээ, эрхмээ. Гэхдээ байцаагч Лаванос утасдаж яаралтай уулзах хэрэгтэй байна гэлээ. Түүнд юу гэж хэлэх вэ?...

-Хэрэггүй. Би өөрөө түүнтэй ярья гээд Демирис зөвлөгөөнд оролцогсод руу хандан,

-Уучлаарай намайг женгельменүүдээ гээд харилцуур авч,

-Демирис сонсож байна гэлээ.

-Ахлах мөдрөн байцаагч Лаванос тав Байрнаас ярьж байна. Ноён Демирис танд дуулгах мэдээлэл манайд байна. Цагдаагийн хэлтэст та ирж чадах уу?

-Танайд миний эхнэрийн талаар мэдээлэл байна уу?

-Би энэ талаар утсаар яримааргүй байна, таныг татгалзахгүй бол тэр шүү дээ.

Демирис хором хэртэй тээнэгэлзсэнээ,

-Одоохон очлоо гээд харилцуураа тавьж нөгөөдүүл рүүгээ эргэн,

-Яаралтай чухал хэрэг гарлаа. Та нар цайны газарт ороод миний саналын талаар ярилцаж бай. Би эргэж ирэнгүүтээ энэ талаар авч хэлэцэнэ гэлээ.

Тэнд байгсад зөвшөөрч байгаагаа илэрхийллээ. Таван минутын дараа Демирис эхсэг дээр хэдийнэ очсон байлаа.

Комиссарын өрөөнд түүнийг зургаан цагдаа хүлээж байсан нь эргийн харшид очиж байсан хүмүүс мөн байлаа.

-Энэ бол онцгой хэргийн мөрдөгч Дельма...

Дельма гэдэг нь өтгөн хөмсөгтэй дугуй царайтай нягталсан хурц нүдтэй намхан эр ажээ.

-Юу болоо вэ? Та нар миний эхнэрийн талаар шинэ зүйл олж мэдээ юу?

-Үнэнийг хэлэхэд бидэнд байгаа баримтууд нилээд будлиантай болж орхиод байна, ноён Демирис. Таныг бидэнд тусална гэдэгт найдаж байна.

-Тусалж чадна гэдэгтээ эргэлзэж байна. Энэ бүхэн намайг бүр цочирдуулж гүйцлээ...

Өдрийн гурван цагийн орчим та тэр байшинд эхнэртэйгээ уулзах болзоооти байсан юм уу?

-Юу? Үгүй. Хатагтай Демирис над руу утасдаж долоон цагт ирэхийг надаас гуйсан юм..

Байцаагч Дельма түүн рүү анхааралтай ширтэн,

-Энэ л биднийг гайхуулж орхиод байна даа. Танай шивэгчин эмэгтэй хээлхдээ таныг өөрөө хоёр цагийн үед утасдаж наран шарлагын газарт гурван цагт уулзахыг хүсээд тэндээ үхлээж байя гэсэн гэж мэдүүлсэн.

Демирис хөмсөг зангидан,

-Тэр андуурсан бололтой. Эхнэр маань өөрөө над руу ярьж долоон цагт уулзья гэсэн шүү дээ.

-Шивэгчин андуурсан байх нь.

-Хараажаар илт байна.

-Харин эхнэр тань юуны учир тантай уулзах гэснийг та мэдэх үү?

-Бодоход тэр намайг гэр бүлээ бүү салгаач гэж ятгахыг хүсэх гэж байсан байх.

-Та эхнэрээсээ салах гэж байсан гэх гээд байна уу?

-Тиймээ.

-Шивэгчин хүүхний сонссон ярианаас үзвэл хатагтай Демирис өөрөө танаас салахыг шаардаж байсан гэнэ.

-Шивэгчний юу гэж хэлснийг би нулимж орхино. Энэ бүгд яг түүний хэлсний эсрэг болсон гэдгийг би батална.

-Ноён Демирис та эргийн харшдаа усны хувцсаа орхиогүй биз? гэж ахлах байцаагч асуув.

-Эргийн харшид уу? Үгүй шүү. Би далайд сэлэхээ болиод удаж байна. Хотын байшингийнхаа дэргэдэх усан санг илүүд үздэг.

Байцаагч ширээнийхээ шургуулгаа онгойлгон гялгар уутанд хийсэн хоёр гурван богино өмд гаргаж ирэн уутнаас гарган Демирис үзүүлэн,

-Таных мөн үү, ноён Демирис? гэж асуув.

-Минийх байх бүрэн боломжтой.

-Дээр нь таны нэрний эхний үсгүүд бичээстэй байна.

-Би таньж байх шиг санагдана. Тиймээ, минийх байна.

-Бид үүнийг танай эргийн харш дахь ханын шүүгээн дотроос олсон.

-Тэгээд юу гэж? Тэд эртнээс тэнд хэвтэж байсан биз. Ямар ...

-Эд хатаж амжаагүй байсан. Шинжилгэгээр далайн ус болох нь нотлогдсон. Нилдээ цусан толбо болсон байсан.

Байдал хурцдав.

-Тэгвэл хэн нэгэн хүн өмссөн байх нь гэж Демирис хатуухан хэлэв.

Онцгой хэргийн мөрдгөч,

-Ингэх нь хэнд хэрэгтэй юм бэ? Бидний санааг зовоогоод байгаа юмны нэг нь энэ байгаа юм гэлээ.

Ахлах байцаагч ширээн дээр хэвтэх бяцхан дутгуйг онгойлгон дотроос нь алтан товч гаргаж ирэв.

-Манай хүмүүсийн нэг нь энэ товчийг тэр байшингийн хивсний дор байхыг олсон. Таньж байна уу?

-Үгүй.

-Таны хүрэмнүүдийн нэгнийх. Бид зориг гарган өнөө өглөө танай хувцасны шүүгээг онгичуулан хүрэмнүүдийн тань товчийг шалгуулахаар явуулсан юм. Утас нь ч мөн байсан, Хүрмийг ердөө долоо хоногийн өмнө цэвэрлэгээнээс авсан байна.

-Би...

-Ноён Демирис, та эхнэртээ салах тухай хэлж тэр чинь таныг ятгах гэж байсан гэж нотлоод байна уу?

-Үнэн.

Ахлах байцаагч нэрийн хуудас авч өгвөл наран шарлагын газар үзсэн нөгөө мөрдөгчийн товчооных болох нь илт.

-Манай хүмүүсийн нэг өнөөдөр "Кателанос" мөрдөх товчоонд очиж уулзсан.

-Би энэ тухай анх удаа сонсож байна гэж хэлсэн шүү дээ.

-Таны эхнэр тэдэнд хандаж хамгаалахыг гуйсан байна.

Демирис биеэ барих чадвараа алдаж самгардан,

-Мелина юу даа? Хэнээс хамгаалуулах гэж?

-Танаас. Товчооны эзний хэлснээр бол танай эхнэр танаас салахыг шаардсанд та хариуд нь салбал ална гэж сүрдүүлсэн байна. Яагаад цагдаагийн газарт хандаагүйг нь асуухад эхнэр чинь шуугиан тарихыг хүсэхгүй байна гэж хэлсэн байна.

Демирис босож,

-Энэ бүх хуурмаг явдлыг би цаашид сонсож тэвчигүй нь. Та нарт ... байхгүй.

Ахлах байцаагч дахин ширээний шургуулганаас дугтуй гаргаж ирсний дотор энэ удаад хутга байлаа.

-Та урьд нь үүнийг огт хараагүй гэж хэлсэн билүү?

-Гарцаагүй үнээн.

-Хутган дээр таны хурууны хээ байгааг та юу гэх вэ?

-Миний... миний хурууны хээ юу? Энд ямар нэг алдаа гарчээ. Ийм байж таарахгүй.

-Түүний тархи учир томгүй хурдтайгаар ажиллаж байв. Тэрээр энэ бүх баримтуудыг эргэцүүлэн ... эхнэрийнхээ утасдсан яриа... шивэгчний эмдүүлэг...товч...хутган дээрх цусан толбо болон хурууны хээг...бодлоо.

-Мулгуунууд аа, та нар харахгүй байна уу? Намайг хэрэгтэн болгох гэж бүх талаар оролдсон байна шүү дээ. Хэн нэгэн хүн энэ өмднүүдийг байшинд аваачиж, цусанд дүрээд, хутгыг цусанд бялдаж, товч хүрэмнээс салган авсан байна.

Онцгой хэргийн мөрдөгч түүний үгийг таслан,

-Ноён Демирис, хутган дээр хурууны чинь хээ яаж гарсныг тайлбарлах гэж биеэ зовоосны хэрэггүй дээ...

-Би мэдэхгүй байна... Хүлээгээрэй. Аа саналаа. Мелина надаас уутны амсар огтлоод өгөхийг гуйж байсан юм байна. Магадгүй түүний өгсөн хутга наадах чинь болж таарах нь дээ. Хээний учир ингээд олдлоо.

-Тийм байж. Уутан дотор юу байсныг мэдсэн үү?

-Үгүй, би зөвхөн уяаг нь тасдаж өгсөн. тэр уутныхаа амсрыг онгойлгоогүй.

-Та хивс болон элсэн дээр цусны толбо дусаасныг хэлж өгч чадах уу?

-Энэ ойлгомжтой байна шүү дээ. Тэрээр өөрийгөө хөнгөхөөн гэмтээж орхиод усны зах хүртэл цусаа дуслуулаад та нарын намайг алсан гэдэгт итгүүлэх гэж роолджээ. Тэр намайг сална гэсний хариуд дөнгөх гэж оролдож байгаа юм болов уу... Одоо тэр хаа нэгтээ нуугдаж орхиод цагдаа нар намайг баривчилж байгааг харан тавлаж суугаа. Мелина амьд мэнд байгаа гэдгийг би батлая.

-Тийм байгаасай гэж хүсүүштэй боловч өнөө өглөө бид түүний цогцсыг уснаас татаж гаргасан. Эхлээд хутгалж алаад дараа нь живүүлсэн байна. Ноён Демирис, бид таныг эхнэрээ алсан хэрэгт сэжиглэн баривчлахаас өөр аргагүй боллоо гэж онцгой хэргийн мөрдөгч ширүүн хэлэв.

Хорин дөрөвдүгээр хэсэг

Эхэндээ Мелина хэрхэн бодсоноо гүйцэлдүүлэхээ мэдэхгүй байв. Гэхдээ нөхөр нь ахыг нь алах гэж байгааг сайн мэдэж байсан учир үүнийг зөвшөөрч явч чадахгүйгээ мэдэж байлаа. Костаг зогсоох арга байх л ёстой. Түүний өөрийн амь амьдрал хамаагүй. Түүний хувьд өдөр бүхэн дарлал доромжлол дунд өнгөрдгөөс хойш амьдрал утгаа алдсан. Анх нөхөрт гарахын цагт "Чи түүнтэй гэрлэж болохгүй. Тэр чинь мангас, махчин амьтан. Тэр чамайг үгүй хийнэ" гэж хэлж байсан ахынхаа үгийг тэр үед тоогоогүй юмсанж. Тэгэхээр одоо өөрийнхөө нөхрийг устгах хэрэгтэй болоод байв. Харин яаж хийх вэ? "Коста яаж хидг, яг түүн шиг сэтгэ" гэж өөртөө хэлэв. Тэгээд ч тэр ёсоор бүгдийг хийжээ. Өглөө гэхэд бүх юм бэлэн босон байв. Цаашдаа бүх зүйл энгийн хялбар боллоо.

Мелина Демирисын өрөөнд орвол тэр ажлаа хийж байлаа. Мелина гартаа уяагаар боосон амтай уут барьсан байх агаад нөгөө гартаа гал тогооны хутга барьжээ.

-Коста, чи энийг тасдаад өгөхгүй юу? Би чадахгүй байна.

Демирис ууртай толгой өндийн,

-Чи чинь яаж байгаа чинь энэ вэ? Хутганы ирнээс хэн барьж байлаа? Зарц нараас нэгийг нь гуйж болсонгүй юу? гэж хэлээд хутгыг бариулаас нь авч олсыг тасдаад өгөв.

-Май гээд өгсөн хутгыг Мелина ирэн дээрээс нь болгоомжтой авснаа эр нөхөртөө хандан,

-Коста цаашид ийм байдлаар байж болохгүй биз. Чи үнэхээр намайг хайрлахаа больчихлоо гэж үү дээ? Би одоо болтол чамд хайртай шүү. Хамтдаа бид ямар аз жаргалтай байсныг мартлаа гэж үү? Бал сарын анхны шөнийг чи санаж байна уу? ... гэлээ.

-Христийг бодоод ойлгож үзээч. Бүх юм дууссан. Чи надад хэрэггүй. Эндээс Тонил цаашаа. Цахамайг харахаас дотор муухайрч байна гэж огцом хэлэв.

Мелина түүнийг харж удаан зогслоо. Эцэст нь аяарханаар,

-За яахав. Хүссэнээрээ л бол до гэж дуугараад хутгаа бариж эргэж өрөөнөөс гарлаа.

-Чи ууттайгаа мартчихлаа! хэмээн араас нь Демирис хашгирсан болвч Мелина хэдийнэ өрөөнөөс гараад явсан байлаа.

Мелина нөхрийнхөө хувцасны шүүгээг онгойлгон хэдэн арван хүрэм өлгөөстэй байхыг харж нэг товчийг нь таслан авч халаасандаа хийв. Дара нь дотуур хувцасны шүүгээг онгойлгож нөхрийнхөө нэрний эхний үсэгтэй богино өмд гаргаж авав.

"За ингээд боллоо"

"Кателанос" товчоо нь Софлеоус гудамжинд хуучин туйпуун байшинд байдаг аж. Мелина товчооны эзэн ноён Кателаносын өрөөнд ороход уруул дээрээ нарийхан живэр сахалтай

духнаасаа халцарч яваа хүн угтав.

-Өглөөний мэнд, хатагтай Демирис. Танд юугаар туслах уу?

-Би хамгаалал эрж явна.

-Ямар?

-Мини нөхрөөс намайг хамгаалаач.

Кателанос хөмсөг зангидан гай зовлон үнэртэх шиг болсонд царайгаа барайлгав. Энэ бүхэн ёстой санамсаргүй боллоо. Демирис шиг ийм том хүний хэрэгт оролцоно гэдэг дэндүү утгагүй хэрэг.

-Та яагаад цагдаагийн газарт хандая гэж бодохгүй байгаа юм бэ?

-Чадахгүй ээ. Хүмүүс шуугиан тарахаас би айж байна. Би нөхрөөсөө салахыг хүсэж байгаагаа хэлсэн боловч тэр намайг ална гэж сүрдүүлсэн. Тэгээд л би ирсэн юм.

-Ойлгомжтой. Биднээс яг юу хүсэж байгаа юм бол?

-Манай гэрт хамгаалах хүн тавьж өгнө үү?

Кателанос Мелинаг анхааралтай ширтлээ. "Ямар үзэсгэлэнтэй хүүхэн бэ! Тэгээд бараг солиорохын даваан дээр байгаа бололтой" гэж бодов. Ийм хүүхэнд нөхөр нь муу юм хийнэ гэхэд санаанд багтамгүй юм. За тэгээд гэр бүлийн хэрүүл маргаан их л удаж хэд хоноод намдах байлгүй. Тэр хооронд хүүхэн надад овоохон зоос шидэх байх гэж давхар санаа өвөрлөөд Кателанос азаа үзэхээр шийдэв.

-Тэгье. Надад тохирох сайн залуу бий. Хэзээ түүнийг явуулах вэ?

-Даваа гаригт.

"Тэгэхээр түүний зөв байх нь. Яарах юм алга."

Мелина босож,

-Би утасданаа. Танд нэрийн хуудас бий юу? гэсэнд,

-Байлгүй яахав гээд нэг нэрийн хуудас өгч хаалга руу дөхүүлж өглөө.

"Аятайхан үйлчлүүгчид гэдэг ч энэ дээ. Түүний зөвхөн нэр нь л бусад үйлчлүүлэгчид сүрлэг сонсогдоно доо" гэж тэр бодно.

Мелина гэртээ буцаж ирээ ах руугаа утасдлаа.

-Спирос, надад сайхан мэээ байна гэж тэр сэргэлэн дуугаар хэллээ. -Коста эвлэрхийг хүсэж

байна гэв.

-Юу? Би түүнд итгэхгүй байна. Энэ бас л ов мэх...

-Үгүй дээ. Үнэн. Бие биетэйгээ дайсагналцах хичнээн тэнэг болохыг тэр ойлгосон. Гэр бүл дотор эв найрамдалтай байхыг тэр хүсэж байна.

Удаан дуугүй байснаа,

-Үнэндээ мэдэхгүй байна.

-Эцсийн удаа түүнд боломж өгөөч. Тэр өнөөдөр 3 цагт Акрооринф дахь байранд чамтай уулзъя гэсэн шүү.

-Энэ чинь машинаар 3 цаг явах газар шүү дээ. Яагаад хотод уулзах боломжгүй байгаа хэрэг вэ?

-Тэр үүнийхээ учрыг тайлбарлаагүй. Гэвч эвлэрлийн тухай яригдаж байгаа болохоор...

-За яахав, би очно. Гэхдээ зөвхөн чиний төлөө шүү.

-Бидний төлөө гэснээ,

-Үүрд баяртай гэж аяархан нэмж хэлэв.

-Баяртай.

Дараа нь тэр Демирисийн ажил руу ярилаа.

-Юу болоо вэ? Би завгүй байна гэх дуу сонсогдов.

-Саяхан Спирос ярилаа. Тэр чамтай эвлэрхийг хүсэж байна хэмээн Мелина хэлээд хариуд нь тачигнатал инээхийг дуулав.

-Вас хүсэх юмтай байх нь. Би түүнийг устгах цагт л тэр амар заяагаа үзэх байлгүй.

-Тэр цөөшид чамтай өрсөлдөхгүй гэсэн, Коста. Мөн чамд бүх флотоо худалдахад бэлэн байна гэж хэлсэн.

-Бүгдийг нь надад худалдах гэн ээ? Чи үнэн хэлж байна уу? гэх дуунд сонирхо цуурайтна.

-Тиймээ, тэр залхаж гүйцсэн гэсэн.

-За яах вэ. Надруу нягтлангуудаа явуулаг л даа.

-Үгүй ээ, тэр чамтай өнөөдөр 3 цагт Акрокоринф дахь байранд уулзъя гэсэн.

-Түүний байшинд уу?

-Тиймээ. Энэ чинь нилээд эртний бөглүүд газар л даа. Гэхдээ хэн ч та нарт саад болохгүй. Тэр чимээ шуугиан гарахаас айгаад байгаа юм.

"Мэдээж хүсэхгүй байлгүй яах вэ. Энэ тухай бусад хүмүүс мэвдэл түүнийг шоолон инээлдэх болно" гэж сэтгэл хангалуун бодоод,

-За яах вэ, би очно гэж хэл гэлээ.

Акрокоринф орох зам дэндүү урт аж. Замын хажуугаар өтгөн ногоон өвс халиуран усан үзмийн талбайн сайхан үнэр цитрусын анхилам үнэртэй хойлдон таатай нь аргагүй хамар сэнгэнүүлнэ. Спирос Ламброугийн бодлыг Демирис бүрэн эзэмджээ.

Спирос байранд түрүлж ирэв. Тэр байшингийн үүдэнд машинаа тулгаж зогсоогоод хэсэг зуур бодол болов. Демирис үнэхээр эвлэрэе гэж бодов уу эсвэл бас нэгэн заль мэх зохиож байна уу гэж эргэлзсээр. Ямар ч гэсэн түүнд муу юм болбол Мелина хаашаа явсныг мэдэх юм хойно айх зүйлгүй. Спирос машинаас бууж байшинд орлоо.

Коринф маягаар хийсэн сайхан байшин билээ. Бага ахуй цагтаа Спирос энд амралтын өдрөө авгайтайгаа ирж амардаг байв. Тэд уул руу явцгааж бяц хан шувууд агнадаг байж билээ. Энэ удаад харин хавьгүй том шувуу таарчээ.

Арван таван минутын дараа Демирис ирлээ. Спиросыг байшинд ирснийг хараад сэтгэл тэнийж давилуун зан нь оргилоод ирэв. Тэгээд машинаасаа бууж байшинд ороод тэд өөд өөдөөсөө харан дуугүй зогсоцгоолоо.

-Хүндэт ах минь, бид ингээд замынхаа төгсгөлд ирэх шив дээ гэж Демирис хэлэв.

-Энэ бүх ухаангүйдэл зогсох болсон гэж би маш ихээр хүсэж байна, Коста. Бид хэтэрхий удаан тулалдлаа.

-Чамтай үнэхээр санал нэгтэй байна. Чи хэдэн хөлөг онгоцтой билээ, Спирос оо?

Ламброу гайхан түүн тийш харж,

-Чи юу хэлэв ээ?

-Чамайг хэдэн онгоцтой вэ гэж байна. Би нэгийг ч үлдээлгүй худалдаж авья. Үнэ буулгах гэж өчүүхэн ч оролдохгүйгээр шүү.

-Миний онгоцнуудыг худалдаж авья гэнээ?

-Цөмийг нь авья. Тэгээд би дэлхий дээр хамгийн том флот эзэмшигч болох болно.

-Чи чинь солиоров уу? Яагаад намайг флотоо худалдана гэж бодоов?

Одоо Демирисийн гайхах ээлж иржээ.

-Бид тэгэх гэж л уулзаж байгаа юм биш үү?

-Чи эвлэрхийг санал болгосон болохоор л бид уулзаж байгаа шүү дээ.

Демирисийн царай бараантаж,

-Хэн чамд ийм тэнэг юм хэлэв ээ?

-Мелина.

Тэд юу болсныг бараг нэгэн зэрэг ухаарав.

-Тэр тэгээд намайг чамтай эвлэрхийг хүсэж байна гэж хэлээ юу?

-Тэр чамд намайг флтоо зарна гэж хэлсэн байх нь ээ?

-Тэнэг гичий. Тэр биднийг уулзуулж ямар нэг талаар тохиролцоо хийлгэж дөнгөнө гэж бодсон бололтой. Тэр Ламброу чамаас ухаан муутай, тэнэг амьтан юм. Та нараас болж хагас өдрийг дэмий үрж орхилоо.

Константин Демирис хурдхан эргэж байшингаас гарч явав. Спирос түүний араас харан зогсохдоо "Мелинад биднийг хуурах хэрэг байхгүй сэн. Тэр биднийг хэзээ ч хэл амаа ололцохгүй гэдгийг ойлгодог л байх ёстой доо. Ялангуяа одо бол бүр ч илүү. Хэтэрхий оройтож дээ, оройтож" гэж бодож байлаа.

Үдээс хойш нь Мелина шивэгчин хүүхнээ дуудаж,

-Андреа, надад аьга цай аваад ирээч гэж гуйлаа.

-Тэгье ээ, хатагтай гээд гарч арван минутын дара эргэж ирлээ. Эргэж ирэхд үедээ Андреа хатагтайгаа утсаар ярьж байхыг дуулав. Дуунд нь уур хилэн дүүрэн байх ажээ.

-Үгүй ээ, Коста, би шийдсэн. Би чамаас сална, гэхдээ аль болох их шуугиан тарихыг хичээнэ гэдгээ хэлчихье.

Гэр бүлийн хэрүүл маргаан болж байгааг гадарласан Андреа хүүхэн эвгүйцэн эргэтэл Мелина гар дохин түүнийг үлд хэмээн дохиод харилцуурт үргэлжлүүлэн хашгирч,

-Хичнээн л бол хичнээн занаж бай л даа, тэглээ гээд би бодлоо өөрчлөхгүй. Хэзээ ч ... Чамайг дахин сонсохыг ч хүсэхгүй байна ... Би чамаас айхгүй ээ, Коста ... Үгүй ... Ямар утгаар? ... За больж үз. Гэрийнхээ ойролцоо дэвсэг дээр уулзъя л даа. Гэхдээ энэ ямар ч ашиггүй гэж мэдэрэй. Би очноо, тийм. Цагийн дараа юу? За тэгье гэлээ.

Мелина ярьж дуусаад харилцуураа аажуухан тавилаа. Царайд нь түгшүүр илэрнэ. Тэгээд Андреа тийш эргэн,

-Би нөхөртэйгөө уулзахаар эргийн харш руу явлаа. Намайг зургаан цаг гэхэд эргэж ирэхгүй

бол цагдаа дуудаарай гэж тушаалаа.

-Жолоочоор хүргүүлэх үү?

-Үгүй. Демирис намайг ганцаараа ирнэ үү гэж хүссэн.

-Ойлголоо, хатагтай.

Бас нэг зүйл үлдээд байна. Юу гэвэл Кэтрин Александрын амь насанд аюул заналхийлж байгаа болохоор түүнийг анхааруулан дуулгах хэрэгтэй. Алуурчин нь тэднийд оройн хоол зооглосон гурван этгээдийн нэг байх ёстой. "Чи түүнийг дахиад харахгүй. Би энэ талаар аль хэдийнэ санаа тавьсан" гэж Демирис хэллүү.

Мелина нөхрийнхөө Лондон дахь контор руу утасдаад,

-Танайд Кэтрин Александр ажилладаг уу? гэж асуув.

-Тэр одоогоор алга байна. Өөр хэн нэг нь танд тусалж болох юм даа?

Мелина эргэлзлээ. Түүний дуулгах гэж байгаа зүйл гадны хүний сонорт хүрнэ гэхэд хэтэрхий осолтой байв. Гэвч тэр даруй Костагийн маган ярьж байсан сод ухаант хүн Уйм Вандиныг саналаа.

-Тэгвэл ноён Ванидныг дуудаж өгнө үү.

-Жаахан хүлээгээрэй.

Харилцуурт эрэгтэй хүний дуу гарч,

-Сонсож байна гэлээ.

Хүүхэн үгээ зовж байж сонгон,

-Би Кэтрин Александрт нэг үг дамжуулах гэсэн юм. Энэ маш чухал болохоор та дамжуулж тусална уу?

-Кэтрин Александр ий?

-Тийм ээ, түүний амь нас аюулд учраад байна гэж түүнд дамжуулна уу. Түүнийг Афинаас ирсэн төлөөлөгчдийн нэг нь алах гэж байна.

-Афин гэнэ ...

-Тиймээ,

-Афины хүн ам найман зуун жаран мянга ...

Энэ хүн түүнийг ойлгосонгүй гэсэн сэтгэгдэл түүнд төрөв. Гэхдээ тэр чадах бүхнээ хийсэн

учрас харилцуураа тавилаа.

Уйм ширээнийхээ ард суугаад саяхан утсаар дуулсан зүйлээ эргэцүүлэн бодсон нь: "Кэтрин александрыг алах гэж байна. Англид энэ жил 114 хүн амины хэрэг гарсан. Кэтрин Александр 115 дахь нь болно. Афинаас ирсэн төлөөлөгчид боох Жерри Хейли, Ив Ренард, Дино Маттуси гурвын нэг нь түүнийг ална гээд Уймын тооцоолон бодох машин шиг тархи эдгээр хүмүүсийн талаар мэдэх зүйлээ шинжилж үзээд: "Хэн болохыг нь би мэднэ" гэж дүгнэлээ.

Хожим Кэтринийг конторт эргэж ирэхэд Уйм утсаар сонссон зүйлийнхээ талаар юу ч хэлсэнгүй.

Алуурчныг тэр зөв таасан эсэх нь түүнд сонин байжээ.

Орой болгон Кэтрин зочдын хэн нэгэнтэй уулзах хэрэгтэй болно. Өглөө түүнийг ажилдаа ирэхэд Уйм хүлээн суж байдаг болов. Амьд мэнд хүрээд ирэхийг нь хараад урам хугарах шиг болно. "Түүнийг хэзээ алах юм бол доо? Утсаар ярьсан зүйлийн талаар түүнд хэлэх хэрэгтэй ч юм болов уу? Гэвч хэлвэл өөдгүй хэрэг болно л доо".

Хорин тавдугаар хэсэг

Эргийн харш хүртэл зам нэг цагийн газарт орших бөгөөд хорин жилийн дурсамжийг өгүүлнэ. Бодох ч юм, дурсах ч юм их байлаа. Залуу зандан байх үедээ Коста "Гоо үзэсгэлэн гэж юу байдгийг үхэх үйлтэй юмнуудад мэдүүлэхээр тэнгэрээс таныг илгээсэн гэдэг эргэлцээгүй. Танд бахдан бишрэх үгээ хэлээд ч багадна..." гэж хэлж байж билээ. Хөлөг онгоц дээр тэд ямар гайхамшигай цаг мөчийг өнгөрөөж, Псар арал дээр хичнээн тансаг амарч цэнгэлээ дээ. Тэр өдрүүд бол санамсаргүй үнэт бэлэг ар араас нь хүлээн авч шунал тачаал дүүрэн шөнүүдийг нисэх мэт худартайгаар өнгөрүүлж байсан үе сэн. Харин дараа нь энэ үр зулбалт болж Ноэль Пейжтэй холбоотой баахан таагүй явдлууд цуварсан. Тэгээд дээр нь хэрүүл доромжлол... Тэр хэлэхдээ: "Чамд амьдрах ямар хэрэг байна? Чи амиа хорлвол яасан юм бэ?" гэсэн. Бас сүүлд нь Спиросыг устгана гэж занасан.

Үүнийг л харин Мелина хүлээн зөвшөөрч огт чадахгүй.

Харшийн байшинд хэн ч байсангүй. Тэнгэрт бараан үүлс хуралдаж, далайгаас хүйтэн салхи үлээнэ. "Энэ бол тэнгэрийн дуудлага" гэж хүүхэн бодлоо.

Тэр нүдэнд дасал болсон танил авсаархан тавилгатай өрөөнд орж сүлчийн удаа тойруулан харлаа.

Дараа нь эд хогшлоо аажуухан хөдөлгөнөөр нурааж чийдэн хагаллаа. Даашинзаа тайлж шалан дээр шидэв. Цүнхнээсээ мөрдлөгийн агентлагийн хаяг бүхий хуудсыг гарган ширээн дээр тавьж ширдэг доогуур алтан товч шургуулж орхилоо. Дараа нь Костагийн бэлэглэсэн алтан цагийг гарнаасаа авч цохиж хагалаад шидчихэв.

Гэрээсээ авчирсан нөхрийнхөө дотуур өмднүүдийг авч гадагш гаран тэнгисийн усанд норгоод гэртээ эргэж ирлэ. Одоо ганц л зүйл үлдэв.

"Цаг болжээ" гэж тэр өөртөө хэлээд гүнзгий амьсгаа авснаа гартаа хоолны хутга авч бариулыг нь ороосон нимгэн цаасыг хөндөхгүйг хичээн болгомжтой барьж түүнийгээ ширтэн удаан зогслоо. Шийдвэрлэх мөч болох нь тэр. Энэ бүхэн санаатай үйлдэгдсэн аллага шиг харагдах ёстой. Төлөвлөгөө эцэст нь хүртэл амжилттай явуулахын тулд хүүхэн өөрийгөө хутгалах ёстой.

Ингэж бодоод хутгаа өргөж хажуу тал руугаа хүчтэй бүллээ. Цус садран гарахад нойтон өмднүүдийг шархан дээрээ нааж цус болгоод шүүгээний булан руу шидэв. Толгой нь эргэж эхэллээ. Тэр юу ч мартаагүй гэдэгтэ итгэхийн тулд эргэн хараад гуйвсаар гарав. Хивсэн дээгүүр болон далайн эрэг хүртэл элсэн дээгүүр цусан мөр тунаран үлдэнэ. Цус улам ихээр урсан гарахад хүүхэн "Би чадахгүй нь. Коста дахиад л өндөр аван гялалзах болно Үгүй, би түүнийг ингүүлэхгүй" гэж бодон ганц ганцаар урагш алхсаар байна.

"Зогсож болохгүй. Би үүнийг Спиросынхоо төлөө хийж байна. Хөөрхий хонгор ах Спирос" гэж бодон урагшилсаар.

Далай хүртэл асар хол байх шиг санагдана. "Нэг алхам, дахиад нэг..." гэж шивэгнэнэ.

Аймшигт өвдөлтийг тэсвэрлэн аажуухан алхсаар байв. Нүд нь юм харахаа байж өвдөг сөхрөн уналаа. "Үгүй, зогсож болохгүй" гэж бодоод арайхийн босож өөрийн ухаангүй шахам алхсаар усны захад хүрлээ.

Чанх дээр нь сүглийж байсан үүл аажуухнаар доошлохыг харав. Цусан судал татуулсаар нүдийг нь бүрхэх үед гэнэт гайхамшиг болж үүлнүд доошлон буужу ирээд түүнийг тэврэн энхрийлэхийг мэдэрлээ. Өвдөлт алга болж тайван амгаланд уусан ороход "Би гэртээ харьж явна. Арай гэж нэг юм гэртээ ирдэг байжээ" гэж баяртайгаар боджээ.

Хорин зургаадугаар хэсэг

"Бид таныг эхнэрээ алсан хэрэгт баривчлах хэрэгтэй боллоо"

Үүнээс хойших явдлууд яг л удаашрулсан кино зураг шиг болж өнгөрчээ. Түүнийг хянагчийн мэдэлд өгч хурууных нь хээг дахин авч дараа нь зургийг нь аваад камерт хийжээ. Түүнтэй ингэж харьцаж байна гэж бодоход итгэмээргүй санагдана.

-Питер Демонидосыг дуудагтун. Би яаралтай уулзмаар байна гэж хэл.

-Ноён Демонидос ажлаасаа халагдсан бөгөөд одоо мөрдөгдөж байгаа.

Хандах хүнгүй болсон байх нь э. "Би энэ бүхнээс мултрах л болно. Би чинь Константин Демирис шүү дээ" гэж тэр бодлоо. Тэгээд онцгой хэргийн мөрдөгчийг дуудахыг хүсэв.

Цагийн дараа Дельма шоронд ирж,

-Та надтай уулзах гээ юу? гэж асуулаа.

-Тиймээ. Миний ойлгосноор та нар миний эхнэрийг гурван цагт нас барсан гэж тогтоосон гэсэн байх аа?

-Тиймээ, яг үнэн.

-Би цаашид эвгүй байдалд удаан байхгүйн тулд энэ цаг мөчид Акрокорфинд байсан гэдгээ нотолж чадна.

-Та яаж нотлох юм бэ?

-Нотолгооноос ч илүү юм байна. Надад гэрч байгаа.

Спирос Ламброуг ирэхэд тэд цагдаагийн комиссарын өрөөнд сууцгааж байлаа. Демирис түүнийг хармагцаа царай нь гийж,

-Спирос минь, бурханы авралаар чи ирлээ шүү! Энэ тэнэгүүд намайг Мелинаг алсан гэж сэжиглээд байна. Тийм биш гэдгийг чи хэлээд өгөөч. Хэлээд өг тэдэнд гэхэд,

-Юу хэлэх юм бэ? гэж Спирос хөмсөг зангидан асуув.

-Мелинаг өчигдөр гурван цагийн үед алсан байна. Тэр үед чи бид хоёр Акрокоринфод уулзаж байсан биз дээ. Би машинаар тэндээс долон цагаас нана ирж чадахгүй нь ойлгомжтой. Тэнд уулзсан тухайгаа тэнд хэлээд өгөөч.

Спирос Ламброу үл ойлгосон янзтай харж,

-Юун уулзалт билээ? гэв.

Демирисийн нүүр рүү цус хуран,

-Өчигдөр өдөр .. бидний уулзалт. Яагаав Акрокоринф дахь байранд гэв.

-Чи нэг л андуураад байх шиг байна, Коста. Би өчигдөр ганцараа явсан. Чиний төлөө би худлаа хэлж чадахгүй.

Константин Демирис уурандаа шатан,

-Чи надтай ингэж харьцах учиргүй! гээд пиджакных нь захнаас шүүрэн авч: -Үнэнийг хэлэх үү, үгүй юу? гэлээ.

Спирос түүнийг түлхэж, -Үнэн гэвэл миний дүү нас барсан, түүнийг минь чи алсан гэлээ.

-Худлаа! Худал ярьж байна! гээд Демирис дахин түүн рүү давшлахад цагдаа нар түүнийг барьж тогтоов.

-Муу новш! Чи намайг буруугүй гэдгийг мэдэж байгаа шүү дээ!

-Буруутай эсэхийг шүүх л шийдэг дээ. Чамд сайн өмгөөлөгч хэрэгтэй гэж бодож байна.

Энэ л мөчид Константин Демирис хорвоо дээр ердөө ганц л хүн түүнийг аварч чадах байсныг ухаарлаа.

Тэр бол өмгөөлөгч Наполеон Чотас байсан юм.

Хорин долдугаар хэсэг

Задруулахыг хориглоно.

Кэтринтэй хийсэн ярилцлагын хуулбар:

К: Алан, та зөн билэгээ итгэдэг үү?

А: Шинжлэх ухаан нотлоогүй ч гэсэн итгэдэг ээ. Та юу зөгнөө вэ?

К: Би нэг л аймшигтай юм болох гэд байгааг зөгнөж байна.

А: Хуучин зүүдний чинь нэг хэсэг үү?

К: Үгүй, ноён Демирис Афинаас гурван төлөөлөгч ирүүлсэн гэж би ярьсан.

А: Тиймээ.

К: Тэр тэднийг харж хандахыг гуйсан болохоор нь би тэдэнтэй байнга уулздаг.

А: Тэдний зүгээс аюул занал ирэх юм шиг санагдаад байгаа юм уу?

К: Үгүй. Яг ч тим бишээ. Тайлбарлахад их хэцүү юм. Тэд яагаа ч үгүй боовч би нэг л ю болно доо гээд хүлээгээд байх юм.

А: Надад тэрнийхээ тухай ярич?

К: Нэг нь Ив Ренадр гэдэг франц хүн. Тэр надтай цуг музей үзье гэж шахаж шаардах мөртлөө тэднийг огт сонирхохгүй юм ... Дараа нь Жерри Хейли гэдэг америк харахад нүдэнд дулаахан хүн мөртлөө бас л нэг сонин нууц хүн. Гурав дахь нь итали эр Дино Маттуси гэгч Демирисийн компаний ажилтан, тэр өөрөө мэдэх мөртлөө маш олон асуулт тавиад л байдаг .. бас нэг зүйл байна.

А: Юу вэ?

К: Уйм сүлийн үед нэг л сонин болчихсон.

А: Юугаар илэрч байна?

К: Өглөө болгон намайг ажилдаа ирэхэд тэр намайг хүлээгээд зогсож байдаг болсон. Урьд нь огт тэгдэггүй байсан юм. Тэгээд намайг хармагцаа юунд ч юм ихэд уурсах шиг болдог. Утгагүй байгаа биз, тийм үү?

А: Бүх юманд учир байдаг юм, Кэтрин. Түлхүүрийг нь л олох хэрэгтэй. Дахиад зүүдэлсэнгүй юу ингэхэд?

К: Константин Демирисийг зүүдэлсэн. Гэхдээ би их муу санаж байна.

А: Санаж байгаа зүйлээ ярина уу.

К: Түүнээс яагаад надад ийм сайн байдгийг асуусан ...

А: Тэр юу гэж хариулсан бэ?

К: Мэдэхгүй ээ. Би хашгираад сэрж орхисон.

Алан Гамильтон эмч Кэтриний ярилцлагыг анхааралтай судалж дахин дахин сонсож чухам юу тэр хүүхнийг зовоогоод байгааг мэдэхийг оролдов. Афинаас ирсэн гурван хүн тэр хүүхэнд аймшигтай санагдсаны учир бол Кэтриний хувьд маш их зовлон үзсэн тэр газраас нь ирсэн болохоор тэр гэж Алан бодов. Харин Уймын тухай яриа түүнийг гайхуулж орхижээ. Кэтринд зүгээр тэгж санагдсан байж болох юм. Эсвэл үнэхээр Уйм хачин сонин авир гаргаад байгаа юм болв уу? Уймтай уулзах өдөр хэдэн хоногийн дараа товлосон байгаа. Түүнтэй аль болох хурдхан уулзах хэрэгтэй.

Кэтрин Алан Гамильтоны тухай бодлоо авч хаях гээд үнэндээ чадахгүй л байлаа. "Бүү тэнэглэ. Тэр чинь эхнэртэй хүн. Бүх эмчлүүлэгчид өөрийн эмчтэйгээ ийм харьцатай байдаг л байх" гэж тэр өөрөө өөртөө хэлэв. "Ер нь надад эмчээ солих хэрэг гарах нь дээ?" гэж бодлоо.

Кэтрин хоёр хоногийн дараа Алантай уулзах ёстой. "Хоолойгоо давгал намагт шигдчихээсээ өмнө больдог ч юм билүү. Хэтэрхий оройтож дээ" гэж Кэтрин бодлоо.

Алан Гамильтон дээр очих өглөөнөө Кэтрин үсчингээр орж үсээ нямбай сайн янзаллаа. "Өнөөдөр би түүнтэй сүүлчин удаа уулзах учраас аятайхан харагдахад болохгүй юм юу байх билээ?" гэж тэр бодсон байв.

Тэрнийг Аланы өрөөнд орж амжаагүй байхад л хамаг шийдвэр сарнин алга болжээ. "Яагаад тэр ийм аятайхан харагддаг юм бол, чөтгөр аваг? Яагаад би түүнийг ганц бие байхад нь учирч болоогүй юм бо? Би ямарч х дутагдалгүй жирийн хүн байхдаа учрахгүй яав аа? Гэвч надад өө сэв байгаагүй бол бид огт уулзахгүй байх байсан шүү дээ".

-Та юу хэлэв ээ?

Кэтрин бодож байснаа чанга хэлчихсэнээ ойлгов.

Сүүлчийн удаа түүн дэр ирж байгаагаа хэлэх цаг болжээ.

Тэгээд Кэтрин амьсгаа аван,

- Алан ... гээд хамаг зориг шийдвэр үгүй болов. Ширээн дээрх жаазтай зураг руу харан: -Та гэрлээд удаж байна уу? гэж асуувал,

-Гэрлээд ий? гэснээ доктор түүний харцыг дагуулан хараад, -Аа, энэ миний дүү бүсгүй хүүтэйгээ байгаа нь гэж хэллээ.

Кэтрин баяр хөөрөнд авгаж,

-Өө, ямар сайхан юм бэ! Би түүнийг ... сайхан хааргдаж байна гэж хэлэх гэсэн юм.

-Кэтрин, зүгээр үү?

Энэ асуултыг Кирк Рейнольдс байнга асуудаг сан. "Тэр үед бүх зүйл хэвийн биш байжээ. Харин одоо бол бүх зүйл хэвийн байна" гэж бодоод,

-Зүгээр. Та эхнэргүй юм уу? гэж асуув.

-Үгүй.

"Надтай цуг оройн хоол идэхгүй юу? Надтай унтах уу? Надтай гэрлэхгүй юу? хэмээн санаж байгаа бүхнээ асууж орхивол түүнийг лав эрүүл бус ухаантай байна гэж бодох байлгүй. Эсвэл ерөөсөө би болхоо байчихсан юм болов уу"

Тэр Кэтрин руу харан хөмсөг хөдөлгөн,

-Кэтрин, бид дахиад энд уулзаж болохгүй байх гэж айж байна. Өнөөдөр сүүлчийн удаа гэхэд хүүхний зүрх палхийж,

-Яагаад тэр вэ? Би болохгүй юм хийсэн ю уу? хэмээв.

-Танд учир нь байгаа юм биш. Манай мэргэжлийн зарчимд эмч хүн өвчтөнтэйгөө ямар нэг байдлаар холбоотой байж болдоггүй юм.

Одоо Кэтрин түүн рүү нүдээ гялазуулан харж,

-Та надад ямар нэг талаар холбоотой болчихлоо гэж хэлэх гээд байна уу? гэвэл,

-Тийм ээ, яг энэ шалтгаанаар ...

-Та үнэхээр зөв ярьж байна. Энэ тухай өнөө оройн зоогон дээр ярилцъя гэж Кэтрин баяртайгаар шулганалаа.

Тэд Сохогийн төвд орших бяц хан итали зоогийн газарт оройн зоог барилаа. Тэд юу идэж байгаагаа ч анхаарахгүй зөвхөн бие биенээ л залгичих шахан ширтэцгээнэ.

-Энэ чинь шударга бийш явдал шүү, Алан. Чи миний тухай бүгдийг мэддэг атал, би .. Өөрийнхөө талар яриач. чи эхнэртэй байсан уу?

-Үгүй. Нэг л удаа сүй тавьж үзсэн.

-Тэгээд яасан гэж?

-Дайн болчихсон. Бид бяц хан байранд хамтдаа амьдарч байсан тэр үед хотыг аймшигтайгаар бөмбөгдөж байлаа. Би эмнэлэгт орой болтол ажиллаад гэртээ харьтал ...

Дуунд нь гуниг сонсогдохыг мэдэрлээ.

- ... байшин маань байдаггүй. Юу ч үлдээгүй.

Хүүхэн гарыг нь атгаж,

-Надад их харамсалтай байна гэлээ.

-Би хэвийн байдалдаа орох гэж тун ч их удсан даа. Тэгээд л гэрлэчихмээр хүнтэй дахин дайралдаагүй.

Кэтрин түүний нүднээс: "Тэгэхдээ өнөөдрийг хүртэл дайралдаагүй шүү" гэсэн илт үг байхыг олж уншжээ.

Тэд зоогийн газарт бараг дөрвөн цаг шахам суж хорвоогийн есөн шидийн юм хамж шимэн ярилцаж театр эмнэлэг, улс төрийн талаар ч орхисонгүй. Харин гол асуудлаа л орхиод байв. Тэдний хооронд цахилгаан гүйдэл үүссэн мэт бие биедээ асар хүчит давалгаагаар татагдсаар байлаа.

Эцэст нь Алан асуудлыг төгсгөл болгохоор шулуудан,

-Кэтрин ээ, би чамд эмч өвчтөн хоёрын хоорондын харьцааны талаар ярьсан тэр зүйл бол ... гэсэнд хүүхэн үгийг нь таслан,

-Энэ тухай гэртээ очоод л надад хэлж өгөөрэй гэлээ.

Тэд зэрэг хоромхон зуур хувцсаа тайлцгаав. Кэтрин дашинзаа газарт унагах үедээ Кирк Рейнольдстой бүх юм хичнээн өөр байсныг санав. "Ялгаа нь гэвэл би одоо дурласанд байгаа юм. Би энэ хүнд хайртай".

Тэр оронд орж хэвтэн Аланыг хүлээлээ. Алан дэргэд нь хэвтэж тэврэн авахад түүний бүх айдас аюл болгоомжлол тэр чигтээ алга болж эрэгтэй хүнтэй хэзээ ч хамт унтаж чадахгүй байх гэсэн аймшигт бодол нь уусан ариллаа. Тэд бие биенээ энхрийлэнсээр тэсэж чадахаа болиход хүртэл тачаадан таалцгаав. Залуу түүнийг эзэмдэн авах үед Кэтрин аз жаргалдаа мансууран өөрийн эрхгүй дуу алдав. "Пөөх, би сая л өөрийгөө оллоо. Баярлалаа чамд"

Ядарч сульдсан тэд удаан хэвтэж Кэтрин Аланг чанга тэврэн хэзээ ч салмааргүй санагдана.

Тэр дахин ярих чадвартай болох үедээ л эрхэлнгүй дуугаар "Хүүе эмч ээ, та чинь өвчтөнтэйгөө ямар харьцаатай байгаагаа мэдэж байгаа биз?" гэж асуулаа.

Хорин наймдугаар хэсэг

Константин Демирисийг эхнэрээ алсан хэргээр баривчлагдсаныг сонингоос олж мэдлээ. Энэ явдалд Кэтрин их цочирджээ. Ажил дээрээ ирэдэх нь бүх ажилчин албан хаагчид шоконд орсон байв.

-Чи сонин уншив уу? Бид одоо яанаа? хэмээн эвелин ориллоо.

-Юу ч болоогүй юм шиг ажлаа үргэлжлүүлэн хийцгээе. Энэ ямар нэг аймшигтай алдаа гэдэгт би итгэлтэй байна. Түүнтэй холбоо барихыг оролдоё гэж хариулсан боловч тэр холбоо барьж чадсангүй.

Константин Демирис Афины төв шөрөнгийн хоригдлууд дотор хамгийн чухал хоригдол байв. Байцаагч түүнийг гадаад орчинтой ямар нэгэн харьцаа холбоотой байлгахгүй талаар санаа тавьжээ. Демирис харилцуур утас, телекс, зарлага өгөхийг шаардсан боловч түүнд татгалзжээ.

Өдрийн ихэнхийг тэр Мелинаг хэн алсан байж таарах вэ гэж тунгаан бодсоор өнгөрөөнө.

Эхэндээ гэрт нь дээрэмчин орсныг Мелина мэдчихээд тэр нь алж орхисон байх гэж боджээ. Гэвч бүх баримт түүний эсрэг байгаа болохоор түүнийг л хэрэгт унагах санаатайг ойлгов. Хэн тэр вэ? Спирос Ламброуг л хардвал хамгаас зохилтой атал Спирос энэ дэлхий дээр хамгаас хайртай дүүдээ муу юм хиймээргүй.

Дараа нь Демирис Тони Рицзолитой холбон бодож үзэв. Магадгүй тэд түүний юу хийснийг мэдээд хариугаа авч байгаа нь тэр юм болов уу? Гэвч тэр энэ бодлоос шууд татагалзав. Мафийнхан түүнээс өшөө авья гэсэн бол эхнэр хүүхнээр оролдохгүй шууд түүнийг алах байсан.

Ганцаар суугаад Демирис бүх талаас нь эргэцүүлэн бодож бусад боломжтой бүх зүйлүүдийг бясалган цорын ганц зөв дүгнэлтэнд хүрсэн нь: Мелина амиа хорложээ гэхдээ өрийн үхэлд түүнийг буруутгахаар бүгдийг бодож зохицуулсан байх нь. Ноэлль Пейж, Ларри Дуглас хоёртой хэрхэн тооцоо бодсоноо Демирис эргэн санах. Хоржоонтой хувь тавилан одоо түүнийг яг тэдэн шиг нөхцөл байдалд оруулжээ. Түүнийг хийгээгүй хэргийнх нь төлөө шүүх болно. Тэгээд яллана.

Шоронгийн харгалзагч түүнд,

-Таны өмгөөлөгч ирлээ гэж хэлэв.

Демирис харгалзагчийг даган явсаар байцаалтанд зориулагдсан жижигхэн өрөөнд очив. Тэнд Висалики гэдэг нэртэй тавь орчим насны өтгөн буурал үстэй, киноны од шиг зүстэй, гялалзаж яваа өмгөөлөгчид тооцогдож байгаа хүн түүнийг хүлээж байв. Эрүүгийн хэргээр тэр их юманд хүрсэн хүн юмсанж.

-Таны мэдэлд арван таван минут өглөө гэж харгалзагч хэлээд гарч явав.

-За тэгээд? гэж Демирис шаардангуй өнгөөр дуугаран,

-Та намайг эндээс гаргаж авахын тулд ю хийх гэж байна? Юуны төлөө би мөнгө төлөх вэ? гэлээ.

-Ноён Демирис, бүх зүйл амаргүй байна шүү. Ерөнхий яллагч татгалзсан ... гэтэл,

-Тэр чинь тэнэг мануухай. Тэд намайг энд суулгаад байх эрхгүй. Барьцаа тавих талаар юу бодож байна? Би хүссэн мөнгийг нь өгнө шүү.

Василики цухалдангуй уруулаа долоон,

-Таныг барьцаагаар суллуулах тухай санал тавьсанд тэд татгалзсан. Би цагдаагийнхны цуглуулсан эд мөрийн баримтуудтай танилцсан, хэрэг дэндүү ноцтой байна гэхэд нь Демирис,

-Ноцтой, ноцгүй нь хамаагүй. Би Мелинаг алаагүй. Би буруугүй гэв.

Өмгөөлөгч звшөөрөн толгой дохиод,

-Тэгэлгүй яах вэ, харин хэн алсныг нь та хэлж чадах у? ... гэлээ.

-Хэн ч алаагүй. Миний эхнэр амиа хорлосон.

Өмгөөлөгч түүн рүү гайхан харж,

-Өршөөгөөрэй, ноён Демирис, энэ бол өөрийгөө өмгөөлөх тийм чиг сайн арга биш гэж надад санагдаж байна. Та өөр үүнээс илүү юм бодож оох хэрэгтэй гэсэнд Демирис цухалдан байж өмгөөлөгчийн зөв болохыг ойлголоо. Нэг ч шүүгч үүнд итгэхгүй нь лав.

Маргааш өглөө эрт өмгөөлөгч хүрч ирээд,

-Би их муу мэдээтэй ирсэндээ харамсаж байна гэж хэлжээ.

Демирис тачигнатал инээх орхисонгүй арай гэж биеэ барив. Тэр хэдийнэ хүн амины хэрэгт сэжиглэгдээд шоронд сууж байхад энэ тэнэг толгой муу мэдээгээр бас айлгах гэнэ шүү. Ямар их гай вэ?

-Таныг сонсож байна.

-Энэ таны эхнэрийн ахад хамаатай юм.

-Спиростой юу? Тэгээд ю юм бэ?

-Тэр Кэтрин Дуглас нэртэй эмэгтэй одоо болтол амьд байгааг цагдаагийн газарт мэдэлсэн байна. Ноэль Пейж, Ларри Дуглас нарын хэргийг би сайн мэдэхгүй л дээ...

Гэтэл Константин Демирис хэдийнэ түүнийг сонсохоо больжээ. Энэ эх толгойгоо алдсан юманд ороолцолдоод тэр Кэтринийг бүр мартаж орхисон байв. Хэрэв түүнийг эрж олбол Ноэлли Пейж, Ларри Дуглас нарын үхэлд түүнийг буруутай гэж илчлэхүйц юм донгодож орхих нь мэдээж. Тэрэр түүний учрыг олуулахаар Лондон руу хэдийнэ хүн илгээсэн боловч хэргийг яаралтай гүйцэтгэх шаардлага тулгарчээ.

Тэгээд өмгөөлөгч рүүгээ бөхийн гарыг нь атгаад,

-Та Лондон руу яаралтай цахилгаан утас илгээх хэрэгэй байна гэлээ.

Тэрбээр цахилгаан утсыг хоёр дахь удаагаа уншаад бэлгийн дур хүсэл төрөхийг мэдрэв. Хэрэг шийдвэрлэх үедээ ойртох болгонд ийнхүү сэрэлд автдаг байжээ. Тэрээр өөрийгөө Эзэн Тэнгэр мэтээр сэтгэнэ. Хэн үхэх, хэн амьд үлдэх нь зөвхөн түүнээс л хамаарна. Тэр өөрийн эрх мэдэл дор хүмүүсийн амьдралыг барьж байдаг, түүгээрээ хүмүүсийг сөхрүүлдэг хэмээн сэтгэнэ. Одоо хэргийг яаравчлах хэрэгтэй болсон тул анх төлөвлөснөөрөө хийж чадахгүй нь. Гэнэтийн ан авлах цаг ирлээ.

"Золгүй явдал шигээр харагдуулах хэрэгтэй" гэсэн. Өнөөдөр орой л...

Хорин есдүгээр хэсэг

Задруулахыг хориглоно.

Уйм Вандинтай хийсэн ярилцлагын хуулбар:

А: Таны бие өнөөдөр ямар байна?

У: Хэвийн байна. Би хөлсний тэргээр ирлээ. Жолоочийг нь Рональд Кристи гэдэг. Үнэмлэхнийх нь дугаар 3011, таксины дугаар 30-17. Замдаа бид 37 "ровер", 1 "бентли", 10 "ягуар", 6 "остин", 3 "роллс ройс", 27 мотоцикл, 6 дугуйтай тааралдлаа.

А: Ажлаар сонин юу байна даа?

У: Та мэднэ шүү дээ.

А: Ярь л даа.

У: Тэднийг бүгдийг үзэн ядаж байна.

А: Тэгвэл Кэтрин Александр? ... Уйм, Кэтрин Александрыг юу гэж бодож байна, Уйм?

У: Аа тэр үү. Тэр удахгүй тэнд ажиллахаа болино.

А: Чи үүгээрээ юу хэлэх гэсэн юм?

У: Түүнийг ална.

А: Юу? Яагаад ингэж бодоо вэ?

У: Тэр надад хэлсэн.

А: Тэр гэж хэн? Кэтрин өөрөө юу?

У: Үгүй, өөр эмэгтэй.

А: Өөр ямар эмэгтэй?

У: Түүний эхнэр.

А: Хэний эхнэр?

У: Константин Демирисийн.

А: Тэр Кэтринийг ална гэсэн юм уу?

У: Тэр биш. Түүний эхнэр. Грекээс утасдсан.

А: Хэн Кэтринийг алах юм?

У: Энэ хүмүүсийн нэг нь.

А: Та Грекээс ирсэн хүмүүсийн нэг гэх гээд байна уу?

У: Тиймээ.

А: Уйм, яриагаа дуусгая. Би явах хэрэгтэй.

У: Тэгье.

Гучдугаар хэсэг

"Грекийн худалдааны корпораци"-ын контор зургаан цагт хаалаа. Хэдэн минутын өмнө Эвелин болон бусад албан хаагчид явахаар бэлдэж байв.

Эвелин Кэтриний өрөөнд орж ирлээд,

- "Критерион" кино театрт "34 дүгээр гудамжны аймшиг" гарч байна. Дажгүй кино гэж ярилцана. Өнөөдөр үзэх үү?

- Чадахгүй байх. Баярлалаа, Эвелин. Би Жерри Хейлитэй театр үзнэ гээд амлачихсан.

- Тэд чамд уйтгарлах ч зава өгөхгүй нь бололтой. За за, цагаа сайхан өнгөрүүлээрэй.

Бусад хүмүүсийн гарч явахыг Кэтрин сонслоо. Арай гэж нам гүм болов. Ширээн дээрх зүйлсээ эмхэлж тавиад хүрмээ өмсөн цүнхээ авч хонгилоор алхав. Бараг гарах хаалганы дэргэд хүрээд утас дуугархыг сонсов. Хариу өгөх үү яах вэ гэж жаахан эргэлзэж зогсло. Цагаа харвал болзооноосоо нилээд хоцорчээ. Утас үргэлжлэн хангинасаар. Кэтрин өрөө рүүгээ гүйн орж харилцуураа аваад,

- Сонсож байна гэсэнд,

- Кэтрин! гэх Аланы сандарсан дуу гараад,

- Бурханы авралаар би чамтай холбоо барьж чадлаа гэв.

- Ямар нэг юм болоо юу?

- Чамд аюул учраад байна. Хэн нэгэн хүн чамайг алах гэж оролдоод байх шиг байна.

Хүүхэн ёоллоо. Түүнийг нөмөрсөн аймшигт зүүд биелэлээ олж эхлэх шиг. Гэнэт толгой нь эргэж эхлэв.

- Хэн бэ?

- Мэдэхгүй. Гэхдээ чамайг хашаа ч битгий гар гэж хэлэх гэсэн юм. Хэнтэй ч бүү ярь. Би одоохон очлоо.

- Алан, би...

- Бүү зов, би одоо гарлаа. Хаалгаа сайн хааж түгж. Бүх юм сайхан болно гээд утсаа таслав.

- Бурхан минь!

Кэтрин харилцуураа тавилаа. Хаалган дээр Атанас үзэгдэв. Тэр Кэтриний царайг хараад хурдан алхлан ойртов.

-Ямар нэг юм болоо юу, хагагтай Александр?

Кэтрин түүн рүү эргэн,

-Хэн нэгэн хүн... намайг алах гэж байна гэв.

-Яагаад? Хэн... хэн ийм зүйл хийж чадах юм бэ?

-Мэдэхгүй ээ.

Гарах хаалгыг цохих чимэ дуулдав. Атанас Кэтрин рүү харан,

-Би онгойлгох уу? гэхэд,

-Үгүй. Хэнийг ч битгий оруулаарай гэж доктор Гамильтон хэлсэн. Тэр наашаа ирж яваа гэж Кэтрин сандран хэлэв. Дахиад л хаалга хүчтэй цохино.

-Хонгилд нуугдаж болох байхаа. Тэнд та аюулгүй гэж Атанас хэлэв.

Хүүхэн толгой дохин,

-Тиймээ гэв. Тэд гудмаар гүйж хонгил руу ордог хаалган дээр тулж ирлээ.

-Гамильтон эмчийн ирэхээр нь намайг энд байна гэж хэлээрэй.

-Та доор ганцаараа байхдаа айхгүй юу?

-Үгүй.

Атанас гэрэл асааж хүүхний өмнө орон шатаар уруудаж эхлэв.

-Эндээс таныг хэн ч олохгүй. Харин хэн таныг алах гээд байгааг та мэдэж байгаа юу? гэж асуулаа.

-Би итгэлгүй байна...

-Хэн гэдгийг нь би мэднэ гэж Атанас шивэгнэн хэлээд хүүхнийг харав.

Кэтрин гайхан харж,

-Хэн гэж? гэвэл,

-Би гэж хэлмэгц түүний гарт гэнэт хаанаас ч юм бэ хута бий болоод хүүхний хооойд тулгах нь тэр.

-Атанас, одоо тоглох цаг биш...

Хутга хоолойд нь тулж шигдэхийг мэдэрлээ.

"-Самара дахь уулзалт"-ыг уншсан уу? Кэтрин? Чи ер нь уран зохиол уншдаг уу үгүй юу? Тэгвэл одоо оройтож. Тэр зохиолд нэг хүн үхлээс зугтаж Самара ордог боловч яг Самарад түүний үхэл хүлээж байдаг юм. Чиний Самара чинь энд гэж мэд.

Энэ үгс гэмгүй гэнэхэн хөвгүүний амнаас гарч байна гэхэд дэндүү хатуу ширүүн сонсогдож байлаа.

-Атанас, гуйя. Чи болохгүй...

Тэр хүүхнийг алгадаад,

-Яагаад? Би жаахан хүү болохоор тэр гэж үү? Би чиний гайхлыг төрүүлж байна уу, тийм үү? Яагаад гэвэл би аугаа их жүжигчин. Би хэдийнэ гуч гарсан шүү, Кэтрин. Яагаад хүүхэд шиг харагддагийг минь мэдэх үү? Яагаад гэвэл би дандаа өлөн зэлмүүн, хоосон ходоодтой өссөн болохоор тэр. Хоол надад ямаг дутагддаг байсан. Би шөнийн цагаар угаадасны нүхнээс хог хаягдал олж иддэг байлаа гээд хүүхний хоолой руу хутгаа улам шигтэн хананд шахаж,

-Намайг жаахан байхад цэргүд мини эцэг эхийг хүчиндээд дараа нь хоолойгий нь огтлоод дараа нь намайг хүчиндэж зодож занчаад үхсэн гэж бодоод орхисон юм гээд Кэтриниг хонгилын гүн рүү улам түлхсээр байв.

-Атанас, би чамд хэзээ ч муу юм хийгээгүй... Би,

-Энд хувийн хонзогнол гэж байхгүй. Зөвхөн жирийн нэг даалгавар юм. Чамайг алаад л би 8000 доллар авна гэж Атанас хүүхдэрхүү инээмсэглэн хэлэв.

Түүний нүдний өмнүүр хөшиг буулгах шиг болж хамаг юм улаанаар бүрхэгдлээ.

-Чамд зориулж бэлтгэсэн сайхан төлөвлөгөө байсан юм. Даанч эзэн яаруулсан болохоор даруй хөдлөх хэрэгтэй болсон юм.

Хурц хутга улам шигдэж хоолойг нь зүсэж эхлэхийг Кэтрин мэдрэв. Тэр гарын гэнэтийн шалмаг хөдөлгөөнөөр хүүхний даашинзны дээрээс нь доош нь хүртэл цуу татаж орхив.

-Сайхан байна, тун сайхан. Эхлээд би чамаар зугаагаа гаргая гэж бодож байсан. Гэвч чиний найз наашаа замд гарсан болохоор бид яарах хэрэгтэй, тийм биз? Чи ч азгүй юм даа. Би ёстой эр хүн шиг эр хүн юм шүү гэв.

Кэтрин амьсгаадан зогсоно. Үг хэлж чадахаа больжээ. Атанас халаасаа уудлан цайвар өнгин шингэнтэй жижиг лонх гаргаж ирэв.

-Чи цахвганы дарс амсаж үзсэн үү? Алив, чиний азгүй явдлын төлөө ууцгаая гээд хутгаараа лонны бөглөөг хөшиж онгойлгов. Яг энэ үед Кэтрин зугатах найдвар тээн гялсхийсэн боловч амжсангүй.

-Уу, амс, чамаас гуйя гэж Атанас аяархан хэлэв.

Кэтрин арайхийн уруулаа доломдож,

-Сонс л доо, би чамд мөнгө өгье...мөнгө...Би...

-Хоолойгоо гамна гэж Атанас хэлээд шилтэйгээсээ том балгаснаа хүүхэдн өгч: -Уу гэж тушаав.

-Үгүй, би...

-Уу, чи!

Кэтрин шилтэйг авч ялигүй жаахан амсав. Гашуун архи хоолойг нь зуураад явчихсанд Атанас шилтэйг буцаан авч дахин том балгав.

-Тэр эмчид чамайг алах гэж байгаа тухай хэн дуулгаж орхив?

-Би... би мэдэхгүй байна.

-За, энэ хамаагүй гээд Атанас таазанд тулсан бүдүүн модон багана руу зааж: -Тэнд очиж зогс гэлээ.

Кэтрин хаалга руу хяламхийсэнд тэрхэн зуур хутганы ир хоолойд нь дахин шигдэж,

-Надаар хоёр дахин бүү хэлүүээрэй гэлээ.

Кэтрин баганы дэргэд очиж зогсвол,

-Сайн охин гэж Атанас магтад,

-Одоо суу гээд түрхэн зуур цаашаа харав. Үүнийг ашиглан Кэтрин үүд рүү харайлгав. Тэр шатанд тулж очин дээш нэг алхаад хоёр дахь гишгүүр дээр хөлөө тавих гэтэл Атанас хөлнөөс нь татан доош чирэн унагав. Тэр аймшигтай чадалтай ажээ.

-Гичий! гээд тэр хүүхний үснээс зуурч аван нүүрийг нь өөррүүгээ ойртуулан,

-Чамайг дахиад зугтах гэж оролдвол хөлийг чинь хуга цохино шүү гэлээ.

Хоёр далных нь хооронд хутгаар чичихийг хүүхэн мэдрэв.

-Хөдлөөрэй!

Атанас түүнийг багана руу чирч аваачин шалан дээр түлхэж орхиод,

-Чимээгүй суу гэв.

Атанас олсоор багласан цаасан хайрцаг овоолсон булан руу очиж олс тасдаж авахыг Кэтрин харлаа.

-Гараа багана дээр тавь, хурдал!

-Атанас, хэрэггүй л дээ. Би...

Атанас хүүхний шанаа руу хүчтэй цохиход бүх юм дайвалзаад явчихав. Атанас түүн рүү тонгойн,

-Надад "үгүй" гэж хэзээ ч битгий хэлж бай. Хоолойг чинь огтлоогүй байгаа дээр миний хэлснийг л хий, мэдэв үү? гэв.

Кэтрин баганы ардуур тойруулан тэврэхэд хормын дараа олс арьсанд нь чивчрэн оров. Гар нь дорхноо мэээ алджээ.

-Гуйя, ийм чанга битгий уяач.

-За боллоо гэж тэр санаа амарсан янзтай хэлээд мөн хөлийг нь баганатай бэхлэн шагайгаар нь чанга дарж уяв. Тэгээд шилтэйгээсээ дахин нэг балгаснаа,

-Уух уу? гэж асуухад хүүхэн толгой сэгсрэв.

Тэр хайхрамжгүйхэн мөрөө хавчаад,

-Чиний л хэрэг гээд дахин шилтэйг уруулдаа наав. "Тэр согтотлоо уугаад унтаж орхиж юун магад" гэж горьдон бодов.

-Би өдөрт яг нэг литрийг уудаг нормтой гэж Атанас гайхуулаад,

-Ажилдаа орох цаг боллоо хэмээн хоосон шилийг шала дээр шидэв.

-Чи юу хийх гээд байгаа юм бэ?

-Жаахан золгүй явдал зохион байгуулах хэрэгтэй байна. Демирисээс хоёр нугласан хөлс авахын тулд шүү дээ.

"Демирис гэнэ! Энэ бүхэн зүүд биш байжээ. Энэ бүх аймшгийн ард тэр л зогсож байжээ..."

Атанас аварга том бойлер руу дөхөж очихыг хүүхэн харав. Нүүрний нь хаалтыг аваад ил гарч ирсэн дохионы чийдэнг харж халаах найман ялтсыг оролдож эхлэв. Төмөр хайрцагт бэхлээстэй байгаа хамгаалалтын хавхагийг шалан дээрээс авсан модны хугархайгаар ажиллах аргагүй болтол хөшиж тогтоов. Халаалтын дээр температур хэмжих заалт дээр цельсийн 150 градус хэмэн заасан байв. Атанас заалтын хамгийн дээд цэгт тулгаж тавиад сэтгэл хангалуун буцаж ирэн,

-Энэ зуух юу болж дуусахыг мэдэж байна уу? Дэлбэрч л таарах байх гэж айж байна. Дулааны хэм 400 градуст хүрэх үед тогоо дэлбэрнэ. Дараа нь юу болно гээч? Хийн хоолойнууд хагарч ялтаснууд хавиралдаж, хий дэлбэрнэ. Тэгээд л байшин тэр аяараа агаарт тоос болон хийснэ дээ.

-Чи солиорчээ. Энд ямар ч гэмгүй хүмүүс дүүрэн бий.

-Буруугүй хүн гэж байдаггүй юм. Америкчууд та нар цөмөөрөө л санаа амар нүд анина гэж итгэж байдаг хүмүүс шүү. Мулгуу амьтад. Сайхан төгсгөл гэж байдаггүй юм гээд хүүхний гарыг хэр чанга уяснаа шалгаж үзэв. Атанас гараа явуулан хүүхний нүцгэрсэн цээжийг илж, хөхийг нь базсанаа дараа нь бөхийж амандаа хиж үнслээ. Үсдэж аван толгойг нь арагш гэдийлгэн уруулыг нь шунаглан үнссэнд амнаас нь спирт хурцаар ханхлав.

-Үүрд баяртай, Кэтрин гээд арагш болов.

-Намайг бүү орхиоч. Тохиролцоё л доо... гэж хүүхэн түүнээс аргадангуй гуйв.

-Онгоцноосоо хожимдох нь байна. Афин руугаа буцах минь гээд шатаар дээш өгсөнгөө,

-Гэрлийг чинь асаалттай орхиё. Юу болж байгааг сайн ажиглана биз гээд дахин нэг хором өнгөрхөд хаалга дээр хаагдаж нам гүм болохыг сонсов.

Тэр цор ганцаар үлджээ. Хэмжих зүү хурдан өгсөж нүдэн дээр нь 160, 170 градус болсон боловч цааш өгслөө. Тэр хамаг хүчээ шавхан уяаг тасдах гэж оролдон гараа суллах гэсэн боловч уяа улам чивчирч байлаа. Хэмжүүрийн зүүг дахин харвал 180-д хүрчээ. Аврагдах зам алга байлаа!

Алан Гамильтон доктор Уймроул гудамжаар машинаа жолоодон цагдаа нарын дохиог үл анзааран галзуурсан хуртай довтолгож явав. Гэтэл өмнөхөн талд нь зам засварын хөндлөвч мод тавьсан байсанд тэр зүүн тийш эргэн Оксфордын циркээр тойрохоор эргэв. Машин урсгал явахад саад болж байлаа.

Бон стирд дэх байшингийн хонгил дахь бойлерын зүү хоёр зууд хүрчээ. Тэсэхийн аргагүй халуун боллоо.

Гудамжны хөдөлгөөн бараг бөглөрч хурдлах битгий хэл зогсоход хүргэлээ. Алан юу хийхээ үл мэдэн жооныхоо ард сууна. "Цагдаагийн газар руу утасдах хэрэгтэй байх. Гэвч тэгээд яах ч юм билээ? Тэд шоолон инээх байлгүй. Би өөрөө л асуудлыг шийдэх хэрэгтэй". Машин хөдөлж эхэллээ.

Хэмжүүрин зүү хэдийнэ 300г заажээ. Байшинд чөтгөр тогтохын аргагүй халуун. Тэр дахиад л гараа суллах гэж оролдсон боловч амжилт олсонгүй.

Тэр Оксфордын гудамжаар эргэмэгц хурдаа нэмэн гарцаар хоёр хөгшин хатагтай сугадалцан явж байгаагийн дэргэдүүр сүнгэнэ гарлаа. Ард нь цагдаагийн шүгэл тас хихийг сонсоод зогсож цагдааг авч явья хэмээн бодсон боловч түүнд учрыг тайлбарлаж байх цаг байгаагүй учир араагаа солин хурда нэмэн одлоо.

Уулзвар дээр түүний замыг хөндөлсөн ачааны том тэрэг гарч ирсэнд Алан тэсгэлгүй хурдаа хасав.

Дахиад цааш хөдлөх боломжтой боллоо. Ердийн үед арван минут зарцуулдаг замыг Алан

Гамильтон доктор гучин минутанд туулах болжээ.

Хонгил дахь хэмжүүрийн зүү 400 дээр ирээд гозойлоо.

Эцэст нь конторын байр харагдлаа. Алан булан тойрч тоормос гишгээд хаалгаа онгойлгон машинаас үсрэн буув. Байшингийн зүг хэдхэн алхаж ч амжаагүй байтал газар доргин тэр том байшин бүхэлдээ дэлбэрэн тэр хавийн газар нилдээ галд автлаа.

Бас үхэлд...

Гучин нэгдүгээр хэсэг

Атанас Ставич сэтгэл нь хөөрөөд дээд оргилдоо тулаад байв. Даалгавраа биелүүлсэний дараа нисэх явдал түүнд байнга тохиолдог байлаа. Түүнд баримталдаг нэг зарчим байсан нь ю гэвэл, хохирогч болох гэж байгаа хүнтэйгээ эхлээд эр, эм ялгалгүй бэлгийн хурьцалд орж гажиг хүслээ хангана. Дараа нь амийг нь тасаладг байв. Харин энэ удаад Кэтринийг зовоож хүчирхийлж чадаагүйдээ уур нь хүрч явав. Түүнийг нарийн гудамжаар алхахад гудамжны булан тохойд зогсоцгоох хүүхнүүд хажуугаар өнгөрөх эрчүүдийг сонжин,

-Хүүе, хонгор минь. Орой франц хэлний хичээл хийвэл ямар вэ?

-Хонгор минь, зугаацахыг хүсэхгүй байна уу> гэцгээн өднө.

Атанас руу харин нэг ч хүүхэн тоон хандсангүй, ажсан ч үгүй. Тэр савхин богино банзал өмссөн, шаргал үстэй өндөр хүүхэнд дөхөж очоод,,

-Оройн мэнд гэж найрсгаар мэндлэв.

-Мэнд үү, дүү минь. Ээж чинь чамайг одоо болтол орондоо ороогүй энд тэнэж яваг чинь мээж байгаа юу? гэж өхөөрдөн асуусанд Атанас дарууханаар инээмсэглэн,

-Тиймээ, хатагтай. Хэрэв таныг завтай бол... би бодсон юм гэвэл янхан хүүхэн учиргүй хөхөрч,

-Юу гэнээ? Намайг завтай бол чи юу гэж? Чи ер нь хүүхэнтэй унтаж үзсэн юм уу гэж асуув,

-Нэг л уда гэж Атанас аяархан хэлээд,

-Надад их таалагдсан гэв.

-Чиний нуруу туруугий чинь харахад хөтөвчнөөсөө салаагүй гэмээр харагдана. Уг нь бол би жижиг юмнуудтай явдаггүй. Гэвч өнөөдөр жаахан урагшгүй байна. Тэгээд чамд арван зоос байгаа юм уу?

-Бий, хатагтай.

-Тийм бол дээшээ гарцгаая, хонгор минь.

Тэр хүүхэн Атанасыг дагуулан байшингийн хоёдугаар давхарт гарч ганц хүний жижигхэн өрөөнд орлоо.

Атанас түүнд мөнгөө өглөө.

-За алив, одоо юу хийж болохыг харцгаах уу даа гэж хэлээд хүүхэн хувцасаа тайлж гарлаа. Тэр хүүхэн Атанасыг нүцгэрэх үед нь харснаа гайхан дуу алдаж,

-Бурхан минь, чинийх ямар том юм бэ?! гэлээ.

-Тийм байна уу?

Хүүхэн орон дээр хэвтээд хэлсэн нь,

-Болгоомжтой хийгээрэй, намайг өвтгөв өө.

Атанас оронд ойртлоо. Уг нь тэр муусайн янхнуудыг зодож байж дураа хангадаг байсан боловч өнөөдрийн хувьд цагдаа нарт ул мөрөө үлдээж болохгүй тул хүмүүсийн анхаарлыг нэг их татаад яах вэ гэж боджээ. Тиймээс янхан хүүхэн рүү харан инээмсэглэж,

-Чамд аз дайрлаа гэж бод гэлээ.

Хүүхнийг бүдүүлгээр эзэмдэн өвдтөл нь хийхдээ орилж ёолон байгаа хүүхэн нь Кэтрин юм шигээр сэтгэн өршөөл гуйж мөргөж байгаагаар төсөөллөө. Гэвч тэр өрөвдөх сэтгэлгүй нэгэн. Хүүхний орилох дуу зөвхөн сэрлийг нь улам гозолзуулан эцэст нь дур ханах болтлоо ийнхүү үргэлжлүүлжээ.

Атанас нүдээ нээвэл Кэтрин биш царай муутай янхан хүүхэнтэй тамтаг болсон ор дэвсгэр дээр тохь тухгүй хавчиг өрөөнд байж байх нь тэр.

Олимп хэмээх нисэх онгоцны буудалд хэдхэн хүн дугаарлан зогсоно. Атанасын ээлж болж шалгагчид паспорт тийзээ сарвайн,

-Нислэг саатахгүй байгаа? гэж асуухад,

-Үгүй гэж хариулаад шалгагч билетийг нь авч нэрийг нь Атанас Ставич гэж уншмагц түүн рүү дахин харц шидсэнээ холгүй зогсох эрэгтэй хүн рүү үл мэдэг дохилоо. Тэр хүн ойртон ирж,

-Та билетээ өгнө үү гэхэд Атанас билетээ өгөх зуура,

-Юу болоо вэ? гэлээ.

-Бид энэ удаагийн нислэгт хэтэрхий олон билет худалдсан шиг байна. Хэрэв танд төвөгтэй биш бол тэр өрөөнд орно уу. Бид таны асуудлыг хурдхан шиг зохицуулаадхая гэж нөгөө хүн хэлэв.

Атанас мөрөө хавчин,

-За тэгье дэ гэлээ.

Эрэгтэйг дагаж заасан өрөөнд орлоо. Сэтгэлд нь аз жаргалын шувуухай жиргэж тэр явах биш нисэж байгаа гэхэд болно. Өдийд Демирисийг лав шоронгоос суллаж орхио байлгүй. Түүн шиг аугаа их хүчнийг ямар ч шорон барьж дийлж чадахгүй. Түүнд хууль хууль биш. Тэгэхээр Демирисээс өөрийн тавин мянгыг аваад швейцарь дахь банкинд хийнэ. Дараагаар нь Риверь юм уу эсвэл Рио орж жаахан амарна. Рио дахь эрэгтэй янхнууд нь мөн ч сайхан шүү!

Атанас толгой өргөн хараад хөшиж орхив. Царай нь зэвхийрч,

-Чи үхсэн! Чи үхсэн шүү дээ! Би чамайг алсан! гэж ер бусын хачин хоолойгоор гэнэт орилов.

Цагдаагийн бүрхүлтэй машинд чирч оруулаад авч явах хүртэл Атанас ийнхүү хашгирсаар байлаа. Дараа нь Алан Гамильтон эмч Кэтрин рүү харж,

-Бүх юм ард үлдлээ, хонгор минь. Ингээд нэг юм дуусдаг байжээ гэж сэтгэл амран хэллээ.

Гучин хоёрдугаар хэсэг

Энэ явдлаас хэдэн цагийн өмнө Кэтрин хонгилд хүлээсээ тайлах гэж хүчлэн оролдож байлаа. Гэвч хүлээс улам чангарч хуруунууд нь бүр мэдээ алджээ. Бойлерын хэмжих зүүг харвал 250-г зааж абив. "Зүү 400 хэмд хүрэхэд тогоо дэлбэрнэ. Би эндээс гарч чадахгүй нь" гэж хүүхэн бодно. Үгүй ямар нэг арга байх ёстой. Гэнэт түүний харц шалан дээр хаяж орхисон лонхон дээр туслаа. Зүрх нь хүчтэй цохилж эхэллээ. "Надад боломж байна" гэхдээ тэр чадах болов уу?... Кэтрин баганы ёроолд хүртэл доош суугаад хөлөөрөө лонхонд хүрэхийг оролдов. Дэндүү хол байна. Тэр хөлөө байдгаар нь урагшлууллаа ч гэсэн ердөө ганц дюймын зай үлдлээ. Нүдэнд нь нулимс цийлэгнэж дахин нэг оролдоод үзье хэмээн өөрийгөө дэмжих санаатай хэлэв. Нуруу нь хөшиж өвдөхийг ч үл тоон аль болох сайн доошилж хүрэх гэж тэмүүлсэнд нэг хөл нь аяархан хүрлээ. "Болгоомжтой. Цааш нь түлхэж орхив" гэж бодоод хөлөө хүлсэн олсоор лонхны хүзүүс болгоомжтой гогцоодож аваад бие өөдөө татлаа. Лонх дэргэд нь ирэх нь тэр.

Хүүхэн самбар руу сандран харвал 280 хэмд хүрсэн байлаа. Өөртөө багахан итгэлтэй болсон Кэтрин гараа хөдөлгөж үзвэл хуруу нь бадайраад цусанд будагдан гулсамтгай болжээ.

Хонгилд тэсэх арга алга. Лонх гарт баригдахгүй гулгана. Самбарын заалт 300 хүрчээ. Түүнд зүү дэндүү хурдлаад байх шиг санагдлаа. Тогоны халуун уур гадагш савсан гарна. Дахин нэг оролдого хийлээ.

Арай гэж бүтлээ! Лонхыг гартаа чанга атгаад багана руу хүчтэй дэлсэж хагалхыг оролдтол ямар ч амжилт олсонгүй. Гараас нь авралт лонх арай л мултраад унасангүй, хэмжүүрийн зүү эцэж цуцалгүй урагш тэмүүлэн 350 хэмд хүрэв. Кэтрин гүнзгий амьсгаа авад байдаг хүчээрээ цементэн шаланд цохиж хагалаад "Бурханы аврал" гэж дуу алдаад аль болох хурдан хөдлөхийг оролдон олсыг хэрчиж эхлэв. Шилний хагархай гарыг нь зүсэж өвгөхийг тоолгүй хурдан огтчиж олс сулрахыг мэдрэн нэг гарын хүлээс алдарлаа. Хүүхэн яаравчлан нэг гараа чөлөөлөөд хөлийнхөө олсыг барьж авлаа. Хэмжүүрийн зүү 380 хэмд ойртож явав. Тогооны уур хүржигнэн дуугарна. Кэтрин хөл дээрээ арай хийн бсолоо. Хонгилын хаалгыг Атанас гаднаас нь түгжсэн байсан тул гарах арга алга. Кэтрин тогоо руу гүйн очиж хамгаалагч хавхыг тээглүүлсэн хөшүүр морын хугархайг сугалах гэж оролдосн боовч бас л бүтсэнгүй. Зүү 400 хэмд чичигнэсээр ойртлоо. Шийдвэрлэх мөч болоход хэдхэн хором үлджээ. Тэр бөмбөгнөөс хоргодох байрны үүдийг онгойлгод үсрэн орж хаалгыг ташийлгэн хаалаа.

Том цооног нүхний цементэн шалан дээр хүндээр амьсгаадан уналаа. ТРаван минутын дараа бүх юм чичигнэн доргисноо аймшигт дэлбэрэлт болов. Тэр харанхуйд амьсгаа дарахыг хичээн цагиргалан хэвтэж хаалганы цаана модонд гал авалцан дүрэлзсэн түймэр гарахыг чагнан байлаа. Кэтрин аюулгүй байдалд оржээ. Бүх зүйл ард хоцрох нь тэр. "Үгүй, бүгд биш" гэж тэр бодоод "Бас нэг юм хийх үлдсэн" гэж бодлоо.

Цагийн дараа түүнийг аврагчид олж дээш гаргахад нүдээ нээгээд ож харсан анхны хүн нь Алан Гамильтон байв. Кэтрин түүн рү ухас хийн очиж чанга тэвэрлээ.

-Кэтрин, хайрт минь. Би ямар их айв аа. Чи яаж амьд мултрав аа?...

-Дараа ярьж өгье. Харин одоо Атанас Ставичыг барих хэрэгтэй гэлээ.

Гучин гуравдугаар хэсэг

Тэд Аланы дүүгийн эдлэн газраас холгүйхэн оршдог сүмд гадны хүмүүс оролцуулалгүйгээр чимээ шуугиан багатайхан гэрлэлээ. Аланы ажлын өрөөний ширэн дээр зураг нь байсан дүү хүүхэн аятайхан эмэгтэй байв. Хүү нь сургуулийн сурагч болсон ажээ. Кэтрин Алан хоёр тэндээ амралтаа өнгөрөөгөөд Венеци руу бал сараа тэмдэглэхээр нисчээ.

Дундад зууны билэг тэмдэг болсон Венеци олон суваг зуун хориод жижиг арал гүүр хөвсөн үлгэрийн хот байлаа. Алан, Кэтрин хоёр Местрийн дэргэд орших Марко Поло онгоцны буудалд газардаж талбайд хүрэв. Тэд Дожын ордны зэргэлдээ орших эртний хуучин буурчийн газар болох "Роял, Даниэли" зочид буудалд буужээ.

Захиалсан өрөө нь хуучны гоёмсог тавилгатай цонх нь суваг тийш харсан байлаа.

-За юунаас эхлэмээр байна? хэмээн Аланы асуухад Кэтрин түүнийг тэврэн,

-Таа л даа гэжэ.

Чемодан саваа тэд хожуухан янзалжээ.

Венеци хот Кэтрины өнгөрсөн аймшигтай амьдрал сэтгэлийн шархыг бүрмөсөн эдгээжээ.

Тэд Венецээр хөндлөн гулд явж үзлээ. Гэгээн Маркын талбай гэхэд л тэдний бусан зочид буудлаас ердөө хэдхэн зуун ярдын зайтай орших боловч цаг хугацаанз хувьд хэдэн зуун жилээр алслагдах аж. Талбайн цогчин гуанд уран зургийн галерэй байрлана. Дуганы хана таазыг сэтгэл догдлуулам гоёмсог шигтгээсээр чимэглэжээ.

Тэд Дажын ордонд мөн очиж гайхамшигт өрөө тасалгаагаар орж, зуу зуун жилийн өмнө хоригдлуудыг цаазаар авдаг байсан Санаашралын гүүрэн дээр зогсож үзэцгээв.

Тэнд байхдаа Кэтрин өрөвдмөөр ганцаардмал найдалд өнгөрөөсөн бяцхан сүмийн цэцэрлэгийг өөрийн эрхгүй санав. Гэлэнмаа нарын сүмд байснаа санахаар дэргэд байгаа хонгорхон Аланыг хараад,

"Баярлалаа танд Бурхан минь" гэж дотроо залбирдаг байлаа.

Баасан гаригт тэднийг буцахаар зэхэж байтал хүчтэй аадар орж эхэллээ.

Кэтрин Алан хоёр буудалдаа, цонхны дэргэд зогсон бороог ширтлээ.

-Бороо орсонд уучлал хүсье, хатагтай Гамильтон. Өргөн чөлөөнд гараад нартай сайхан байхыг амлая гэж Аланыг хэлэхэд,

-Юун бороо? Би үнэхээр аз жаргалтай байна, хайрт минь! гэж Кэтрин инэн хэлэв.

Цахилгаан цахиж тэнгэр дуугарахад Кэтринд тогооны аймшигт дэлбэрэлт санагдаж нөрөх рүүгээ эргэн,

-Миний санахад өнөөдөр шүүхийн шийдвэр гарах байх даа гэсэнд Алан хариу хэлэхээсээ өмнө нилээд эргэлзэж байснаа,

-Тиймээ. Гэхдээ би чамд энэ тухай сануулмааргүй байсан, яагаад гэвэл...

-Би хэвийн байна. Тайвширч үз, би зүгээр л мэдэхийг хүсэж байна гэж хэлбэл Алан хэсгэ зуур харж байснаа толгой дохиж,

-За за гэлээ.

Тэгээд өрөөний буланд тавиастай байгаа радио хүлээн авагч руу ойртон очиж асаалаа. Алан шинэ мэдээ дамжуулж буй Би-Би-Си радио станцын долгионыг барьтал товчийг эргүүллээ.

-... ерөнхий сайд чөлөөндөө гарах зөвшөөрөл гуйлаа. Сайд шинэ засгийн гаар байгуулах төлөвлөгөөтэй байна гэснээ хүлээн авагч паржигнан чимээгүй болов.

-Борооноос болж байна гэж Алан хэлэв.

Хүлээн авагч дахин дуугарч,

-Афинд Константин Демирисын шүүх хурал саяхан болж дууслаа. Хэдхэн минутын өмнө шүүгчид ялын тогтоол гаргажээ. Хүмүүсийн гайхлыг төрүүлсэн тогтоол гарч..

Радио таг болов.

Кэтрин Алан руу эргэн,

-Чи ямар шийд гарсан гэж бодож байна вэ? гэхэд Алан түүнийг тэвэрч,

-Чи итгэнэ үү, байна уу, бүх зүйл сайнаар төгсдөг байх ёстой гэдгээс шалтгаална гэж хариуллаа.

Төгсгөл

Константин Демирисийн шүүх хурал болтол ердөө тав хоног үлдээд байтал хорих тасалгааных нь хаалга нээгдэж,

-Тан дээр зочин ирлээ гэж харгалзагч хэлэв.

Демирис толгой өргөн харлаа. Өдий болтол түүн дээр өмгөөлөгчөөс нь өөр хэнийг ч оруулаагүй болохоор тэр гайхсанаа нуухыг хичээлээ. Энэ муу новшнууд түүнтэй жирийн хоригдол адил хандахад дургүй нь хүрэх ажээ. Гэвч удахгүй хэн болохоо харуулах л болно. Харгалзагч түүнийг уулзалтын бяцхан тасалгаанд авчирлаа.

-Ийшээ ор.

Демирис алхаж ормогцоо гадас шиг зогсож орхив. Тахир дутуу хүмүүсийн сандалд атигар биетэй өвгөн сууна. Цав цагаан толгойтой ажээ. Нүүр нь түлэгдэлтээс үүссэн эдгэсэн эдгээгүй улаан цагаан өнгийн толбоор дүүрчээ. Уруулд нь зэвүүн хүйтэн инээмсэглэл хөшжээ. Демирис түүний хэн болохыг таних хүртэл хэдэн минут өнгөрлөө. Тэгээд царай нь зэвхийрч,

-Бурхан минь, хайрлан энэрээч гэж дуу алдав.

-Тиймээ, би мөн байна. Хий үзэгдэл, сүг сүнс биш гэж өмгөөлөгч Наполеон Чотас хүржигнэн дуугарлаа.

-Орооч, Коста.

-Түймэр... гэрэл,

-Би байшингаас үсэрч буугаад нурууныхаа ясыг хугалсан. Бойдаа маань намайг гал сөнөөгчдийг ирэхээс өмнө аваад явсан юм. Намайг амьд гарсан гэж чамд мэдэгдэхийг би хүсээгүй юм. Чамтай тэмцэнэ гэхэд би дэндүү ядарчээ.

-Гэхдээ... цогцос олдсон шүү дээ.

-Тэр бол миний нярав аа.

Демирис сандалд унан,

-Би ... чамайг амьд байгаад баяртай байна гэж итгэлгүйхэн дуугарав.

-Тийм бий. Би чиний амь амьдралыг аврахаар ирлээ.

Демирис итгэж ядан харснаа,

-Нээрээ гэж үү? гэхэд,

-Тиймээ, би чамайг хамгаалах болно гэсэнд Демирис чангаар хөхөрч,

-Больж үз, Леон. Энэ олон жилийн турш намайг таньж чадаагүй гэж үү? Би яагаад чиний үгэнд итгэх ёстой гэж? гэлээ.

-Яагаад гэвэл, Коста минь надаас өөр ямар ч өмгөөлөгч чамайг хамгаалж чадахгүй.

Константин Демирис босож,

-Үгүй дээ, баярлалаа гээд эргэн хаалга руу зүглэв.

-Би Спирос Ламброутой ярилцаад хэрэг гарах үед чамайг өөр газарт байсныг гэрчлүүлэхээр болсон.

Демирис хөдөлгөөнгүй болж өмгөөлөгч тийш харан,

-Харин тэр яагаад зөвшөөрсөн юм бол гэхэд Чотас урагш тонгойн,

-Яагаад гэвэл би түүнд чиний бүх эд баялалийг салгах нь амьдралаас нь салгаснаас илүү амттай гэдгийг баталж ойлгуулсан юм гэв.

-Ойлгосонгүй.

-Би түүнд хэрэв чамд ашигтай мэдүүлэг өгөх юм бол чи эзэмшдэг бүхнээ түүнд өгнө гэж хэлсэн. Чиний компани, флот цөмийг тэр шүү.

-Чи солиорчээ.

-Тийм байна уу? Сайн бодоорой доо, Коста минь. Түүний мэдүүлэг чиний амийг аварна. Чамд эд хөрөнгө амьнаас чинь үнэтэй гэж үү?

Удаан дуугүй боллоо. Тэгээд Демирис эргэн сууж,

-Ламброу Мелинаг алагдах үед намайг өөртэйгөө цуг байсныг гэрчлэхийх зөвшөөрч байгаа юм уу? хэмээн эргэлзэнгүй асув.

-Тиймээ.

-Хариуд нь...

-Чамд байгаа бүхийг авна.

Демирис эсэргүцэн толгой сэгсэрч,

-Би... өөртөө үлдээх ёстой.

-Бүгдийг эсвэл юу ч авахгүй гэж тохирсон. Тэр чамд юу ч үлдээхгүй авж байж л эмдүүлэг өгнө. Тэр өшөө хонзонгоо авч байгааг чи ойлгож байгаа биз дээ?

Демирист дахиад асуух зүйл олон байлаа.

-Тэгвэл Леон, чамд ямар ашиг байна?

-Би тэр бүгдийг авна гэлээ.

-Ойлгохгүй байна.

-Чи Ламброуд "Грекийн худалдааны корпораци"-ийг өгөхөөс өмнө өөрийн бүх хөрөнгийг надад харьяалагддаг шинэ компани данс руу шилжүүлсэн байх ёстой.

Демирис түүнээс нүд салгалгүй ширтэн,

-Тэгэхээр Ламброу юу ч үгүй хоосон хоцрох нь ээ? гэсэнд Чотас мөрөө хавчин,

-Нэг нь хожиж, нөгөө нь хожигддог биз дээ гэлээ.

-Ламброуг мэхлэхээр шийдсэн юм бол намайг ч гэсэн мэхлэхгүй гэдэгт би яаж итгэх юм бэ?

-Хонгор Коста минь, бүх юм халбархан. Чи хамгаалагдсан л гэж бод. Чамайг цагаадсан тохиолдолд л шинэ компани миний мэдэлд ирэхээр бид тохиролцоно. Чамайг буруутай гэж тогтоовол би юу ч авахгүй.

Одоо л Демирис үнэнээсээ сонирхож эхэлээ. Тэрээр өмгөөлөгчийн сэг рүү анхааралтай харан сууж "Тэр зөвхөн надтай тооцоо бодох л гэснэдээ ялагдал хүлээж зуун сая долларыг салхинд хийсгэх хүн гэж үү? Үгүй тэр тэнэг хүн биш" гэж бодно.

-Тийм бол зөвшөөрч байна гэж удаанаар хэлэв.

-Сайн байна. Чи дөнгөж сая амь амьдралаа аварлаа шүү дээ гэж Чотас хэлэв.

"Би үүнээс ч илүү аврагдлаа. Надад хэн ч олохгүй газарт нуусан зуун сая доллар бий" гэж Демирис бодлоо.

Спирос Ламброу харин учраа ололцоход Чотаст амаргүй байжээ. Эхлээд тэр түүнийг тасалгаанаасаа хөөж гаргахыг завдав.

-Та надаас энэ мангас махчингийн амийг авар гэж гуйна гэнээ? Чөтгөр шулам руугаа Тонил! гэж хашгирлаа.

-Та чинь өшөөгөө авахыг хүсэж байгаа биз дээ?

-Хүсэж байна. Тэгээд өшөөгөө авах ч болно.

-Тийм үү? Та цаадахаа мэдэхгүй байна. Түүний хувьд мөнгө нь аминаас нь илүү үнэтэй. Хэрэв түүнийг цаазалбал сүүлчийн хэдэн минутанд л тэр зовно. Харин та түүний мөчийг

санжуулж сохор зоос ч үгүй орхивол тэр илүү удаан цээрлэгдэнэ гэсэн үг.

-Тэр надад бүхнээ өгөхөд бэлэн гэж та бодож байна уу?

-Бүх юмаа. Флот, компани гээд байгаа бүхнэ.

Дэндүү амттай болзол тулгаад байлаа.

-Бодох хугацаа олгооч.

Тэгээд Ламброу тэргээ жолоодон гарч яваа өмгөөлөгчийн араас харан: "Өрөвдмөөр ч амьтан бол доо. Ингэж амьдарч яадаг байнаа?" хэмээн бодов.

Шөнө дунд Спирос Ламброу Напоеон Чотаст утасдаж,

-Би шийдлээ. Бид тохиролцсон гэж бодоорой гэлээ.

Хэвлэл мэдээллийнхэн шуугиан тарьсан мэдээгээр ёстой нэг гулгиж байлаа.

Константин Демирис эхнэрээ алсан хэрэгт тулгагдаад шүүгдэж байна. Түүний үхэгсэд дундаас босож ирсэн гэж болох амь үрэгдсэнд тооцогдож явсан асан эрүүгийн гялалзсан өмгөөлөгч хүн өмгөөлөх гэнэ гэж сонин болгоны шахуу эхний нүүрэнд нийтэлжээ.

Шүүх хурал нэгэн цагт Ноэлль Пейж, Ларри Дуглас хоёрыг шүүж асан тэр танхимд болов. Демирис хэрэгтний суудалд сууж дэргэд нь түрдэг тэрэгтэй Наполеон Чотас сууна. Улсын яллагчаар онцгой хэргийн мөрдөгч Дельма томилогджээ.

Дельма шүүгчдэд ханан дараах үгийг хэлэв.

-Дэлхийн хамгийн хүчирхэг хүмүүсийн нэг Константин Демирис онцгой нэр хүндээ ашиглан үлгэрт гардагийн адил баяжсан хүн юм. Гэвч өнөөдөр мөнгөөр хдуалдан авч болдоггүй ганц эрх мэдэл байдаг нь хууль юм. Тэрээр хүйтэн сэтгэл гарган хүний амь хөнөөжээ гээд Демирис руу харснаа,

-Бид Константин Демирисийг маш харгис хэрцгийгээр, санаатайгаар хайрт эхнэрээ хөнөөснийг нотлох гэж байна. Та бүхэн эд мөрийн баримтыг үзэж гэрчийн мэдүүлэгтэй танилцаад энэ хүн хүн амины хэрэг үйлджээ гэсэн цорын ганц үнэн дүгнэлтэнд хүрэх болно гэдэгт би итгэж байна гээд суудалдаа суув.

Ерөнхий шүүгч Наполеон Чотаст хандан,

-Өмгөөллөө эхлэхээс өмнө танд мэдэгдэх зүйл байна уу? гэсэнд,

-Байнаа, эрхэм дээдэс ээ гээд Чотас тэргээ түрэн шүүгчдэд ойртон очиход тэдний нүдэнд өрөвдсөн байдал тодров. Тэд зэрэмлэгдсэн хүний хэлбэр дүрсээ алдсан царайг харж чадахгүй нүүр буруулна.

-Константин Демирисийг баян хүчирхэг гэдгийг нь төлөө шүүж байгаа бус. Гэвч яг тиймээсээ болоод л хэрэгтний суудалд сууж байж ч мэдэх юм. сул дорой хүмүүс хүчирхэг нэгнээ доош хийж уландаа гишгэхийг ямарг эрмэлзсээр ирсэн нь үнэн билээ. Тийм биш гэж үү? Ноён Демирис эрх мэдлтэй баян гэдгээрээ буруутай байж болох хэдий ч миний батлах гэж оролдоод байгаа ганц зүйл бол тэр эхнэрийнхээ үхэлд ямар ч буруугүй юм гэлээ.

Шүүх хурал эхэллээ.

Мөрдөгч Дельма эхэлж дэслэгч Теофилосыг гэрчийн журмаар байцаав.

-Дэслэгч ээ, ноён Демирисийн далайн эргийн харшид анх орохдоо байдал ямар байсныг дурслэн хэлж өгнө үү?

-Сандал ширээнүүд онхолдон унаж бүх юм замбараагүй болсон байсан.

-Тэнд аймаар зодоон болсон юм шиг санагдсан уу?

-Тиймээ, эрхмээ. Байшин руу бүлэг дээрэмчид довтолсон шиг сэтгэгдэл төрсөн.

-Тэгээд та хэргийн газар дээрээс цус болсон хутга олсон уу?

-Тиймээ, эрхмээ.

-Хутган дээрээс хурууны хээ илрүүлсэн үү?

-Тиймээ, эрхмээ.

-Хэнийх гэж тогтоогдсон бэ?

-Константин Демирисийнх.

Шүүхийн гишүүд цөм Демирисийн зүг харцгаалаа.

-Та хэрэг гарсан газрас өөр юу олсон бэ?

-Булангийн ханын шүүгээнээс Демирисийн нэрний эхний үсэг бүхий усны өмд олсон.

-Тэр тэндээ удсан шинжтэй байсан уу?

-Үгүй эрхмэ, тэд нойтноороо байсан.

-Баярлалаа.

Наполеон Чотасын ээлж болов. Тэрээр,

-Мөрдөгч Теофинос, танд хэрэгтэнтэй ярилцах боломж гарч байв уу?

-Тиймээ, эрхмээ.

-Тэр танд ямаршуухан санагдав? Бие бялдарын хувьд шүү дээ?

-За даа... гээд Демирис руу харснаа,

-Том бие бялдартай бадриун хүн гэж хэлж болно гэв.

-Тэр чадалтай болов уу?

-Тиймээ.

-Эхнэрэ алахын тулд гэрээ орвонгоор нь эргүүлэхээр хүн биш биз дээ?

Дельма үсрэн босож,

-Эсэргүүцэж байна гэлэ.

-Эсэргүүцлийг хүлээн авлаа. Өмгөөлөгч өөрийн санааг гэрчид тулган асууж болохгүй.

-Хүлцэл өчье. Эрхэм шүүгч ээ гээд Чотас мөрдөгч рүү хандан,

-Та ноён Демирис тэй ярилцаад түүнийг ер нь ямар хүн гэж бодсон бэ? УХаалаг хүн үү? гэхэд,

-Тиймээ, эрхмээ. Ингэж баяжхын тулд ухаантай байх хэрэгтэй байх.

-Тантай санал нийлэхгүй байж чадахгүй нь, дэслэгч ээ. Өөр нэг сонирхолтой асуулт байна. Константин Демирис шиг хүн ийм хэрэг үйлдэж рохиод хэргийн газар дээр хурууняа хээ бүхий хутгыг цус болсон усны өмдөө орхиод явна гэдэг дэндүү тэнэг хэрэг биш гэж үү? Та үүнийг ухаангүй явдал гэж бодохгүй байна уу?

-За даа, заримдаа гэмт хэрэг хийхдээ хүмүүс хачин юм хийдэг.

-Цагдаагийнхан Демирисийнх байх бүрэн боломжтой хүрэмний алтан товч олсон гэдэг үнэн үү?

-Тиймээ, эрхмээ.

-Тэгээд энэ бас Демирисийн эсрэг эд мөрийн баримт болгож байгаа. Цагдаагийнхан бодож таамаглаж байгаагаар тэр эхнэрээ алах гэж оролдож байх зодооны үеэр эхнэр нь энэ товчийг тасдаж хаясан гэж үзсэн.

-Бүгд үнэн, эрхмээ.

-Тэгэхээр одоо биндий өмнө сууж байгаа энэ хүн маш нямбай цэмцгэр хувцаслаж дадсан хүн. Түүний хүрэмний нэг товч дутуу байхад тэр үүнийг анзаараагүй. Тэр тайлаад шүтгээнд өлгөхдөө мөн л юу ч ажаагүй байна. Ийм байхын тулд хэрэгтэн тэнэг байхаас гадна бас сохор байх хэрэгтэй биш үү.

Дараа нь ноён Ктеланосыг гэрчээр дуудав. Мөрдөх товчооны эзэн гэнэт олнз өмнө гарч ирээд олдсон зөвшөөрлийг өөртөө аль болох ашигтайгаар ашиглаж хүмүүсийн анхаарлыг өөр дээрээ татахыг хичээлээ. Яллагч Дельма түүнд асуулт тавьж эхлэв.

-Та хувийн мөрдөх товчооны эзэн үү?

-Тиймээ, эрхмээ.

-Хэдэн хоногийн өмнө танай конторт хатагтай Демирис очсон уу?

-Очсон, эрхмээ.

-Тэр юу хүссэн юм бэ?

-Тэр өөрийгөө хамгаалуулахыг хүссэн. Тэр нөхрөөсөө салах гэсэн боловч нөхөр нь ална гэж сүрдүүлээд байна гэж хэлсэн.

Танхимд байсан хүмүүс шивнэлдээд явчихлав.

-Хатагтай Демирис зов сандарсан байсан уу?

-Тэгэлгүй яах вэ, эрхмээ. Бараг солиордогийн даваан дээр байсан.

-Тэгэхээр танай товчоог нөхрөөсөө хамгаалуулахын тулд хөлсөлж авчээ.

-Тэгсэн, эрхмээ.

-Баярлалаа, өөр асуулт алга гээд Чотас тийш эргэн,

-Гэрч таны мэдэлд очлоо гэлээ.

Чотас гэрчийн сандал руу тэргээ өнрүүлэн ойртоод,-Кателанос, та мөрдөх ажлаар хэр удаан оролдож байна вэ? гэж асуув.

-Ойролцоогоор арван жил болж байна.

Чотаст энэ хариулт өндөр стэгэгдэл төрүүлэв бололтой.

-Энэ маш урт хугацаа. Та ажилдаа бүр мэргэшсэн байж таарна даа?

-Тийм л болов уу гэж ниадаж байна гэж мөрдөгч даруухан хэлэв.

-Та зовлонд нэрэгдсэн хүмүүстэй байнга харьцдаг уу?

-Тэд надад ханддаг болохоор тэр ээ гэж Кателанос өөртөө хангалуун хэлэв.

-Хатагтай Демирис тан дээр очих үедээ сэтгэл хөнгөн уймарсан байсан уу эсвэл...

-Өө үгүй, тэр маш их цочирдсон байсан.

-Ойлгомжтой. Нөхөр нь түүнийг алах гэд байгаад айсан юм чинь аргагүй.

-Үнэн.

-Түүнийг гарч явахад та тэгээд хэдэн хамгаалагч явуулсан бэ? Нэг үү, хоёр уу?

-Үгүй дээ. Хэнийг ч түүнтэй явуулаагүй.

Чотас хөмсөгөө зангидан,

-Ойлгосонгүй, яагаад тэр вэ?

-Тэр биднийг даваа гаригаас эхлэнэ үү гэж гуйсан юм.

Чотас түүн рүү юу ч ойлголгүй өнгөрч орхисон болов уу гэж айчихлаа.

-Би ямар нэгэн юм ойлгогүй өнгөрч орхисон бололтой. Энэ эмэгтэй тан дээр сандарч цочирдсон орж ирсэн. Харин явахдаа даваа гариг хүртэл ямар ч хамгаалалт хэрэггүй гэж хэлсэн гэж үү?

-Тиймээ, яг тэгсэн.

Наполеон Чотас өөртэйгөө ярих мэт,

-Тэгэхэр хатагтай Демирис тэгтлээ их айсан гэдэгт эргэлзэх хэрэг гарах нь дээ гэлээ.

Дараачийн гэрчээр Демирисийн шивэгчинг дуудав.

-Та хатагтай Демирисийн нөхөртэйгөө ярилцаж байгаа яриаг өөрийн чихээр сонссон уу?

-Тиймээ, эрхмээ.

-Тэд юн тухай ярьсан бэ?

-Хатагтай Демирис нөхөртөө салах хүсэлтэй буйгаа хэлэхэд нөхөр нь салах зөвшөөрөл өгөхгүй гэж байсан.

Дельма шүүгшид руу харж,

-Ойлгомтой гээд шивэгчин ру дахин харж,

-Өөр юу сонссон бэ? хэмээв.

-Нөхөр нь түүнийг далайн эргийн байранд ганцаараа ирэхийг хүссэн.

-Эхнэрээ ганцаараа их гэж хэлсэн үү?

-Тэгсэн, эрхмээ. Хатагтай зургаан цаг болтол ирэхгүй бол цагдаагийн газар руу утасдаарай гэж надад хэлсэн юм.

Энэ мэдүүлэг шүүгч нарт тодорхой сэтгэгдэл төрүүлсэн учир цөмөөрөө Демирисийн зүг харцгаав.

-Өөр асуулт алгаа гэж Дельма өмгөөлөгч рүү харж,

-Гэрч эмэгтэй таны мэдэлд очлоо гэлээ.

Наполеон Чотас гэрч руу ойртон очоод,

-Таныг Андреа гэдэг үү?

-Үнэн, эрхмээ гэж хэлэхдээ шивэгчин түүнээс нүүр буруулав.

-Андреа та хэлэхдээ хатагтай нөхөртөө салах тухайгаа хэлэхэд нөхөр нь зөвшөөрөөгүй тэгээд гурван цагт далайн эрэг дээрх байрандаа уулзахаар болзсон гэсэн.

-Зөв өө, эрхмээ.

-Би таныг зөв ойлгож байна уу?

-Би шүүхийн өмнө тангараг өргөсөн.

-Андреа, та энэ бүгдийг огт сонсоогүй шүү дээ.

-Үгүй дээ эрхмээ, би сонссон.

-Яриа болсон өрөөнд утасны аппарат хэд байдаг вэ?

-Ганц л бий эрхмээ, юу гэж?

-Тэгэхээр та зөвхөн хатагтайн хэлснийг л сонссон болохоос биш ноён Демирисийн үгийг огт сонсоогүй, сонсож чадахгүй байх нь.

-Уг нь тийм л дээ.

-Өөрөөр хэлбэл та ноён Демирисийн эхнэрээ заналхийлсэн үгийг, далайн эргийн байранд уулзая гэснийг болон бусдыг огт сонсоогүй, харин зөвхөн хатагтайн үгээр л ойлгож авсан байх нь.

Андреа бүр балмагдаж,

-За даа, тэгж хэлж болно доо гэлээ.

-Зөвхөн ингэж л хэлж болно. Хатагтай Демирисийн ярьж байхад та өрөөнд байсан юм уу?

-Тэр намайг цай авчруулахаар явуулсан юм.

-Та авчирч өгсөн үү?

-Тэгсэн, эрхмээ.

-Ширээн дээр тавьсан уу?

-Тэгсэн, эрхмээ.

-Та тэгээд яагаад гарч яваагүй юм бэ?

-Хатагтай намайг байж бай гэсэн юм.

-Тэгэхээр тэр танд яриагаа сонсохыг хүссэн байх нь.

-Би... тийм ч байж болох юм.

Чотасын дуу ташуур мэт огцом болж,

-Та тэгэхээр хатагтай Демирисийн утсаар нөхөртэйгөө юу эсвэл өөр хэн нэгэнтэй юу, ер нь хэн нэгэнтэй ярьсан юм уу гэдгийг мэдэхгүй байх нь байна шүү дээ гээд хүүхэнд улам ойртон,

-Хатагтай Демирис маш чухал хувийн яриандаа таныг заавал байлгаж үлдэхийг танаас гуйсанд та гайхахгүй байна уу? Манай гэрт, жишээ нь бидний хэн маань ч зарц шивэгчингүүддээ хувийн яриагаа сонсохыг хүсдэггүй. Харин ч эсрэгээр. Тэгэхээр ийм яриа огт болоогүй гэдгийг та ойлгоосой гэж би хүсэж байна. Зүгээр л тэр эмэгэй нэгэн сайхан өдөр өөрийг нь алсан хэрэгт ноён Демирисийг шүүгээсэй гэж хүссэндэ утсаар ярьж байга мэт жүжиглэх зохион байгуулсан байна. Гэвч ноён Демирис эхнэрээ огт алаагүй. Түүний эсрэг баримтууд бол цөмөөрөө нарийн бодож зохиосон хуурамч баримтууд юм. Эрүүл ухаантай нэг ч хүн ийм олон ул мөр үлдээнэ гэж байхгүй. Константин Демирис шиг хүн бол бүр ч үгүй.

Шүүх хурал дахиад арав хоног сунжирчээ. Яллагчдийн мэдүүлэг, өмгөөлөгчийн мэдүүлэг, шинжээчдийн дүгнэлт, задлан шинжилгээний хариу зэргийг хэлэлцсээр олон түмний санаа бодол Демирисийг ил буруутайд тооцож байв. Наполеон Чотас бусдын нүднээс холхон байж хөшигний ард байхыг эрмэлзэх ажээ. Спирос Ламброуг гэрчээр дуудлаа. Бүр шүүх хурал эхлэхээс өмнө Демирис "Грекийн худалдааны корпораци"-ын бүх хөрөнгө оруулалтыг Спирос Ламброугийн нэр дээр шилжүүлэх гэрээнд гарын үсэг зуржаа. Урьд өдөр нь энэ бүхэн Наполеон Чотаст шилжинэ гэсэн нууц нэмэлтийг оруулж Демирисийг цагаадсан нөхцөлд л хэрэгжих болно гэж заажээ.

-Ноён Ламброу, та болон таны дүүгийн нөхөр Константин Демирис та хоёр бие биенээ хэзээ ч таалж байгаагүй гэдэг үнэн үү? Та хоёр бие биенээ үзэн яддаг гэж хэлбэл буруутах уу?

Спирос Демирис руу харж,

-Зөөлрүүлж хэлэхэд тийм гэлээ.

-Дүү бүсгүй чинь алга болсон өдөр Константин Демирис эхнэрийнхээ нас барсан газраас хол байсан гэж мэдүүлсэн. Өдрийн гурван цагт түүнийг алагдаж байхад тэр тантай цуг Акрокоринфд уулзсан гэсэн. Та цагдаагийнханд байцаалт өгөхдөө энэ баримтыг эсэргүүцжээ.

-Тиймээ, үгүйсгэсэн.

-Яагаад тэгсэн юм бэ?

Ламброу удаан дуугүй суусны дараагаар ярьж эхлэхэд түүний дуунд уурлаж хилэгнэсэн шинж илэрч,

-Демирис миний дүүтэй жигшмээр харьцдаг байсан юм. Түүнийг минь байнга дээрэлхэж доромжилдог байсан. Би хариуг нь авах гэж тэгсэн юм. Би түүний буруугүйн нотолгоог гаргаж өгөхийг хүсээгүй. Түүнд туслахыг огт хүсээгүй гэлээ.

-Тэгвэл одоо яагаад?

-Цаашид худлаа яриад байж чадахгүйгээ мэдэрлээ. Үнэнийг хэлэх ёстой.

-Та тэгэхээр тэр өдөр Константин Демирис тэй Акрокоринфд уулзсан гэж хэлж байна уу?

-Уулзсан, энэ үнэн.

Танхимд шуугиан дэгдээд явчихлаа. Царай нь цонхийсон Дельма үсрэн боосж,

-Эрхэм шүүгч ээ, би эсэргүүцэж байна... гэсэнд,

-Эсэргүүцлийг татагалзаж байна.

Дельма учраа алдан сандалдаа сув. Демирис урагш бөхийгөөд нүдээ гялалзуулан байна.

-Уулзалтынхаа тухай ярина уу. Энэ таны санаа байсан уу?

-Үгүй. Мелинагийн санаа байсан. Тэр бид хоёрыг хоюулыг хуурсан байсан.

-Хуурсан гэнээ? Ямар маягаар?

-Тэр надруу утасадаж түүний нөхөр надтай уулзах хүсэлтэй байна гэж хэлсэн. Дараа нь Демирис утасдаж намайг түүнтэй уулзаж, нэг хэрэг шийдэх хэрэгтэй боллоо гэж хэлсэн юм. Бид түүний үгэнд итгээд уулзсан боловч бидэнд нэг нэгэндээ хэлэх юм ю ч үгүй болох нь тодорхой болсон юм.

-Тэгээд та нарын уулзалт яг миссис Демирисийн үхэх үеэр өдөр дундад болсон юм уу?

-Яг тийм.

-Акрокоринфоос далайн эргийн харш хүртэл машинаар дөрөн цаг явдаг юм билээ. Би хэмжиж үзсэн гэж Чотас хэлээд шүүгчдэд хандаж,

-Тийм маягаар Демирис яагаад ч долоон цагаас эрт Афинд ирж чадахгүй хэрэв гурван цагт Акрокоринфд байсан бол тэр шүү дээ гээд Спирос Ламброу руу дахин эргэж,

-Та үнэн ярих тангараг өргөсөн хүн, ноён Ламброу. Таны бидэнд ярьсан болгон үнэн үү?

-Үнэн, бурхан намайг ивээг!

Наполеон Чотас дугуйт сандалаа эргүүлэн шүүгчид руу хандан,

-Ноёд хатагтай нар аа. Эндээс ганц л шийдвэр гаргаж болно гэхдээ бүхний анхаарлыг өөр дээрээ татаж,

-Тэр буруугүй ээ. Хэрэв яллагч хэрэгтэн эхнэрээ алуулахаар хэн нэгнийг хөлсөн гэж үзсэн бол та нарт ямар нэг эргэлзээ байж болох юм. Гэвч хэргийн бүх нотлох баримт, нотолгоонууд алуурчин яг тэр өрөөнд байж эхнрээ алсан мэт харагдуулахаар хийгджээ. Хүндэт шүүгчид иймэрхүү шүүх хуралд хэргийн учир шалтгаан, үйлдсэн арга барил гэсэн хоёр үндсэн зүйлийг батлах шаардлагатай гэдгийг хэлээд өгөх байх. Хуулиар бол тэд бие биенээсээ салшгүй сиамын ихрүүд шиг л холбоотой зүйлс юм. Ноёд хатагтай нар аа, хэрэгтэнд гэмт хэрэг үйлдэх шалтгаан байсан нь чухал биш харин сүүлчийн гэрчийн мэдүүлснээр сэжигтэн хэргийн газар дээр хэрэг гарсан цагт байх ямар ч боломж үгүйг нотоллоо.

Шүүх бүрэлдэхүүн дөрвөн цаг зөвлөлдлөө. Константин Демирис тэднийг суудалдаа ирж сууцгаахыг харав. Тэрээр цонхийж цайгаад догдолсон сэтгэлээ барьж ядан буй нь илт.

Чотас шүүгчдийг анхаарсан ч үгүй харин Демирисээс нүд салгалгүй харж сууна. Түүний өөртөө итгэлтэй бардам зан нүүрнээс нь бүрмөсөн арилсныг ажиглалаа. Энэ бол үхэл рүү нүүрээ харуулсан сууж байгаа хүн.

-Шүүгчид шийдвэр гаргав уу? гэж ернхий шүгч асуув.

-Тэглээ, эрхэм шүүгч ээ гэж гартаа хуудас цаас барьсан ахмад шүүгч хэлэв.

-Шүүхийн гүйцэтгэгч, тогтоолыг авчирч өгнө үү.

Шүүхийн гүйцэтгэгч шүүх бүрэлдэхүүн тийш очин тогтоол бүхий цаасыг аваад ерөнхий шүүгчид авчирч өгөв.

-Шүүхийн гүйцэтгэгч нарын үзэж байгаагаар сэжигтэн этгээд гэм буруугүй гэдэг шийдвэр гаргав.

Танхим тэр аяараа шуугиад явчихлаа. Дельма сонссон зүйлдээ итгэсэнгүй, толгой нь эргэж ухаан алдах нь уу гэмээр болов. Константин Демирисийн царайд сэтгэл уужирсан байдал

үзэгдэж Чотас тийш баяртайгаар харахыг Чотас нүдээ үл вачин харна.

-Би чамд юу гэж хэлээ, Коста.

-Чамайг бурхан ивээг, Чотас гэж сэтгэл нь хөөрсөн Константин Демирис ерөөв.

Тэднийг шүүхийн байрнаас гаран гартал сэтгүүлчид асуултаар булж энд тэндээс нь зургийг нь авах нь тэргэн дээр суух эрхэм өмгөөлөгчид таатай бус сэтгэгдэл төрүүлнэ.

-Коста, хоюул энэ баяраа манайд тэмдэглэвэл ямар вэ? гэж түүнийг асуухад Демирис "Надад байгаа зуун сая доллараар би ахин хамгийн баян хүн болно" гэсэн амтат бодолд толгой нь эргэсэндээ,

-За тэгье гэж бодох ч үгүй хэлэн толгой дохилоо.

-Ингэхэд байнаа, Ламброу өөрийгөө хоосон хоцорсон гэдгээ мэдээд яах бол? гэж сонирхон асуухад,

-Яах ч үгүй. Энэ дэлхийд нэг нь хожигдож нөгөө нь хожиж явдаг юм. Нэг ч центний үнэгүй компаны эрх түүний гарт очсон гээд жуумалзав.

-Би машинаараа ирсэн байгаа гэж хэлэн Демирист машинаа гайхуулах мэт харуулав.

-Чи чинь жолоочгүй юм уу? гэж үнэхээр гайхсандаа Демирис дуу алдав.

-Тиймээ, энэ над шиг хүмүүст зориулсан тусгай машин. Би бүхнийг ахин сурах хэрэгтэй болсон... гэснээ Демирисийг машиндаа суулгаад хөдөлж эхэллээ.

-Коста, айн гээч. Би энэ золгүй явдал болсны дараа их зүйл бодох болсон. Амьдралын тухай, болсон бүхний тухай. Ноэль Пейж, Ларри Дуглас бас Дугласын өмгөөлөгч залуу... Энэ бүгдэд мөнгө, эрх мэдэл ямар ч хамаагүй тийм үү? Зүгээр л үзэн ядалт, өшөө авалт гэж түүнийг хэлэхэд Демирис юу ч ойлгосонгүй дэмий л чимээгүй сууна.

Машин хурдаа авч эхэллээ.

-Коста, чи Ноэль Пейжид хайртай байсан тийм үү? гэсэнд,

-Тийм... гэж Демирис хариулав.

-Би ч бас түүнд маш их хайртай байсан. Хэтэрхий хайртай байсан ч би чамд тусалж түүнийгээ хороосон.

Демирис түүн рүү гайхан харахыг Чотас мэдэрч бяцхан инээмсэглэл нүүрэнд нь тодорлоо.

Машин улам хурдлан эгц уул өөдөө явж байв. Чотас хаазаа нэмсээр л...

-Арай хурдан яваад байгаа юм биш үү дээ? гэж Демирис үл ялиг айн асуухад,

-Үгүй дээ. Огтхон ч хурдлаагүй байна. Хавцал дээр миний нэг хувийн байшин байдаг юм.

Уулын нарийн, хадтай замаар машин улам хурдлан явж байлаа.

Одоо бол машины цонхоор тэнгис мэлтэлзэн бүх зүйлс илүү тод харагдаж байв.

-Хаашаа яваад байгаа юм бэ? Чөтгөр аваг, Чотас. Машинаа яг одоохон зогсоо гэж сөөнгөтсөн хоолойгоор Демирис ориллоо.

-Коста, бид хийсэн нүглийнхээ төлөө үхэх ёстой гэж би бодсон, хамтдаа.

-Чамд юу хэрэгтэй юм? Чи хэнээс ч илүү баян болсон биз дээ?

-Би огтхон ч баян болоогүй. Үнэнийг хэлэхд чиний найз гэлэнмаа баян болсон. Би чиний бүх хөрөнгийг Янин дахь сүмд хандивласан байгаа гэж хэлээд өрүүлээ эргүүлэхэд,

-Битгий гэж Демирис хачин зэвхий хоолойгоор орилох нь сонсогдов.

Машин хадан хавцлаас унах зуураа хаданд цохигдон дэлбэ үсэрснийг үнэндээ хэн ч мэдсэнгүй. Хэдэн хоромын дараа усанд дэлбэрсэн машины үлдэгдэл уусан шингэж ер хэзээ ч хэн ч үхээгүй мэт нам гүм ертөнцийг нөмрөн авлаа...